

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN: 2313-6170

Түлхүүр үг: Orçuulgazuj

ОРЧУУЛГАЗҮЙ

X

(Монгол уран зохиолын орчуулгын асуудал)

Эрхлэн хэвлүүлсэн: Г.Элдэв-Очир

Улаанбаатар
2022

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ОРЧУУЛГАЗҮЙ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ЦУВРАЛ

№10 (571)

Ариутган хянах зөвлөл

Эрхлэгч:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Ш.Эгшиг (доктор, дэд профессор)

Г.Элдэв-Очир (доктор, дэд профессор)

Э.Равдан (ШУ-ны доктор, профессор)

Го.Аким (доктор, профессор)

С.Эрдэнэмаам (доктор, профессор)

Л.Чулуунбаатар (доктор, профессор)

Г.Буяннэмэх (доктор, профессор)

О.Чинбаяр (МОЭ-ийн ерөнхийлөгч)

М.Чимэдцэеэ (доктор, дэд профессор)

К.Окада (Токиогийн ГСИС, доктор, профессор)

Б.Баярмэнд (ӨМИС-ийн МСС, доктор, профессор)

В.В.Мароши (Новосибирскийн УБИС, доктор, профессор)

Мари Доминик Эвен (ФҮШУСТөв, доктор, профессор)

Хоу Ваньжуан (Бээжингийн их сургуулийн Монгол

судлалын төвийн зөвлөх, профессор)

Санаачлагч: МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн профессорын хамтлаг

Хянан засварласан: Ш.Эгшиг, Г.Элдэв-Очир

Хуудасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 18 хх

Хэвлэсэн тоо: 50 ш

Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

ISSN: 2313-6170

Key title: Орчуулгазүж

TRANSLATION STUDIES

X

Compiled by: G.Eldev-Ochir

Ulaanbaatar
2022

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

TRANSLATION STUDIES

RESEARCH SERIES №10 (571)

Editor: Egshig.Sh (National University of Mongolia, Mongolia)

Secretary: Eldev-Ochir.G (National University of Mongolia, Mongolia)

Editorial Boards:

Ravdan.E (National University of Mongolia, Mongolia)

Akim.G (Ph.D, Professor, Mongolia)

Erdenemaam.S (Mongolian State University of Education, Mongolia)

Chuluunbaatar.L (National University of Mongolia, Mongolia)

Buyannemekh.G (National University of Mongolia, Mongolia)

Chinbayar.O (President of the Mongolian Translators Union, Mongolia)

Chimedtseye.M (National University of Mongolia, Mongolia)

Okada.K (Tokyo University of Foreign Studies, Japan)

Bayarmend.B (Inner Mongolia University, P.R.China)

Maroshi.V.V (Novosibirsk State Pedagogical University, Russia)

Marie-Dominique Even (French National Center for Scientific Research, France)

Hou Wanzhuang (Center of Mongolian studies of Peking University, P.R.China)

Founder: Professors Team for Translation Studies, Division of Humanities,
School of Arts and Science, National University of Mongolia

Edited by: Egshig.Sh, Eldev-Ochir.G

Paper size: A4

Number of pages: 18

Number of prints: 50

Press: Udams oyol LLC

ГАРЧИГ

Өмнөтгөл үг	7
-------------	---

ХЭЛ ШИНЖЛЭЛ

Д.Отгонтуяа, З.Энхмаа	Нейро хэл шинжлэлийн нэр томъёог орчуулах асуудалд	10
Э.Пүрэвжав	“Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн тухай	26
Л.Чойжилмаа,		
Ц.Гүндэгмаа, Б.Сүнжидмаа	Хятад хэлний тоолох үг монгол хэлнээ илрэх нь	31
Л.Одонтуяа, М.Баасанжав	Дарьганга аялгууны өвөрмөц онцлог	39

ОРЧУУЛГАЗҮЙ

Д.Бүрнээ	Буддын шашин соёлын холбоотой үг хэллэг, нэр томъёог орчуулах асуудалд	46
Г.Элдэв-Очир	“Монголын нууц товчоо”-ны хятад орчуулгад хийсэн Ажиглалт	51
Ц.Магсар	Жагдалын Лхагвын орчуулгад хийсэн ажиглалт	56
Ө.Нарантуяа	Д.Тарвын “Дамирангийнхан” зохиолын үгүйсгэх утга илэрхийлсэн “огт”, “ер” зэрэг үгийн орчуулгын тухай	62
Ш.Эгшиг	Монгол уран зохиолын хятад орчуулгын байдал, онцлог	67
Н.Амаржаргал	Орчуулгын хичээлийн гарын авлага бэлтгэж сургалтад хэрэглэх асуудалд	78
Б.Батчимэг	Реали үгийг буулгасан аргын тухай	83
Д.Долгорсүрэн	Монгол шүлгийн хэмжээ хэмнэл, уншигдах “аялгууг” орчуулах нь	89
С.Дугармаа, А.Амарзаяа,		
Б.Оюунсайхан	Монгол хэлний дүр байдал заасан дүрслэх үгийн утгыг англи хэлэнд илэрхийлэх нь	94
Г.Бат-Учрал, В.И.Павлов	Орчуулагчийн хэлзүйн чадамжийн тухайд	100
Т.Мягмарсүрэн,		
О.Халиунаа	Уран зохиолын реали үгийг орчуулах нийтлэг аргуул, тэдгээрийг утга илэрхийлэх түвшнээр эрэмбэлэх нь	106

ЭРДМИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Орчуулгын өдөрт зориулсан эрдмийн хэлэлцүүлэг: Орчуулгаар нэгдье, Олимпизмыг дэлгэрүүлье!	120
“Хятад хэлний хэлзүйн нэршлийн монгол оноолт” хэлэлцүүлэг	133

ОРЧУУЛГЫН САН ХӨМРӨГ

Б.Гэрэлт-Ирээдүй	Баатрын анхны үг	142
------------------	------------------	-----

CONTENTS

Preface		7
LINGUISTICS		
D.Otgontuya, Z.Enkhmaa	On the issue of translating neurolinguistic terms	10
E.Purevjav	About Explanatory Dictionary Chinese and Mongolian New Words	26
L.Choijilmaa, Ts.Gundegmaa,		
B.Sunjidmaa	Chinese quantifiers are expressed in mongolian	31
L.Odontuya, M.Baasanjav	Some features of the Dariganga dialect	39
TRANSLATION STUDIES		
D.Burnee	To the problem of translation on Buddhist words and terms	46
G.Eldev-Ochir	Observations on the Chinese translation of “The Secret History of the Mongols”	51
Ts.Magsar	Some observation made for Lkhagva Jagdal’s translation	56
U.Narantuya	A study on negation meaning of Mongolian some adverbs in Chinese translations	62
Sh.Egshig	The state and features on Chinese translations of Mongolian literature	67
N.Amarjargal	Designing and using a handbook of the translation course	78
B.Batchimeg	Transformation methods used in translation of realia	83
D.Dolgorsuren	The translation of Mongolian verses with their “melodic” onomatopoeic rhythms and tones	89
S.Dugarmaa, A.Amarzaya,		
B.Oyunsaikhan	Iconopoeic Words in Mongolian and Expressing their Meaning in English	94
G.Bat-Uchral, V.I.Pavlov	Some issues on the translator and interpreter’s competences	100
T.Myagmarsuren, O.Khaliunaa	Common methods of translating realia in literature: the ways of arranging them in the order of hierarchy in relation to converting meaning of the realia	106
ACADEMIC DISCUSSION		
Workshop on International Translation Day: Let's unite by translation, Let's spread Olympism!		120
Seminar on "Mongolian translation of Chinese grammatical terms"		133
TRANSLATION ANTHOLOGY		
B.Gerelt-Ireedui	The hero’s first words	142

ӨМНӨТГӨЛ ҮГ

“Орчуулгазүй” сэтгүүл 2013 онд анхны дугаараа гаргаснаас хойш эдүгээ арав дахь дугаараа толилуулж байна. Сэтгүүлийн бодлого бол дэлхийн орчуулгазүйн чиг хандлагыг даган, орчуулга судлал ба хэлмэрчлэхүйн түвшинд судалгаа хийхийг дэмжих, олон улсын өндөр түвшний эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлэн нийтэлдэг сэтгүүлийг хөгжүүлэх явдал юм. Манай улсад гадаад хэлнээс орчуулсан утга зохиолын олон төрөл жанрын орчуулга ихээхэн байдгийн хэрээр энэ талын судалгаа шинжилгээг дорвитой хийж иржээ. Монгол уран зохиол, нийтлэлийн бүтээлийг гадаад хэлнээ орчуулсан байдлын судалгаа дээрх хэмжээнд хүрэхгүй байгаа болохыг ахисан түвшний суралцагчийн дадлагын ажлаар гүйцэтгэсэн бүртгэлд тодорхой туссан юм. Ер нь аливаа улс орон өөрийн орны хэл соёл, түүх, зан заншлын байдлыг бусад гадаад хэлт ертөнцөд таниулах нь соёлын дархлаагаа дэмжих, өөрийн соёлын хүрээ хязгаарыг бий болгон ялгаруулах чухал үүрэгтэй болохыг зарим гадаад орны соёлын бодлогоос бид суралцан мэдэх болсон билээ. Ялангуяа дэлхийн тавцанд хэдий чинээ эдийн засгийн хувьд хүчирхэгжинэ, тэр хэрээр соёлын зөөлөн хүчээ зузаатгах байдал илэрхий тодорч байна. Энэ үүднээс манай улсын гадаад бодлогод мөн үндэстнийхээ соёлыг түгээн дэлгэрүүлэх, монгол судлалыг хөхүүлэн дэмжих, гадаад хэлээр монгол уран зохиол орчуулах явдлыг нэгэн чухал үйл хэрэг болгон, гадаад оронд улс орноо сурталчлах тусгай элч төлөөлөгчийг томилох, монгол судлал, Монгол улсыг сурталчилсан гадаадын иргэдийг онцгой дэмжиж эхэлсэн юм.

2012 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн МУИС-ийн Орчуулгазүйн хамтлагаас зохион байгуулж ирсэн эрдэм шинжилгээний бага хурал энэ жил “Монгол уран зохиолын гадаад хэлээрх орчуулгын асуудалд” сэдэвтэйгээр танхимын орчинд амжилттай зохион байгуулагдлаа. 2022 оны 4 дүгээр сарын 16-нд болсон уг эрдэм шинжилгээний хуралд МУИС-ийн профессор Д.Бүрнээ, профессор Ц.Онон, доктор Ш.Эгшиг, доктор Г.Элдэв-Очир, доктор Б.Гэрэлт-Ирээдүй, доктор Л.Солонго, доктор Л.Дорждэрэм, доктор Д.Отгонтуяа, доктор Д.Долгорсүрэн, Б.Батчимэг, магистрант А.Дуламсүрэн, Э.Тэргэл, А.Буянхишиг, МУБИС-ийн профессор Ц.Магсар, ШУТИС-ийн профессор С.Дугармаа, А.Амарзаяа, Б.Оюунсайхан, Японы Киотогийн Гадаад Судлалын Их Сургуулийн доктор Г.Сайнбаяр, ОУУБИС-ийн доктор Т.Мягмарсүрэн, орчуулга судлаач А.Цэрэнчулуун нарын эрдэмтэн судлаачид илтгэл хэлэлцүүлж, монгол уран зохиолын гадаад хэлээрх орчуулгын асуудалд илүү төвлөрөн орчуулгазүйн чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэв.

Олон улсын орчуулгын өдрийг тохиолдуулан МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын “Гадаад хэлний орчуулга” хөтөлбөрөөс 2024 онд Парис хотод болох зуны олимпын их наадмыг угтан “Орчуулгаар нэгдье, Олимпизмыг дэлгэрүүлье” уриан дор “Спортын сэтгүүлзүйн орчуулгын асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний их семинарыг 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар зохион байгуулсан юм. Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монголын Үндэсний Олимпын Хорооны Ерөнхийлөгчийн зөвлөх Ж.Отгонцагаан «Олимпизмын үг хэллэгийн орчуулга» сэдвээр, Дэлхийн Бөхийн Холбооны Азийн зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга П.Буяндэлгэр «Спортын үгсийн сан, нэр томьёоны орчуулга» сэдвээр тус тус илтгэсэн нь орчуулгын салбарын хувьд нэгэн шинэ сэдвийг хөндсөн явдал болов. Их семинарт спортын сэтгүүлч, орчуулагч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, орчуулгазүйн судалгаа хийдэг багш судлаачид, МУИС-ийн докторант, магистрант оюутнууд оролцож, мөн цахимаар сонирхсон хүмүүс оролцож, сонирхолтой хэлэлцүүлэг хийсэн юм. Энэ хэлэлцүүлгийн зарим илтгэлийн агуулгыг бид бичигт буулган, энэ дугаартаа мөн нийтэлж байна. Манай сэтгүүлийн анхны дугаарт орчуулгазүйн анхны хэлэлцүүлгийг бид мөн нийтэлж байсан юм. Ер нь ийм аман ярианы

зүйлийг бичигт хөрвүүлэн буулгах нь дискурсын шүүмжит задлан шинжилгээний нэг чухал эх хэрэглэгдэхүүн болдог бөгөөд цаашдын судалгаанд ч ашиглах боломжийг бий болгодог гэж үздэг. Орчуулгазүйг шинжлэх ухааны бусад салбар ухаантай холбогдох талаас нь өмнөх дугаарт эхлүүлж байсан ажил маань үргэлжилж байгаа болохыг энд тэмдэглэж байна.

Энэ жилийн бас нэг ажлын ололт бол манай МУИС-ийн Орчуулагч хэлмэрчийн мэргэшлийн үнэлгээний төвөөс сургуулийн дотоод төсөлд тус сургуулийн орчуулгын багш суралцагчдын хамтарсан багийн “Орчуулагч, хэлмэрчийн чадамжийн судалгаа” төсөл дэмжигдэн, бид улсын хэмжээнд орчуулгын чиглэлээр анхны томоохон судалгааг эхлүүлээ. Энэ судалгаагаар ирэх жилүүдэд бодит судалгааны үр дүн гарна гэдэгт бүрэн итгэлтэй байна. Магадгүй сэтгүүлийн дараагийн дугааруудад энэ талаар бичих биз ээ. Үүний зэрэгцээ “Гадаад хэлний орчуулга” докторын хөтөлбөрийг нээх бэлтгэл ажлыг эхлүүлж, хөтөлбөрийг урьдчилан магадлан итгэмжлүүлэх ажлын хэсэг байгуулагдлаа. Энэ нь бид одоо байгаа бакалавр, магистрын түвшний сургалтыг докторын түвшинтэй болгон, бүх шатны сургалтын хөтөлбөрийг иж бүрэн болгож, улмаар сургалт судалгаа хосолсон орчуулагч хэлмэрчийн цогц судалгааны бааз болоход дахин нэг алхам хийлээ.

МУИС-ийн 2016-2024 он хүртэлх стратеги төлөвлөгөөний дагуу сэтгүүлийн чанарыг ахиулах, цахим сэтгүүлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд манай сэтгүүлийн дугаарууд цахим санд орж эхэллээ. Энэ нь сэтгүүлийг олон нийтэд хүргэх, гадаад дотоодод түгээх боломж бүрдүүлж байгаа хэрэг юм. Цахимд шилжүүлэх ажлыг доктор Г.Элдэв-Очир хариуцан, магистрант А.Буянхишиг идэвхтэй ажиллалаа.



“Орчуулгазүй” сэтгүүлийн арав дах дугаар ийнхүү нийтлэгдэж байна. Бид сэтгүүлийг анх үүсгэн хэвлүүлж эхэлснээс хойш жил тутам тогтмол гаргасаар ирлээ. Энэ дугаар Хэлшинжлэл, Орчуулгазүй, Эрдмийн хэлэлцүүлэг, Орчуулгын сан хөмрөг булантай гарч байна. Дугаарын онцлог бол орчуулгазүйн чиглэлийн янз бүрийн байгууллагын эрдэмтэн судлаачдын өгүүлэл шалгаран хэвлэгдэж буй явдал юм. Энэ нь судлаач эрдэмтэд төдийгүй нийгмийн хүрээний төлөөлөл болсон олон хүн орчуулгын үүрэг, ач холбогдлыг сайтар ойлгон, ухамсарлаж байгаагийн илрэл болно. Ер нь эрдэм шинжилгээний сэтгүүлээр тогтохгүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ч орчуулгын талаар асуудлыг ихээр хөндөж байдаг юм. Манай сэтгүүлийн зорилго бол Монгол дахь орчуулгазүйн чиг хандлагыг тодорхойлж, тулгамдаж буй асуудлыг шийдэх эрдмийн индэр болох явдал билээ.

Эрдэмтэн судлаач, номын садан, уншигч та бүхнээс сэтгүүлийн талаарх санал, шүүмж, зөвлөгөө хийгээд бүтээл туурвилаа байнга ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.



Орчуулга бол дэлхийн олон соёлын уулзвар, үндэстэн хооронд бие биеэ танин мэдэх гүүр нь юм. Сэтгүүлийн бичигч, уншигч, дэмжигчдийн эрдэм оюуны гэгээн мэлмий тунгалаг байж, бүтээл туурвилын яруу найралт цагаан мөр нь ямагт дурайж байх болтугай.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбар
Гадаад хэлний орчуулга хөтөлбөр

Таргуд Шагдарсүрэнгийн Эгшиг (Ph.D)



ХЭЛ ШИНЖЛЭЛ





НЕЙРО ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН НЭР ТОМЬЁОГ ОРЧУУЛАХ АСУУДАЛД

Д.Отгонтуяа¹, З.Энхмаа²

Abstract: *Neurolinguistics is a scientific discipline with a significant role of studying the relationship between brain and language. Scientific researches, articles, books and related studies in the field of neurolinguistics is relatively scarce in Mongolian language which results in the inadequacy of its scientific terms translated and used in Mongolia. Hence arises the need to acquaint students, researchers and the public with basic knowledge and terms of neurolinguistics. Translating the most common terms of this scientific field, as well as giving explanation and providing information about the concept is not only crucial for further development of neurolinguistics in Mongolia but also the field of linguistics in general. This paper deals with the translation of most common used terms of neurolinguistics followed by the concept and basic knowledge of the terms. Some detailed definitions and explanations of the translation are also provided to certain terminologies. Furthermore, the translated terms have classified regarding to its methods of translation and types of the terminologies.*

Түлхүүр үг: *Нейро хэл шинжлэл, анагаах ухаан, нэр томьёо, орчуулга, тархи*

УДИРТГАЛ

Нейро хэл шинжлэл (нейролингвистик) нь хэл шинжлэлийн ухаанд чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдүгээ дэлхий нийтэд түгээмэл судлагддаг шинжлэх ухааны салбарын нэг болжээ. Энэхүү шинжлэх ухааны үндсэн зорилго нь хүний хэл ярианы үндэс, түүний хэрэглээг тархи, мэдрэл судлалын үүднээс тайлбарлах явдал юм. Түүнчлэн хэл эзэмших үйл явц, хэл ярианд гарах эмгэгүүд, хэл ярианы мэдээллийг тархинд хэрхэн боловсруулдаг, түүнийг тархины зураглалаар хэрхэн тодорхойлдог гэх зэрэг олон сонирхолтой асуудлыг судалдаг өргөн цар хүрээтэй шинжлэх ухааны салбар болон хөгжиж байна.

Нейро хэл шинжлэл нь олон салбар шинжлэх ухааны уулзвар дээр үүссэн бөгөөд хэл шинжлэл, нейро анатоми, неврологи буюу мэдрэл судлал, нейро сэтгэл судлал, философи, сэтгэл судлал, сэтгэцийн эмгэг судлал, хэл ярианы эмгэг судлал болон компьютерын шинжлэх ухаантай холбогддог. Түүнчлэн нейро биологи, антропологи, хими, хиймэл оюун ухаан, танин мэдэхүйн шинжлэх ухаан нь судалгааны онол, арга зүйн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг (Ahlén, 2006: 4). Үүнээс неврологи буюу мэдрэл судлал, хэл шинжлэл гэсэн үндсэн хоёр салбар ухааны хүрээнд судалгаа хийдэг учир нэг талаар анагаах ухааны, нөгөө талаар хэл шинжлэлийн нэр томьёонууд нейро хэл шинжлэлийн ном бүтээл, судалгааны ажлуудад хамгийн түгээмэл тохиолддог.

Нейро хэл шинжлэлтэй холбоотой, тархи болон хэлний эмгэгийн талаар дурдсан хамгийн эртний баримт бол “Эдвин Смитийн мэс заслын папирус буюу үйсэн дээрх бичиг” (*The Edwin*

¹ Доктор, МУИС, ШУС, Гадаад хэлний төв

² Хэл шинжлэлийн магистр

Smith Surgical Papyrus)” юм. Эртний Египетээс гаралтай энэхүү түүхэн үнэт сурвалжийг МЭӨ 1700 оны үед бичсэн байх магадлалтай гэж үздэг ч түүний эх хувилбарыг МЭӨ 5000 оны үед хамааруулдаг билээ (Volenes, 2015:378). Зохиогч нь тодорхойгүй, бүрэн эхээрээ олдоогүй ч нугасны гэмтэлтэй холбоотой гол хэсгүүд хадгалагдан үлдсэн нь цаашдын судалгаанд ашиглах боломжийг нээж өгсөн байна.

Эртний Грекийн сэтгэгчдийн нэг болох эмч Хипократэс (Гиппократ, МЭӨ 460-370) тархины гэмтэлтэй холбоотой үүссэн хэл ярианы эмгэгт дүн шинжилгээ хийж, афонос [*άφωνος*] буюу “дуугүй”, анаудос [*άναυδος*] буюу “сонсголгүй” гэсэн хоёр өөр төрлийн хэл ярианы эмгэг байдаг гэж тодорхойлсон байна (Ardila, 2015). Тэрээр “үсэг (тэмдгүүд)-ийн санамжаа алдсан” (дуу авианы санамжаа алдсан) өвчтөний талаар бичихдээ: “Хэл ярианы эмгэг илэрсэн үед ихэнх тохиолдолд тархины гэмтэл авсан талаас эсрэг талын биеийн хэсэгт саажилт үүсдэг” гэж тэмдэглэн үлдээсэн байдаг (Volenes, 2015:378).

Олон зуун дамжин салбар дундын судалгаа өргөжин тэлсээр XX зууны эхэн хагасаас “Нейро хэл шинжлэл” нь бие даасан шинжлэх ухааны салбар болж хөгжиж Оросын болон Америкийн гэсэн хоёр үндсэн “дэг сургууль”-д хуваагдсан байна. Нөлөө бүхий “дэг сургууль” нь Александр Романович Луриагийн онолууд болон Норман Гешвинд болон бусад онолчдын нөлөөгөөр бий болсон Бостон дахь “Афазийн судалгааны төв”-ийн онолууд юм (Ahlsén, 2006:39).

Оросын нейропсихологич А.Р.Луриа хүний оюун ухааны үйл ажиллагаа нь тархины олон хэсгүүдийг холбон ажилладаг нарийн төвөгтэй цогц үйл ажиллагаа бөгөөд тус бүр нь өөрийн гэсэн онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүний оюун ухааны үйл ажиллагаа тэр дундаа ухамсарт үйл ажиллагааны (*аялгуу хөг эсвэл сэрүүн байх үйл ажиллагааг хариуцсан хэсэг; мэдээлэл авах, боловсруулах, хадгалах үйл ажиллагааг хариуцсан хэсэг; сэтгэцийн үйл ажиллагааг програмчлах, зохицуулах, хянах хэсэг*) гурван үндсэн нэгжийг боловсруулан гаргасан.

Афазийн судалгаа болон эмчилгээнд маш ихээр нөлөөлсөн дэг сургууль нь Норман Гешвинд болон бусад онолчдын нөлөөгөөр гарсан Бостон дахь “Афазийн Судалгааны Төв”-ийн онолууд бөгөөд 1965 онд “Хүн болон амьтанд илрэх холбоо тасалдах хам шинж” (*Disconnection syndromes in animal and man*) гэсэн онолыг дэвшүүлснээр өнөөгийн неврологи судлалд “Ассоцианизм” *associationism* буюу “холбоо хэлхээсийн тухай онол”-г оруулж ирсэн юм. Энэ нь анатомид суурилсан бөгөөд холбоо тасалдах хам шинж *disconnection syndrome* болох афаз, агнозия (*agnosia* - танин мэдэхүйн чадвараа алдах), апраксия буюу зогсонгошил (*apraxia* - зорилтот үйл хэрэг хийж чадахгүй байх)-уудыг тархины хэсгүүдэд байршсан тухай онол юм.

Нейро хэл шинжлэлийн эртний болон дундад зууны үеийн түүх ихэвчлэн гэмтэлтэй тархин дээр судалгаа хийж өвчтөнүүдэд илрэх шинж тэмдгээр судалгаагаа хийдэг байсан бол орчин цагт хэлийг техник технологийн тусламжтайгаар нарийн судлах болсон байна. Орчин цагийн нейро хэл шинжлэлд хүний хэл яриаг эзэмших үйл явц, хоёр дахь хэл эзэмших үйл явцыг тархины үйл ажиллагааны дүн шинжилгээгээр тайлбарлах, хэл ярианы чадвараа алдсан хүмүүсийн өвчнийг зөв оношлохоос гадна эргэн хэл ярианы чадварыг эзэмшүүлэх, цус харвалтаас болон өөр гэмтлээс үүдэн хэл ярианы чадвараа алдсан хүмүүст тархины зураглалаар дамжуулан тухайн хүний санааг илэрхийлэн гаргах гэх зэрэг олон нарийн судалгааг явуулах боломж байгаа юм.

Нейро хэл шинжлэлийн судалгааны аргачлалууд

Хүний тархи, хэл хоёрын хоорондын холбоо хамаарлын талаар сонирхон судлах болсон цагаас эхлэн судалгааны арга нь гэмтлийн үр дагаврууд болон задлан шинжилгээний үр дүнд суурилсан ажиглалтын арга дээр тулгуурласаар ирснийг бид түүхэн баримтаас харж болох юм. Судалгааны арга нь ихэнх тохиолдолд гэмтэлтэй газрыг тогтоон уг хэсэгт илэрсэн гэмтлийн дараа хүний хэл ярианд ямар өөрчлөлт гарч байгааг судалдаг байжээ. Дээрх үндсэн арга барилыг эрт үеэс дундад зууны үе болон түүнээс ч сүүл цаг үед ашиглаж байсныг нейро хэл шинжлэлийн

судалгааны түүхээс харж болох юм. Харин цахилгаан төхөөрөмж ашиглах, компьютер зураглал хийх зэрэг судалгааны аргачлалууд нь орчин үеийн судалгааны үндсэн арга болж байна.

Нейро хэл шинжлэлийн судалгааг хийхэд компьютерчлэгдсэн рентген зургийн судалгаа (CAT scans, CT scans), тархины цусны урсгалын радио графикийн судалгаа ангиограф (*angiograms*) судалгааны гол аргын нэг болж байсан бөгөөд эдгээр нь афазийн туршилт болон ажиглалтын судалгааг нэмэгдүүлсэн боловч тухайн гэмтэлтэй хэсгийн тодорхой байршлыг олоход хангалттай байж чадаагүй юм. Тархийг дүрслэх (зураглал хийх) анхны аргууд нь тархины аль хэсэгт ноцтой гэмтэл гарсан, эсвэл цусны урсгалыг хязгаарлаж байгаа хэсгийг л харах чадвартай байжээ. Харин 1990 оноос нейро хэл шинжлэлд маш том дэвшил гарсан юм. Шинээр гарсан техник технологийн тусламжтайгаар зөвхөн афазитай, эсвэл тархины гэмтэлтэй хүмүүст судалгаа хийгээд зогсохгүй эрүүл хүний тархинд ч хэл ярианы боловсруулалт хэрхэн явагддаг, хэл ярианы үйл ажиллагаатай холбоотой хэсэг тархины аль хэсэгт илэрч байгаа зэргийг судлах боломжтой болсон байна.

Нейро хэл шинжлэлийн судалгааны аргад ашигладаг орчин цагийн технологиуд нь Функциональ соронзон резонансын дүрслэл (fMRI), Электроэнцефалографи буюу Тархины цахилгаан бичлэг (EEG), Соронзон цахилгаан бичлэг (MEG), Үйл явдалтай холбоотой өөрчлөгдөх харааны дохио Event-related optical signal (EROS), ERP долгионы хэлбэр буюу “үйл явдалтай холбоотой өөрчлөгдөх тархины чадамж” event-related potentials (ERP), Цусны хүчилтөрөгчийн түвшний хамаарал (BOLD), Хэт улаан туяаны ойрын (хэсгийн) скептроскоп Near-infrared spectroscopy (NIRS), Транскраниаль соронзон өдөөлт (TMS) юм. (De Zubicaray & Schiller, 2019).

Нейро хэл шинжлэлийн судалгааг хийхэд ихэвчлэн нейро зураглал (*neural imaging*) ашигладаг бөгөөд товчхон хэлэхэд хүн хэл яриа боловсруулах үед тархинд ямар үйл явц, шинж тэмдэг илэрч байгааг судалдаг судалгааны арга юм. Судалгаанд хамгийн түгээмэл ашигладаг аргууд нь электроэнцефалографи (EEG) болон функциональ соронзон резонансын дүрслэл (fMRI) юм.

Электроэнцефалографи (EEG) нь хүний толгойд (хуйх, нүүр болон хязгаар хэсгүүдэд) электродуудыг байрлуулан тархин дахь био цахилгаан үйл ажиллагааг хэмждэг инвазив бус буюу биед халдахгүйгээр (*non-invasive*) хэмжих аргачлал юм. Эдгээр электродууд нь мэдрэлийн харилцааны салшгүй хэсэг болох цахилгаан потенциалуудыг хүлээн авдаг. Мэдрэлийн дамжуулалт нь эсийн мембранаар цэнэг дамжуулдаг ионуудын урсгалыг агуулдаг бөгөөд ингэснээр цахилгаан потенциал өөрчлөгдөж, татах хүч нэмэгдэн тэлэхийг шаардсанаар цэнэглэгдсэн бөөмс хөдөлгөөн үүсгэх дохиог авдаг. Энэхүү үйл ажиллагааны потенциал (чадамж) нь хүлээн авагч нейроны дендриттэй холбогддог нейротрансмиттерийг ялгаруулах шалтгаан болж, түүний цахилгаан чадавхийг өөрчлөхөд хүргэдэг. Ялгарч буй нейротрансмиттерээс хамааран энэхүү потенциалын өөрчлөлт нь хүлээн авагч эсийг галлах магадлалыг ихэсгэх (өдөөх постсинаптик потенциал буюу EPSP) эсвэл галлах магадлалыг багасгадаг (дарангуйлагч постсинаптик потенциал, буюу IPSP). Эдгээр боломжит өөрчлөлтүүдийг холын зайнаас илрүүлж болох ба электроэнцефалографи бичлэгийн хүлээн авах дохиог бүрдүүлдэг (Nunez M, Nunez D & Srinivasan, 2016).

Хүний танин мэдэхүйн судалгааг хийхэд хүний тархины гадарга цахилгаан-физиологийн бичлэг хийхэд тохиромжтой орчин нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймдээ ч электроэнцефалографи нь мэдрэлийн үйл ажиллагааг шууд хэмжих боломжтой болдог. Тархины гадаргаас ирэх дохио тун бага байдаг тул өргөн талбараас авч үзэх нь зүйтэй. Иймд тархины үйл ажиллагаанаас гадна булчингийн үйл ажиллагаа, нүдний хөдөлгөөн, зүрхний цохилт гэх зэрэг биологийн дохионуудыг авах шаардлагатай байдаг. Танин мэдэхүйн судалгааны ихэнх нь ямар нэг өдөөгч (*stimuli*) үүсгэж эсвэл танилцуулж түүнээс үүссэн (хүний) зан чанарын хариу үйлдлийн дараа

илрэх мэдрэлийн үйл ажиллагааг судлахыг зорьдог. Харин энэхүү тодорхой нэг цагт барьсан (түгжсэн) мэдрэлийн хариу үйлдэл эсвэл үйл явдалд үзүүлэх тархины хариу үйлдлийн хэмжээс (ERPs)-ийг тасралтгүй явуулах электроэнцефалографиас шүүн авдаг (De Zubizaray & Schiller, 2019).

ERP долгионы хэлбэр “үйл явдалтай холбоотой өөрчлөгдөх тархины чадамж” нь электроэнцефалографи (EEG)-тай төстэй тоног төхөөрөмж ашигладаг ч үндсэн ялгаа нь тэдгээрийн дүн шинжилгээ авах арга барил юм. Судалгаанд оролцогчдод зураг, дуу гэх зэрэг өдөөгч хүчин зүйлүүдийг маш олон удаа үзүүлсний эцэст үүнээс ямар хариу үйлдэл, дохио тэмдэг тархинд илрэхийг судалдаг байна. ERP долгионы хэлбэр нь хүчдэлийн эерэг ба сөрөг цуврал хазайлтаас бүрдэх бөгөөд тэдгээр нь үндсэн бүрэлдэхүүний багцтай холбоотой байдаг (Luck & Karpenman, 2012:664). Үйл явдалтай холбоотой өөрчлөгдөх тархины чадамжийн бүрэлдэхүүн (*ERP component*) гэдэг нь олон нарийн төвөгтэй долгионуудын бүрэлдэхүүн юм. ERP бүрэлдэхүүнүүдийг түүний хоёр туйл (эерэг ба сөрөг цэнэг), хугацаа, хүйхны тархалт, даалгавар гүйцэтгэх үеийн мэдрэг шинж зэргээр тодорхойлдог.

ERP бүрэлдэхүүнүүд:

- Сөрөг үл нийцэх байдал буюу *Mismatch negativity* (MMN) нь сонсголын мэдрэхүйн туршилтад ихэвчлэн тохиолддог бөгөөд субъектэд өгөгдсөн стандарт дуунаас өөр буюу хэвийн бус дуу сонсогдоход илрэх электроэнцефалографийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. MMN -г хэл яриаг ойлгож ухамсарлах туршилтуудад ашиглаж болох ба хоёр дахь хэлийг сурч, эзэмшиж буй хүүхэд болон насанд хүрсэн хүний авиалбарын ялгаатай байдлыг (*phoneme discrimination*) судлахад ашигладаг.
- N400-г өгүүлбэрийн боловсруулалтыг утга зүйн түвшинд судлахад ашигладаг. Хэрвээ өгүүлбэрт утга зүйн хувьд алдаатай үг илэрвэл өдөөгч өгснөөс эхлэн маш хүчтэй сөрөг бие (бүрэлдэхүүн) чамархайн хэсэгт 300, 500 м/с хурдтай илэрдэг. Үүгээр үгийг утга зүйн хувьд өгүүлбэрийн утгатай холбоход бэрхшээл ихэссэн үед дээрх байдлаар илэрдэг гэж үздэг.
- N200 бүрэлдэхүүн нь (баруун урд хэсгүүд) үгийн сангийн сонголтын үед саад илрэх үйл явцыг *Go/noGo* парадигмын тусламжтайгаар илрүүлдэг.
- N170 болон P200 бүрэлдэхүүнүүд нь дагзны дэлбээнд илрэх харааны бичгийн боловсруулалтын үзүүлэлт гэж тодорхойлдог.
- P300 бүрэлдэхүүн нь үйлдэл хийх үеийн санах ойг ашиглах үед гарах хүчин чармайлтыг (ялангуяа хуурамч үг, танихгүй үгсийг тайлахад) тусгасан маш хүчтэй эерэг оргил үе (*strong positive peak*) юм.
- N320 бүрэлдэхүүн хэсэг нь авиалбар зүйн боловсруулалт болон код тайлах үйл ажиллагаанд хамаардаг.
- P600 бүрэлдэхүүн нь үг, өгүүлбэр боловсруулалтын үед өгүүлбэр зүйн боловсруулалт болон санах ойн шийдэл гаргах үйл ажиллагаатай холбоотой (Issa, Juhasz, Kozmann, 2018).

Нейро хэл шинжлэлийн өөр нэг түгээмэл судалгааны арга нь Функциональ соронзон резонансын дүрслэл (fMRI) юм. Функциональ соронзон резонансын дүрслэл нь нарийвчлан тодорхойлсон орчин нөхцөлд инвазив бус аргаар (амьд) хүний тархины үйл ажиллагааг хэмжиж зурагладаг техник хэрэгсэл юм. Функциональ соронзон резонансын дүрслэлийн тусламжтайгаар хүний тархинд ямар нэг гаднын биет оруулах, зүсэх гэх мэтээр хөндөхгүйгээр хүний тархийг зураглах боломжтой болжээ. Хүний хэл яриаг, гэмтэл учирсан газрыг байршлын онолоор тогтоох замаар судалж байсан бол энэхүү судалгааны аргаар хэл ярианы доголдол гараагүй, эрүүл тархинд хүний хэл ярианы боловсруулалт хэрхэн явагддагийг судлах боломжтой болсон юм.

Функциональ соронзон резонансын дүрслэл нь цусны хүчилтөрөгчийн түвшний хамаарал (*BOLD Blood oxygen level-dependent*)-ийн шинжилгээний үр дүн дээр тулгуурладаг. Тархины хэсэгт цусны урсгал хүрэх нь мэдрэлийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороход маш мэдрэг байдаг. Хэрвээ хүн нэг гарынхаа дөрвөн хуруунуудыг давтамжтайгаар эрхий хуруундаа хурдан хурдан хүргэвэл тархинд тэрхүү үйл ажиллагааг удирдах хөдөлгөөний хэсэгт цусны урсгал ойролцоогоор 60%-аар ихэсдэг байна. Иймд цусны урсгалд өөрчлөлт гарах нь мэдрэлийн үйл ажиллагааны өөрчлөлтийг мэдэх суурь шалгуур нь болдог юм (Shin, D.,)

Нейро хэл шинжлэлийн туршилтын техникт ашигладаг (тэр дундаа fMRI-д) судалгааны аргачлалын нэг нь хасах парадигм (*subtraction paradigm*) юм. Энэ нь үүрэг даалгавар өгөх үед хэл ярианы боловсруулалтын зарим нэг талыг хамарсан байж болох тархины идэвхжилийг үүнтэй ижил төстэй хэлний бус үйл явц (боловсруулалт)-ыг багтаасан боловч хэл шинжлэлийн үйл явцыг оролцуулахгүй гэж үзсэн суурь даалгаврын идэвхжүүлэлттэй харьцуулж үздэг. Жишээ нь: судалгаанд оролцогч үг унших үеийн тархины идэвхжилийг ямар нэг салангид үсэг уншихад илрэх суурь идэвхжилтэй харьцуулах, эсвэл утга зүйн хувьд хүнд өгүүлбэр унших үеийн тархины идэвхжилийг энгийн, хялбар өгүүлбэр унших үеийн идэвхжилтэй харьцуулан судалдаг байна. (En.wikipedia, 2021).

Сэтгэл судлалын судалгааны аргачлалууд нь нейро хэл шинжлэлийн судалгааны аргачлалуудад чухал нөлөө үзүүлсээр ирсэн билээ. Вэйсэньбург, Мкбрайд (*Weisenburg and McBride 1935*) нарын афазитай болон хяналтын бүлгийн (өвчтөнүүдэд) хэл шинжлэлийн болон хэл шинжлэлийн бус танин мэдэхүйн чадварын судалгаанд ашигласан “Сэтгэл судлалын тест” гэх судалгааны арга нь нейро хэл шинжлэлийн судалгааны аргад их хувь нэмэр оруулсан гэдэг (Ahlsén, 2006:36). Сэтгэл судлалд ашигладаг анхдагч боловсруулалтын аргачлал (*Priming*) гэх аргачлалыг нейро хэл шинжлэлд мөн ашигладаг ба үг тархины хаана хадгалагдаж мөн сэргээн санагддаг талаарх өргөн хүрээний асуудлыг судлахад ашигладаг. Анхдагч боловсруулалтын аргачлал гэдэг нь судалгаанд оролцогч өөрт нь өмнө нь утгын хувьд төстэй үг танилцуулсан тохиолдолд дараа нь түүнтэй ижил төстэй буюу холбоотой үгийг сонгох үзэгдэл юм. Жишээ нь: субъектэд эмч гэсэн анхдагч буюу *prime* үгийг үзүүлбэл дараа нь сувилагч гэсэн үгэнд хандах хандлага нь эрс нэмэгддэг. Үгийн сангийн шийдвэр гаргалт *Lexical decision*-ийн үүрэг даалгавар нь дээрх (*priming*) аргачлалд ашиглагддаг бөгөөд үүний учир нь судалгаанд оролцогчид хэрвээ өмнө нь танилцуулсан үг харвал дараа нь түүнтэй холбоотой буюу ойролцоо үгийг сонгох магадлал өндөр байдаг байна (Fiorentino & Poeppel, 2007:103).

Дээрх дурдсан аргууд нь нейро хэл шинжлэлийн хамгийн түгээмэл, олонд танигдсан, үндсэн аргууд болно. Нейро хэл шинжлэлийн судалгааны аргууд уламжлалт аргачлалаас гадна орчин цагийн техник технологийн тусламжтайгаар олон шинэ аргуудыг ашигладаг болж, судалгааны хүрээгээ өргөн тэлсээр байгаа юм.

Нейро хэл шинжлэлийн нэр томъёоны орчуулгын судалгаа

Нейро хэл шинжлэл нь Монголд шинээр судлагдаж буй салбар учир энэ шинжлэх ухааны үндсэн ойлголт, түүх, онол, судалгааны аргачлал зэрэгт элбэг тохиолдох нэр томъёонууд, утга агуулгын талаар тайлбар хийсэн бүтээл төдийлөн гараагүй байгаатай холбогдуулан нейро хэл шинжлэлийн нэр томъёог орчуулж, зарим нэр томъёонуудад утгын тайлбарыг хийлээ. Эл судалгаандаа нейро хэл шинжлэлийн ухаанд түгээмэл хэрэглэгддэг 100 нэр томъёог түүвэрлэн авч, орчуулгын тодорхой арга зарчмуудыг баримтлан монгол хэлнээ орчууллаа.

Аливаа шинжлэх ухааны салбарын орчуулагдаагүй нэр томъёог орчуулж, шинээр нэр оноохдоо утгын тайлбар хийлгүй дан ганц нэр оноох нь нэр томъёоны агуулга хаягдах, хүмүүст төөрөгдөл үүсгэх, буруу ойлголт өгөх зэрэг олон сөрөг үр дагаварт хүргэх тул зайлшгүй шаардлагатай нэр томъёоны утгыг тайлбарлаж, нэр оноох шалтгааныг хамтатган тайлбарлав.

Нейро хэл шинжлэлийн нэр томьёог орчуулахад тухайн салбар ухаантай холбогдох бусад шинжлэх ухааны талаар тодорхой ойлголттой байх, тэдгээрийн нэр томьёоны мөн чанарыг танин мэдэх нь зайлшгүй билээ.

Нейро хэл шинжлэлийн судалгаа, ном зохиол, гарын авлагад буй нэр томьёог ажиглахад нэр үг бүтээх -л болон -лт дагавар залгаж үүссэн нь цөөнгүй байв. Эрдэмтэн Г.Гэрэлмаа “Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж” бүтээлдээ үйлийн үр дүн, болц заасан нэр томьёо бүтээх дагаварт -лан (лэн, -лон, -лөн), -лт, -л, -дас⁴, -хуун, -хүүн, -мж зэрэг дагавруудыг багтаасан бөгөөд энэ дагаврууд нь үйл үндсэнд залгаж, үйлийн үр дүн, болц, үйлийн явцад үүссэн эд юм, шинж чанар заасан нэр үүсгэдэг гэж үзсэн байна (Г.Гэрэлмаа 2020:110).

Нейро хэл шинжлэлийн нэр томьёонд -лт дагавар орсон нэр томьёонууд нь: *Language processing* - Хэлний боловсруулалт, *Language storage* - Хэлний хадгалалт, *Speech perception* - Ярианы ойлголт, *Speech production* - Ярианы боловсруулалт зэрэг байв.

Нейро хэл шинжлэлийн нэр томьёог монгол хэлнээ буулгахад олонтоо хэрэглэсэн өөр нэг дагавар нь -л дагавар байв. Энэхүү дагаврын утгыг Л.Болд “уул дагавар нь үлэмж идэвхтэй хэрэглэгддэг бөгөөд нэлээд олон утга илтгэдэг. Тухайн үйлийн үр дүнд үүсэж бий болсон юмыг заан нэрлэсэн утга бүхий нэрийг үүсгэнэ” гэж үзсэн (Л.Болд, 1986:95) Ю. Мөнх-Амгалан, Кан Шин нар -л дагаврыг “үйлийн явц заасан утга, үйлийн үр дүнд үүссэн утга, үйлийн хэрэглэгдэхүүн болох юмны утга”-тай гэж ангилсан байна (Мөнх- Амгалан, Кан Шин, 2014: 34).

“Байгалийн ухааны салбарт -л дагавар залган үүссэн нэр томьёо их төлөв үйлийн үр дүнг илтгэсэн утгатай тул анагаахын салбарт өвчилсний үр дүнг заасан утгатай нэр томьёо цөөнгүй байгаа нь ажиглагдаж байна. Турсны улмаас тураал, хатанхайрсны улмаас хатанхайрал, саатахын улмаас саатал зэрэг нийлмэл нэр томьёо бүтээх нь түгээмэл аж” гэж Г.Гэрэлмаа “Монгол хэлний нэр томьёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж” бүтээлдээ -л дагаврын тухай тайлбарлажээ. Нейро хэл шинжлэлийн нэр томьёог орчуулахад -л дагаврыг олонтоо ашигласныг дээрх тайлбаруудтай холбон авч үзэж болох юм.

Нейро хэл шинжлэлийн -л дагавар бүхий нэр томьёо нь: *Agrammatism* - Хэл зүйн доголдол, *Apraxia of Speech* - Хэл ярианы ухамсарт хөдөлгөөний алдагдал буюу хэл ярианы зогсонгошил, *Apraxia of Pose* - Ухамсарт хөдөлгөөний алдагдал, *Auditory representation* - Сонсгол дууны дүрслэл, *Articulatory dysfluency* - Өгүүлэхүйн эрхтний үйл ажиллагааны бэрхшээл, *Auditory verbal agnosia* (pure word deafness) - Сонсголын доройтол (Нэг төрлийн үгийн дүлийрэл), *Brain imaging* - Тархины зураглал, *Brain lateralization* - Тархины аль нэг талын давамгайлал, *Cognitive deficit* - Танин мэдэхүйн хомсдол, *Language formulation* - Хэлний томьёолол, *Linguistic representation* - Хэл шинжлэлийн илэрхийлэл, *Motor representation* - Хөдөлгөөний дүрслэл, *Neuro imaging* - Мэдрэлийн зураглал, *Neurolinguistics* - Мэдрэл хэл шинжлэл / Нейро хэл шинжлэл, *Priming* - Анхдагч боловсруулалтын аргачлал, *Speech delay* - Ярианы хоцрогдол, *Verbal deafness* - Үгийн дүлийрэл, *Violation technique* - Зөрчлийн аргачлал гэх зэрэг болно. Дээрх -л, -лт дагавар бүхий нейро хэл шинжлэлийн нэр томьёонуудыг бүтэхэд орсон анагаахын болон хэл шинжлэлийн ухааны нэр томьёонуудын тооны харьцаа ойролцоо байна.

Нейро хэл шинжлэлтэй холбоотой анагаах ухааны болон хэл шинжлэлийн нэр томьёог орос, англи хэлнээс орчуулан авч хэрэглэхдээ ихэнхдээ нэр томьёоны тайлбар сэлтгүйгээр шууд галиглан буулгасан нь түгээмэл. Хэвшин тогтсон нэр томьёог өөрчилж шинээр оноох нь зохисгүй буюу олон нийтэд болон салбар шинжлэх ухааныханд төөрөгдөл үүсгэх магадлалтай. Нэр томьёонуудыг орчуулгын аргууд болох утгачлах, үгчлэх, дүйлгэх, тайлбарлан орчуулах зэргийг ашиглан анагаахын шинжлэх ухаан болон хэл шинжлэлийн салбарт түгээмэл ашигладаггүй, судалгааны бүтээлүүдэд өмнө нь дурдагдаагүй, галиглан буулгасан зөвхөн невролог (мэдрэл судлал)-ын бус нейро хэл шинжлэлийн шинэ нэр томьёонууд байсан учир шинээр нэр оноон орчуулж, утгын тайлбар хийснийг дараах жишээнүүдээс харж болно.

Neurolinguistics / *Невролингвистика* гэсэн нэр томъёоны орчуулгын тухай асуудлыг хөндье. *Neurolinguistics* / *Невролингвистика* гэсэн нэр томъёог нейро хэл шинжлэл (Мэдрэл / мэдрэлийн тогтолцооны хэл шинжлэл гэсэн утгатай) хэмээн хэрэглэж байна. “*Neuro*” гэсэн үг нь эртний Грекийн νεῦρο ‘*nerve*’ гэсэн үгээс гаралтай бөгөөд “шөрмөс, хөвч” мөн “*neuron*” буюу “хөгжмийн мяндас, нумын хөвч” гэсэн утгатай байжээ. Грекчүүд утсан хүүхэлдэйг мөн *neurospastos* (νευρόσπαστος) гэдэг байсан аж. Харин “*nerve*” латинаар “*nervus*”, өвөг Энэтхэг-Европын хэл (PIE)-д “(s)neu”, санскритаар “*snavan*” гэсэн үгсээс гаралтай бөгөөд бүгд “судас шөрмөс, холбоос утас, мяндас” гэсэн утгатай байна. Түүнээс гадна хүч чадал, тамир тэнхээ гэсэн утгаар ч мөн хэрэглэгдэж байв (Etymonline, online etymology dictionary).

Энэхүү үг түүхэн цаг хугацааны явцад утга нь өөрчлөгдөн хувьсаж өнөөдрийн бидний мэдэх “мэдрэл”, “мэдрэлийн систем буюу үйл ажиллагаа” гэх утгаар хэрэглэгдэх болжээ. Дээрх баримтаас харахад *Neurolinguistics* гэсэн нэр томъёог: 1. Нейро хэл шинжлэл, 2. Мэдрэл /мэдрэлийн тогтолцооны/ хэл шинжлэл 3. Тархи судлалын эсвэл Тархи хэл шинжлэл” хэмээн орчуулж тогтсон нэг нэршлээр томъёолоогүй байна.

Neurolinguistics “*neuro*” гэдэг нь мэдрэл / мэдрэлийн үйл ажиллагаа гэсэн утгатай бөгөөд невролог судлал буюу мэдрэл судлал нь дотроо төв мэдрэлийн систем (тархи болон нуруу нугас), захын мэдрэлийн систем (бусад бүх мэдрэлийн бүрэлдэхүүн хэсэг болох нүд, чих, арьс мэдрэхүйн хүлээн авагч гэх мэт) гэсэн хоёр үндсэн салбарт хуваагддаг. Нейро хэл шинжлэл нь хэл ярианы үйл ажиллагааг тархи хэрхэн боловсруулж байгааг судлах шинжлэх ухаан боловч мөн чанартаа “гол удирдлага” нь мэдрэлийн үйл ажиллагаа учраас цаашид “нейро хэл шинжлэл” юм уу, “мэдрэл хэл шинжлэл” (мэдрэлийн гэвэл утгазүйн алдаа гарна) гэж нэрлэн тогтох нь зүйтэй санагдана. Харин олон нийтийн хүртээлд “мэдрэл хэл шинжлэл” гэх нь гоозүйн хувьд зохимжгүй учир дээрх хоёр хувилбараас “нейро хэл шинжлэл” гэсэн нэрийг оноох нь зөв болов уу.

Нейро хэл шинжлэлийн судалгаанд тохиолдох түгээмэл нэр томъёо нь хэлний эмгэг болон гэмтлийн дараах хэл ярианд гарах өөрчлөлтүүдтэй шууд холбогдоно. Хэлний эмгэг өвчнүүдийн талаар эртээс эдүгээ хүртэл судалж ирсэн нь тархи, хэл яриа хоёрын хоорондын холбоо хамаарлыг судлахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Хэлний эмгэг нь “хэлний олдмол эмгэгүүд” *acquired language disorders*, “хэлний хөгжлийн (үе шатны) эмгэгүүд” *developmental language disorders* гэсэн хоёр төрөл байдаг.

Хэлний олдмол эмгэгүүд (*acquired language disorders*) нь тархины гэмтлийн улмаас үүсдэг бөгөөд төрөлхийн, эсвэл, хөгжлийн үйл явцад илэрдэггүй учир “олдмол” хэмээн орчуулав. Харин хэлний хөгжлийн (үе шатны) эмгэгүүд (*developmental language disorders*)-ийг хүүхдийн хэл ярианы чадвар, түүний насанд тавигдах үзүүлэлт, түвшнээс хэр бага байгаад үндэслэн оношилдог. Ийнхүү хөгжлийн шатанд тавигдах шалгуураар уг хэлний эмгэгийг тодорхойлдог учир “*developmental language disorders*” гэдэг нэр томъёог “хэлний хөгжлийн (үе шатны) эмгэг” гэж орчууллаа.

Хэлний олдмол эмгэг болох “Афазу” (*Aphasia*/ *Афазия*) нь нейро хэл шинжлэлийн судалгааны төв буюу хамгийн их судалдаг сэдэв юм. Энэ нь тархины гэмтлээс үүдэн хэл ярианы чадвараа алдах үзэгдэл юм. Нэр томъёо нь олон улсад “*Aphasia* (GB), *Афазия* (RUS), *Aphasie* (FR), *Afasia* (ESP) гэсэн нэрээр танигдсан учир “Афазу” гэж галиглан буулгаж ард нь уг өвчний тодорхойлолтыг тусгалаа. Афазийг зарим толь бичигт “хэлгүйдэл” гэж орчуулсан байх боловч энэ нь өвчний шинж тэмдэгтэй таарахгүй байна. Тиймээс афазийн талаар ерөнхий мэдээлэл өгөх хэрэгтэй гэж үзлээ.

“Афазу” нь дотроо олон төрөл байх ба түгээмэл илрэх афазу нь: Брокагийн афазу (*Broca’s aphasia*), Верникегийн афазу (*Wernicke’s aphasia*), дамжуулалтын афазу (*conduction aphasia*), авиаг буруу дуудах (*paraphasia*) юм. Афазу нь олон төрлийн шалтгаанаас үүсэж болох бөгөөд

тухайлбал, цус харвалт, инфаркт буюу тархины шигдээс (тархинд судасны бөглөрөл үүсэх үзэгдэл), цус алдалт (судаснаас цус алдах) болон тархины гэмтлээс шалтгаалан үүсдэг (Ahlsén, 2006:6).

Олдмол афази (*Acquired Aphasia*)-ийн хамгийн түгээмэл шалтгаан нь цус харвалт юм. Энэ нь хоёр шалтгаантай бөгөөд нэгд, цус харвалт нь маш түгээмэл, хоёрт цус харвалтын дараа афази үүсэх магадлал өндөр байдаг байна. Хамгийн түгээмэл цус харвалт нь тархины цусан хангамжийн артери цусны бүлэнгээр бөглөрөх (тромбэмболи) үед тохиолддог “Ишемийн цус харвалт” (*Ischemic stroke*) /нийт цус харвалтын 85%-д тохиолддог/ юм. Цусны урсгал буурах эсвэл саатсанаас артераар хангагдсан бүсүүдэд шигдээс (эсийн үхжил) үүсдэг.

Тархины дунд артери (*middle cerebral artery*) гэж нэрлэгдэх том артери Силвийн хоолой (*Sylvian fissure*)-аар дамжиж, тархины хажуу тал бөмбөлөг (*lateral cerebral hemispheres*)-ийн ихэнх хэсгийг хангадаг судлууд болж салаална. Хэлний чухал хэсгүүд болох Брокагийн хэсэг болон Верникегийн хэсэг нь силвийн хоолойн хэсэгтэй тун ойролцоо байрлах тул тархины дунд артерийн өөр өөр салаанд гарсан бөглөрөл нь хэлний тодорхой хэсгүүдийг гэмтээдэг байна. Түүнчлэн тархины дунд артерийн судсанд бөглөрөл үүссэнээр хэл ярианы олон хэсэг гэмтдэг аж. Зүүн талын тархины дунд артерт гарсан ишемийн цус харвалт афази үүсгэх хамгийн их магадлалтай ч тархины бусад хэсэг дэх цус харвалтууд афази үүсгэх боломжтой юм. Тархины тал бөмбөлгийн үлдсэн хэсгийг хангадаг өөр хоёр артери байдаг. Эдгээр нь тархины арын артери болон тархины урд артери юм. Эдгээр хоёр артерийн, тэр дундаа тархины арын артерит гарсан ишемийн цус харвалт нь ихэвчлэн афази үүсгэдэг байна.

Ишемийн цус харвалтаас гадна “*hemorrhagic stroke*” буюу эсийн гэмтэл эсвэл эсийн үхжилд хүргэдэг тархины судасны цус алдалт (цоорол) нь афазид хүргэх магадлалтай байдаг. Энэ төрлийн цус харвалт ишемийн цус харвалттай харьцуулахад хамрах газар нь өөр ч түгээмэл гэмтлийн хэсгүүд нь суурийн зангилаа (*basal ganglia*), харааны товгор (*thalamus*), тархины тал бөмбөлөг (*cerebral hemisphere*) юм. Эдгээр хэсгүүдэд бүгдэд нь гэмтэл гарснаар афази өвчин үүснэ (De Zubizaray & Schiller, 2019).

Афази үүсэх хоёр дахь үндсэн шалтгаан нь мэдрэл сөнөрлийн өвчин (*neurodegenerative disease*) юм. Энэ өвчин нь дотроо олон төрөл байх бөгөөд тархины өөр өөр хэсэгт, олон янзаар илэрдэг. Хэлний хэсэг нь тархины бусад хэсгээс түрүүлж гэмтвэл хэл ярианы доголдол нь уг өвчний анхны шинж тэмдэг болдог байна. Энэ төрлийн өвчнийг “Афазийн голомтын архагшил” *Primary Progressive Aphasia (PPA)* гэж нэрлэдэг (De Zubizaray & Schiller, 2019).

Энэ нь хэл ярианы чадвар аажмаар доройтдог мэдрэлийн хам шинж юм. “*Primary*” гэдэг нь анагаах ухаанд нэг талаар анхдагч (цаг хугацаа эсвэл хөгжлийн үеийн эхэнд илрэх зүйл), нөгөөтгээгүүр өвчин илрэх болсон анхны хэсэг буюу урхгийн голомт гэсэн утгатай бол “*Progressive*” гэдэг нь өвчин архагшин даамжрах (аажмаар доройтох, хүндрэх) гэсэн утгатай. Дээрх утгуудыг харгалзан үзэж *Primary Progressive Aphasia* гэсэн нэр томъёог “Афазийн голомтын архагшил” гэж орчууллаа.

Хэл ярианд илрэх эмгэгийн анхны шинж тэмдэг нь “чөлөөтэй ярих афази” буюу *fluent aphasia (Wernicke’s aphasia)* /тухайн хүний үгийн бүтээх (боловсруулалт)/-н хэмжээ хэвийн эсвэл нэмэгдсэн түвшинд байна. Хүн хэвийн ярих боловч заримдаа санаанаасаа үг зохиож эсвэл утгагүй үг оруулан ярьдаг учир ийнхүү орчуулав), эсвэл, “чөлөөтэй бус ярих афази” буюу *non-fluent aphasia (Broca’s aphasia)* байж болно /яриа нь идэвхгүй, цөөн үг бүтээх буюу боловсруулна/. Түгээмэл биш буюу ховор тохиолдолд хүн үг олох чадваргүй болж, нэр оноох, ойлгох чадвар доройтдог, харин үгээр илэрхийлэх чадвар хадгалагдан үлддэг (National aphasia association, n.d.). Дээрх нэр хоёр нэр томъёог шууд буюу үгчлэн орчуулахад өвчний шинж тэмдгийн утга агуулга алдагдахгүй байгаа тул *fluent aphasia*-г чөлөөтэй ярих афази, *non-fluent aphasia*-г чөлөөтэй бус ярих афази гэж орчуулав.

Олдмол афази нь маш олон шалтгаанаас болж үүсдэг ч хэлний олдмол эмгэгийн өөр нэг нь хэл ээдрэх эмгэг (*dysarthria*) юм. Өвчний үндсэн шалтгаан нь булчингийн сулрал бөгөөд энэ өвчний үед хүний хэл яриа бүтээхэд оролцдог булчингууд суларсан, мэдээ алдсан, эсвэл, гэмтсэн байдаг. “*Dysarthria*” гэсэн нэр томъёог өвчний хамгийн үндсэн шинж тэмдгээр нь нэрлэн орчуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хэл ээдрэх эмгэг (*dysarthria*) нь “Төв мэдрэлийн хэл ээдрэх эмгэг” *Central dysarthria* (тархины гэмтлээс шалтгаалан үүснэ), “Захын мэдрэлийн хэл ээдрэх эмгэг” *Peripheral dysarthria* (хэл ярианд оролцох эрхтнүүдэд гэмтэл гарснаас үүснэ) гэсэн ерөнхий хоёр төрөл байна (Cleveland clinic,n.d).

Анагаах ухаанд “central” гэдэг нь төв буюу биеийн гол гэсэг гэж үздэг бол “peripheral” гэдэг нь хүний гар хөл зэрэг захын эрхтнүүдийг төлөөлдөг. Харин анагаах ухаан тэр дундаа мэдрэл судлалд “central nervous system”-ийг “төв мэдрэлийн систем” гэдэг бөгөөд төв мэдрэлийн системд тархи, нуруу нугас багтдаг бол “захын мэдрэлийн систем” буюу “*peripheral nervous system*”-д тархи болон нуруу нугаснаас салаалах бүхий л мэдрэл багтдаг бөгөөд үүнд хүний булчин болон бусад эрхтнүүд ордог байна. Иймд дээрх нэр томъёонуудыг анагаах ухаанд тогтсон нэр томъёог ашиглан, түүн дээр орчуулагдаагүй нэр болох “*dysarthria*”-г шинж тэмдгээр нь нэрлэн холбовол “төв мэдрэлийн хэл ээдрэх эмгэг”, “захын мэдрэлийн хэл ээдрэх эмгэг” гэсэн нэр томъёо бүтэж байна. Утгазүйн хувьд өвчний шинж тэмдгийн нэрлэн илэрхийлж чадаж байгаа гэж үзэн ийн орчуулав.

Хэл ярианы бусад түгээмэл эмгэгүүд нь Апракси ***Apraxia*** (зогсонгошил) буюу ухамсарт хөдөлгөөний алдагдал (*apraxia*), хэл ярианы ухамсарт хөдөлгөөний алдагдал (*apraxia of speech*), тархины гэмтэл (*brain trauma*), ухааны хомсдол буюу тэнэгрэл (*dementia*), танин мэдэхүй – харилцан ярианы чадвар (*cognitive-communication skills*)-ын эмгэгүүд юм.

Ухамсарт хөдөлгөөний алдагдал буюу Апракси (*Apraxia*) нь тархины гэмтлээс үүдэлтэй хөдөлгөөний эмгэг юм. Нейро хэл шинжлэлийн хүрээнд уг өвчний үед ярихад бэрхшээл тулгарах ба дуу авиа болон үг хэлэхийн тулд их хүчин чармайлт гарах хэрэгтэй болдог (ASHA,n.d.). Энэхүү нэр томъёог толь бичигт апракси эсвэл ухамсарт хөдөлгөөний алдагдал гэж орчуулжээ. *Apraxia*-г мөн “зогсонгошил” гэж товч нэрлэж болох талтай. Апракси нь мэдрэлийн гаралтай эмгэг бөгөөд хүний хий гэсэн буюу даалгавар өгсөн зүйлийг ойлгосон ч хийж, гүйцэтгэж чадахгүй буюу хөдөлгөөн үйлдэж чадахгүйд өвчний гол шинж тэмдэг байгаа учир “зогсонгошил” хэмээн дүйлгэн орчуулж болох юм.

Хэлэхүйн ухамсарт хөдөлгөөний алдагдал (*Apraxia of Speech*)-ийн үед ярихад оролцох хэл уруулын хоорондын зохицол алдагддаг бөгөөд авиа гаргаж чадахгүйд хүргэдэг (IUP,n.d). *Apraxia*-г толь бичигт орчуулснаар ухамсарт хөдөлгөөний алдагдал гэсэн нэрээр авч харин “*apraxia of speech*” -г “хэлэхүйн ухамсарт хөдөлгөөний алдагдал” гэж орчууллаа. Үүнийг дээр дурдсанаар “зогсонгошил” нэрээр оноовол “хэлэхүйн зогсонгошил” болох аж.

Оюун ухааны хомсдол буюу тэнэгрэл гэж анагаах ухаанд үздэг ***Dementia*** нь тархины гэмтлийн улмаас ой санамж, оюун ухаан, ойлголт, хувь хүний зан чанараа алдах эмгэг юм. Хэлний гажиг нь уг өвчний олон төрлийн үед илэрдэг боловч ихэвчлэн оюун ухаанаа алдах гэсэн ерөнхий шинж тэмдэгт хамруулан авч үзсэн байдаг (National Aphasia Association,n.d.).

Танин мэдэхүйн – харилцан ярианы чадвар (*Cognitive-communication skills*)-т гарсан эмгэгийн үед хүн харилцан ярианы үед бодох болон санах үйл явцад өөрчлөлт ордог байна. Харилцан яриаг зөв явуулахын тулд хүний анхаарал төвлөрөлт сайн, орчин тойронд болж байгаа зүйлээ ухамсарлах ёстой байдаг. Харин тархины баруун талд цус харвасны улмаас эсвэл тээврийн хэрэгслийн ослын дараа танин мэдэхүйн-харилцан ярианы чадварын эмгэг илэрдэг байна (IUP,n.d).

Хэлний хөгжлийн эмгэг (Developmental Language Disorder [DLD])-ийг хүүхдийн хэл ярианы чадвар түүний насанд тавигдах үзүүлэлт, түвшнээс хэр бага байгааг үндэслэн оношилдог. Хэлний хөгжлийн эмгэгийн үед хэлний хомсдол нь аутизмын спектрийн эмгэг эсвэл дауны синдром зэрэг мэдэгдэж буй био-анагаахын эмгэг байхгүй тохиолдолд илэрдэг бөгөөд хүүхдийн хүмүүстэй чөлөөтэй харилцах чадварт саад учруулна. Хүүхэд өсөж хөгжих тусам түүний хэл яриа улам нарийн бүтэцтэй болдог. Харин энэ төрлийн эмгэгтэй хүүхдүүдэд энэ чадвар нь хөгждөггүй. Жишээ нь, энгийн хөгжилтэй хүүхэд “*тэр хүүхэд хурц хайчаар цаасаар дүрс хайчилж байна*” гэж хэлэх чадвартай байхад уг эмгэгтэй хүүхэд “*хүү хайчилж байна*” гэж хэлэх жишээтэй. Энэ эмгэгийн үед хүүхэд өөрийн санаагаа бүрэн ойлгуулахад хүндрэлтэй тулгарахаас гадна хэл яриаг ойлгоход мөн бэрхшээл үүсдэг.

Хэлний хөгжлийн эмгэгтэй хүүхдүүдэд авиалбар зүй, утга зүй, өгүүлбэр зүйд зөрчил үүсэн харилцан ярих, нийгмийн харилцаанд орох дүгнэлт хийх, дүрслэх үг хэллэг бүтээхэд бэрхшээл тулгардаг байна (Norbury, n.d.).

Унших чадваргүйн эмгэг (Dyslexia) нь хэлний хөгжлийн эмгэг (DLD)-ийн нэгэн адил мэдрэлийн хөгжлийн эмгэг (*neurodevelopmental disorder*) ч хэлний хөгжлийн эмгэгтэй адилтган авч үзэж болохгүй юм. Уг өвчний талаарх олон тодорхойлолтуудад өвчний үед үг унших, үсэглэх, үсэг тэмдгүүдийг танихад бэрхшээл тулгарна гэж бичсэн байдаг. Унших чадваргүйн эмгэг (Dyslexia)-ийн үед ихэвчлэн авиа зүйн бэрхшээл гардаг бол хэлний хөгжлийн эмгэг (DLD)-ийн үед авиа зүй, үг зүй, утга зүй, хэл зүй болон нийгмийн харилцааны хэрэглээн дэх хэлд бэрхшээл тулгардаг байна (Kinnane, 2019). Энэхүү нэр томъёог өвчний шинж тэмдгээр нь унших чадваргүйн эмгэг гэж оноов.

Афазийн олон нэр томъёо Вернике Лихтаймын загварт түгээмэл тохиолдоно. Вернике Лихтаймын загвар долоон төрлийн афазийн хам шинжийг гаргаж иржээ. Үүний нэг нь *Conduction aphasia* юм. Анагаах ухааны толь бичгүүдэд *Conduction* гэдгийн “дамжуулалт” хэмээн орчуулжээ. Уг эмгэг нь Брока болон Верникийн хэсгүүдийг холбох судлуудад гэмтэл гарсны улмаас үүсдэг бөгөөд дамжуулах хэсгийн үйл ажиллагаа тасалдсанаас үүсдэг учир “*дамжуулалтын афази*” хэмээн буулгалаа.

Нейро хэл шинжлэлийн орчуулгад нэлээд давтагдах нэр томъёонууд нь Хэнри Хээдийн дөрвөн төрлийн афазийн нэр томъёо бөгөөд үүнийг:

- **Үйлийн афази (Verbal aphasia)** - оновчтой үг олоход бэрхшээл гарах афази
- **Өгүүлбэр зүйн афази (Syntactic aphasia)** - өгүүлбэрийн хэмнэл болон өгүүлбэр дэх үг хоорондын дүрмийн харилцаа холбоонд доголдол гарах үзэгдэл,
- **Нэрийн афази (Nominal aphasia)** - өвчтөн өөрийн санаа бодол, ойлголтоо үгээр илэрхийлж чадахгүйд хүрэх
- **Утга зүйн афази (Semantic aphasia)** - үг өгүүлбэрийг зөв ойлгож чадахгүй байх гэж тус тус тайлбарлан орчууллаа.

Мэдрэхүйн афази (Сонсгол, оюун ухааны доройтлын афази) Sensory aphasia (Acoustic-gnostic aphasia)

Мэдрэхүйн афазийн хам шинж буюу Верникегийн афазийн үед сонсголын буюу дуу авианы ойлгоцын чадвар хамгийн ихээр гэмтдэг байна. Түүнчлэн өвчний үед сонсголын анхан шатны хомсдол буюу доройтол байхгүй тохиолдолд авиалбарын сонсголын хомсдолтой байх явдал юм (Luria, 1970:104).

Авиалбарын ойлголтын доройтол (хомсдол) нь нэн түрүүнд ярианы ойлголтоос ажиглагддаг бөгөөд өвчтөнд өөр үгийн утгын авиалбар мэт санагдуулан буруу ойлголт төрүүлдэг байна. Энэ өвчний тохиолдолд өвчтөнүүд үгийн дуудлагыг давтаж (дуурайж) чаддаг боловч түүний утгыг ойлгож чаддаггүй ажээ.

Өвчин хүндэрсэн тохиолдолд, мэдрэхүйн афазитай өвчтөнүүд бусад хүний яриаг ямар нэг утга авцалдаагүй дуу чимээ гэж хүлээж авдаг бол хөнгөн шатандаа зөвхөн эсрэгцсэн авиалбар (*b - p, d - t* гэх мэт)-ийг ялгахад бэрхшээлтэй байдаг байна. А.Р.Луриагийн үзэж байгаагаар мэдрэхүйн афазитай өвчтөнүүдийн яриа нь утга зүйн хувьд их алдаатай байдаг бөгөөд авианы нэгдэл болон түүний утга хоорондоо авцалдаагүй байдаг гэж үзжээ. Тэрээр үүнийг “авиалбар болон авиалбарын дарааллын ерөнхий зөрчил” гэж тодорхойлжээ (Luria, 1970:125). Дээрх байдлаас нэгтгэн үзвэл өвчтөн хэлц хэллэгүүдийг хэвийн буюу зөв дуудах боловч үгийн сан, үгийг зөв оноох чадвар маш муу байдаг ба зөвхөн өгүүлбэр зүй нь бага хэмжээгээр гэмтсэн байдаг байна.

Сонсголын доройтол, ой тогтоолттой холбоотой афази (*Acoustic-mnemonic aphasia*)

Яриа болон дууг санах ойдоо удаан хадгалж чадахгүйгээс аливаа зүйлийг нэрлэх, зөнгөөрөө ярих арафази буюу авиаг буруу дуудах (авиалбар ба үг солилцох)-д нөлөөлдөг. Харин өгүүлбэр болон үг дуудахад асуудал гарахгүй (Ahlsén, 2006:44).

Энэ хам шинж нь мэдрэхүйн афази өвчин эдгэх шатанд илэрч болох ба эсвэл тусдаа бие даасан хам шинжээр илэрч болох юм. А.Р.Луриагийн үзэж байгаагаар дээрх гэмтлүүдийн эхэн шатанд авиалбарын сонсголын хувьд *agraphia* (бичих чадваргүй байх) болон үгээр хэлж ярьж чадахгүй байсныг эс тооцвол ямар нэг ноцтой гэмтлийн үр дагавар илрэхгүй байсан байна. Анхан шатны гэмтлийн үед дууны санамжийн гэмтэл илэрч байсан ба энэ нь үг мартах, урт өгүүлбэрүүдийг цээжлэхэд бэрхшээлтэй тулгарах эсвэл богино хэмжээний үгийн дарааллыг мартах гэх мэт үзэгдэл (шинж тэмдэг)-ээр илэрч байжээ.

Хэл эзэмшихүй (*Language acquisition*) Нейро болон сэтгэц хэл шинжлэлийн судалгаанд тархины эмгэгээс гадна хамгийн их судлагддаг сэдэв бол хэл яриаг хүн хэрхэн эзэмшдэг тухай юм. Үүний тухай маш олон судалгааны сэдэв, бүтээлүүд байдаг ба хамгийн түгээмэл судлагддаг нь хүүхдийн хэл ярианы эзэмших үйл явц болон хүн хоёрдогч хэлийг хэрхэн эзэмшдэг талаарх судалгаанууд юм.

Нейро хэл шинжлэл нь хүүхдийн хэл эзэмших явц, хэлний үйл ажиллагааг судлахдаа Электроэнцефалографи (EEG)-ийн бүрэлдэхүүн болох үйл явдалд үзүүлэх тархины хариу үйлдлийн хэмжээс буюу *Event-related potential (ERP)*-ыг түлхүү ашигладаг байна. Хүүхдэд тодорхой нэг мэдрэхүйн өдөөгч (үг, үгийн үе гэх мэт) эсвэл танин мэдэхүйн үйл явцад гарах өгүүлбэр, хэлц, хэллэгийг таних үеийн цахилгаан идэвхжилийн тусгалыг хэмждэг (Kuhl, 2011).

Соронзон резонансын дүрслэл (MRI)-ийг хоёрдогч хэл эзэмших явцыг урьдчилан таамаглахад мөн ашигладаг байна. Бүтцийн MRI -аар нярайд хэмжилт хийснээр тэдний тархины бүтцийг судалж энэ тэдний цаашдын хэл яриа эзэмших явцад холбоо хамааралтай эсэхийг хэмжихэд тус болдог байна (Ortiz-Mantilla, Choe, Flax, Grant & Benasich, 2010). Хэл эзэмших явцын судалгаа нь маш өргөн хүрээний нарийн судалгаа бөгөөд *Language acquisition* буюу хэл эзэмшихүй нь нейро хэл шинжлэлийн судалгааны үндсэн нэр томьёоны нэг болжээ.


Хэлний боловсруулалт (*Language processing*)

Нейро хэл шинжлэлийн тухай ном сурах бичиг, судалгааны ажилд түгээмэл тохиолдох нэр томьёоны нэг нь хэлний боловсруулалт (*Language processing*) юм. Хэлний боловсруулалт нь хамгийн ерөнхий ярианы дуу авиа, авиалбарыг илрүүлэх буюу олж таних үндсэн чадварт суурилсан байдаг (Marvel, 2006). Хэлний боловсруулалт гэсэн нэр томьёо нь шууд утгаараа орсон ба үндсэн утга нь хүн хэрхэн үг хэллэг, өгүүлбэрийг бүтээдэг тухай юм.

Хэлний боловсруулалтад оролцох тархины хамгийн чухал хэсгүүд нь зүүн чихний дээд талын орчимд байрладаг байна. Тархины зүүн тал бөмбөрцөгт байрлах үндсэн дөрвөн хэсэг нь хэлний боловсруулалт болон хэлний ойлгоцод оролцдог аж. Эдгээр нь (1) Брокагийн төв, (2)

Верникегийн төв, (3) Хөдөлгөөний бор гадарга болон (4) Нуман хонгорцог (нуман судал) юм (Awan, 2018).

Зураг 1. Хэлний боловсруулалт болон хэлний ойлгоцод оролцдог тархины дөрвөн үндсэн хэсэг. (Awan, 2018)



Нейро хэл шинжлэлийн судалгааны бүтээлд түгээмэл тохиолдох хэл шинжлэлийн судалгаанд түлхүү хэрэглэгддэг зарим нэр томьёо нь Language acquisition - Хэл эзэмшихүй; Language assessment - Хэлний үнэлгээ; Language comprehension - Хэлний ойлгоц; Language formulation - Хэлний томьёолол; Language function - Хэлний үйл ажиллагаа; Language input - Хэлийг хүлээн авах (хэлийг хүлээн авах чадвар); Language output - Хэлэхүй (хэлээр илэрхийлэх чадвар); Language processing - Хэлний боловсруулалт; Language storage - Хэлний хадгалалт; Lexical decision - Үгийн сангийн шийдвэр гаргалт; Lexical deficit - Үгийн сангийн хомсдол; Linguistic performances - Хэл шинжлэлийн үйл ажиллагаа; Linguistic representation - Хэл шинжлэлийн илэрхийлэл; Speech delay - Ярианы хоцрогдол; Speech perception - Ярианы ойлголт; Speech production - Ярианы боловсруулалт; Speech recognition - Яриаг танихуй; Stammering speech - Түгдрээ яриа зэрэг болно.

Энэхүү судалгаандаа нейро хэл шинжлэлд түгээмэл тохиолдох дараах нэр томьёог орчуулан орууллаа.

1. Abstract attitude - Хийсвэр хандлага
2. Acoustic-mnestic aphasia - Сонсголын доройтол, ой тогтоолттой холбоотой афази (хэл ярианы эмгэг)
3. Acquired language disorders - Хэлний олдмол эмгэгүүд
4. Afferent motor aphasia - Төв рүү тэмүүлэх хөдөлгөөний афази
5. Agnosia - Агнозия (танин мэдэхүйн чадвараа алдах эмгэг)
6. Agrammatism -Хэл зүйн доголдол (хэл зүйн алдаа гаргах эмгэг)
7. Agraphia - Бичих чадваргүйн эмгэг
8. Alexia - Унших чадваргүйн эмгэг
9. Amnestic aphasia - Ой тогтоолтын афази
10. Amphasia - Амфазия (сэтгэл хөдлөлөөс болон хэл ярианы чадвараа алдах)
11. Anarthria - Ойлгомжгүй ярих эмгэг / ойлгомжтой ярих чадвараа алдах
12. Anaudos – Сонсголгүй
13. Anomia - Нэр оноох чадваргүй
14. Aphasia - Афази/ хэлгүйдэл буюу хэл ярианы чадвараа алдах/ хэл ярианы эмгэг
15. Aphasic syndrome - Афазийн хам шинж
16. Aphonos – Дуугүй, авиагүй (хэл ярианы эмгэг)
17. Apraxia – Зогсонгошил (зорилтот үйл хийж чадахгүй байх)
18. Apraxia of Speech - Хэл ярианы ухамсарт хөдөлгөөний алдагдал
Хэл ярианы зогсонгошил
19. Apraxia of Pose- Ухамсарт хөдөлгөөний алдагдал
20. Articulatory dysfluency - Өгүүлэхүйн эрхтний үйл ажиллагааны бэрхшээл
(ээдрэх шинж тэмдэг)
21. Associationism - Ассоцианизм буюу “холбоо хэлхээсийн тухай онол”
22. Asymbolia - Тэмдэг ялгахгүй байх эмгэг
23. Auditory representation - Сонсгол-дууны дүрслэл
24. Auditory verbal agnosia (pure word deafness)- Ярианы ойлголтын доройтол
(Нэг төрлийн үгийн дүлийрэл)

25. Brain function - Тархины үйл ажиллагаа
26. Brain imaging - Тархины зураглал
27. Brain lateralization - Тархины аль нэг талын давамгайлал
28. Broca's aphasia - Брокагийн афази
29. Central dysarthria – Төв мэдрэлийн хэл ээдрэх эмгэг
30. Cognitive deficit - Танин мэдэхүйн хомсдол
31. Concept field - Ойлголтын талбар
32. Conduction aphasia - Дамжуулалтын афази
33. Coprolalia - Зохисгүй үг хэллэгийн эмгэг
34. Developmental language disorders – Хэлний хөгжлийн эмгэгүүд
35. Disconnection syndrome - Холбоо тасалдах хам шинж
36. Dynamic aphasia - Хөдлөнгө афази (динамик афази)
37. Dynamic localization of function - Үйл ажиллагааны идэвхтэй байршлын тухай онол
38. Dysarthria - Хэл ээдрэх эмгэг
39. Dysgraphia - Бичгийн хэлний эмгэг
40. Dyslexia - Унших чадварын эмгэг
41. Dysphasia - Ярианы хэлний эмгэг
42. Dyspraxia - Хөдөлгөөний чадварын эмгэг
43. Echolalia - Давталтын эмгэг
44. Efferent motor aphasia - Төвөөс гарах хөдөлгөөний афази
45. Event-related potential (ERP) - Үйл явдалд үзүүлэх тархины хариу үйлдлийн хэмжээс
46. Evolution-based theory - Хувьсалд тулгуурласан онол
47. Flow of information - Мэдээллийн урсгал
48. Fluent aphasia - Чөлөөтэй ярих афази
49. Global aphasia (Бүрэн афази) - хамгийн хүнд төрлийн афази бөгөөд өвчтөн хэл ярианы ямар ч чадваргүй болдог
50. Holistic theory - Нэгдлийн онол
51. Isolated speech area - Алслагдмал ярианы хэсэг
52. Language acquisition - Хэл эзэмшихүй
53. Language assessment - Хэлний үнэлгээ
54. Language comprehension - Хэлний ойлгоц
55. Language formulation - Хэлний томьёолол
56. Language function - Хэлний үйл ажиллагаа
57. Language input - Хэлийг хүлээн авах (хэлийг хүлээн авах чадвар)
58. Language output - Хэлэхүй (хэлээр илэрхийлэх чадвар)
59. Language processing - Хэлний боловсруулалт
60. Language storage - Хэлний хадгалалт
61. Lexical decision - Үгийн сангийн шийдвэр
62. Lexical deficit - Үгийн сангийн хомсдол
63. Linguistic performances - Хэл шинжлэлийн үйл ажиллагаа
64. Linguistic representation - Хэл шинжлэлийн илэрхийлэл
65. Localization theory - Байршлын тухай онол
66. Mental lexicon - Оюуны үгийн сан
67. Mismatch negativity (MMN) - Сөрөг үл нийцэх байдал
68. Motor representation - Хөдөлгөөний дүрслэл
69. Motor speech disorder - Ярианы хөдөлгөөний эмгэг
70. Naming disorder, anomia aphasia – Нэр оноолтын бэрхшээл, нэр оноох чадваргүйн эмгэг

71. Neural function - Мэдрэлийн үйл ажиллагаа
72. Neuro imaging - Мэдрэлийн зураглал
73. Neurolinguistics - Мэдрэл хэл шинжлэл / Нейро хэл шинжлэл
74. Nominal aphasia - Нэрийн афази
75. Non-fluent aphasia - Чөлөөтэй бус ярих афази
76. Peripheral dysarthria - Захын мэдрэлийн хэл ээдрэх эмгэг
77. Phonological paraphasias - Авиаг буруу дуудах
78. Primary Progressive Aphasia (PPA) - Афазийн голомтын архагшил
79. Priming - Анхдагч боловсруулалтын аргачлал
80. Semantic aphasia - Утга зүйн афази
81. Sensory aphasia (Acoustic-gnostic aphasia) - Мэдрэхүйн афази (Сонсгол, оюун ухааны доройтлын афази)
82. Speech delay - Ярианы хоцрогдол
83. Speech perception - Ярианы ойлголт
84. Speech production - Ярианы боловсруулалт
85. Speech recognition - Яриаг танихуй
86. Stammering speech - Түгдрээ яриа
87. Subcortical motor aphasia- Бор гадаргын доод талын хөдөлгөөний афази
88. Subcortical sensory aphasia- Бор гадаргын доод талын мэдрэхүйн афази
89. Subtraction paradigm - Хасах парадигм (харьцуулалтын загвар)
90. Syntactic aphasia – Өгүүлбэр зүйн афази
91. Syntactic disorder – Өгүүлбэр зүйн эмх замбараагүй байдал
92. Transcortical motor aphasia- Бор гадаргын дагуух хөдөлгөөний афази
93. Transcortical sensory aphasia- Бор гадаргын дагуух мэдрэхүйн афази
94. Traumatic aphasia - Гэмтлийн дараах афази
95. Unitarists - Нэгдлийн онолчид
96. Verbal aphasia - Үйлийн афази (оновчтой үг олох бэрхшээлийн афази)
97. Verbal deafness - Үгийн дүлийрэл (хүний хэлсэн үг яриаг ойлгохгүй; хэл ярианы дүлийрэл)
98. Violation technique- Зөрчлийн аргачлал
99. Voxel-wise modeling - Соронзон резонансын дүрслэлээр бүтээсэн зураглалын ухаалаг загварчлал
100. Wernicke's aphasia - Верникегийн афази

Дүгнэлт

Орчин үед нейро хэл шинжлэл нь дэлхийн эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсан хэл шинжлэлийн салбарын чухал судлагдахууны нэг болоод байна. Хүний уураг тархи хийгээд хэл ярианы хоорондох холбоо хамаарлыг судлах нейро хэл шинжлэлийн талаарх судалгаа шинжилгээг дэлхийн түвшинтэй харьцуулбал манай оронд хараахан гүнзгийрүүлэн судалж эхлээгүй байна. Энэхүү судалгааны ажлаараа нейро хэл шинжлэлийн онолын ойлголт, судалгааны арга зүйд тулгуурлан нэр томьёог нарийвчлан судалж, түгээмэл хэрэглэгддэг нэр томьёо, түүний үндсэн ойлголтыг тайлбарлах, зарим нэр томьёог монгол хэлнээ орчуулан буулгалаа.

Хэл ярианы чадвар аажмаар доройтдог мэдрэлийн хам шинж болох “*Primary Progressive Aphasia Primary*” гэх эмгэгийг шууд үгчлэн орчуулбаас утгаа алдана. *Primary* гэдэг нь анагаах ухаанд нэг талаар анхдагч, нөгөөтээгүүр өвчин илрэх болсон анхны хэсэг буюу ургийн голомт

гэсэн утгатай бол *progressive* гэдэг нь анагаах ухаанд өвчин архагших гэсэн утгатай. Дээрх утгуудыг харгалзан үзэж *Primary Progressive Aphasia* гэсэн нэр томъёог “Афазийн голомтын архагшил” гэж оноон орчуулав.

Нейро хэл шинжлэлийн түүх, онол, судалгааны аргачлалуудад тохиолдох нейро хэл шинжлэлийн дээрх түүвэрлэсэн авсан 100 нэр томъёог орчуулгын арга зарчмыг баримтлан монгол хэлнээ шинээр орчуулахад утгачлан орчуулсан 29, үгчлэн орчуулсан 38, тайлбарлан орчуулсан 6, галиглан буулгасан 4, найруулан орчуулсан 23 нэр томъёо байна.

Нейро хэл шинжлэлийн түүх, онол, судалгааны арга зүйн талаарх ойлголтыг нарийвчлан гаргахын тулд түгээмэл хэрэглэгддэг нэр томъёонуудыг түүвэрлэн тайлбарлаж, зарим нэр томъёоны хувилбар монгол орчуулгыг санал болгон дэвшүүллээ. Нейро хэл шинжлэлийн нэр томъёонуудыг монгол хэлнээ орчуулалгүй, шууд дуудлагаар нь ашиглаж хэвших нь тохиромжтой биш бөгөөд гадаад нэр томъёо хэрэглэхээс зайлсхийх, нэг нэр томъёоны олон өөр орчуулга бий болж төөрөгдөл үүсгэхээс сэргийлэх, тогтсон нэр томъёотой болох зэрэг ач холбогдолтой юм. Нөгөө талаар зөв, оновчтой орчуулан оноож болохгүй тохиолдолд дэлхийн олон хэлэнд хэрэглэгдэж хэвшсэн байдлаар нь эх хэлнээ нутагшуулах нь зүйтэй болов уу.

Ном зүй

Монгол хэлээр:

- Болд, Л. (1986). Орчин цагийн монгол хэлний дагавар, Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г. (2020). Монгол хэлний нэр томъёо бүтэх нийлэг болон задлаг хэв шинж, Улаанбаатар.
- Гэрэлмаа, Г., Шинэбаяр ба бусад (2014). Монгол нэр томъёо судлалын товчоон, Улаанбаатар.
- Нансалмаа, Н., Долгор, С. (2014). *Танихуйн хэл шинжлэл*, Соёмбо принтинг, Улаанбаатар.
- Мөнх- Амгалан, Ю., Кан Шин. (2014). Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал, Улаанбаатар.
- Төмөртоогоо, Д., Энхбат, Д., Бат-Ирээдүй, Ж., (2016) *Хэл шинжлэлийн Монгол-Англи толь бичиг*, МУИС Пресс, Улаанбаатар.
- Цэвэл, Я., (2013). *Монгол хэлний товч тайлбар толь*, Мөнхийн Үсэг ХХК, Улаанбаатар.
- Энхбат, Д., (2003) *Хэл шинжлэлийн Англи-Орос-Монгол толь бичиг*, Ундарга Принт, Улаанбаатар.

Гадаад хэлээр:

- Ahlsén, E., (2006). *Introduction to neurolinguistics*. Philadelphia, PA: John Benjamins.
- Ardila, A., (2015). *A Proposed Neurological Interpretation of Language Evolution*. Behavioural Neurology, 1-16. <https://doi.org/10.1155/2015/872487>
- De Zubicaray, G. and Schiller, N., (2019). *The Oxford handbook of neurolinguistics*, Oxford University Press
- Fiorentino, R., Poeppel, D., (2007). *Processing of compound words: an MEG study*, Brain and Language, (1–2): 8–249, 103 . [doi:10.1016/j.bandl.2007.07.009](https://doi.org/10.1016/j.bandl.2007.07.009).
- Kuhl P. K. (2011). *Early Language Learning and Literacy: Neuroscience Implications for Education*. Mind, brain and education: the official journal of the International Mind, Brain, and Education Society, 5(3), 128–142. <https://doi.org/10.1111/j.1751-228X.2011.01121.x>
- Luria, A. R. (1970). *Traumatic Aphasia: Its Syndromes, Psychology, and Treatment* (D. Bowden, Trans.), Mouton, The Hague, The Netherlands.
- Luck, S.J., Kappenman, E.S., (2012). The Oxford Handbook of Event-Related Potential Components, Newmark, P. (1984) *Approaches to Translation*. Oxford and New York.
- Oxford University Press, 664.
- Nunez, M. D., Nunez, P. L., & Srinivasan, R. (2016). *Electroencephalography (EEG): neurophysics, experimental methods, and signal processing*. In Ombao, H., Linquist, M., Thompson, W. &

- Aston, J. (Eds.) Handbook of Neuroimaging Data Analysis, 175-197, Chapman & Hall/CRC. Advance online publication. doi: 10.13140/rg.2.2.12706.63687
- Ortiz-Mantilla S, Choe MS, Flax J, Grant PE, Benasich AA. (2010). *Association between the size of the amygdala in infancy and language abilities during the preschool years in normally developing children*. NeuroImage. 49:2791–2799.
- Volenec, V., (2015). *Kratka povijest neurolingvistike*, Rasprave: Časopis Instituta za Hrvatski Jezik i Jezikoslovlje 41/2.

Цахим эх сурвалж:

- Awan, H., (2018). Language Processing in Brain, BS (Hons English Literature at University of Education (PK)
- Issa, M.F., Juhasz, Z., Kozmann, G., (2018). *EEG analysis methods in neurolinguistics: a short review*, IME, Research gate article, Retrieved from https://www.researchgate.net/publication/333558840_EEG_analysis_methods_in_neurolinguistics_a_short_review
- Shin, D., *What is fMRI*, Center for functional MRI, Retrieved from: <https://cfmriweb.ucsd.edu/Research/whatisfmri.html>
- <http://merriam-webster.com>
- <http://www.etymonline.com>
- <http://en.wikipedia.org>
- <http://www.aphasia.org>
- <http://www.asha.org>



“ХЯТАД, МОНГОЛ ШИНЭ ҮГСИЙН ТАЙЛБАР ТОЛЬ”-ИЙН ТУХАЙ

Э.Пүрэвжав³

Өвөр монголын ардын хэвлэлийн хорооноос 2020 онд “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн хоёрдугаар хэвлэлийг гаргаж, өргөн олон нийтийн хүртээл болгосон байна. Хөх хотноо хэвлэн гаргасан энэхүү шинэ үгсийн шинэ толь бичиг болбоос 1396 хуудастай том толь бичиг юм. Хэн дуртай хүн хийж чадамгүй энэхүү их гарын “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн голлон найруулагчаар профессор Ц.Сүмбэрбат, Э.Хастуяа, дэд голлон найруулагчаар Г.Гэрэлмаа, М.Насан, Шю Лян, Хасцэцэг нар гар сэтгэл нийлж, хамтран ажиллажээ. Энэхүү толийн тэргүүн бүлэг буюу 1-1106 дугаар талд “Хятад толгой үгийн шинэ үгс”, дэд бүлэг буюу 1109-1152 дугаар талд “Латин галиг эхтэй шинэ үгс”, 1153-1163 дугаар талд “Араб тоо эхтэй шинэ үгс”, 1163-1185 дугаар талд “Байнга хэрэглэгддэг компьютерын үгс”, 1186-1198 дугаар талд “Байнгын хэрэглээний хятад, монгол төрөл хуваасан үгс”-ийг тус тус багтаан оруулсан бол 1199-1380 дугаар талд буй “Хавсралт” хэсэгтээ “он тооллын хүснэгт”, “ром тоо”, “байнга тохиолддог англи, америк овог нэр”, “олон улсын жин хэмжүүр”, “равжунгийн он тоолол”, “баяр дурсгалын өдөр”, “арван хоёр жил”, “төрөл садны хэлхээ”, “зурхай тоо”, “улсуудын туг далбаа”, “элементүүдийн үелэх систем” тэргүүтэн хэн хүнд хэрэг болохуйц 28 зүйлийн ойлголт ухагдахууныг багтааж оруулснаараа уншигчдад хэрэглээний чухал ач холбогдолтой болж чадсан гэж бодож байна. “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн анхны хэвлэлийн хавсралтын тухай алдарт тользүйч, эрдэмтэн Ц.Норжин гуай “Хятад, монгол шинэ үгийн тайлбар толь”-ийн найруулагч 22 төрлийн агуулга бүхий хавсралтыг бүтээлчээр байрлуулсан нь толиныхоо гол агуулгатай тэнцмээр үнэ цэнтэй байр суурьтай болжээ” гэж үнэлж байсныг дурдахад илүүдэх юун.

Орчин үеийн дэлхий дахины толь бичгийн хэвлэлд түгээмэл хэрэглэж байгаа толгой үг, гол тайлбар, үндсэн утга, нэр томъёог өнгө ялгаруулан тэмдэглэх хэвлэлийн шинэлэг арга технологийг боломжийн хэрээр сайтар ашигласан байна. Тухайлбал:

巴士 bāshi. Англи хэлний “bus”-ын авиачилга. Нийтийн үйлчилгээний олон суудал бүхий авто машин: [△ нийтийн машин, автобус](#), [▲ автобус](#).

对讲机 duìjiǎngjī. Биедээ авч явдаг жижиг радио харилцуур: [△ ярилцуур](#), [▲ богино холбоо](#).

二传手 èrchuánshǒu. Уул нь алгадах бөмбөгийн дамжуулагчийг заадаг. Шинэ утга нь: ажил явдал гүйцэтгэхэд зуучилдаг хувь хүн буюу хамтлаг: [△ зуучлагч, дамжуулагч, холбогч](#), [▲ зуучлагч](#).

网站 wǎngzhàn. Адил бус зохион байгуулалт буюу хувь хүний интер сүлжээн дээр зохиомжлон байгуулсан цэг: [△ сүлжээний өртөө](#), [▲ цахим өртөө](#).

Ингэхдээ хятад толгой үгийн ханзны дуудлагыг олон улсын галиг үсгээр хадмаллан өгч, утгын гол тайлбарыг монгол бичгийн хэлээр аль болох дэлгэрэнгүй үйлдэж, Өвөр монголд хэрэглэж буй монгол нэр томъёог монгол бичгийн хэлээр бичиж, Монгол Улсад хэрэглэж буй

³ ШУА, ХЗХ, доктор, профессор

монгол нэр томьёог нь орчин цагийн кирилл үсгээр тэмдэглэсэн нь хэрэглэгч хүмүүст ашиглахад үнэхээрийн хялбар дөхөм болсон нь сайшаалтай хэрэг юм. Энэ толийн хоёрдугаар хэвлэлд орчин цагийн монгол хэлний нэр томьёог кирилл үсгээр тэмдэглэн оруулсан нь хэрэглэгчдийн цар хүрээг нэмэгдүүлсэн шинэлэг зүйл болжээ.

Ийнхүү хэдэн арван мянган толгой үгийг эмхлэн бүрдүүлэхдээ БНХАУ-д хэвлэсэн хятад хэлний нийгмийн хэрэглээний голлох ач холбогдолтой толь бичгүүдийг түшиглэсэн байна. Хэрэглэгч олон түмэнд аль болох ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байх талыг тэргүүн зэрэгт тавьж өгсөнд энэ толь бичгийн гол ач холбогдол оршино. Уул “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн “Хөтөч үг”-ийг уншиж танилцвал, иймэрхүү том хэмжээний “хэлний хэрэглээний гарын авлагын шинжтэй хэрэглэгдэхүүн болсны хувьд шинэчлэлт нь маш удаан, бараг 10-20 жилд нэг удаа явагддаг” (Сүмбэрбат, Хастуяа, 2020:29) гэсэн бичигдээгүй хуулийн дагуу болсон байна. Сайн чамбай ажлыг эрхлэн найруулагч хүний ёсзүйг сайтар баримтлан хийвэл цаг хугацаа их зарцуулах нь дамжиггүй. Цаг хугацаа их зарцуулсан эрдмийн ажил нь чанар чансаатай болдог жам тавилантай билээ.

Голлон найруулагч Ц.Сүмбэрбат “Хөтөч үг”-ийнхээ “Орчуулгын зовлон жаргал” хэмээх толь зохиоход учирсан бэрхшээлтэй зүйлийн талаарх гуравдугаар зүйлдээ “Шинэ үгс нь соёлын үүдэлт бөгөөд шинэчлэлтийн ачаалагч мөн. Тэр нь хүмүүсийн үгийн санг баяжуулж, хэлний хэрэглээг улам амьд дүрслэг болгох төдийгүй, цаг үеийн цог жавхааг ч харуулж чаддаг. Яг ийм байдгаараа манай улсын хятад хэлний шинэ үгс байнгын шинжтэй түгээн дэлгэрдэг бөгөөд хэрэглээний давтамж өндөр байдаг. Тасралтгүй буй болж байгаа хятад хэлний шинэ үгсийг монгол хэлэндээ хэрхэн зөв оновчтой, ялгам шулуун орчуулан хэрэглэх бэ гэдэг нь үнэхээр нэгэн яршиг төвөгтэй ажил байсан боловч тэдгээр шинэ үгсийг заавал монгол хэлэндээ улируулан авчрах нь тулгам асуудал болж байсан тулд туулж гарахаас биш тойрч гарч үл болно. Шалтгаан нь: Нэгд, шинэ үгс нь давтамж ихтэй. Шинэ үгс нь Дундад ард түмний хэл ярианы тогтолцоонд хэрэглээний давтамж ихтэй үгийн сангийн бүрэлдэхүүн хэсэг нь болдог. Жишээлбэл: “сүлжээний өргөн бүс” 宽带, “соронзон карт” 磁卡, “баарт ширгэх” 泡吧, “таксидах” 打的, “илчлэх, илрүүлэх” 曝光 гэх мэт. Эдгээр шинэ үгсийг ард түмний хэлний харилцаанд нэн сайн үйлчлүүлэхийн тулд орчуулагч буюу хэл соёлын ажилтнууд тэдгээрийг заавал орчуулах хэрэгтэй. Хоёрт, шинэ үгс нь ил тод цаг үеийн шинжтэй. Шинэ үгс нь хүмүүсийн одоогийн амьдралын эл хүрээ хэмжээнд холбогддог тул “өнөөдрийн үлгэрийг заавал өнөөдрийн хэл яриагаар ярих” нь зүй биз. Тухайлбал: “эм эмнэлгийн даатгал” 医保, “барааны гүйлгээ” 物流, “гудамжны бүжиг, зээлийн бүжиг” 街舞, “хугацаат зээллэг” 按揭, “нутагшуулах” 本土化 гэх мэт цоо шинэ үгс нь манай монголчуудын амьдралтай ч нягт холбоотой байдаг. Гуравт, шинэ үгс нь амьдлаг шинжтэй. Шинэ үгс нь хүмүүсийн хэлний хэрэглээнд орж чаддагийн учир нь түүнд шинэ соргог, амьд дүрслэг онцлогтой буй. Ялангуяа түүний буй болсон түүхт ахуй байдал, үүслийн нөхцөл шалтгаан зэрэг нь хүмүүсийн үг ярианы сэдэв болж байдаг. Жишээлбэл: “органик идээ” 绿色食品, “оддыг шүтэгчид” 追星族, “элсэн шуурга” 沙尘暴, “гар утсаа шагайгсад” 低头族 гэх мэт (Сүмбэрбат, Хастуяа, 2020:38) өвөрмөц онцлогтойг тодорхойлон гаргасан нь шинэ үгийн судлалд амьдлаг шинжилгээ болсон байна. Шинэ үгийг гярхай түүвэрлэн олж, шинэ утгыг үнэн зөвөөр зүй зохистой тайлбарлах нь хариуцан гүйцэтгэгчээс олон талын өндөр боловсрол, олон хэлний чадвар, шинжлэх ухааны олон салбарын цэгцтэй мэдлэг шаардсан амаргүй ажил гэдгийг заавал онцлон хэлмээр байна.

“Толь бичиг” гэдэг нь үгийн жагсаалт бүхий ном бөгөөд тэгэхдээ зөвхөн жагсааснаар хязгаарлагддаггүй, уг үг ямар зүйл, ямар үйл явдлыг заасан болох, яаж бичдэг, хэрхэн дууддаг, яаж яаж хувирдаг зэргийг тайлбарласан, эс бөгөөс өөр нэг хэлний утга таацах үгтэй дүйлгэсэн байдаг (Шагдарсүрэн, 2009:126) онцлогтой. Аливаа толь бичиг бол шинжлэх ухааны нэгэн

салбарт л зориулагддаг бус, олон шинжлэх ухааны эрдэмтэн судлаачдад өргөн ашиглагддаг учраас хэрэглэгдэх цар хүрээ, тооцогдох ажлын хариуцлага, үнэлэгдэх гол шалгуур үнэлэмжийн хувьд ердийн судалгааны ном бүтээлээс арай өөр гэж бодох нь зүй ёсны хэрэг. Яагаад гэвэл, өргөн олон шинжлэх ухааны салбаруудын элдэв олон төрлийн нэр томьёог нэгэн арга зүйд нэгтгэн оруулж, нэгэн толь бичигт багтаана гэдэг хэлэхэд амархан ч гэсэн хийж бүтээхэд туйлын амаргүй нүсэр ажил юм. Амаргүй ажлын ард амжилттай гарсан уг толийн бүх зохиогч, найруулагч нарт эрдэм судлалын арвин амжилтыг хүсэн ерөөе. Толь бичгийн ажлыг манай ахмад эрдэмтэд маань “зугаагүй бөгөөд чимхлүүр ажил” гэж их оновчтой тодорхойлсон байдаг.

Академич Цэндийн Дамдинсүрэн 1966 онд бичиж нийтлүүлсэн “Перец гэдэг халуун ногоо, толь гэдэг хэцүү ажил” хэмээх өгүүлэлдээ энэхүү толио яаж хийж байгаа тухайгаа орос хэлний “перец, перечень” зэрэг үгийг чухам яаж орчуулсныгаа жишээ болгон тайлбарлахдаа “Би өдөр бүр 50 орчим орос үгийг орчуулан бичиж байна. Гэвч заримдаа хэцүү үг тохиолдоход 50 байтугай 5 үгийг ч орчуулж чадахгүй удаа олон тохиолддог. Заримдаа нэг үгэн дээр хэдэн өдөр суух ч удаа байдаг. Энд би “перец” гэдэг үгийг яаж орчуулснаа тайлбарлаж ярих санаатай байна. Толь бичгүүдийг шүүрдэж байгаад “хар перец”-ийг “поваари”, “улаан перец”-ийг “чинжүү” гэдгийг магадтай мэдсэн боловч “хуажуу” буюу “ерма” нь ямар перец болохыг мэдээгүй байлаа. Улаан үрлэн перецийг “хуажуу”, “ерма” гэж бичье гэж шийдлээ. Олон толь бичгийг шалгаж үзэх дашрамд “налишам шидүү” гэдэг нэг монгол төвөд үгийг олсон бөгөөд энэ бол “цагаан перец” буюу амтлаг перецийн нэр бололтой юм. Тэгээд ганц “перец” гэдэг үгэн дээр гурван өдөр суулаа. “Перец гэдэг халуун ногоо, толь гэдэг хэцүү ажил” гэж шинэ үг зохиож болмоор санагдлаа” (Дамдинсүрэн, 1966) хэмээн “толь бичиг эмхлэн зохиох” гэдэг нь туйлын нарийн чимхлүүр мөртлөө нүсэр бэрх ачаалалтай ажил болох талаар тодорхой өгүүлжээ. Толь бичиг эмхлэн зохиох нүсэр ажлыг “эрдэм шинжилгээний зугаагүй хар ажил” (Лувсандэндэв, 1966) гэж туйлын зөв зүйтэй тодорхойлсон нь буй.

2020 онд хэвлэгдэж гарсан энэхүү “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн зохиох үндсэн аргазүйг анхлан боловсруулж, хийж гүйцэлдүүлэх амаргүй их ажлыг БНХАУ-ын Төвийн үндэстний хэвлэлийн хорооны хянан найруулагч, профессор Ц.Сүмбэрбат хариуцан гүйцэтгэжээ. Тэрбээр хятад, монгол хоёр хэлний толь бичиг эмхлэн зохиох ажлаас эхлүүлээд, толь бичгийн хэвлэлийн шинэ арга хэлбэрийг түгээн дэлгэрүүлэх, толь бичгийг судлан шинжлэх ажилд хоёргүй сэтгэлээр уйгагүй зүтгэж байгаа туршлагатай агаад тулхтай сайн найруулагч гэдэгтэй олон монголч эрдэмтэн санал нийлнэ гэдэгт бүрэн итгэж байна. Ямарваа толь бичиг зохиогч нь яахын аргагүй судлаач хүний л олон жилийн туршид цөхрөлтгүй хийх ажил байдаг болов уу. Тэр тусмаа аливаа хэлний шинэ үгийн толь бичгийг хэн дуртай аавын хүү болгоны гарын үзүүрээр хийх амархан ажил биш шүү гэдгийг зориуд тэмдэглэн хэлмээр байна. Энэхүү шинэ үгийн толь бичгийн хоёр дахь хэвлэлийг үнэндээ хийх ёстой хүн нь л голлон найруулжээ гэхэд уянгын хэтрүүлэл болохгүй буй за.

Монгол Улсын шинэ нэр томьёог нягтлан ажиглавал, “нэр томьёо тогтоохдоо олон улсын нэр томьёо тогтоох зарчмыг баримтлан, нэр томьёо нэг бүрийг эрдэм шинжилгээний үндэслэлтэй боловсруулж, монгол бичиг, ярианы хэлний бүхий л баялгийг өргөн ашиглана гэсэн үндсэн зарчмыг ихээхэн анхаарч, монгол хэлний уламжлалт заншлыг эрхэмлэн хүндэтгэсээр ирсэн” (Сүмбэрбат, 2008:68)-ийг энэхүү тольдоо тусган оруулсан нь нэг ижил нэр томьёо, нэг адил ойлголт гэсэн зарчмыг баримтлахад эрдэм шинжилгээний арга зүйн хувьд гол чиг хандлага болсон бололтой.

Монгол судлаач Ц.Сүмбэрбатын голлон хариуцаж гаргасан энэхүү “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь” нь дорно дахины уламжлалт толь зохиох аргад голлон түшиглэхийн зэрэгцээгээр өрнө зүгийн толь зохиох шинэлэг зарчмыг харгалзан хийснээрээ өвөрмөц онцлогтой сайн толь бичиг болж чаджээ хэмээн дүгнэмээр байна. Мөн “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар

толь”-ийн хоёрдугаар хэвлэл нь анхны хэвлэлээсээ хуудасны тоо, ерөнхий овор хэмжээ, шинэ нэр томъёоны хэрэглээ, агуулга багтаамжийн хувьд бараг л хоёр дахин том болж чадсаныг зориуд хэлье.

“Хятад, монгол шинэ үгийн тайлбар толь” хэмээх суурь судалгааны бүтээлээ анх 2007 онд нийтлүүлж, өргөн олны хүртээл болгосон билээ. Энэхүү том “Тайлбар толь”-ийн анхны хэвлэлийн оновчтой агаад чанар чансаатай болсныг нь “Шинээр хэвлэгдсэн “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь” бол одоо үеийн монгол хэл, соёлын эрт цагийн хөгжилтийн хэрэгцээ шаардлагаар зохиогдсон онол үйлдэгчийн чанар, эрдэм шинжилгээт чанар, хэрэгцээт чанараар чанга мөртөө, энэ талаар урьд өмнө гараагүй хоосныг нөхвөрлөсөн бүтээлч чанартай толь болов” (Бөхжаргал, 2008:33) гэж өндөр үнэлсэн байдаг бөгөөд эл толийн хэрэглээний ач холбогдлыг нь “Толгой үгийн орчуулгад товойм илрэлээ олж, толгой үг нь толь бичгийн хамгийн жижиг элемент, хамгийн үндсэн мэдлэгийн нэгж” (Отгонбаяр, 2008:93) мөн болохыг шинжлэх ухаанчаар тайлж тайлбарласан байдгийг дахин дурдалтай. Ерөөсөө толь бичгийн ажил алдаа гаргах нь амархан ч, амжилт олох нь бэрхтэй учир туйлын хариуцлагатай хүнд ажилд тооцогддог. Эл хүнд ажлыг 13 жил ахин дахин үргэлжлүүлэн тасралтгүй хийж “Хятад, монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн хоёрдугаар хэвлэлийг гаргасан нь юутай сайн хэрэг билээ. Энэ толийн сайн талыг өгүүлэхийн ялдамд нэгэн зүйлийг тэмдэглэн хэлмээр байна. Аливаа хэлний нэг нэр томъёог өөр хэлэнд орчуулж хөрвүүлэхэд нэг бус, нэлээн хэдэн ижил утгатай ойролцоо үгээр зэрэгцүүлэн буулгах нь хэлний хэрэглээний талд сөргөөр нөлөөлж, будилаан гаргаж болзошгүйг хэлэхгүй өнгөрч боломгүй байна. Нэг шинэ нэр томъёог дөрөв таван үгээр монголчлон орчуулжээ. Үүнд:

拔尖人才 bájiānréncái: Δ гоц чадвартан, оройлогч, манлайлагч.

财气 cáiqì: Δ эдийн буян, олзын хийморь, мөнгөний хийморь, ид баян.

瓷男 cínnán: Δ хэврэг эр, тэсвэргүй эр, хүүхэн шиг эр, ичимтгий эр, ширвээлэг эр.

关停并转 guāntíng bìngzhuǎn: Δ хаах, зогсоох, нийлэх, солих.

Толь бичиг бол хийж эмхэтгэхэд цаг их зарцуулдгаас гадна, эцэслэн хэвлэхэд засвар уншилт, нэмэлт засалт ихээхэн шаарддаг тун ч хариуцлагатай бэрх хөдөлмөр байдаг. Академич А.Лувсандэндэв “Хэл мэддэг бүхэн толь хийдэг юм биш, толь хийх техник эзэмшсэн нь хийдэг юм” (Лувсандэндэв, 1966) хэмээн хэлснийг зориуд тэмдэглэе. Анхны хэвлэлийг гаргаснаас хойш 13 жилийн хооронд шинжлэх ухааны олон салбарын нээлт улам гүнзгийрч, улс төр, эдийн засаг, соёлын бүтээн байгуулалт сараас сард хөгжин шинэчлэгдэж байгааг хэлний баримтаар баталгаажуулж, шинэ үгээр оноон нэрлэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Толь бичгийн толгой үгийг хэрхэн сонгох нь тухайн толь бичгийн амин чухал асуудал болдог. Түүхэн тодорхой цаг үе, нийгмийн хөгжлийн үе шатыг дагалдан, хүмүүсийн хэлний бодит амьдрал урьд өмнө байгаагүйгээр өргөжин тэлж, аливаа хэлний үгийн сан, түүний дотор шинэ нэр томъёогоор сэлбэгдэж, тасралтгүй баяжсаар байдаг түүхэн үзэгдэл мөн.

Толь бичиг гэдэг бол олон хүний хөлс хүч, оюун ухааныг цөлбөн шавхсан, олон жилийн нөр их хөдөлмөрийн үр дүн гэдэг нь хэнд ч ойлгомжтой буй за. Эмхэтгэн зохиогч эзнээ элдэвлэн зовоодог ч гэлээ, хэрэглэгч өргөн олон нийтийн цагийг нь арвилан хэмнэсэн, оюуныг нь баяжуулан тэтгэсэн ашдын буянтай бүтээл туурвилын нэг бол толь бичиг (Адъяа, Пүрэвжав, 2021:156) мөн. Аливаа улс орон, үндэстэн угсаатны хэл соёл, үүх түүх, зан заншил, ёс уламжлалаа хадгалан хөгжүүлж, хойч үедээ өвлүүлэн дамжуулах үйл хэрэгт толь бичиг шийдвэрлэх чухал үүрэгтэй байдаг. Юмс үзэгдлийн өөр хоорондын учир холбогдол, тэдгээрийн харилцан хамаарал тэргүүтнийг илтгэн гаргахад хэл ярианы арга хэрэглүүр, хэлний хэм хэмжээг зүй зохистой ухааран ойлгож, зөв чадамгай илэрхийлэхэд нэр томъёоны шинэ үгийн толь бичиг нь түүчээлэн манлайлагч луужин, итгэлтэй дагуулагч хөтөч болдгийг тэмдэглэн хэлмээр байна.

АШИГЛАСАН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

- (Адьяа, Пүрэвжав, 2021) - О.Адьяа, Э.Пүрэвжав. Эх хэлний боловсролд толь бичгийн үүрэг, хэрэглээ. -“О.Адьяа. Монгол нэр томъёо судлал: уламжлал, шинэчлэл”, гутгаар дэвтэр [өгүүлэл, илтгэл, дурсамж, ярилцлага]. Улаанбаатар., 2021. х.155-168
- (Бөхжаргал, 2008) - Бөхжаргал. Шинэ харалт, шинэ сэтгэц, шинэ бүтээл (Сүмбэрбатын эрхлэн найруулсан “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн тухай). -“Монгол хэл бичиг” сэтгүүл, № 4. Хөх хот., 2008. х.32-34
- (Дамдинсүрэн, 1966) - Ц.Дамдинсүрэн. Перец гэдэг халуун ногоо, толь гэдэг хэцүү ажил. -“Утга зохиол, урлаг” сонин, № 2 (471). 1966 оны I сарын 7
- (Лувсандэндэв, 1966) - А.Лувсандэндэв. Перецийн асуудал дуусаагүй байна. -“Утга зохиол, урлаг” сонин, № 6 (475). 1966 оны II сарын 4
- (Отгонбаяр, 2008) - С.Отгонбаяр. “Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь”-ийн найруулан бичсэн онцлог шинж. -“Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”, № 1. Хөх хот., 2008. х.90-95
- (Сүмбэрбат, 2008) - Ц.Сүмбэрбат. Монгол хэлний үгсийн сангийн хөгжлийн асуудалд. Улаанбаатар., 2008. 231 х
- (Сүмбэрбат, Хастуяа, 2020) - Ц.Сүмбэрбат, Э.Хастуяа. Хятад монгол шинэ үгсийн тайлбар толь (хоёрдугаар хэвлэл). Хөх хот., Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2020. 1396 х
- (Шагдарсүрэн, 2009) - Ц.Шагдарсүрэн. Монгол хэлний толь судлал. -“Монгол хэлний үгийн сан судлал”. Улаанбаатар., 2009. х.126-185



ХЯТАД ХЭЛНИЙ ТООЛОХ ҮГ МОНГОЛ ХЭЛНЭЭ ИЛРЭХ НЬ
(уран зохиолын жишээгээр)

Л.Чойжилмаа⁴, Ц.Гүндэгмаа⁵, Б.Сүнжидмаа⁶

Abstract: Language is a facilitator for understanding a nation's culture, traditions, ideological characteristics and mentality. Since 1957, Mongolian National University began to teach Chinese to more than 10 students. Today, my country is very interested in Chinese learning. Next, it is important for us to learn Chinese to compare theoretical issues of language, such as Mongolian-Chinese vocabulary and grammar, and to analyze the norms of translation, editing, and usage. In this study, we compare how Chinese quantifiers are represented in Mongolian using literary examples. Chinese quantifiers are a special phenomenon of a language in the category of Chinese grammar.

Түлхүүр үг: 汉语, 名量词, 动量词, 文学翻译

УДИРТГАЛ

Хэл бол олон зуун жилийн турш тухайн улс үндэстний харилцааны нэн чухал хэрэглүүр болж ирсний хувьд ахуй байдал, нийгэм улс төр, эдийн засаг, оюун санаа, ёс заншил, гоозүй, ёсзүйн тусгал болсон байдаг.

1990-ээд оноос эхлэн манай улс хятад улстай найрсаг харилцаагаа улам идэвхжүүлэх болсноор хятад хэлийг сурах хэрэгцээ, шаардлага нэмэгдсэн билээ.

Хятад хэлэнд тоолох үг нь тусгайлсан үгийн аймаг болдог бол монгол хэлэнд тусгай үгийн аймаг болдоггүй, нэр үгийн аймагт харьяалагддаг үг хятад хэлний тоолох үгтэй дүйцэж байна.

Монгол хэлэнд аливаа зүйлийг тоочин хэлэхдээ ерөнхийлөн авч үздэг бол, хятад хэлэнд тоолох үг нь юмс бүр дээр өөр өөрөөр нарийн заагтай хэрэглэгддэг.

Сэдвийн үндэслэл

Бид судалгааны ажлын хүрээнд орчин цагийн хятад хэлний тоолох үгийн аймгийг сонгон авч монгол хэлнээ хэрхэн илэрч буйг судлахыг зорилоо. Учир нь хятад хэлний тоолох үг нь хэлзүйн нэг онцлог үзэгдэл юм.

Судалгааны ажилдаа Шюй Зөчэний “Бээжин хотоор гүйсэн нь” зохиолын хятад эх болон монгол орчуулгын зохиолыг ашиглалаа. Хятад эхээс тоолох үг орсон жишээ өгүүлбэрийг түүж дүйцэх монгол өгүүлбэрийг орчуулгын зохиолоос түүвэрлэн, монгол хэлнээ хэрхэн илэрч буйг судлав.

Судалгааны арга

Судалгааны ажилдаа түүвэрлэх, тоон болон харьцуулан дүн шинжилгээ хийх, зэрэгцүүлэн судлах зэрэг аргуудыг ашиглалаа.

⁴ Дэд проф., доктор, ШУТИС, ГХС, Ази судлалын салбар

⁵ ШУТИС, ГХС, Ази судлалын салбар

⁶ ШУТИС, ГХС, Ази судлалын салбар

Судалгааны ажлын ач холбогдол

Энэхүү судалгааны ажлыг хийснээр тоолох үгийн хэлзүйн онцлог, түүний монгол хэлэнд хэрхэн илрэх, орчуулгын талаарх зохих мэдлэгийг хятад хэл суралцагч оюутан залуус болон судлаач нарт практик ач холбогдолтой болно.

Судлагдсан байдал

Хятад хэлийг идэвхтэй судалж буй судлаач, суралцагчдын тоо нэмэгдэхийн хэрээр хятад хэлийг харьцуулан судлах эрдэмтэн судлаачид жил бүр ихэссээр байна. Хятад хэлний тоолох үгийн талаар хийсэн эрдэм шинжилгээний бүтээл, илтгэл өгүүлэл, ном сурах бичиг төдийлөн их байхгүй ч Т.Чахар, Л.Соёл нарын хамтын бүтээл “Хятад хэлний тооллого үгийн толь бичиг” (2012), Ц.Базаррагчаа “Хятад хэлний тооллого үг” толь бичиг, Гэрэлмаа “Хятад хэлний нэгж үгийн тухай” зэрэг судалгааны ажил, толь бичиг, мөн хятад хэлний хэлзүйн сурах бичгүүдэд тоолох үгийн тухай дурдсан байна.

1. Монгол хэлний тоо хэмжээ заасан үгийн тухай

Дэлхийн соёлт ард түмнүүдийн нэгэн адил монголчууд өнө эртнээс ахуй амьдрал, шинжлэх ухааны сэтгэлгээнд, ялангуяа одон зурхайн ухаанд олон оронтой тоог нэрлэн хэрэглэж байжээ. Энэ тухай манай улсын түүх, хэл соёл, шинжлэх ухааны эртний дурсгалт бичгүүдэд дурдсан баримт нэлээд бий. Тухайлбал, “Гучин зургаатын тайлбар толь”-д 21 хүртэл оронтой тооны нэр байх ба 21 оронтой тоог “Цаглашгүй” гэсэн монгол нэрээр нэрлэдэг бөгөөд монгол хэл нь тооны нэрээр үлэмж баялаг болохыг харуулж байна. Жишээлбэл, дан (нэгж), арав, зуу, мянга, түм, бум, маш дэлгэмэл (14 оронтой тоо), шалтгааны зүйл (30 оронтой), тэгш (58) оронтой, өгүүлшгүй (63 оронтой тоо), сэтгэшгүй (67 оронтой тоо) гэх мэт.

Монгол хэлний тоо хэмжээ заасан үгийн талаар эрдэмтэд дараах тодорхойлолтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- “.....аливаа юмны олон цөөн зэрэг дугаар мэт бөгөөд, ер тоо лугаа холбогдсон үгсийг нэгтгэн тооны нэр хэмээмүй” (Б.Ишдорж, 1930:41)
- “.....хийсвэр тоо хийгээд аливаа хүн амьтан, юмны олон цөөн, дэс дугаар, бүхэл, бутархай болон үйл явдлын хэдэн удаа болсон зэргийг илэрхийлсэн нэр...” (Э.Вандуй, 1966:118)
- Хүн юмын тоо ширхэг, дэс дараалал, хам, цуг, бүхэл, бутархай болон үйл байдлын хэдэн удаа болохыг заасан нэг, хоёр....тав, хорин гурав, зуун тавин хоёр, хоёул, хоёрдугаар, тавны нэг, арваад, гурван удаа гэх мэт үгсийг тооны нэр гэнэ. (П.Бямбасан, 1975:73)
- Аливаа хүн, юмны олон цөөний тоо хэмжээ, дэс дугаар, үйл явдлын хэдэн удаа болсон зэргийг заасан үгийг тооны нэр гэнэ. (Л.Балдан, 1987:55)
- Бодит ертөнцийн юмс үзэгдлийн тодорхой тоо ширхэг, дэс дугаар, хам цуг, бүхэл бутархайг нэрлэх үгсийг тооны нэр гэнэ. (Ц.Өнөрбаян, 2004:236)

Тооны нэрийн үндсэн шинж

Юмсын тоог хэлэнд ерөнхий, тодорхой хоёр янзаар илрүүлдэг бөгөөд тооны нэр нь тодорхой тоо заана. Тоо бол чанарын нэг адил обьектив зүйл бөгөөд бодит юмстай салшгүй холбоотой учраас юмнаас ангид хийсвэр тоо гэж байхгүй. Тооны нэр нь юмсын тоо ширхэг, үйлийн хэдэн удаа болсныг заасан үүргээрээ жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолддог үл хувилах нэр юм. Харин жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэхээрээ тийн ялгал, хамаатуулахын нөхцөлөөр хувилдаг.

Тооны нэрийн үндсэн шинжийн талаар судалсан эрдэмтдийн судалгаанаас үзвэл:

П.Бямбасан: Тооны нэр нь тэмдэг нэрийн хамтаар үл хувилах нэрийн бичил айг үүсгэн улмаар төгс хувилах жинхэнэ нэр ба дутмаг хувилах орон цагийн нэрийг багтаасан хувилах нэрийн бичил айтай эсрэгцэн нэрийн аймгийн дэд тогтолцоог бүрдүүлдэг байна. Тооны нэр нь тэмдэг нэрийн адил нэрийн ерөнхий аймгийн тийн ялгал, хамаатуулахын нөхцөлөөр хувилахгүй. Энэ бол тооны нэрийг үл хувилах нэрийн бичил тогтолцоонд хамааруулж байгаа гол шалгуур

үндсэн шинж болно. Харин тооны нэрээр тодотгуулж байгаа жинхэнэ нэр нь хураагдаж хэлзүйн гол үүргээ уг тооны нэрд шилжүүлбэл тооны нэр нь тийн ялгал, хамаатуулахын нөхцөлөөр хувилж болно. Жишээ нь:

Айргын тавыг цоллон магтах нь найраг

Азарга арслангийн гуниг дуудах нь найраг гэх мэт.

Тооны харьцааны нэрс нь гарахын тийн ялгалын нөхцөл нэрсийг захирч чаддаггүй. Зөвхөн нэрлэх, харьяалах хааяа үйлдэхийн тийн ялгалын нөхцөлт нэрсийг захирч чадна. Жишээ нь: *Байшинд тав, гэрт гурав бий.*

Ц.Өнөрбаян: Монгол хэлний тооны нэр нь утгазүй, хэлзүйн өвөрмөц онцлогтой бие даасан үгийн аймаг юм. Үүнд:

- Орчин цагийн монгол хэлэнд тооны зохицол байхгүй тул тооны нэрээр тодотгуулж байгаа жинхэнэ нэр нь олон тооны нөхцөлөөр хувилахгүй. Харин эртний монгол хэлэнд тоогоор зохицох ёс байсныг бичгийн дурсгалуудаас мэдэж болно.
- Монгол хэлний тооны нэрийг бүтцээр нь энгийн ба нийлмэл гэж ангилан. Нэг язгуур оролцож бүтсэн тооны нэрийг энгийн, хоёр ба түүнээс дээш энгийн тооны нэр нийлж бүтсэн бол нийлмэл тоо гэдэг.
- Монгол хэлний ихэнх (нэг хоёроос бусад) тооны нэр жинхэнэ нэрийн өмнө тодотгол болж орохдоо үндэс үүсэх “-н” дагавартай тохиолдоно. Жишээ нь: *гурван морь, дөрвөн хүүхэд, хорин хоног, гучин хүн, мянган хонь гэх мэт.*
- Үндсэн тооны нэр нь бусад тооны нэрийг бүтээх үндэс суурь нь болдог. Тухайлбал, үндсэн тооны нэрийн үндсэнд “-дугаар дүгээр, дахь дэх, аад⁴” зэрэг дагавар залгаж, дэс дугаар, тойм барагцаа, хам цугийг заасан тооны нэр бүтээхээс гадна “гурав дөрөв, хоёр хоёр, хоёрны нэг, хоёр удаа, хорь гаруй” гм-ээр үндсэн тооны нэрийг давтах, хорших, хавсрах зэрэг задлаг аргаар тойм, түгээл, дахих, бутархай тоог үүсгэдэг.
- Тооны нэр нь язгуур, үндсийн олон хувилбартай үгс юм. Жишээ нь: гурав гэсэн тооны нэр нь гу-(гуч, гутгаар), гур-(гурав, гурамсан) гэх мэт язгуурын хувилбартай байна.
- Тооны нэрийн үндсэнд “-хан⁴” нөхцөл залгаж тухайн тоог чамласан сэтгэлийн аяс илтгэнэ. Жишээ нь: *Чинийх долоо, минийх зургаахан. Би аравхан морьтой гэм мэт.*
- Тооны нэр нь жинхэнэ нэрийн үүргээрээ байхдаа өмнө үгээ захирах чадвар султай. Харин жинхэнэ нэрийн үүрэг гүйцэтгэх үедээ ихэвчлэн харьяалахын тийн ялгалаар өмнөх үгээ захирна. Жишээ нь: *Тэдний тав нь ирлээ. Дөрвийн нэг нь бүжигчин гэх мэт.*

2. Хятад хэлний тооны нэрийн хэлзүйн онцлог болон өгүүлбэрзүйн үүрэг

- Тооны нэр ихэнхдээ тоолох үгтэй нийлэн холбоо үг болж нэр үгийн утгыг тодотгодог. Жишээ нь:

一辆车 yi liang che- нэг ширхэг машин

Мөн тооны нэрийг ихэвчлэн давтдаггүй. Тооны нэр нь өгүүлэгдэхүүн, тодотгол, тусагдахуун болж болно. Жишээ нь:

二二得四 er er de si- Хоёр хоёр хүртвэр дөрөв

- Бас өгүүлэхүүн гишүүн ч болж болно. Жишээ нь:

今年我二十三, 他二十四。 Jinnian wo er shi san, ta er shi si - Энэ жил би 23, тэр эрэгтэй 24.

- Хятад хэлний тоо нь тоолох үгтэйгээн нийлэн тоо хэмжээ заасан холбоо үгийг үүсгэн өгүүлбэрт тодотгол, нөхвөр болон байц гишүүн болдог. Жишээ нь:

四位先生 si wei xiansheng - Дөрвөн ширхэг ноёнтон

看一篇 kan yi pian- Унших нэг удаа

3. Хятад хэлний тоолох үгийн тухай

Хятад хэлний тоолох үгийг судлаачид дараах байдлаар тодорхойлжээ.

Г.Нямдорж: Орчин цагийн хятад хэлний нэр үгийг тооны нэртэй шууд холбон хэрэглэж болдоггүй. Нэр үгийг тооны нэртэй холбоход зайлшгүй нэгж үг авах хэрэгтэй. Үүнийг нэрийн нэгж үг гэнэ. Үйл хөдлөлийн хэдэн удаа болсныг заасан нэгж үгийг үйлийн нэгж үг гэнэ. (2004:33)

Л.Чойжилмаа: Хүн болон юмс хийгээд үйл хөдлөлийн тоо ширхгийг заадаг үгсийг тоолох үг гэнэ. (2014:56)

Г.Элдэв-Очир: Хятад хэлний тоолох үгийг “нэрийн тоолох үг” болон “үйлийн тоолох үг” гэж хоёр ангилдаг. Нэрийн тоолох үг нь харьцангуй олон бөгөөд өгүүлбэрт нэр үгийн өмнө орж тодотгол гишүүн болдог. Харин үйлийн тоолох үг нь үргэлж үйл үгийн нөхвөрлөхүүн гишүүн болно гэжээ. (2010:13)

Хятад хэлний тоолох үгийг **нэрийн тоолох үг** болон **үйлийн тоолох үг** гэж 2 ангилдаг.

1. Нэрийн тоолох үг

Хятад хэлний тооны нэр ихэвчлэн нэр үгтэйгээн шууд залгагдахгүй хооронд нь заавал тоолох үг нэмдэг. Жишээ нь: “一桌子”yì zhuōzi “нэг ширээ” хэмээн шууд залгаж болохгүй бөгөөд “一张桌子”yì zhāng zhuōzi “нэг ширхэг ширээ” гэж хавтгай биетийн тоолох үг болох “张 zhang”-г нэмнэ.

Нэрийн тоолох үгийг дотор нь:

Ширхэглэх зүйлийн тоолох үг:

把 ba-иш бариултай болон гараар атгаж авч болох нарийн урт зүйлийг тоолно.

本 ben-ном дэвтрийг болон кино жүжгийг ангиар нь тоолно.

滴 dī-шингэн зүйлийн дуслах хэмжээг хэмжинэ.

个 gè-хүн буюу юм болон тусгай тоолох үг авдаггүй бодит нэрсийн өмнө хэрэглэнэ.

根 gē-үндэстэй ургамлын зүйл болон нарийн урт хэлбэртэй зүйлсийг тоолно.

颗 kē-мөхлөг хэлбэртэй зүйл болон бууны сум, хадаас зэргийг тоолно.

粒 lì-мөхлөг хэлбэртэй зүйлийг тоолно.

条 tiáo-урт нарийн зүйл болон гуу жалга хавцал зэргийг тоолно.

张 zhāng-хавтгай биет болон хүн амьтны нүүр зэргийг тоолно.

支 zhī-гонзгой хэлбэртэй урт зүйл болон дуу хөгжмийг тоолно.

座 zuò-уул арал болон барилга байгууламжийг тоолно.

Нийлц зүйлийн тоолох үг:

对 duì-эсрэг хүйсийн хос хүн болон хос эд эрхтнийг тоолно.

副 fù-салгаж нийлүүлж болох зүйлийг тоолно.

伙 huǒ-бүлэг хүмүүсийг тоолно.

批 pī-бөөн бараа болон нэгэн зэрэг хөдөлсөн хүмүүсийг тоолно.

群 qún-адуу малыг сүргээр нь болон уул нуруу зэргийг тоолно.

双 shuāng-хос юмс болох эрхтэн, хувцас өмсгөл, савс зэргийг тоолно.

套 tāo-иж бүрдэл юмсыг тоолно.

Хэмжүүр заасан тоолох үг:

尺 chǐ-уртын хэмжээг хэмжих нэгж-тохой

寸 cùn-уртын хэмжих нэгж-ямх

吨 dūn-хүндийг хэмжих нэгж-тонн

分 fēn-мөнгөний хэмжүүр

分米 fēnmǐ-уртын хэмжүүр-дециметр

公斤 gongjin-хүндийг хэмжих нэгж-килограмм
 公里 gongli-уртыг хэмжих нэгж-километр
 公顷 gongqing-талбайг хэмжих нэгж-гектар
 公升 gongsheng-эзлэхүүнийг хэмжих нэгж-литр
 毫克 haoke-ОУ-ын хүндийг хэмжих нэгж-миллиграмм
 毫升 haosheng- ОУ-ын эзлэхүүнийг хэмжих нэгж-миллитр
 斤 jin-жингийн ерөнхий нэр. Ойролцоогоор 500 гр.

Тодорхойгүй тоолох үг:

一些 yixie-нэр үгийн өмнө хэрэглэж тодорхойгүй тоолох үгийг илэрхийлнэ.
 一点 yidian-нэр үгийн өмнө орж эд зүйлийн “тоо хэмжээ бага” гэсэн утга илтгэнэ.
 有点 youdian-дайвар үг, өгүүлбэрт тэмдэг нэр болон шинж байдал заасан үйл үгийн өмнө орно.

Тогтсон тоолох үг:

分钟 fenzhong-цаг хугацааг хэмжих нэгж-минут
 国 guo-улс орныг тоолно.
 秒 miao-цаг хугацааг хэмжих нэгж-секунд
 年 nian-жилийг тоолно.
 省 sheng-мужийг тоолно.
 天 tian-нэг хоног болон тэнгэртэй холбоотой зүйлийг тоолно.
 星期 xingqi-долоо хоногийн хугацааг хэмжинэ.
 月 yue-сарыг тоолно.

Нийлмэл тоолох үг:

架次 jia ci-онгоцны нислэг, хөдөлгөөн болон зарим дараалсан тооны нийлбэрийг илэрхийлдэг.
 秒立方米 miao li fang mi-гол, урсгал усны секундэд урсах усны хэмжээг хэмжих нэгж-куб.метр/секунд
 人次 ren ci-ямар нэг үйл ажиллагааг үзсэн хүний тоо, удааг нэгтгэж тоолно.

Нэрийн зээлдмэл тоолох үг:

鼻子 bizi-хамартай холбоотой юмсыг заана.
 车 che-ямар нэг унаа, тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн ачаа бараа, хүн зорчигчдыг тоолно.
 床 chuang-орны хөгжил гудас, даавуу болон бусад орны хэрэглэлийг тоолоход хэрэглэнэ.
 壶 hu-шингэн бодисын хэмжээг данх, гүцээр хэмжиж тоолно.
 盆 pen-саванд хийж болохуйц зүйлсийг тоолно.
 瓶 ping-лонх гэсэн утга.
 身 shen-тухайн хүний бүрэн хувцасласан байдлыг тоолно.
 腿 tui-хөл дээр ямар нэг зүйл асгарсан, наалдсан зэргийг илэрхийлнэ.
 碗 wan-идээ ундааны зүйлийг аягаар хэмжиж тоолно.
 屋子 wuzi-хүн болон байр байшинтай холбоотой юмсыг тоолно.

2. Үйлийн тоолох үг

Үйл хөдлөл болон өөрчлөлт давтамж заасан хэмжих нэгжийн тоолох үгийг үйлийн тоолох үг гэнэ. Үйл хөдлөлийн тоо хэмжээг зааж өгүүлбэрт нөхвөрлөхүүн болдог. Үйлийн тоолох үгийг дотор нь:

Тусгайлан хэрэглэх үйлийн тоолох үг :

遍 bian-үйл эхлээд дуусах хүртэлх бүх явцыг тоолно.
 场 chang-урлаг уран сайхан, биеийн тамир спортын үйл ажиллагааг тоолно.

次 ci-дахин давтагдаж болохуйц үйл хөдлөлийн болсон, эсвэл, болох давтамжийг тоолно.
顿 dun-хүний өдөрт идэх, хоолны удаа дарааг илэрхийлнэ. Мөн зодох, загнах үйлийн болсон удааг заана.

番 fan-аливаа үйл хөдлөлийн давтамжийг тоолно.

回 hui-үйлийн болсон тоог заана. Мөн ном болон өгүүллэгийн нэг хэсгийг тоолно.

趟 tang-үйлийн болсон удааг тоолно. Нэг газраас нөгөө газар луу очоод буцаж ирсэн гэсэн утгыг заана.

下 xia-үйл маш богино хугацаанд хурдан болж өнгөрөхийг заана.

阵 zhen-хэсэг хугацаанд үргэлжилсэн үйлийг тоолно.

Үйлийн зээлдмэл тоолох үг:

刀 dao-хутгаар хэрчсэн, зүссэн, хальсалсан үйлдлийг тоолно.

斧子 fu zi-сүхээр цавчих үйлийг тоолно.

脚 jiao-хөлөөрөө өшиглөх, гишгэх тоо хэмжээг тоолдог.

口 kou-идэх, уух, хазах, зажлах гэх мэт амны хөдөлгөөнийг тоолно.

枪 qiang-буу мэтийн галт зэвсгийн буудсан тоог тоолно.

眼 yan-аливаа зүйлийн үзсэн харсныг тоолно.

针 zhen-оёх үйлийн тоог болон тариа хийх удааг тоолно.

4. Судалгааны ажил

Бид судалгааны ажилдаа Шюй Зөчэний “Бээжин хотоор гүйсэн нь” зохиолын хятад эх болон философич С.Молор-Эрдэнийн багийн орчуулсан бүтээлийг гол хэрэглэгдэхүүнээ болгосон.

Судалгааны ажлын хүрээнд нийт 1530 жишээ түүсэн. Үүнээс нэрийн тоолох үг орсон жишээ 1486, үйлийн тоолох үг орсон жишээ 44 илэрлээ.

Нэрийн тоолох үг орсон жишээ

Хүснэгт 1

№	Тоол ох үг	Хятад жишээ	Илэрс эн тоо	Монгол орчуулга
1	个	三 个月了, 妈妈的, 一根青草也长不出来。	455	Бүтэн гурван сар өнгөрчөөд байхад ганц ч новшийн өвс алга.
2	点	阳光一点都不刺眼, 敦煌还是流了泪, 怎么说也是阳光。	187	Хэдийгээр нарны гэрэл хурц биш байсан ч нар л хойно нүд гялбуулж нүднээс нулимс гарав.
3	把	他把嘴里的沙土吐出来, 旋风已经跑远了。	168	Тэр аманнаасаа элсээ нулимахад хар салхи зугтсан байв.
4	片	眼前是一大片野地, 几棵树上露出新芽, 地上的青草还看不见。	103	Түүний өмнө уудам газар нутаг үргэлжлэв. Ганц хоёр модны нахиа ургаж эхэлжээ.
5	声	我出来啦。敦煌张开嘴想大喊一声, 一个旋风在他面前升起来, 细密的沙尘冲进他的鼻子、眼睛和嘴, 只好先打喷嚏。然后揉眼睛。	91	Би гарчихлаа. Дунхуанг хоолойгоо шахан чанга хашгирах гэсэн боловч агаарт дэгдсэн элсний ширхгүүд түүний хамар нүд ам руу хийсэн ирж наалдав. Тэр хэсэг зуур ханиаж бас нүдээ нухлав.
6	包	我钱包没了!手机也没了!	88	Миний түрүүвч, миний утас алга болчихлоо.
7	张	便宜了, 六块钱一张卖给你。	87	Хямдхан, би чамд зургаан доллароор л заръя.

8	间	他背着包先去了西苑，三个月 前他和保定住在这儿的 两间 民房里。	72	Тэр цүнхээ түрүүлж Шиюань руу зөөж, гурван сарын өмнө Баодингтай хувийн байшинд амьдарч байв.
9	本	他 基本 上等于文盲。	36	Тэр үндсэндээ бичиг үсэггүй.
10	转	敦煌稍稍安了一点心，他一直担心 一转身 北京就 变 了。	35	Яагаад гэвэл тэр Бээжин хотыг буцаад танихгүй байх гэж эморч байсан.
11	根	都被土埋上了，敦煌想，用脚踢一下 门旁的枯草，伸着头着，还是一 根 青草也找不到。	31	Бүгдийг нь булсан гэж Дунхуан бодов, хаалганы хажууд байх үхсэн өвсийг хөлөөрөө өшиглөж, хараад нэг ч ногоон өвс олдсонгүй.
12	种	敦煌估计，这 种 事可能一点乐趣也不会有。	31	Дунхуан ийм зүйл огт хөгжилтэй биш байх гэж тооцоолжээ.
13	辆	他骑着 辆 破自行车一路狂奔，经过一 处朦胧闪亮的大门，好像还看见了几个当兵的站在 那里，没当回事。	28	Тэр замдаа эвдэрсэн унадаг дугуйгаар явж, бүдэгхэн гялалзсан хаалгыг өнгөрч, хэдэн цагдаа зогсож байхыг харсан бололтой.
14	处	他骑着辆破自行车一路狂奔，经过 一 处 朦胧闪亮的大门，好像还看见了几个当兵的站在 那里，没当回事。	26	Тэр бүүдгэр гэрэлд туссан хаалганы хажуугаар дугуйныхаа дөрөөг хүчлэн жийж өнгөрөх бүрдээ цэргүүд рүү харан нэг ч болов өөр лүү нь анхаарч харахгүй болов уу гэж горьддог байв.
15	帮	他真想回去对那 一群老菜 帮 子说，要知道什么是沙尘暴，那还得到广阔的天地里来。	19	Тэр үнэхээр буцаж очоод дээрэмчдэд элсэн шуурга гэж юу болохыг мэдэхийг хүсвэл энэ нь өргөн уудам ертөнцийг хар гэж хэлэхийг хүснэ.
17	句	出门的时候，他听见女孩吐完瓜子壳后嘀咕了 一句 ：神经病！	16	Дунхуанг дэлгүүрээс гарах үед эмэгтэй амнаасаа шийгуаны үр гарган нулимж ингэж хэлэв “Мэдрэл муут”
18	班	小服务员果然怕了，赶快去找领 班 。	12	Бяцхан зөөгч үнэхээр айсан тул ахлагчаа хурдхан л олохыг хүснэ.
19	群	他真想回去对那 一群 老菜帮子说，要知道什么是沙尘暴，那还得到广阔的天地里来。	7	Тэр буцаад шорон луу орж гиюүрэн суух хоригдлуудад ингэж хэлмээр санагдав “Элсэн шуурга ямар байдгийг үзэх гэвэл эндээс гарч ертөнцтэй танилц” гэж хэлмээр санагдав.
20	副	夏小容开门时 一副 日常表情，接着就去厨房下面 条，区别在于昨晚一个荷包蛋，今晚两个。	5	Шиаорун энгийн царай гарган хаалгаа онгойлгоод гал тогооны өрөө рүү оров. Ялгаа нь гэвэл өнгөрсөн шөнө нэг чанасан өндөг харин өнөө шөнө хоёр өндөг.

Үйлийн тоолох үг орсон жишээ

Хүснэгт 2

№	Тоолох үг	Хятад жишээ	Илэрсэн тоо	Монгол орчуулга
1	次	第一次 他把两条中南海带回家，他爸高兴坏了，一来客人就散，庄严地介绍，中南海，国家领导人待的地方，他们都抽这个。	41	Анх хоёр Жүннанхайг гэртээ авчрахад аав нь ихэд баярлаж, зочид ирэнгүүт гарч очин, төрийн удирдагчдын буудалласан Жүннанхайд бүгд энийг татдаг хэмээн ёслол төгөлдөр танилцуулав.
2	遍	他在电话里一遍遍重复，知人知面不知心。	3	Нүүр царайг нь мэддэг ч сэтгэлийг нь мэдэхгүй утсаар байн байн ярьсаар байв.

Дүгнэлт

1. Монгол, хятад хэл хоёулаа тооны нэрийн аймагтай. Монгол хэлний үндсэн тоо нь хятад хэлний бүхэл тоотой дүйж байна.
2. Нэрийн тоолох үг нь үйлийн тоолох үгнээс илүү давамгайлсан байдаг болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна.
3. Нэрийн тоолох үг монгол хэлэнд орчуулагдахдаа ихэвчлэн илрэхгүй, тухайн өгүүлбэрийн утгандаа далдаар илэрч байсан.
4. Үйлийн тоолох үг монгол хэлнээ ихэвчлэн орчуулагдахгүй хам сэдвийн утгаар илэрч байна.

Ном зүй

1. Ишдорж Б. (1930), Монгол хэлний дүрэм, УБ.
2. Вандуй Э. (1966), Эрдэм шинжилгээний өгүүллүүд, УБ.
3. Бямбасан П. (1975), Монгол хэлний тооны айн тогтолцооны тухай, УБ.
4. Балдан Л. (1987), Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал, УБ.
5. Өнөрбаян Ц. (2004), Орчин цагийн монгол хэлний үг зүй, УБ.
6. Нямдорж Г. (2004), Орчин цагийн хятад хэлний хэл зүй, УБ.
7. Чойжилмаа Л. (2014), Хятад хэлний хэрэглээний хэлзүй, УБ.
8. Элдэв-Очир Г. (2010), Хэрэглээний хятад хэл зүй, УБ.
9. Чахар Т., Соёл Л. (2012), Хятад хэлний тооллого үгийн толь бичиг, УБ.
10. 黄伯荣. (1992), 现代汉语, 北京市出版社.
11. 徐则臣. (2012), 跑步穿过中关村, 北京市出版社.
12. Молор-Эрдэнэ С. орчуулгын баг. (2018), Бээжин хотоор гүйсэн нь, УБ, Монсудар.



ДАРЬГАНГА АЯЛГУУНЫ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ

Л.Одонтуяа⁷
М.Баасанжав⁸

***Аннотация:** Дialectы - это такие нелитературные варианты языка, которые употребляются людьми на определенных территориях в сельской местности. Дialect может отличаться от литературного языка и своими словами, и элементами грамматики, и особенностями произношения. Дialectы могут быть непонятным, если они используются в литературном языке, так как они связаны с историей языка этноса или этнического меньшинства. Классификация современных монгольских dialectов и говоров делится на три категории: dialectные, устные dialectы и отраслевые dialectы, исходя из языковых особенностей. В данной статье рассматривается происхождение и развитие дариганского dialectа, одного из монгольских dialectов, в историческом плане, а также рассматриваются специфические черты некоторых дариганских dialectов, например, фонологически отличные слова от халхского dialectа, и проводится сравнение двух словарей дариганского dialectа.*

Түлхүүр үг: утга зохиолын хэл, нутгийн аялгуу, аман аялгуу, халх аялгуу, дарьгангын салбар аман аялгуу, үгийн сан, толь бичиг

УДИРТГАЛ

Хэл бол хүн төрөлхтний харилцааны хэрэглүүр бөгөөд үндэстэн, ястнууд өөрийн гэсэн хэлтэй ч тэдний үг аялгуу, дуудлага харилцан адилгүй байдаг билээ. Аливаа хэл бол тухайн үндэстний соёл, уламжлалын онцгой нэгэн элемент юм. Дарьгангачуудын өвөрмөц үг хэллэг, аялга нь Монгол Улсын түүх, соёлын бүрэлдэхүүний нэгэн хэсэг тул түүнийг гүнзгийрүүлэн судлах нь монгол судлалд зайлшгүй тулгамдсан сэдвийн нэг мөн хэмээн үзэж байна.

Тухайн ард түмний улс төр, соёл, шинжлэх ухааны бүх салбарт хэм тэгш үйлчилж байгаа, харьцангуй боловсорч, тогтворжсон зөв бичих, дуудах, найруулгазүй, үгийн сангийн хэм хэмжээ бүхий үндэстний хэлийг утга зохиолын хэл гэдэг бөгөөд тэр нь аман ба бичгийн хэлтэй байдаг ажээ. Утга зохиолын хэл нь, хэлнийхээ ерөнхий шинж, зүй тогтлыг хадгалсан боловч өөр хоорондоо өвөрмөц ялгаа бүхий нутгийн аялгуудад хуваагдах бөгөөд тэдгээр нутгийн аялгуудын дотроос тодорхой үзүүлэлтүүдээрээ ялгаран товойсон, утга зохиолын хэл тогтворжин хөгжих шимт хөрс болсон тэр аялгууг утга зохиолын хэлний суурь аялгуу хэмээн нэрлэдэг байна. Нутгийн аялгуун доторх, газар нутаг болон аялгууны шинжээрээ ялгавар бүхий хэсэг бүлэг аялгуудыг аман аялгуу, аман аялгуун доторх, өөр хоорондоо ихэвчлэн угсаа гарвалын хувьд ялгавар бүхий, мөн аялгууны шинжээрээ багахан ялгаатай бэсрэг аялгуудыг салбар аман аялгуу гэнэ. Өөрөөр хэлбэл, утга зохиолын хэл нь нутгийн аялгуудад, нутгийн аялгуу нь аман аялгуудад,

⁷Доктор, МУИС, ШУС, ГХТӨв

⁸Багш, МУИС, ШУС, ГХТӨв

аман аялгуу нь салбар аман аялгуудад хуваагддаг хэмээх нэгдсэн ойлголтыг чухалчлан авч болох юм. (Ш.Лувсанвандан, 1959:26)

Монгол хэлний нутгийн аялгуудын талаар судалгааны бүтээл арвин байдаг, тухайлбал, Г.И.Рамстедт, Сравнительная фонетка монгольского письменного языка и халхаско-ургинского говора, СПб, 1908, 65 с, Б.Я.Владимирцов, Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия, Л, 1929, 437 с, Г.Д.Санжеев, Сравнительная грамматика монгольских языков, М, 1953, 240 с, Н.Н.Поппе, Строй халха-монгольского языка, Л, 1936, 23 с, Ш.Лувсанвандан, Монгол хэл аялгууны учир, УБ, 1959, Д.Төмөртоогоо, Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ, 1992, 219 тал гэх мэт холбогдох бүтээлүүдийг дурдаж болно.

Өнөөгийн монгол хэл аялгуутанг ангилан хуваах талаар эрдэмтдийн дотор үндсэн хоёр санал байдгийн нэг нь монгол хэлтэн хэмээх нэгэн нэрийн доор багтах олон нутгийн аялгуунууд байна гэх, нөгөө нь тус тусдаа биеэ даасан хэд хэдэн монгол хэлнүүд байгаа бөгөөд эдгээр нь дотроо олон, цөөн нутгийн аялгуудтай юм хэмээх санал юм. Монгол хэл нь халх, ойрд, буриад, өвөрлөгч нутгийн аялгуудаас бүрджээ. Халх аялгуу нь дотроо төв халх, дорнод халх, өрнөд халх хэмээн салбар аман аялгуудад хуваагджээ. (Ж.Санжаа, Г.Батзаяа, 2005) Дорнод халх аялгуунд дарьганга аялгуу багтана. Дарьгангачууд түүхэн хөгжлийн ээдрээтэй замыг туулахдаа хэл аялгууны ялгаа бүхий эдийн ба оюуны соёлын өвөрмөц онцлогтой угсаатан болон бүрэлдэн тогтжээ. Дашрамд өгүүлэхэд Монгол Улс олон мянган жилийн тэртээгээс олон үндэстэн, ястны өлгийн нутаг байсаар ирсэн. Эдүгээ Монгол улсад хориод ястан оршин суудаг.

Дарьгангачуудын хэл, аялгууны онцлог нь тэдний угсаа гарвалтай хүйн холбоотой. Бидний сонордуулж байгаа дарьганга аялгууны онцлогийг тодруулах асуудалд угсаатны зүй төдийгүй түүх, эдийн болон оюуны соёлын талаар холбож үзэх зүйл олон байна. Түүхчдийн судалгаанаас үзвэл XVII зууны сүүлчээр Манж гүрний Энх-Амгалан хаан эдүгээгийн Улаанбаатар хотын ойролцоох “Зуун мод” хэмээх газар Ойрадын Галданбошигтыг цохисны дараа үлэмж мал, цэрэг иргэдийг олзолж, Баруун Монгол гаралтай засаг ноён Цэрэнжавыг харьяат албатууд болон олзныхны хамт Дарьгангад шилжүүлэн суулгажээ. “Монголын түүх” бүтээлд тэмдэглэснийг үзвэл “... Манж нар зүүн гар хаант улсыг байлдах үед олзлогдсон өөлд, дөрвөд зэрэг ойрдуудыг Дарьгангад аваачин үржил сүргийг маллуулжээ. Чингэж Дарьгангачууд буй болжээ.” (Монгол улсын түүх. Дөтгөөр боть, 2003:168) гэсэн байдаг. Энэ зэрэгцээ Манжийн хаан Дарьгангад хонь сүрэг бий болгож, түүнийг маллах маллагчдыг Цахраас гаргасан удаатай. Эрдэмтэн, судлаач Жамсрангийн Урангуа Дарьгангын сүрэгчид газар зүйн байршлын хувьд Халхын Сэцэн хан, Түшээт хан аймгийн нутаг дэвсгэрт хамааралтай хэмээн түүхчид бичдэг боловч уугуул оршин суугчдын зэрэгцээ олзлогдож, нүүдэллэж ирсэн хүмүүс зонхилж байснаас сүрэгчин иргэдийг дан халх хэлтэн гэж тодорхойлох боломжгүй юм хэмээн “Түүх судлалын жимээр” (Ж.Урангоо, 2014:155) тэмдэглэжээ. Дарьгангад Халх, Цахар, Ойрад угсааны бүлэг жачин, порни, хар үхэрт, амбагайт, хөхий, марлан, адаа зэрэг овог (аймаг) байсны дотор хотгойд, хэрээд, зээрдүүд, шарнууд гэх зэрэг баруун Монголд олонтой байдаг овгууд одоо ч байгаагаар нотлогдож байна” хэмээн эрдэмтэн Л.Жамсран бичсэн бөгөөд энэ талаар Э.Лувсанбалдан “Дарьгангын түүх” (Э.Лувсанбалдан, 2013:69), Онгон сумын нэвтэрхий толь (Э.Лувсанбалдан, 2015:106), Я.Жигмидцэрэн “Чахарын түүх шинэчлэл” (Я.Жигмидцэрэн, 2008:135-139) зэрэг бүтээлүүдэд мөн адил дурджээ. (Л.Жамсран, 1994:8) Үүнээс үзвэл Дарьгангад Манжийн эзэн хааны сүргийг адгуулан хариулах алба үүргийг Ар, Өвөр Монголын зааг нутагт гүйцэтгэж байсан иргэд нь монгол туургатны олон хошуу нутгаас дайчлагдан ирсэн халх, цахар, ойрад гэсэн олон угсаатны бүлгийн хүмүүс байв. Дарьгангын сүрэгчид нь тусгай заагдсан засаг захиргаа, тодорхой эзэмшил нутагт он удаан жил нутаглан сууснаар бусад угсаатны бүлэгтэй ижилсэх, хэл аялгуу, зан заншил, соёлын нөлөөг шингээсний хувьд өөрийн гэсэн онцлог бүхий угсаатны бүлгийг бүрдүүлсэн байна. Дарьгангачууд аж ахуй, соёл, зан заншил, хэл аялгууны хувьд халх аялгуутай

нийтлэг төстэй боловч, угсаатны бүлгийн өвөрмөц хэл яриа, аялгын хүрээнд зарим ялгаа бий. Жишээ нь: Бэр гуйх зан үйлийн тухайд халхчууд ам турших, буриадууд бэри эрихэ, захчинд хэл хүргэх, баядад ам хадаг тавих, мянгадад ам хэлэх, цахарт ам дурсах хадаг, ордост бага алчуур тавих, алашаад зөв батлах, дөрвөдөд ам алдуулах, даригангад хадаг тавих, хотонгууд морь туших гэх мэтээр нэрлэнэ. Ийнхүү дарьгангачуудын болон угсаатны олон бүлгийн зан үйлтэй холбоотой хэл ярианы агуулга нь өөр хоорондоо ялгаатай юм.

Чингэхдээ Дарьгангачууд, Халхчуудын хоорондын харилцаанд хэл хэзээ ч саад тотгор болж байгаагүй гэж үзэж болно. Хэдий тийм боловч Дарьгангачуудын нутгийн аялгуу бол монголчуудын аман өвийн биет бус бүтээл мөн тул түүнийг хойч үедээ өвлүүлэх үйлст манай эрдэмтэд анхаарч байсныг үгүйсгэх аргагүй. Дарьгангын уугуул эрдэмтэн А.Лувсандэндэв 1955 онд Сүхбаатар, Дорнод аймагт нутгийн аялгуу, ардын аман зохиол судлах шинжилгээний ангийг удирдан ажиллахдаа Дарьгангыг хамруулжээ. Түүхийн шинжлэх ухааны доктор Л.Жамсран “Дарьгангын сүрэг хошуу” (УБ, 1994) “Дарьганга” (УБ, 2000), Ж.Урангоо “Түүх судлалын жимээр” Т.Билэгсайхан “Дарьгангын түүхийн тойм, XVIII зууны сүүлчээс XX зууны эхэн” (УБ, 2015) бүтээлүүдэд угсаатан, хэлний зүйн асуудлыг буурь суурьтай хөндсөн байдаг.

Хэл шинжлэлийн судлаачид монгол хэлний холбогдолтой суурь бүтээлүүд туурвиж байгаа ч дарьганга аялгууны онцлогийг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлсон нь хомс юм.

Бид энэхүү өгүүлэлдээ зарим бүтээлүүд тухайлбал, Г.Далантай “Дарьганга өвөрмөц сонин содон үг хэллэг” товч тайлбар толь (УБ, 2012), Ш.Чимэдцэе “Дарьганга хэл аялгууны мянгатын толь бичиг”, (УБ, 2015), Ш.Чимид-цэе “Жаахан шарга” дууны түүврийн (УБ, 2012) нэр томъёонуудад ажиглалт хийж дарьганга аялгууны зарим онцлогийг тайлбарлахаар зорилоо.

Дарьгангачуудын хэл аялгуу халх аялгуунаас нэлээд зөрүүтэй боловч он жилийн саалтад халх аялгуутай адил төстэй болжээ. Дарьганга хэлний өвөрмөц онцлог, хөгжлийн үе шатыг авч үзвэл:

нэгдүгээр үе - XVII зууны сүүлчээс XX зууны дунд хүртэл,

хоёрдугаар үе - XX зууны дундаас эдүгээг хүртэл хэмээн ангилж болох юм.

Тухайлбал:

Нэгдүгээр үе:

- Дарьгангын суугуул оршин суугчид болон манж хааны сүрэг буй болсонтой холбоотой Ар, Өвөр Монголоос энэ нутагт хуран цугларсан хүмүүсийн өвөрмөц хэл яриа, соёлын шинэ нийтлэг бүрэлдэн, бүтэн, хагас зуун жил үргэлжилсэн.

- 1940-өөд оноос дарьгангачууд Монгол Улсын засаг захиргааны нийтлэг зохион байгуулалтад шилжин орсноор халхчуудтай айлссан бэлчээр, усны нөхцөлөөс шалтгаалан хамтран аж төрөх болсон.

Хоёрдугаар үе:

- 1945 оноос Монгол Улс кирилл үсэгт шилжиж, хуучин монгол бичгээс эрс ялгаатай буюу дуудсанаараа бичдэг болсон. Үүнтэй уялдан бүх албан хэрэг, сургалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл төв халх аялгуугаар явагдах болсон нь дарьганга аялгууны өвөрмөц онцлог аажмаар өөрчлөгдөхөд хүргэжээ.

Дарьгангачуудын хэлийг авиа зүйн үүднээс шинжихэд зарим авианы дуудлага нь халх аялгуунаас ялгаатай сонсогддог. Монгол даяар мэддэг ч ганц хоёр авианы зөрүүтэй үгийг энд дурдаж болно. Тухайлбал: зарим үгийн эхэнд орсон “э” эгшгийг “а”-аар сэлгэж (ээрүү-ааруу) дуудна. Зарим үгийн эхний “т”-г “д”-ээр тус тус сэлгэдэг. Жишээ нь: тарчиг-дарчиг, тасархай-дасархай, төвчигнөх-дөвчигнөх гэх мэт. Зарим үгийн эхний “ц” авиаг “з”-ээр дуудна. Цас-зас, цочих-зочих, зарим үгийн дунд орсон “д”-г “с”-ээр дуудна. Өвдөх-өвсөх, хавдах-хавсах гэх мэт. Зарим үгийн эхний “ц” авиаг “ч”-ээр: цавчих-чавчих, цагдаа-чагдаа, зарим үгийн эхний “ш”-ийг “ч”-ээр: шатар-чатар, шалчигнах-чалчигнах, зарим үгийн “х”-г “г”-ээр (хашигирах-гашигирах,

хасах-гасах, хас-гас, харцага-гарцага, хучих-гучих, хөтлөх-гөтлөх) гэх мэтээр дууддаг. Мөн үгийн үеийн “о”, “я” эгшгийг “у”-аар (болжмор-булжмар, бяслаг-бушлаг) гэж дуудах нь бий. Зарим үгийн нэг, хоёрдугаар үеийн “б”-г тонгоруулж: элбэг-эвлэг, олбог-олвог, халбага-хавлага гэх мэт хэлдэг онцлогтой. Дарьганга хэлний эдгээр аялгуу нь авиа зүйн тогтолцоо, хэл зүйн хэлбэр, үгсийн сангийн хүрээнд халх, өвөрлөгчдийн хэлтэй харьцангуй холбоотой хөгжсөн шинжээ хадгалсаар ирсний гэрч юм.

Хуучирсан, утга агуулга нь баларсан нэр томъёог сэргээж нэхэн тайлах нь дарьганга үгсийн санг судлахад чухал юм. Тухайлбал, халх аялгуунд байдаггүй үгийг дарьгангачууд хэрхэн авиалдгийг кирилл үсгийн цагаан толгойн дарааллаар доорх жишээнүүдээс мэдэж болно. Үүнд:

А

А ч үгүй* - Огтхон ч мэдэхгүй, өгүүлэн буй сэдвийн тухайд ямар ч төсөөлөлгүй
Аагаа багтаах* - дэмий, зүгээр суух. Ажил өрнөж байхад аагаа багтааж (зүгээр) суух юм.
Авзантай* – зориут, нүдгүй шуурганаар хорьсоор байхад авзантай (зориут) яваад хохирсон.

Аазгай* – зэвүүцэм, хүний үгэнд ордоггүй аазгайтай (зэвүүцмээр) хүн.

Аазай – гэргий

Агтлах* – 1. Хаалгыг гар, хөлөөр чагтлах

2. мал хөнгөлөх

Альзуур* – аль хэдийнээ

Амнаас унам* - амт муутай хүнс

Арандаггүй* - жудаггүй

Ахарчлах* - цухалдах, бухимдах, уцаарлах. Ажил ундрахад ахарчлаад яах вэ.

Адцага* - адсага, турж үхсэн малын арьс. Зан авирын тухайд; адсага шиг ааштай гэх мэт

Аягилах* - аашилж загнах

Б

Бажгадах* - сандрах

Багвар* - тагтай модон таваг

Балгардах* – тулгамдах, мунхрах, толгой эргэх

Балтгар* - намхан

Борлуун* – хойрго, өр төлбөрт хойрго

Бутан* - архи, шар тос хадгалдаг ваар, сав

Г

Гавсай* – хайрсан боов

Гавчаар* – эхнэр хүний толгойн чимэг

Гажууд* - зөрүүд

Голцуу* – зонхи, олонх

Гоочлох* - өдөх, хэрүүл өдөх

Гуйрамч* гуйлгачин, гуйлгаар амьдрагч

Д

Да* - албан тушаалтан, сүрэгчний хамгийн бага тушаалтан, хоньчны гарын да (дарга)

Даажигнах* - тохуурхах

Даамай* - гүнзгий

Дилбаганах* – дальбалзах

Далиу* – сөөлжүү

Дараасан* - дарамт

Дахлай* – эрт гарсан хурга

Дургаах* – дуурайх

Е, Ё

Егөөдөх* – ёжлох

Енхөр* – том толгойт

Ёнхор* – гэзэг уртасгасан мяндсан сүлжмэл

Ж

Жаал* – эрэгтэй хүүхэд

Жалавч* – тогоо нэрэхэд бүрхээрийн дээр тавьдаг жижиг тогоо

Жацуу* – нас тэнцүү

Жийг – гичий

З

Зухуур* – цухуйх, цухуур (цухай) ч үгүй

Зөөн* – адууны мах

Зум* – хонины зумалсан бүтэн мах

Зүггүй* – дэггүй гэх мэт

Чингэхдээ дарьганга аялгууны онцлог эдүгээ бүрэн арилсан гэж үзвэл бас үгүй. Зарим шүлэг, дууны үгэнд дарьганга үг хадгалагдсаар ирснийг эш татъя.

Уужных нь хажлага угалзтайяа хө

Унжлага бэл сүйхтэй яа

Зурмал луучин гуталтай яа хө

Зургийн хуар шиг өөшгөө юу да хө

Дүнчүүр холдоо бэр болжээ хө

Тунхуу бариа цэмцгэр байна хө

Айл гэрийн голомтыг асаасан

Агдан болсон аазай юу да хө хэмээн Ш.Чимид-цэеэгийн “Жаахан шарга” дууны түүвэрт (Ш.Чимид-цэеэ, 2012:105) орсон энэ дууг сонссон Дарьганга бусчууд ойлгоход бэрх. Гэтэл үүнийг халх аялгуунд хөрвүүлбэл: “бэл” хэт хутга, гоёлын зүйлийн оосрын чимэг, “сүйх” – эмэгтэйн чихний угалзтай ээмэг, “өөшгөө” –үс тэнгийн найз, “тунхуу” том данх, “агдан” –том, “аазай” – гэргий гэсэн утгатай.

Г.Далантайн зохиосон “Дарьганга өвөрмөц сонин содон үг, хэллэг” тайлбар толь 800 гаруй үг багтааснаас 430 нь зөвхөн дарьганга аялгууны үг, 255 нь монголчуудын нийтээр мэддэг боловч ганц хоёр авианы зөрүүтэй, 130 нь хоёрдмол утгаар хэрэглэдэг үгийг түүж цугларуулан эмхэтгэжээ. Г.Далантай “Дарьганга өвөрмөц сонин содон үг хэллэг” товч тайлбар толь: *амьсах*, *ажаа*, *арви* – (өсөх, элбэгших, харимтлахын нөөц), *арч* – (арчлах), *арсалдах* – (сав л хийвэл мэтгэлцэх), *боргио* – (шингэний ёроолын тунадас), *бөлөгвөр* – (амт шимтгүй), *бяцхан* – (жижиг юм), *давтир* – (нямба, буурь суурь, тэвчээр), *жавх* – (чулуу харвах хэрэгсэл), *займчуулах* – (бултаж зайлсхийх), *мэгиших*, *мэлмэрэх* – (мэлмэрүүлэн уйлах), *өвгөрөх* – (өвгөн болох шинж бүрдэх), *сэрүүдэх* – (илчлэг бус хоол идэлгүй удсанаас хүний бие хямрах), *сэхээрэх*, *тавиухан* – (жижгээс арай илүү хэмжээ тавих), *тээрх*, *угах* – (хөл муутай хүн суугаагаар юмруу дөхөх), *уриалгахан* – (хүнтэй нийлэмжтэй ялдам шинж төрх), *үүд* – (хаалга, гарц, орц), *хаамааз* – (буруугаа өмөөрч бусдад ёс бус шаардлага тулгаж өөрийгөө өмөөрүүлэх гэсэн ичгүүртэй улайм цайм зоргоороо аашлах зан араншин), *хар* – (сэжиг, сэрэмж), *хигээс* – (тэрэгний), *хямгадах* – (тордох зан чанар), *хөөргөн* – (хөөрөх), *цомцог* – (адууны цомцог), *эрдэх* – (бяр чадлаар бардагнах) зэрэг дарьганга аялгууны бус 59 үг оржээ. Түүнчлэн гадаад үгийг ч дарьганга аялгууны үгийн тоонд багтаасан нь гайхаш төрүүлж байна. Тухайлбал: Төвөдийн *нүүнээ сахих* – (шашны зан үйл, бясалгал), *хүдэг* – (уур хилэн), мөн хараалын *барам*, *дүд*, *золиг*, *хижиг* зэрэг 6 үг, орос хэлний сигнал гэдгийг дарьгангачууд *чагнаал*, *спасибо* – *пашилаа*, *сэнжэй* аягыг *шаасага* гэж бичжээ. Түүнчлэн дарьганга аялгуунд огт хэрэглэдэггүй үгсийг нэмсэн байх ажээ.

Тухайлбал: *аглагдах* – (гадуурхах), *гаанс* – (ганс), *ганга* – (гоёл чимэглэл), *гижнээн* – (хичнээн), *зэм* – (хэрэгцээ хангахгүй машин техникийг голж муучилсан нэр) гэж тайлбарласан нь ташаарал болов уу. Зохиогч толиндоо орчин үеийн этгээд үгийг ч оруулсан байна. Жишээлбэл: *баавардах* – үүнийгээ омгорхох, бүхнийг мэдэгч, чадагч болох хэмээн тайлбарласан байна. Энэ мэтчилэн дарьганга аялгууны үг хэллэгийг халх аялгуутай хутгавал тэдний үгийн санг хэдэн мянгаар тооцоход хүрнэ. Энэ нь дарьганга аялгууны онцлогт зайлшгүй холбогдоно. Мөн Г.Далантай “*чадуу*” хэмээх дарьганга аялгууны үгийн тайлбарыг “ядуу биш, чадал чадвар тэгш, нэлээд тов хийсэн хүний дүр” гэжээ. Гэтэл “чадуу” гэдэг үгийг “чинээлэг” гэж оноосон бол нуршихгүй оновчтой тайлбар байж болмоор байна. “*Улаймишгтай*” гэсэн дарьганга аялгууны үгийг “нэгэнт эхэлсэн ажил үйлсээ хоёрдмол санаагүйгээр тууштай үргэлжлүүлэн эцсийн үр дүнг заавал үздэг мэриймтгий хөдөлмөрч чанар” гэжээ.

Дарьганга ардын дууны бүтээлээр эрдмийн зэрэг хамгаалсан Ш.Чимэдцээс дарьгангачуудын дунд түгээмэл хэрэглэгддэг үг хэллэг, нутгийн аялгууны толь бүтээж олны хүртээл болгосон нь хэл шинжлэл, дарьганга судлалд ач холбогдолтойг дурьдах нь зүйтэй. Гэвч Ш.Чимэдцээсгийн “Дарьганга хэл аялгууны мянгатын толь бичиг” – т нэр томьёонууд кирилл үсгийн цагаан толгойн дарааллаар бус буюу ашиглахад төвөгтэй болсны сацуу зарим үгийг 2-4 удаа давтжээ. Тухайлбал: №426 дээр *дологгүй*, №427 *дологтой* гэж нөхцөл залгасан төдийгөөр давтсан бол “*гасаад*” – “хатгаад” гэдгийг 3 удаа, “*гүч*” – “гүчтэй хүн” гэдгийг 4 удаа давтжээ. Түүнчлэн дарьганга аялгуунд огт байдаггүй “*гуадай*” – долгинох, “*наасхав*” – наадахав, “*дөндийлгөх*” – өрхөө дөндийлгөх зэрэг арваад үг оруулсан нь ажиглагдлаа.

Дарьганга аялгууны энэхүү бүтээлүүд нь өнөөдрийн байдлаар дуусгавар болохгүй цаашид дарьганга аялгуу судлалын эрдэм шинжилгээ, практикийн ач холбогдол нь улам өсөх нь дамжиггүй.

Дүгнэлт

Нутгийн аялгуу нь тухайн үндэстэн, угсаатны ертөнцийг үзэх үзэл, танин мэдэхүй, түүх соёл, зан үйл, сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илэрхийлдэг билээ. Эдүгээ манай гариг дээр нийгмийн бүх салбарт даяаршил эрчимжихийн сацуу түүний нэг сөрөг тал болох аливаа үндэстэн, ястан, угсаатны хэл аялгуу зугуухан устан үгүй болж байгаа үед бид амьдарч байна.

Дарьганга нутгийн аялгууны үг хэллэг нь эгшиг авиа хувьсах, гийгүүлэгч авиа хувьсах тухайлбал, ижилсэх, төсөөрөх, ба ондооших, тонгорох, сэлгэх гэх мэт авиазүйн хувьслаар хувирч өөрийн гэсэн онцлог шинжтэй болжээ. Дээр дурдсан жишээнүүдээс харахад халх аялгуунаас ялгаатай утгатай олон дарьганга аялгууны үг хэллэг байгааг цаашид судлан, нутгийн аялгууны чанартай толь бичиг гаргах шаардлагатай байна

Нэгэнт үүссэн монгол хэлний олон нутгийн аялгууд бичгийн хэл хийгээд түүний суурь болсон аман аялгуунд уусах явц одоо хүртэл үргэлжилсээр байгаа боловч дарьганга салбар аман аялгууны өвөрмөц ялгаа өнгө одоо ч байсаар байна.

Ном зүй

Жамсран Л. (1994), Дарьгангын сүрэг хошуу, УБ.

Жигмидцэрэн Я. (2008), Чахарын түүх шинэчлэл, ӨМ-ын Ардын хэвлэлийн хороо.

Лувсанбалдан Э. (2013), Дарьгангын түүх, УБ.

Лувсанбалдан Э. (2015), Онгон сумын нэвтэрхий толь, УБ.



Лувсанвандан Ш. (1959), Монгол хэл аялгууны учир, УБ.

Монгол улсын түүх. (2003), Дөтгөөр боть. УБ.



Санжаа Ж, Батзаяа Г, (2005), Монгол хэл аялгууны тойм зураг, УБ.

Төмөртоогоо Д. (1992), Монгол хэлний түүхэн хэлзүй, УБ.

Урангоо Ж. (2014), Түүх судлалын жимээр



ОРЧУУЛГАЗҮЙ





БУДДЫН ШАШИН СОЁЛЫН ХОЛБООТОЙ ҮГ ХЭЛЛЭГ, НЭР ТОМЬЁОГ ОРЧУУЛАХ АСУУДАЛД

Д.Бүрнээ⁹

Abstract: Many words and terms of Buddhism have entered the vocabulary of Mongolian literature and enriched the Mongolian language. They are inseparable from the culture of the Mongolian people. This paper analyzes some examples of Mongolian words and terms borrowed from Sanskrit and Tibetan and their English translation in the “Sutra of the Wise and the Foolish,” “Tears of a Venerable Lama,” and “Tales of an Old Lama”. It also compares the translation experience of S.Frey, De.Natsagdorj, and Ch. Bawden. This paper concludes that along with linguistic competence, the knowledge of culture is vital regarding the translation of words and terms of Buddhism.

Түлхүүр үг: буддын шашин соёл, уран зохиол дахь шашны үг хэллэг, зээлдсэн үг, санскрит гаралтай үгийн орчуулга, төвөд гаралтай үгийн орчуулга

Бурхан Буддагийн онол сургаал нь хүнийг хөгжүүлж, ухааныг тэлж, сэтгэлийг ариусгах тухай соёл мэдлэгийн арвин бөгөөд гүнзгий сан хөмрөг юм. (Лувсанцэрэн, 2019: 41). Буддын шашин манай эриний VI-V зуунд Энэтхэг оронд үүссэн бөгөөд улмаар Энэтхэгээс халин гарч, Дундад, Төв, Зүүн хойт Азийн улс орнуудад түгэн дэлгэрсэн түүхтэй. Буддын шашин гэдэг ойлголтод дан ганц шашин гэдэг ухагдахуунаас гадна Энэтхэг болон Азийн янз бүрийн улс орны соёл, мэдлэг ухааны их өв санг хамарсан өргөн ойлголт багтдаг. Буддын шашин Монгол орноо гурван удаа дэлгэрсэн бөгөөд нийт хоёр мянга гаруй жилийн түүхтэй гэж үздэг. XVI зууны үеэс дэлгэрсэн гурав дахь буюу төвөдийн шарын шашны дэлгэрлийн үед буддын шашин манай ард түмний аж амьдрал, ахуй соёлд өргөн далайцтай нэвтэрч, бүх нийтийг хамарсан шүтлэг болж, хэл соёл, зан заншил, сэтгэлгээнд нэвт шингэж, гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн билээ. Түүний нэг илрэл бол орчин үеийн манай зохиолч, яруу найрагчид ард түмнийхээ үүх түүх, ахуй ёс, аж байдлыг зохиол бүтээлдээ дүрслэн харуулахдаа буддын шашин соёлын холбоотой үг хэллэг, нэр томьёог өргөн хэрэглэж байгаа явдал юм. Монгол хэлний үгийн санг баяжуулж ирсэн буддын шашны эдгээр үг хэллэгийн гарал үүслийг авч үзвэл санскрит, уйгар, төвөд хэлнээс гаралтай нь дийлэнх хувийг эзэлнэ. XIII-XIV зууны үед монголчууд төвөд ном судар дахь шашны холбоотой үг хэллэгийг орчуулахдаа монголчлолгүй согд, уйгаруудын хэлэнд нэгэнт орсон байсан санскрит гаралтай үг хэллэгийг зээлж авч хэрэглэж иржээ (Рерих, 1975:237). Харин шашны гутгаар дэлгэрэл буюу XVI дугаар зуун болж ирэхэд төвөд хэлнээс орчуулах арга туршлага хуримтлагдаж ирэхийн хамт, нөгөөтээгүүр санскрит гаралтай үг хэллэгийг монголчилдог төвөд арга тодорхой хэмжээгээр нөлөөлсний улмаас шашны үг хэллэг нэр томьёог зээлэх бус орчуулах хандлага бий болжээ.

Монголчууд Ганжуур, Данжуур тэргүүтэй буддын шашин, эрдэм ухааны хэдэн зуун судар шастирыг эх хэлнээ хөрвүүлэх явцад орчуулгын арга туршлага хуримтлуулж, түүнийгээ

⁹ Доктор, МУИС, ШУС, МХХШТэнхим

үндэс суурь болгож, “Мэргэд гарахын орон” (1742) хэмээх төвөд- монгол нэр томьёоны толь бичиг зохиож, төвөд хэлнээс монгол хэлнээ орчуулах арга зарчмыг нэгтгэн дүгнэж, толь бичигтээ тэмдэглэн бичсэн нь үе үеийн орчуулагчдад онол, практикийн их удирдамж болж байсан, байсаар байгаа билээ. “Мэргэд гарахын орон” толь бичгээр уламжилж ирсэн уйгар, санскрит гаралтай олон нэр томьёо манай орчуулгын үгийн санг баяжуулжээ.

Энэхүү өгүүлэлдээ манай зарим уран зохиолын дотор тааралдах монголын шашин соёлын холбоотой үг, нэр томьёог англи хэлнээ орчуулсан байдлыг ажиглав. Эхний зохиол бол “Үлгэрийн далай” хэмээх монгол Ганжуурын 90 дүгээр ботид байдаг дурсгал бөгөөд Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын дээж бичиг зуун билиг”-тээ тус зохиолоос нэг бүлгийг, Д.Бүрнээ, Д.Энхтөр нар бүрэн эхээр нь хэвлүүлжээ. (Дамдинсүрэн, 1959, Үлгэрийн далай, 2020). Энэхүү зохиолыг англи хэлнээ монгол судлаач эрдэмтэн С.Фрай орчуулж, олон орны уншигчдын хүртээл болгосон (Sutra of the Wise and the Foolish, 1981) бөгөөд уг зохиолын дотор гарч буй буддын шашны холбоотой үг хэллэг, нэр томьёог орчуулахдаа тэр бээр монголчуудын уламжлалт орчуулгын арга туршлагыг хэрэглэсэн болохыг ажиглаж болох байна. Буддын шашин Монгол оронд XIII-XIV зууны үед төвөдөөр дамжин дэлгэрэхээс өмнө согд-уйгараар дамжин дэлгэрснийг манай хэлэнд нэвтэрсэн санскрит үгс илтгэн харуулдаг (Сүхбаатар, 2014:24). Эдгээр үгсийн бүрэлдэхүүнийг авч үзвэл буддын шашин, гүн ухааны нэр томьёоны зүйл байхаас гадна шашнаар дамжин дэлгэрсэн цаг тоолол, од гарагийн зүйл, эмнэлэг-ботаникийн нэр томьёо, газар усны нэр, монгол хүний санскрит нэрийн зүйл гээд олон хүрээ хамарчээ (Сүхбаатар, 2014:3-4). Уйгарууд бурханы шашны нэр томьёог ингэж санскритаар зээлж авдаг байсан уламжлалыг монгол орчуулагчид төвөд судрыг орчуулахдаа даган баримталж байв. Өөрөөр хэлбэл, буддын шашны нэр томьёог монголчлохгүй, санскрит нэр томьёог уйгар хэлнээс зээлж хэрэглэж байжээ. Үүнийг дараах оноосон нэрийн жишээн дээр харж болно.

Төвөд хэлээр	Монгол хэлээр	Санскрит хэлээр
Жамба	Майдар	Maitreya
Жалчэн	Махранз	Mahārāja
Гомбо	Махгал	Mahākāla
Долма	Дара	Tara
Янжинлхам	Сарасвати	Sarasvati

Энэ нь XIII-XIV зууны үед төвөд хэлнээс буддын шашны нэр томьёог орчуулахад монгол хэлнээ бэлэн дүйх үг хэллэг хараахан байгаагүй буюу орчуулах туршлага бага байсантай холбоотой. Тиймээс буддын шашны санскрит гаралтай нэр томьёог уйгар хэлнээс шууд зээлж авч байжээ. Энэ уламжлалыг өнөө цагийн гадаад, дотоодын орчуулагчид ямар нэгэн хэмжээгээр бас даган мөрдсөн байна. Тухайлбал, бурхан, тэнгэр болон хүний нэр, газар орны нэрийн орчуулгыг С.Фрай хэрхэн орчуулсныг авч үзье.

Монгол хэлээр	Санскрит хэлээр	Англи хэлээр
Түүнчлэн ажирсан	Tathāgata	Tathāgata
Ариун идээт	Śuddhodhana	Śuddhodhana
Ананд	Ānanda	Ānanda
Шаарийбуу	Śāriputra	Śāriputra
Хүрдэн орчуулагч	Cakravartin	Cakravartin
Эсэр тэнгэр	Brahma	Brahma
Хурмаст	Indra	Indra
Замбуутив	Jambudvīpa	Jambudvīpa
Варанис	Benares	Benares
Ширавасун	Śrāvastī	Śrāvastī

Дээрх хүснэгтээс харвал С.Фрай “Түүнчлэн ажирсан” хэмээх бурханы алдар болон бурхан Буддагийн эцгийн “Ариун идээт” хэмээх алдарыг англи хэлнээ орчуулсангүй, харин санскрит нэрээр нь сэргээн буулгажээ. Бурханы шавь Анандын нэрийг төвөд хэлээр “Гунгабо” (тө. kun dga’ po, мо. хотол баясгалан) гэнэ. Бурхан Буддагийн өөр нэг шавь болох “Шаарийбуу”-гийн нэрийг монголчууд санскритаас төвөд рүү буулгасан хөрвүүлгийг хуулбарлан авчээ. “Шаарийбуу” гэсэн нэрийн “буу” (тө.bu)-г санскритаар “путра” гэх тул С.Фрай мөн санскрит бичлэгийг сэргээн буулгажээ. Эсэр (тө. tshangs pa, мо. ариун) болон Хурмаст (тө. brgya byin, мо. зуун өглөгт) тэнгэрийн нэрийг монголчууд уйгар орчуулгын уламжлалыг дагаж уйгараар нэрлэж заншсан бөгөөд эдгээр нэрийг С.Фрай мөн л санскрит нэрээр нь сэргээн “Брахма”, “Индра” гэж авчээ. Газар орны оноосон нэрийн тухайд ч тэр бээр санскрит бичлэгийг сонгосон нь тухайн үгийн гарал үүслийг тусгаж буй эх бичвэрийн зөв шийдэл болно.

Бидний ажигласан дараагийн зохиол болох Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” өгүүллэгийг хөрвүүлэхдээ Д.Нацагдорж санскрит гаралтай буддын шашны нэр томьёо, оноосон нэрийг мөн монгол орчуулгын уламжлалаар санскритаар нь сэргээн буулгасныг дараах хүснэгтээс харж болно (Natsagdorj, 2003).

Монгол хэлээр	Санскрит хэлээр	Англи хэлээр
Винай (тө. ‘dul pa)	Vinaya	Vinaya
Дар эх (тө. sgrol ma)	Tara	White ¹⁰ Tara
Бурхан (тө. sangs rgyas)	Buddha	Buddha

С.Фрай “бурхан” хэмээх үгийг зарим газар “Lord” гэж орчуулжээ. “Англи- Монгол толь”-д (2006) “Lord”-ыг “Ертөнцийн эзэн”, харин “Buddha”-г “бурхан” гэж орчуулсныг анхаарч үзвэл эл үгийг “Buddha” гэж хөрвүүлэх нь зөв юм. Түүнээс гадна “Монгол- Англи толь”-д “бурхан”-ыг “Buddha” гэж буулгасан нь оноосон гэж бодож байна (Bawden, 1997). Загалмайтны шашны “Ертөнцийн эзэн”, Буддын шашны Будда хоёрыг хольж хутгасан мэт өнгөндөө харагдавч, нарийндаа бол уншигчийг төөрөлдүүлж буй хэрэг юм. Энэ ташрамд хэлэхэд Библийн 2013 оны монгол орчуулга дотор “Lord”-ыг “Эзэн” гэж орчуулахын сацуу, “Lord God” гэснийг “эзэн бурхан” гэж орчуулсан тааралдана. Зүй нь “эзэн тэнгэр” гэж орчуулмаар санагдана.

Гурав дахь зохиол бол Ц.Дамдинсүрэнгийн “Өвгөн Жамбалын яриа” юм. Энэ зохиолд XIX дүгээр зууны сүүл, XX дугаар зууны эхэн үеийн Монголын нийгэм, шашин соёлын түүхийг өвгөн Жамбалын ярьснаар Ц.Дамдинсүрэн тэмдэглэн авч, 1959 онд хэвлүүлжээ. Тус өгүүллэг 35 хэсгээс бүрдэх бөгөөд тэр цагийн хүрээ хийдийн бүтэц, тахил шүтээн, лам нарын боловсрол, аж байдал, шашны зан үйл гээд буддын шашны холбоотой сонирхолтой олон зүйлийг өгүүлжээ. Тус зохиол дахь манай хэлнээ нэгэнт хэвшин хэрэглэгдэж буй төвөд гаралтай үг хэллэг, нэр томьёог Ч.Бауден орчуулахдаа ихэвчлэн монгол бичлэгийг нь хуулбарлан буулгажээ. Тухайлбал:

Монгол хэлээр	Англи хэлээр	Төвөд хэлээр
лам	lama	лама (тө. bla ma)
ханчин	khanchin	ханчэн (тө. mkhan chen)
цорж	tsorj	чойжэ (тө. chos rje)
гэвш	gevsh	гэшэй (тө. dge bshes)

¹⁰ Дара эхийг санскритаар Tara гэх тул энд “white” буюу “цагаан” гэсэн тодотгол илүү болжээ.

Дээрх жишээнээс харвал “лам”-аас бусад нэр томьёог англи хэлээр буулгахдаа кирилл бичлэгийг мөрдсөн нь харагдана. “Лам”-ын тухайд төвөд дуудлагаар нь англи хэлнээ “lama” гэж тэмдэглэдгийг анхаарсан бололтой.

Санскрит гаралтай үгсийг англи хэлнээ хөрвүүлэхдээ С.Фрай санскрит бичлэгийг гол болгож, Ч.Бауден төвөд гаралтай үгсийн төвөд бус харин монгол бичлэгийг буулгахыг зорьжээ. Шашны зан үйлийн холбоотой зарим нэр томьёог Ч.Бауден төвөд эх бичвэрийг баримталж, төвөд хэлнээс үгчлэн орчуулжээ. Тухайлбал, жинсрэг (тө. sbyin sreg) гэсэн шашны зан үйлийн нэрийг үгчилж буулгавал “өглөгийг шатаах”, “өгснийг шатаах” гэж буй (Damdinsüren, 1997:63). Энэ хэллэгийг Ч.Бауден “the burnt offering” гэж төвдөөс нь үгчлэн буулгасан байна. Харин “лүйжин” (тө. lus sbyin) гэсэн шашны зан үйлийн нэрийг ингэж төвөд хэлнээс орчуулалгүй, монгол дуудлагыг дагаж “lūjin” гэж буулгажээ (Damdinsüren, 1997:40). Энэ зан үйлийн тайлбарыг Ч.Бауден нэлээд эрж хайсан бололтой. Ц.Дамдинсүрэнгийн “Ламын рашаан” өгүүллэгт энэ нэр томьёо тааралдсаныг тэр бээр дурдаад, тус өгүүллэгт шоронгоос оргосон хүнийг аврах зорилгоор нэгэн лам ном уншиж буй хэсэг, мөн “Монгол ёс заншлын дунд тайлбар толь”-д “хуучны оршуулах ёс” хийхэд зоч ламыг залж лүйжин тавиулдаг тухай өгүүлснийг эш татжээ. Түүнчлэн цахар монголын эрдэмтэн Ч.Халтодын тайлбарлаж өгснийг эш татсан байна. Ч.Халтод “лүйжин” хэмээх зан үйлийг хийж дадсан эмэгтэйчүүд Өвөр Монголд цөөнгүй байдаг тухай, мөн “лүйжин” тавих зан үйлийн талаар ярьсан зүйлийг тэмдэглэн авч, “их сонин зан үйл” гэж дурдаад, өөр бусад тайлбар олдсонгүй гэснээс үзвэл Ч.Бауден энэ тайлбараа бүрэн гүйцэд гэж үзээгүй бололтой (Damdinsüren, 1997:63). “Лүйжин” гэдэг бол “биеийн өглөг” гэсэн утгатай төвөд үг бөгөөд тус зан үйлийг сүсэгтэн олны хүсэлтээр аливаа гай зэтгэр, саад тотгор, гэм хорыг зайлуулах зорилгоор манай сүм хийдүүдэд одоо ч гэсэн хийж байна. Англи-монгол толь-доо Ч.Бауден эл үгийг “нас барсны дараа хийх шарын шашны гүрмийн нэр” гэж тайлбарлажээ. Энэ зан үйлийг лам нараас асуувал ерийн үед ч хийдэг гэж хэлж байна. “Сүншиглэх” (тө. gzungs gzugs) буюу “тарни оршуулах” гэдэг зан үйлийг “enliven” буюу “амилуулах” гэж ерөнхий утгаар нь орчуулаад, “бурхан (зурмал, цутгамал, шуумал гэх мэт Д.Б) болон суварга дотор хийх тарни буюу тахилын эд зүйл” гэж тайлбарлажээ (Damdinsüren, 1997:7). Нөгөөтээгүүр, Ч.Бауден зарим тайлбартаа эргэлзсэн тухайгаа бас тэмдэглэсэн байна. Тухайлбал, “далхаа” (тө. dgra lha, мо. дайсны тэнгэр) буюу монголоор “сүлд тэнгэр” утгачилж орчуулдаг сахиусын нэрийг англиар “Horse God” буюу “Морины тэнгэр” гэж орчуулаад зүүлтэндээ “Enemy God” буюу “дайсны тэнгэр” байх магадгүй гэжээ (Damdinsüren, 1997:19). Тэгэхээр Ч.Бауден эл үгийн эхний орчуулгад эргэлзэж, зүүлтэнд оруулсан “Enemy God” гэсэн хөрвүүлгээ арай оновчтой гэж үзсэн бололтой. Ер нь орчуулагчдад эргэлзэх зүйл бишгүй тааралддаг. Тэр бүрийг нягтлан үзэж, магадалж байхыг Ч.Бауденгийн орчуулгын туршлага харуулж байна.

Ийнхүү монголын уран зохиол дахь шашин соёлын холбоотой үг хэллэг, нэр томьёог орчуулсан зарим жишээг нэгтгэн дүгнэвэл санскрит гаралтай монгол нэр томьёог англи хэлнээ санскрит бичвэрийг хуулбарлан буулгах, төвөд гаралтайг монгол дуудлагаар нь галиглах, төвдөөс нь үгчлэн буулгах, тайлбарлах зэрэг аргыг хослон хэрэглэсэн болохыг ажиглаж болох юм.

Буддын шашны нэр томьёог хэдэн зууныг дамнан орчуулж ирсэн манай монголчуудын арга туршлага гадаад судлаачдын анхаарлыг татаж байжээ. Үүний нэг тод жишээ бол монголчуудын зохиосон *Төвөд-Монгол дохионы бичгүүдийг* монгол болон төвөд толгойтой хэд хэдэн хэлний толь зохиохдоо ашиглаж байсан явдал юм. Тухайлбал, *Монгол-Орос-Франц толь* (О.Ковалевский 1844-1849, I-III боть), *Монгол-Орос толь* (К.Р.Голстунский 1883- 1895, I-III боть), *Төвөд-Герман толь* (Я.Шмидт, 1841)-ийг дурдаж болно. *Монгол-Англи толио* (1997) зохиохдоо Ч.Бауден дээрх толь бичгүүдээс ашиглахын сацуу буддын шашны холбоотой үг хэллэг, нэр томьёо зэргийг судалж, тайлбарлаж, гарал үүслийг тэмдэглэж, санскрит, төвөд нэр

томъёог латин үсгээр галигласан байгаа нь монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийх хүмүүст чухал гарын авлага болж байгаа билээ.

Дүгнэлт

Аливаа улс үндэстний сэтгэлгээний онцлог хэл, соёл, шашин шүтлэгээр илрэх тул орчуулах зохиолын хэл, соёлыг сайтар судлах, шашин хоорондын ялгаа зөрөөтэй үг хэллэгийг хэрхэн яаж буулгах талаар эрэл хайгуул хийх нь үр дүнтэй болохыг орчуулагчдын арга туршлага харуулж байна. Францын зохиолч Виктор Хюго-гийн “Парисийн Гэгээн Мариагийн сүм” (фр. Notre-Dame de Paris) хэмээх зохиолын нэрийг “Парисын Дара эхийн сүм” гэж загалмайтны шашны шүтээнийг буддын шашинтны сүмээр сольж орчуулсныг Б.Ринчен шүүмжилсэн байдаг. Энэ бол өөр өөр шашны үзэл ойлголтыг хольж хутгаснаас үүдэлтэй буюу шашин соёлын ялгаа зөрөөг анхаараагүй, тэр талын мэдлэг дутсанаас үүдэлтэй ажээ. Өөрөөр хэлбэл, гадаад хэлний мэдлэгээс гадна шашин соёлын суурь мэдлэг чухал болохыг нэрт орчуулагчдын туршлага харуулж байна.

Ном зүй

- Дамдинсүрэн Ц (1959), Монголын уран зохиолын дээж бичиг зуун билиг оршвой.
- Лувсанцэрэн Г (2019), Буддын гүн ухааны сэтгэлгээ, Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, төв үзэл төвшин бодлого, бүтээл туурвилын эмхэтгэл.
- Рерих Ю.Н (1975), Хэл зохиол судлал, Т-Х, fasc. 16. Орчуулсан Ц.Шагдарсүрэн.
- Сүхбаатар О. (2014), Монгол хэлэн дэх самгарди махбод, УБ. Соёмбо принтинг хэвлэлийн үйлдвэр.
- Үлгэрийн далай (2020), худам монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэн оршил, тайлбар бичсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, Удам соёл хэвлэх үйлдвэр.
- Bawden Ch (1997), Mongolian-English Dictionary, London and New York.
- Damdinsüren Ts (1997), Tales of an Old Lama, translated with Notes by C.R.Bawden From a Mongolian Text Recorded and Edited by Ts.Damdinsüren, Published by the Institute of Buddhist Studies, Tring, U.K.
- English- Mongolian Dictionary (2006), first edition, edited by Amarsanaa Luvsandorj, Oxford Monsudar publishing.
- Natsagdorj D (1976), Tears of a Venerable Lama, translated by De.Natsagdorji, УБ. “Орчуулгазүй”, МУИС, ШУС-ийн ЭШБ, 2020 №8 (529).
- Sutra of the Wise and the Foolish (1981), Translated from the Mongolian by Stanley Frey, Library of Tibetan works and Archives.



“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-НЫ ХЯТАД ОРЧУУЛГАД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Г.Элдэв-Очир¹¹

Abstract: “Mongolian secret history” has been translated into many languages of the world, and only a few Chinese translators have translated it in their own way. One of them is Xie Zaishan, who translated Ts. Damdinsuren's “Mongolian secret history” published in 1947, in 1956.

Therefore, in this article, we have tried to compare Chinese translation of some verses of the “Mongolian secret history” to the original version.

Түлхүүр үг: МНТ, монгол шүлгийн онцлог, хятад шүлгийн онцлог, шүлгийн орчуулга

“МНТ”-г дэлхийн олон хэлэнд орчуулсан байдгаас зөвхөн хятад хэлэнд хэд хэдэн орчуулагч өөр өөрийн арга барилаар орчуулжээ. Эдгээрийн нэг нь Ц.Дамдинсүрэн гуайн 1947 онд орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн “МНТ”-г орчуулагч Ше Зайшаний (谢再善) 1956 онд хийсэн орчуулга юм.

Тэрбээр энэхүү орчуулгын бүтээлийнхээ өмнөх үгэнд “урьд нь би хятад хэлээр авиачлан буулгасан МНТ-г (元朝秘史) монгол хэлээр сэргээх гэж оролдож байсан бөгөөд дараа нь монгол хэлнээс хятад хэлнээ орчуулав. Харин 1947 онд БНМАУ-ын ШУА-аас хэвлэсэн Ц.Дамдинсүрэнгийн орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн МНТ-г үзэж, 1956 онд хятад хэлнээ орчуулан хэвлүүлсэн болно” гэжээ.

Ше Зайшань бол МНТ-г нэлээд гүнзгий судалж, энэ чиглэлээр мэргэшсэн судлаач, орчуулагч хүн юм. Уг орчуулгыг ерөнхийд нь авч үзвэл, эхийг ягштал сайн баримтлан, утгачлах, үгчилэх хоёр аргыг чадамгай хослуулсан байна.

Иймд бид энэхүү өгүүлэлдээ МНТ-ны зарим шигтгэл шүлгийг хятад хэлнээ хэрхэн орчуулсан талаар уг эхтэй нь харьцуулан үзэхийг оролдлоо.

56-р зүйл.

1. Тэврэх хайрт эр чинь
2. Тэртээ давааг давав.
3. Уйлан санах эр чинь
4. Ус олныг гэтлэв.
5. Хайлж уйлавч
6. Харж чамайг үзэхгүй,
7. Хайж эрэвч
8. Хаалга зам нь олдохгүй.

¹¹ Доктор, МУИС, ШУС, Ази судлалын тэнхим

Хятад орчуулга:

1. 你的亲爱的丈夫
2. 已经越过了千山
3. 你的心爱的丈夫
4. 已经度过了万水。
5. 你虽然痛哭
6. 但也不能回顾你一下
7. 你虽然想去寻觅
8. 但是找不着道路了。

Хятад орчуулгыг үгчлэн орчуулбал:

1. Энхрий хайрт нөхөр чинь
2. Мянган уулыг хэдийн давжээ
3. Зүрхний хайрт нөхөр чинь
4. Түмэн голыг хэдийн гаталжээ.
5. Чи хэдий уйлан гашуудавч
6. Чамд буцаад ирэхгүй
7. Чи хэдий эрэн хайхыг бодовч
8. Зам мөрийг нь олж чадахгүй.

“МНТ”-ны 56-р зүйлд буй энэхүү шүлгийн орчуулгад хэлбэрийн талаас 1-3 мөр, 2-4 мөр, 5-7 мөр, 6-8 мөрийн толгойг эн зэрэгцүүлэн холбож, мөрийн үеийн тоог 7-8 байхаар тааруулан тэнцүүлж, монгол шүлгийн үг, үеийн тоо тэнцүү байдаг дэг ёсыг хадгалахыг зорьж, хятад шүлгийн айзам, хэмнэлийн зарчмыг баримталсан боловч зарим хэсэгт эхээс ондоо буюу утгын хувьд ойролцоо боловч эхийг яг таг баримтлаагүй, утгыг дэлгэрүүлэн орчуулсан байдал ажиглагдлаа. Тухайлбал, “Тэврэх хайрт эр чинь, тэртээ давааг давав...” гэдгийг “Энхрий хайрт нөхөр чинь, мянган уулыг хэдийн давжээ...” гэж орчуулснаар, “тэртээ даваа” гэснийг “мянган уул” хэмээн орчуулж, “Уйлан санах эр чинь, ус олныг гатлав...” гэдгийг “Зүрхний хайрт нөхөр чинь, түмэн голыг хэдийн гаталжээ...” гэж “Ус олныг” гэснийг “түмэн гол” хэмээн хятад хэлний тооны бэлгэдлийг ашиглаж, “маш олон” гэсэн санааг агуулж, эхэд байхгүй утга санааг нэмэн дэлгэрүүлсэн нь ажиглагдаж байна. Гэвч энэхүү орчуулга ерөнхийдөө эхийн агуулгыг бүрэн гаргаж, АБАБАВАВ хэлбэрээр толгой холбон эхийн хөг аялгууг хадгалахыг зорьжээ.

64-р зүйл.

1. Харь улсыг үл довтлон
2. Хацар сайт охидоо
3. Хасаг тэргэнд суулгаж
4. Хар буур хөллөж
5. Хатируулж одож
6. Хаан болсон та нарын
7. Хатан сууринд дэвшүүлж
8. Хамт суулгана.
9. Өөр иргэнийг үл тэмцэн
10. Өнгө сайт охидоо
11. Өлжгэтэй (суудалтай) тэргэнд суулгаж
12. Өл буур хөллөж
13. Үүсгэж одож

14. Өндөр суурь эзлэгчдийн
15. Өрөөл хань болгоно.

Хятад орчуулга:

1. 不侵伐他人的国土
2. 使美貌的女子
3. 坐在大车上
4. 驾着黑色骆驼
5. 一点一点地跑到
6. 合罕你们的面前
7. 让她作为妃子
8. 和合罕坐在一起。
9. 不争夺他人的百姓
10. 使美貌的女子
11. 坐在有座的车上
12. 驾着青色骆驼
13. 一晃一晃地走到
14. 至尊高位的身旁
15. 作为亲密的伴侣。

Хятад орчуулгыг үгчилэн орчуулбал:

1. Харь улсад үл довтолж
2. Хацар гоо охидоо
3. Том тэргэнд суулгаж
4. Хар тэмээ хөллөж
5. Аажим аажим давхиулж
6. Хаантан та нарын өмнө
7. Түүнийг хатан болгож
8. Хаантай хамт суулгана.
9. Бусдын иргэдийг үл довтолж
10. Хацар гоо охидоо
11. Суудалтай тэргэнд суулгаж
12. Өл тэмээ хөллөж
13. Сажилуулан алхуулж
14. Эрхэм дээдсийн дэргэд
15. Дотны хань болгоно.

“МНТ”-ны 64-р зүйлд буй энэхүү шүлгийн орчуулгад эхийн адил 1-8, 9-15 дугаар мөрөнд утга санааг багцалсан ч толгой холбох, эн зэрэгцүүлэх, мөрийн үеийн тоог тэнцүүлэх зэрэг хятад шүлгийн айзам, хэмнэлийн зарчмыг баримтлаагүй байна. Гэвч эхийн утга санаа ерөнхийдөө бүрэн буусан боловч зарим хэсэгт, тухайлбал, “хатируулж одох, үүсгэж одох” гэдгийг “аажим аажим давхиулж, сажилуулан алхуулж” гэсэн байдлаар эхийн утга санааг өөрчилжээ. Гэвч энэ нь утга санааны хувьд өөрчилсөн мэт боловч хэлбэрийн талаасаа “一点一点地跑到”, “一晃一晃地走到” гэж 5 ба 13 дугаар мөрийг айзам хэмнэлээр хослуулж, тухайн шүлгийн багцалсан утга санаанд хөг аялгуу нэмж буй нь сайшаалтай байна. Шүлгийн орчуулгад агуулга, хэлбэрийн аль

нэгийг орчуулж, нөгөөг нь орхиж болохгүй (Д.Дашдаваа, 1988:72) хэмээх үзэл санааг орчуулагч Ше Зайшань баримталж орчуулжээ гэж үзэж болно.

96-р зүйл.

1. Хар булган дахын чинь хариуд
2. Хагацсан улсыг чинь
3. Хамтатгаж өгье
4. Булган дахын чинь хариуд
5. Бутарсан улсыг чинь
6. Цуглуулж өгье.
7. Бөөр нь бөгсөнд байг
8. Цэр нь цээжинд байг
9. (Ах захтай болог) гэв.

Хятад орчуулга:

1. 黑貂鼠皮袄的报答是
2. 要把你的离散的部众
3. 给你聚集来。
4. 黑貂鼠皮袄的报答是
5. 要把你的离散的部众
6. 给你招集来。
7. 蛋应在裤裆里
8. 痰应在喉咙里。
9. (应该有上有下)

Хятад орчуулгыг үгчилэн орчуулбал:

1. Хар булган дахын хариуд
2. Хагацсан түмнийг чинь
3. Хурааж чамд өгье.
4. Хар булган дахын хариуд
5. Хагацсан түмнийг чинь
6. Хурааж чамд өгье.
7. Өндөг нь салтаанд байг
8. Цэр нь хоолойд байг
9. (Дээр, доор гэж байх ётсой)

“МНТ”-ны 96-р зүйлд буй энэхүү шүлгийн орчуулгад 1-3 дугаар мөрийг 4-6 дугаар мөрөнд давтаж, 1 ба 3, 4 ба 6 дугаар мөрөнд *hei, gei* гэх авиа ойролцоо үгээр эн зэрэгцүүлэн холбож, 7-8 дугаар мөрөнд *dan, tan* гэж мөн авиа ойролцоо үгээр толгой холбож, 7-8 дугаар мөрөнд 6 үеэр айзам хэмнэлийг үүсгэн орчуулсан нь уран яруу болгожээ. Харин эхэд буй “Бөөр нь бөгсөнд байг, Цэр нь цээжинд байг” гэх хэллэгийг “Өндөг нь салтаанд байг, Цэр нь хоолойд байг” гэсэн байдлаар ерөнхий утга нь ойролцоо боловч хятад уншигчдад ойлгомжтой байх үүднээс бага зэрэг өөрчлөн орчуулжээ. Мөн монгол хэлэнд “ах захтай байх” тухай хэллэг байдаг бөгөөд хаалтанд оруулсан энэ хэсгийг хятад хэлний “дээр, доор гэж байх ёстой” буюу хятад сэтгэлгээний онцлогийг харгалзан буулгажээ. Гэвч хятад хэлний “дээр, доор” гэх үгэнд “ихэс дээдэс болон эгэл ард” гэх эсрэгцсэн утга ч агуулагддаг. Тухайлбал, хятад хэлэнд “上有政策, 下有对策” гэх хэллэг байдаг бөгөөд үгчилэн орчуулбал “дээр бодлого байдаг, доор арга байдаг” буюу төр засагт

бодлого гэж бий, эгэл ардад арга заль гэж бий гэсэн утга агуулдаг. Гэсэн хэдий ч ерөнхий утга агуулга нь ойролцоо байгаа нь чухал юм.

Манай нэрт яруу найрагч Б.Явуухулан “Яруу найргийн орчуулгын асуудалд” хэмээх өгүүлэлдээ, яруу найргийн орчуулгад эрхэмлэвэл зохих 4 зүйл бий. Үүнд: 1. Санааг тод буулгах 2. Дүр, зураглалын өвөрмөц нарийныг хадгалах 3. Шүлгийн өнгө аяс, хөгжмийг хадгалах 4. Шүлгийн хэлбэрийг хадгалах хэрэгтэй гэжээ. (Д.Дашдаваа, 1988:64) Үүнээс үзэхэд, шүлгийн орчуулгад агуулга, хэлбэрийн зохицол, хэм хэмжээг нарийн тохируулах нь туйлын чухал болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, агуулга, хэлбэрийн аль нэгийг оmtгойлох аваас эх зохиолоос холдон хөндийрдөг. Шүлэг, яруу найраг нь тухайн хэлний онцлогт тохирсон айзам хэмнэл, бүтэцтэй тул “МНТ”-ны шүлэг ч мөн ийм байдлаар бичигдсэн байдаг.

Ше Зайшаны “МНТ”-ны орчуулга нь туйлын нягт нямбай, эхийн утга санааг тун нарийн ойлгож, судалж орчуулсан бөгөөд Ц.Дамдинсүрэн гуайн “МНТ”-г хятад хэлээр авиачлан буулгасан “МНТ”-той харьцуулан судалж, цаад утга агуулгыг бүрэн судалсан нь харагдаж байна. Дээрх шүлгийг орчуулгаас гадна, “МНТ”-ны үндэсний онцлог бүхий үг хэллэг, хэлц хэллэг, хэл найруулга, дүр дүрслэл зэргийг хэрхэн орчуулсныг мөн тал бүрээс нь судлан шинжилж, монгол-хятад орчуулгын онцлог, өвөрмөц талыг нь гаргаж ирэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ном зүй

Дамдинсүрэн.Ц, Монголын нууц товчоо, Улаанбаатар, 1990
Дашдаваа.Д, Уран зохиолын орчуулгын тухай, Улаанбаатар, 1988
Хүрэлбаатар.Л, Монгол орчуулгын товчоон, Улаанбаатар, 1995
Ше Зайшань, Монголын нууц товчоо, Шанхай, 1956



ЖАГДАЛЫН ЛХАГВЫН ОРЧУУЛГАД ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Ц.Магсар¹²

***Товч утга:** Жагдалын Лхагвын 80 насны ойд зориулсан энэхүү өгүүлэлд орос хэлнээс орчуулсан зарим зохиолуудад нь ажиглалт хийж орчуулагчийн хэрэглэж байсан түгээмэл арга, хувиргалын онцлогийг жишээ баримтад тулгуурлан тайлбарлав. Тухайлбал, утга тодруулж орчуулах, тэр дундаа утга дэлгэрүүлэх ба ялгаруулах, чимэг нэмэх, өөрийн дүрслэлээр баяжуулах, мөн утга ерөнхийлж орчуулах, утга тонгоруулж орчуулах зэрэг аргыг тэрээр орчуулгадаа нийтлэг хэрэглэдэг байжээ.*

***Түлхүүр үг:** яруу найраг, орчуулга, утга дэлгэрүүлэх, утга ялгаруулах, инверс*

Жагдалын Лхагва орос, украин, испани хэлнээс уран зохиолын орчуулга хийдэг, яруу найраг, үргэлжилсэн үгийн аль ч төрлөөр орчуулгын ихээхэн өв үлдээсэн, өөрийн гэсэн арга маягтай, баримталдаг зарчимтай орчуулагч байжээ. Мэдээж тэр орост сурч, орос хүмүүстэй нөхөрлөж байсан учраас цаад соёлын онцлогийг сайн мэддэг, өөрийн ахуй соёл, эх хэлний арвин баялаг мэдлэгтэй тул соёлын болоод хэлний үзэгдлүүдэд хувиргал хийх чадвар сайтай, түүнийг нь өөрийнх нь билэг авьяас байнга хөхиүлэн хөөрөгдөж байдаг онцлогтой байсан гэж хэлж болно. Цаад ард түмнийхээ гүнд байсан нь бичсэн зохиолуудаас нь харагддаг. Жишээ нь, “Прощай”, “Дарцаг чамайг үүрд дурсана” өгүүллэгүүд байна. “Прощай” өгүүллэгт дадлага цуг хийж байсан Света охины дотоод сэтгэлийн илэрхийллийг их сонин маягаар, тэгэхдээ “прощай” гэдэг үгийн утга хэлбэртэй уялдуулж гаргасан байдаг. Дадлагаа дуусаад явахдаа Света охинд “баяртай” гэж хэлэх гээд “прощай” буюу “үүрд баяртай” гэдэг үг хэлээд тавьчихсан нь охины сэтгэлийг оволзуулж, тэр нь бүр суурь машин дээр Светагийн зорж байсан эд ангийн зоргодост яаж илэрч байгааг:

“Прощай гэж хэлсэн өөрийнхөө дууг таньсангүй. Света үг ч дуугаралгүй огцом эргэж хутга тохируулдаг бариулаа ууртай дугтарч нарийвчаа зорж эхлэв. Энэ л лав гологдол боллоо гэдгийг би туршлагаасаа мэдэж байлаа. Хутгаа хэт гүнзгий зоосноос хиншүү ханхлан хутга харлаад солонгын өнгөтэй халуун зоргодос п-р-р-р-о... хэмээн дугуйрч байснаа ...щай гэж тэнийгээд шалан дээр унав” хэмээн үйлдэл, сэтгэл хоёрын хооронд уран нарийн холбоо тогтоож, бас нэлээн хөгжилтэй дүрсэлсэн байдаг. “Прощай” гэдэг үгийг энд гарчиг болгосон нь санамсаргүй хэлсэн нэг үг хэрэг тариад зогсохгүй, Света охины сэтгэлийг таниулж, бага зэрэг хошигнолтой дүрслэлдээ суурь машины зоргодсоор хэлүүлж буй тэр үг нэг ёсондоо Светагийн амнаас гарч байгаа хариу, гунигтай сэтгэлийнх нь илэрхийлэл болсон нь дүрслэлийн ярууслыг гойд олсон уран сайхны шийдэл гэмээр ажээ.

Ж.Лхагвын уран сайхны сэтгэлгээний энэ онцлог орчуулгад нь ч мөн нөлөөтэй байсан гэдгийг үгүйсгэх аргагүй юм. Ерөнхийдөө орчуулгын зохиолоо сонгохдоо нэгдүгээрт, өөрийнх

¹² Доктор, профессор, МУБИС

нь дүрслэн сэтгэх онцлогт нийцтэй, хоёрдугаарт, тухайн цаг үедээ шинэлэг бүтээл хэмээгдэн олонд танигдсан, гуравдугаарт, Монголтой холбоотой буюу Монголын сэдвээр бүтээл туурвил хийж, дурсамж, сэтгэгдэл үлдээсэн, заримтай нь танилын холбоотой зохиолчдыг сонгож авсан байдал ажиглагддаг. Түүний орчуулгын зохиолуудыг харьцуулж үзвэл дараах хэдэн аргыг түгээмэл хэрэглэдэг байсан нь харагдаж байна.

Нэгдүгээрт, утга тодруулж орчуулах зарчим. Яруу найрагт давамгайл, монгол шүлгийн жаягийг баримталсан чөлөөт хэлбэрийн орчуулга Ж.Лхагвын хувьд Ц.Дамдинсүрэнгийн “Алтан загасны үлгэр” зэрэг зохиолын орчуулгад баримталж байсан аргатай үндсэндээ төстэй. Жишээ нь, Е.Исаевын “Суд памяти”, “Даль памяти” гэдэг хоёр найраглал тухайн үедээ сэтгэлгээний шинэлэг түвшинд бичигдсэн гэж шуугиулсан зохиолууд. “Суд памяти”-г Ж.Лхагва орчуулсан.

Он шёл в засеянный простор,
В зарейские поля.
Вокруг него во весь напор
Работала земля.
Вся до корней напряжена,
Вся в дымке голубой...

Рейн мөрний чанад
Элчилгүй өргөн талд
Бодол болсон хүмүүн
Бор шороо туучна
Үр цацсан талбай
Үүлгэр мөртлөө чамбай
Хөх суунаг татах нь
Хөл хүндэрсэн эхнэр шиг

Энд “Он шёл” гэсэн дискурсын зангилааг “Бодол болсон хүмүүн Бор шороо туучна” гэсэн нь тухайн зангилаан дээр өгүүлэмжийн санааг төвлөрүүлсэн байна. Үүнийг ажиглахад, нэгдүгээрт, зохиолчийн баатартаа хандаж буй цаад санааг дэлгэрүүлсэн, хоёрдугаарт, “хүмүүн” гэдэг ерөнхий хийсвэр нэрээр утгыг тодруулсан байдал харагдаж байна.

Стоял по правилам по всем
Он, двадцати трёх лет, —
В полярный цвет железный шлем,
Мундир — в полярный цвет.

Хорвоод өр авцаагүй
Хорин гурван нас
Бүдэг ногоон дуулга
Бүрэн тоног хувцас

/Е.Исаев. Суд памяти./

Утга тодруулж орчуулахдаа аль болох монгол хэл, сэтгэхүйн нарийн нандин зүйлсийг түлхүү хэрэглэх эрмэлзэлтэй байжээ. “Стоял по правилам по всем, Он, двадцати трёх лет” гэдгийг “Хорвоод өр авцаагүй Хорин гурван нас” гэх жишээтэй.

Утга тодруулах дотроо дээрх байдлаар *утга дэлгэрүүлэхээс гадна утга ялгаруулж орчуулах* аргыг зайлшгүй байдлаар хэрэглэж байсан жишээ мэр сэр ажиглагдав.

Приснись мне, а то я уже забываю,
Что надо тебя мне любить и беречь.
Приснись, не сердись, я ведь тоже живая!
Приснись, прикоснись.
Можешь рядом прилечь.

Зүүдэнд ирээч!...
Эс тэгвэл би чамайг мартаж
Энхрийлэн хайрлах сэтгэлээ гээх нь
Амьд хүн шүү дээ би,
Уурлаад яахав, зүүдэнд ир!
Амьсгааг чинь мэдэрч,
Аяыг чинь дагамаар ойртож ир!

/Р.Казакова. Зүүдэнд ирээч/

Энд “прикоснись, можешь рядом прилечь” гэдгийг “Амьсгааг чинь мэдэрч, Аяыг чинь дагамаар ойртож ир” гэсэн нь “биеэрээ хүрэлц, зэрэгцээд хэвт” гэснээс илүү гойд яруусалтай болжээ. Мөн утга тодруулж орчуулахдаа мэдрэмжээ дагаад чимэг нэмэх тохиолдол байна.

Я остров, я атолл, коралл,
и среди бела дня
мужчина, как большой корабль,
уходит от меня.

Гэрэл тансаг шүрэн арал билээ би
Гэтэл эр хүн, хөлөг онгоц шиг
Гэгээн цагаан өдрөөр
Гэнэт намайг хаяж одлоо

Ер нь чимэг нэмэх арга яруу найргийн орчуулгад найруулгыг яруу тансаг болгодог, гэхдээ орчуулагчаас чамгүй авьяас, ур ухаан, нарийн мэдрэмж шаарддаг чимхлүүр ажил. Учир нь сонголтоо буруу хийх аваас цаад эхийн өнгө аяс, утгын шиж чанарыг гажуудуулах магадлалтай тул яг л донжийг нь олох хэрэгтэй.

Я родился — нескладным и длинным —
в одну из душевных ночей.
Грибные июньские ливни
звенели, как связки ключей.

Ус тунасан нойтон шөнөөр би
Урт улаан юм төрсөн гэдэг
Мөнгөн түлхүүрийн хэлхээ шиг
Мөөгөн зүс шаагиж байсан гэдэг.

/Р.Рождественский/

Энд “нескладный и длинный”, “душные ночи” үгнүүдийн яс утгыг барьж орчуулъя гэвэл тийм ч яруу тансаг болно гэхэд хэцүү. Тийм учраас “Урт улаан юм”, “Ус тунасан нойтон шөнө” гэх мэт тодотголын түвшинд ихээхэн хувиргал хийснээс гадна “связки ключей” гэдгийг “мөнгөн түлхүүрийн хэлхээ” гэхэд сая яруу найраг төрхөө олсон байна.

Снятся усталым спортсменам рекорды.
Снятся суровым поэтам **слова**.

Ядарч сульдсан тамирчин
Аваргын амжилт зүүдэлнэ.
Яруу найрагч
Алт шиг үг зүүдэлнэ.

/Р.Рождественский. Эзгүй арал./

Утга тодруулж орчуулах явцад орчуулагчийн авьяас амаа авч давхих морь аятай цалгиж, орчуулгаа өөрийн дүрслэлээр баяжуулах тохиолдол бишгүй байна. Энэ бол яах аргагүй орчуулгад яруу найрагчийн мэдрэмж, зохиолчийн дүрслэн бодохуй оролцоод эхэлж байна гэсэн үг.

Реки Сибири,
как всякие реки,
начинаются ручейками.

Сэм хуйвалдах мэт
Далдуур нийлэх горхидоос
Сибирийн их мөрөн эхтэй юм.

Гол мөрнийг бүрдүүлэгч горхинууд ийнхүү “сэм хуйвалдах мэт далдуур нийлдэг” гэсэн дүрслэл эхэд харагдахгүй байна. Ингэж дүрслэлийг баяжуулсан нь шүлгийн хэмнэл, холбоцыг жигдлээд зогсохгүй, байгалийн сайхныг чихэнд сонсогдож нүдэнд харагдтал буулгаж, орчуулгыг яруусалтай болгожээ гэж үзүүштэй юм.

Шальные,
покрытые пеной сивой,—
реки ведут разговор...

Хөөсөн дороо
Манцуйд юм шиг хөлбөчиж
Хүүхэд адил эрх хонгор
Эхтэй юм...

/Р.Рождественский. Гол мөрөн далай

Энд мөн “шальной” гэдэг үгийн цаад санааг өөрийн дүрслэлээр баяжуулж, “манцуйдаа хөлбөчих эрх хонгор хүүхдийн” дүрслэл оруулж ирж байх жишээтэй.

Ийнхүү утга тодруулж орчуулах зарчмыг баримтлахдаа Ж.Лхагва монгол хэл, сэтгэхүйн онцлогт аль болох нийцүүлж, хэлбэрийн төдий биш, монгол уншигчид наалдацтай мөн чанарын хувиргал хийх чиглэлийг түгээмэл баримталж байжээ.

Хоёрдугаарт, утга ерөнхийлж орчуулах зарчим. Ялангуяа газар усны нэр, оноосон нэрийг орчуулахад, тэр тусмаа яруу найрагт ямар нэгэн хэмжээгээр хувиргал хийх хэрэгтэй болдог. Энд түгээмэл хэрэглэдэг аргын нэг бол утга ерөнхийлөх арга юм. Ж.Лхагва энэ аргыг байнга хэрэглэдэг байжээ.

Вдруг —
ведешь меня
в леса!
Вдруг —
в Сахары!

Гэнэт намайг ойд хөтөлж
Гэнэгүй байхад **цөлд хаяна**

/Р.Рождественский/

Энд “Сахарт хаяна” гэж орчуулбал өөдтэй юм болохгүй гэдгийг орчуулагч сайн мэдэж байгаа учраас “цөл” гэсэн ерөнхий утгаар нь хувиргасан байна.

Поэзия - мужичье дело,
вологий труд, солёный пот.
Зачем же
Орлеанской девой
в поэты девочка идёт?

Яруу найраг эр хүний ажил
Ядаж байж дусаасан шорвог
хөлс
Зовлонт энэ үйлсийн алдар өөд
Зоригт бүсгүй яах гэж мацна вэ?

“Орлеанская дева” /буюу Жанна д’Арк/ бол түүхэн бие хүн (Ф.Шиллерийн жүжиг, П.Чайковскийн дуурь зэрэг томоохон бүтээлийн гол дүр) бөгөөд уг нэрийг “зоригт бүсгүй” гэсэн ерөнхий нэрээр орчуулсан байна. Түүнээс гадна энэ шүлгийн орчуулгад ур ухаан зарсан сонирхолтой шийдлүүд байгаа юм. Жишээ нь, “вологий труд” (хүчир хөдөлмөр) гэдгийг “солёный пот”-той нь нийлүүлээд “ядаж байж дусаасан шорвог хөлс” гэж тун гайхалтай орчуулсан. “Зачем же... в поэты девочка идёт?” гэдгийг “яруу найрагч” гэдэг үгэнд баригдалгүй, мөн л ерөнхийллийн түвшинд хувиргал хийж “Зовлонт энэ үйлсийн алдар өөд ... яах гэж мацна вэ?” гэсэн байна. Ийнхүү энд утгыг ерөнхийлөх, мөн тодруулах аль алийг хослуулсан онцлог ажиглагдаж байна. Уг шүлгийн төгсгөлд харин Жанна нэрийг хэвээр хадгалж зүүлт тайлбар хийсэн шиг байгаа юм. Энд нэгдүгээрт, орчуулагч өөрөө судалгаатай хандсан, хоёрдугаарт, танин мэдэхүйн ач холбогдлыг нь чухалчилсан талтай гэж хэлэхээр байгаа юм.

Гуравдугаарт, инверс буюу утгыг нь тонгоруулж орчуулсан тохиолдол ажиглагдаж байна. Энэ нь гол төлөв үндэсний сэтгэлгээний шалтгаантай бөгөөд өөр өөр язгуур бүхий хэл хоорондын орчуулгад логик чанартай хувиргал хийхэд туйлын оновчтой арга гэдгийг Ж.Лхагва орчуулгадаа харуулсан байна. Жишээ нь:

Я похожа на землю,
что была в запустенье веками.
Небеса очень туго,
очень трудно ко мне привыкали.

Үе улирч эзгүй болсон газартай
Үнэндээ би адилхан байсан
Тэнгэр хүртэл ээнэгшин дастлаа
Тэнхээ чадлыг минь олонтаа шалгасан

/Р.Казакова/

“Небеса очень туго, очень трудно ко мне привыкали” гэсэн өгүүлэмжээс “маш хэцүү, арайхийж” гэсэн санааны логикийг урвуугаар “Тэнхээ чадлыг минь олонтаа шалгасан” хэмээн өөрөө шалгуулсан байдлаар хувиргал хийсэн байна.

тонкие-тонкие,
белые-белые,
длинные-длинные
облака
Ветры,
которым под небо не тесно,
птицы,
поющие нараспев

Нимгэн цагаан,
Хөнгөн цагаан,
Хөвөн цагаан үүлс.
Тэнгэрийн доор зугаалах
Чөлөөт салхин,
Тэнхээ мэдэн дуулалдах
Жигүүртэн шувууд

/Р.Казакова. Эзгүй арал/

Энд “ветры, которым под небо не тесно” гэдгийг “тэнгэрийн доор салхи давчдахгүй” гэсэнгүй, харин “тэнгэрийн доор зугаалах чөлөөт салхин” хэмээн дүрслэлээ дагасан логиктой болгон хувиргажээ. Энэ хэсэгт байгаа мөн нэг сонин зүйл бол орос эхдээ байгаа хүч нэмэгдүүлсэн давталтыг хооронд нь найруулж бие биед нь тодотгол болгосон байна.

Живу на свете дураки:
На бочку мёда - дёгтя ложка.

Халбага давирхай торх баланд багтахгүй
Хан хорвоод тэнэгүүд ер мундахгүй

“Ложка дёгтя в бочке мёда” гэсэн өвөрмөц хэллэгийн утга нь “торх балыг халбага давирхай баллана” гэсэн санаа юм. Үүнийг “Халбага давирхай торх баланд багтахгүй” гэж орчуулсан нь уг санааны логикийг тун өвөрмөц сонин болгож, бас монгол сэтгэлгээний онцлогийг нэг мөр харуулсан тал ажиглагдаж байна.

Ж.Лхагвын орчуулга дахь нийтлэг нэг онцлог бол харь сэтгэлгээнд ямагт үндэсний өнгө үнэр оруулж орчуулах хандлагатай, уг онцлог зохиолыг уншигчдад соёлын болон сэтгэл зүйн ямар нэгэн саадгүй хүргэх давуу тал болжээ гэж үзүүштэй байна.

Не держи на леске, на поводе,
на узде, на беде,
ни на приводе, ни на проводе,
ни в руках и нигде!

Жолоо цулбуураар хазаарлаж
Зовлонгоор бурантаглахыг бүү бод
Аргамжаа, зэлэнд тогтох нь бүү хэл
Алган дээр чинь удаан суухгүй

/Р.Казакова/

Мы **перебежали рельсы наперерез трамваю**,
садились и спрыгивали только на ходу.

Бид **трамвайны хамар доогуур зам**
хөндлөн гүйж, явуут дунд нь л бууж
сууна.

/Ю.Нагибин. Цэнгэг цөөрөм/

Ийнхүү Жагдалын Лхагвын орчуулгыг ажиглахад ихээхэн бүтээлч, гоо зүйн үүрэг зорилгыг ямагт тэргүүн зэрэгт тавьсан, судалгаатай, өөрийн гэсэн арга зүй, хувиргалын зарчимтай сайн орчуулгууд байна.

Жагдалын Лхагва бол нэн түрүүн хүүрнэл зохиолын төрлөөр өөрийн гэсэн уран сайхны ертөнцийг бүтээсэн XX зууны монголын уран зохиолын томоохон төлөөлөгч. Гэвч тэр бас яруу найргийн билэг авьяастайгаа харуулж яруу найраг, үргэлжилсэн үгийн олон зохиол орчуулсан, улс түмнүүдийн соёлын элч байсныг мэндэлснийх нь 80 насны ой тохиож байгаа энэ цаг мөчид бахархан тэмдэглэхэд таатай байна.

Ашигласан эх сурвалж:

- М.М.Бахтин. Эстетика словесного творчества. М., 1986
М.Л.Гаспаров. Очерк истории русского стиха. М., 2002
Е.Исаев. Ухаан бодлын цааз (Ж.Лхагвын орчуулга). 1987
Р.Казакова. Хүүхэн заяа (Ж.Лхагвын орчуулга). 1986
Ц.Магсар. Яруу найргийн орчуулгын уран чанарын тухайд. “Орчуулгазүй” сэтгүүл. 2015, №4.
Ю.Нагибин. Цэнгэг цөөрөм (Ж.Лхагвын орчуулга). 1978
Р.Рождественский. Эргэх хорвоо (Ж.Лхагвын орчуулга). 1984
К.Н.Яцковская. Поэты Монголии XX века. М., 2002

Резюме: Статья под названием “Некоторые наблюдения над переводами Жагдалын Лхагва” посвящена 80-летию со дня его рождения. Знаменитый монгольский прозаик Ж.Лхагва, активно занимаясь переводческой деятельностью, познакомил монгольских читателей с творчеством таких замечательных русских писателей, как Е.Исаев, Р.Казакова, Ю.Нагибин, Р.Рождественский и др. Его переводы поэтических текстов отличались свободной манерой, гибкостью подбора аналогичных образных средств и мастерством художественно-эстетического оформления. В целях трансформации качественных показателей художественных текстов переводчиком больше применялись такие переводческие способы, как конкретизация, генерализация, инверсия, расширение эпитетами и другими собственными образно-выразительными средствами.



Д.ТАРВЫН “ДАМИРАНГИЙНХАН” ЗОХИОЛЫН ҮГҮЙСГЭХ УТГА ИЛЭРХИЙЛСЭН “ОГТ”, “ЕР” ЗЭРЭГ ҮГИЙН ОРЧУУЛГЫН ТУХАЙ

Ө.Нарантуяа¹³

Abstract: A study on Mongolian adverbs of ‘ep’[er], ‘ogt’[ogt] with negation meaning and corresponding expressions in Chinese translation from the literature work “The Damiran’s family”. The aims of this study is to compare the meanings and relation of words syntactically and semantically. By analyzing the difference between Mongolian and adverbs and its corresponding Chinese expressions, this study will reveal the similarities and differences between the two languages on their syntactic and semantic meaning. Those of Mongolian adverbs correspond not only Chinese adverbs with negation meaning of ‘从来’, ‘简直’ but also a variety of other Chinese categories. In syntetical aspects, Mongolian and Chinese adverbs show similarities that those adverbs usually modify the adjectives, some verbs and adverbs. Finally, its need to make a comparative study between Mongolian and Chinese translation as well as adverbs with negation meaning in more detail for various aspects.

Keywords: The Damiran family, comparative analysis, negation, literature translation, lexical and grammatical analyze

Оршил

Далантайн Тарва нь Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт, МЗЭ-ийн шагналт зохиолч юм. Д.Тарва нь 1923 онд Дорнод аймгийн Халх гол суманд төржээ. Тэрээр яруу найргийн авьяаслаг зохиолч бөгөөд “Дамирангийнхан”, “Анхны шинэ жил” зэрэг тууж нь хятад хэлээр орчуулагдсан байна. “Дамирангийнхан” тууж нь тухайн үеийн ажилчин, малчин, хилчин зэрэг социалист нийгмийн бүтээн байгуулалтынхан хэрхэн шаргуу зүтгэн ажиллаж байсныг Дамирангийн гэр бүлээр төлөөлүүлэн өгүүлсэн зохиол юм.

Уг туужийг 1956 онд Чэнь Найшюны орчуулгаар Бээжин хотноо “Зохиолчдын хэвлэх үйлдвэр”-т хэвлэж байсан байна.

Энэхүү судалгаагаар зохиолч Д.Тарвын “Дамирангийнхан” зохиолын хятад хэлээрх орчуулгын эхийг монгол орчуулгатай нь тулган, уг зохиолд гарч буй үгүйсгэх утгатай “огт”, “ер” хэмээх үгийн орчуулгын дүйцлийг үгийн сан, орчуулгын хувьд хятад хэлээр хэрхэн оноосныг харьцуулан авч үзлээ.

“ЕР” гэдэг үг “Монгол хэлний их тайлбар толь”-д 3 утгатай байна. Үүнд:

1. Тодорхой мэдэгдэхгүй, огт, зүгээр: **ер дуулдаггүй** (а. Угаасаа сонсдоггүй; б. Огт дуулдаггүй),

2. [шилжсэн] Хэрэв, харин, хэрвээ - *Ер нь таныг эс дааж оруулахгүй бол хэнийг дааж оруулах юм билээ дээ.* Ши.Аюуш. Түүвэр зохиол

¹³ Отгонтэнгэр Их Сургууль, Дорно дахин, агаарын тээврийн үйлчилгээний тэнхим, магистр

3. Энгийн, жирийн, байдаг л: **ерийн айлтгах бичиг** [хуучирсан] (мэдээлэх зорилгоор тамга даралгүй айлтгасан бичиг),

4. Ерөнхийдөө, тоймдоо: **ер нь зүйтэй** (ерөнхийдөө зөв);

5. Үргэлж, дандаа, угаасаа, ямагт, бас - *Ерөөс цэргийн газар дан идэр залуу эрүүл чийрэг улс байдаг хойно*. Б.Ринчен. Үүрийн туяа., **ер байхгүй** (огт байхгүй, үргэлж байхгүй) - *Бууз хуушуурыг бол хонины махаар хийнэ гэж ер байхгүй*. Д.Мягмар. Нийлэх замын уулзварт., **ер болдоггүй** (угаасаа болдоггүй), **ер сайн морь** (хамар нь сартгар, уруул өмгөр, нүд бүлтгэр, бие бүдүүн, хавирга матархай ихтэй, сүвээ цухал, ташаа тэгшхэн, ясан сүүл урт, дөрвөн хөл бүдүүн, салтаа омруу агуу, бөгс сайхан морины шинж), **үгүй ер** (үгүй бас) - *Ямар их турж эцсэн байх юм бэ гэж бодсоноо үгүй Мандхай чинь тураад улам булбарай, улам аятайхан харагддаг байна шүү гэж бас бодож үгүй ер эмэгтэй хүн гэж сонин юм*. Ш.Нацагдорж. Мандхай цэцэн., **ерийм** (угаас тийм) - *Ажваас ч ер ийм унаанд тэнгэр заяатай та мэт морилохоос биш гуйрамч ядууст заяасангүй бололтой*. Д.Гармаа. Харуул Алтай., **ерөөсөө тийм** (дандаа тийм), **ерөөс тийм** (угийн тийм) - *Гурван залуус, ерөөс тийм том могой байдаг гэж сонсохоос биш, бараагийг нь ч урьд өмнө үзээгүй тул, тэр муухай том амьтны гулдарч явахыг хараад, айдас нь хүрэвч хүч хурды нь мэдэхгүй*. Б.Ринчен. Заан Залуудай.

Харин “**Огт**” гэдэг үгийг “Монгол хэлний их тайлбар толь”-д: Бүр, хэрхэвч, ер, эрс тэс: **огт байхгүй** (бүр байхгүй), **огт айхгүй** (ерөөсөө айхгүй) - *Чоно нохойг дайралдана гэж Донхор огт айхгүй билээ*. Л.Түдэв. Уулын үер., **огт өөр** (тэс ондоо), **огт танихгүй хүн** (урьд өмнө уулзаж байгаагүй хүн), **огт хамаагүй хэрэг** (ямар ч холбоо хамааралгүй хэрэг), **огт ирэхгүй байх** (бүр ирэхгүй байх), **огт хийгээгүйгээс орой хийсэн нь дээр** [зүйр цэцэн үг] (цаг хугацаа хожимдсон ч хийх хэрэгтэй гэсэн санаа) хэмээн тайлбарласан байна.

“Ер” гэдгийг үйлийн дүрийн дайвар үг (В.Л.Котвич, 1902), өгүүлбэрийг угтан чимэх үг (Ц.Өнөрбаян, 1991), тодорхой бус утгатай оруулсан үг (Т.Бертагаев, 1964), ерөнхийлөх баймж үг (Н.Д.Доржиев, 1973), баймж үг (Ц.Өнөрбаян, 1987) гэх мэтээр нэрлэдэг.¹⁴

Дээрх тайлбар тольд тайлбарласнаар “огт, ер” зэрэг үг нь “огт байхгүй, огт танихгүй” гэхчлэн үгүйсгэсэн утгатай байгаа учраас үгүйсгэлийн талаар судалж шинжиллээ.

Монгол хэлний үгүйсгэлийн талаар гадаад, дотоодын эрдэмтэд, тухайлбал, А.Попов, Г.Ц.Пюрбеев, Л.Мишиг, П.Бямбасан, Б.Пүрэв-Очир, М.Базаррагчаа, Ю.Мөнх-Амгалан нар тусгайлан судалжээ.

Монгол хэлний үгүйсгэх утгатай өгүүлбэр болон үгүйсгэх сул үгийн талаар Ю.Мөнх-Амгалан “Ер нь үгүйсгэх утга нь батлах утгын эсрэг зүйл бөгөөд үүний ерийн үгүйсгэл юм” гээд “үл, эс, биш, бус, үгүй, -лгүй, -шгүй” зэрэг нөхцөл, алга зэрэг үгийг баймжийн захын тогтолцоо буюу үндсэн баймж чанарт багтааж баймж утгын талаас болон хэлзүйн талаас нарийн тайлбарлан бичсэн байна.

Монгол хэлний үгүйсгэх утгатай нөхцөл, үг хэллэгийн хэлзүйн бүтэц, утга, хэрэглээний талаас Ж.Бат-Ирээдүй дэлгэрэнгүй судалж, “-гүй нөхцөл бол үгүй хэмээх үгүйсгэх утгатай үгийн товч хэлбэр бөгөөд нэр үг болон үйлт нэрийн дараа тохиолдож, өгүүлбэр төгсгөдгөөрөө бусад нөхцөлөөс онцлогтой” гэжээ.

Бид энэхүү зохиолын орчуулга дахь үгүйсгэсэн утга бүхий “ер”, “огт” (огтхон) хэмээх үгийн утга дүйлгэсэн байдлыг хэлзүй болон үгийн сангийн талаас нь авч үзсэн юм. Ингэхдээ эх сэдэв болон орчуулгын эхийг харьцуулан үгүйсгэсэн утга бүхий “ер”, “огт” (огтхон) үгс орсон жишээ түүн ангилж, ажиглалт хийсэн болно. Эдгээр үгийг сонгож авч эхийг орчуулгатай нь харьцуулснаар хятад хэлийг сонирхон судалж буй оюутан залуусын мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд ач холбогдолтой хэмээн үзэж байна.

¹⁴ Ю.Мөнх-Амгалан “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, Улаанбаатар, 1998, 96-р тал

1. “Ер”, “огт” зэрэг үгийн орчуулгыг үгийн сангийн хувьд харьцуулсан нь

Аливаа зохиол бүтээлийг орчуулахдаа хоёр хэлний хэрэглүүр хоорондоо нийцэж, дүйцэж байгаа үг хэллэгийг олж сонгох чадвар байдаг. Тухайн зохиолд гарч байгаа “ер” болон “огт” хэмээх үгсийг орчуулгатай нь тулгаж үзээд хятад хэлний хэрэглүүртэй нийцэж байгаа эсэхийг жишээ баримтаар авч үзсэнийг харцгаая.

- (1) а. ... ах маань ойрдоо ер захидал ирүүлсэнгүй, одоо ч нэг захидал ирэх болсон баймаар юм.

一直盼望着哥哥的信，却总收不到，现在他也应当来一封信啦。

- б. ... адуун тийш явахыг хэд дахин гуйсан боловч Хишигт ер зөвшөөрсөнгүй.

可是他要求了好几次，母亲总不答应他到马群那边去。

Энэ (1a) болон (1б) жишээнээс үзвэл ер гэдэг үг нь хятад хэлээр 总, 总...不 үгүйсгэсэн утга бүхий үгтэй хоршиж синтагмд цуваа цэгт орсон байгааг харж болно.

- (2) а. ... Аав нь энэ нөхөдтэйгөө хамт ер давгүй өнгөрсөн. Ер нь шуурга биднийг хэзээ дийлж байсан билээ дээ.

风雪始终没有战胜他们，倒是他们战胜了风雪。

- б. ... Шуурган дунд сунаад хэвтэж байгаа тэр цагаан юмны учрыг олох гэж ажиглавч сэтгэлд нь ер туссангүй.

但是仔细地观察了一番，却也看不出格究竟来。

- в. ... Чимээ шуугиан үргэлжлэвч зарим нь ер хайхрахгүй унтана.

虽然还是闹哄哄的，但是有些人却不理会这些，睡熟了。

Харин ер гэдэг үгийг 始终, 却 гэсэн үгээр орчуулсан байна. Ингэхдээ 却 утгвар үг нь мөн не үгүйсгэсэн утгат үгтэй хоршиж, цуваа цэгт орсноор үгүйсгэсэн утга илэрхийлж байна.

Харин дараагийн жишээнд огт гэдэг үгийг хятад хэлэнд өөр үгээр орчуулсан болохыг тулгаж үзье. Тухайлбал,

- (3) а. ... огт танихгүй хүн ирсэнд ганцхан Дамиран ч биш, хот айлынхан нэгэн адил гайхацгаав.

激动的情绪平静下来：来了一个不完全认识的人，这不仅使得大米轮，而且也使得村子里其他人们都感到同样的惶

- б. ... Чи надтай жил шахам үерхэхдээ миний энэ дэвтрийг огт сөхөж үзээгүй байх.

你和我交朋友已经将近一年了，却从来没有翻过一翻我这个本子。

... Би ер тэгж санаагүй шүү.....

我从来也没有那样想过。

Дээрх хоёр жишээнд бол ер гэдэг үгийг огт гэдэг үгээр сольсон ч утга өөрчлөгдөхгүй байгаа бөгөөд хятад орчуулгад ч мөн адил байгааг харж болно.

Огт, бүр, өчүүхэн ч: огтхон ч нуухгүй байх (нуух зүйлгүй, ил тод байх) - *Дугар даргадаа өөрийнхөө бүхий л амьдралыг огтхон ч нуусангүй бүгдийг тоочин ярьжээ*. Н.Банзрагч. Зам., огтхон ч үлдээхгүй авчрах (бүгдийг нь хуу авчрах), огтхон ч саад болохгүй (огт саад болохгүй)

Үүний зэрэгцээ ер гэдэг үгтэй ойролцоо утгатай огт, огтхон гэдэг үгийн утга хятад орчуулгад хэрхэн дүйснийг жишээгээр дурдвал:

Огтхон гэсэн үгийн орчуулгыг мөн харьцуулж ажигласан болно.

“Дамирангийнхан” туужид огтхон хэмээх үгийг дараахь байдлаар орчуулсан байна.

- (4) а. ...Дондогмаа огтхон ч дуугарахгүй байв.

... 但是董德马默不作声。

б. ... Албаны юм уу? Амины юм уу? гэдгийг огтхон ч сонирхож амжсангүй.

.... 他丝毫不及去思索。

в. ... Огтхон ч байхгүй байна.

.... 简直没有。

Дээрх жишээнд гарсан “огтхон ч” гэдэг үгийг орчуулахдаа “бүр, хэрхэвч, өчүүхэн ч” гэсэн ойролцоо утгатай үгээр буулгасан нь утгын хувьд тохирч байна. Монгол хэлэнд “огт” гэдэг үгийг “ер, огтхон ч” зэрэг үгээр солиход утгын хувьд өөрчлөгдөхгүй байгаа боловч хятад хэлэнд арай өөр болох нь ажиглагдаж байна.

Тухайлбал, (4а) жишээнд огтхон ч гэдэг үгийг дангаар нь бус, дуугарахгүй гэдэг арын үгтэй нь хамт хятад хэлний 默不作声 гэх хэлц үгээр дүйлгэсэн нь оновчтой болжээ.

(4б) жишээний хувьд өчүүхэн ч, хэрхэвч гэсэн ойролцоо утгатай үгээр орчуулсан байна.

Энэ гурван жишээ нь тухайн үгүйсгэсэн утгыг харьцуулан ойролцоо утгатай үгээр орлуулан орчуулбал ямар өөрчлөлт гарахыг харуулж байна.

“Огтхон” гэдэг үгийг үгийн бүтцээр нь задалж үзвэл *огт-хон* болж байна. Энэхүү *-хан* гэдгийг монгол хэлний эрдэмтэд судалсны үндсэн дээр онцгой морфем гэж үзсэн байдаг.

“Огт” хэмээх үгэнд залгавал *-хан (-хэн, -хон, -хөн)* морфемийн байр бусад морфем үгтэй харьцах байдал, утга үүргийн шинжийг нягтлан ажиглавал, дагавар нөхцөлийн алинтай ч адилгүй өвөрмөц байдалтай, зөвхөн өгүүлэгчийн сэтгэлийн аясыг илэрхийлж байна.¹⁵

“-хан” морфемийг сэтгэлийн өнгө аяс илэрхийлэх нэг хэрэглүүр гэж үзэж байна. Өгүүлбэрийн дотор байгаа *-хан (-хэн, -хон, -хөн)* морфемтай үгийн *-хан (-хэн, -хон, -хөн)* морфемын хасчихад уул өгүүлбэрийн бүтэц, бүрэлдэхүүнд ямар ч өөрчлөлт гарахгүй, *-хан (-хэн, -хон, -хөн)* морфем бүхий үгийн гол үндсэн утга нь хэвээр үлдэж, зөвхөн өгүүлэгчийн сэтгэлийн тааламж, аясыг илэрхийлсэн утгын нэмэлт өнгө нь арилах төдий өөрчлөлт орно.¹⁶

Үүнээс гадна, “Ер, ерөөс, ер нь, ердөө нь цаг хугацааг тодорхойлон батлах утгатай” гэж үздэг. (Б.Ваанчиг, 1990)

Үүнээс үүдээд мөн “ер нь” гэдэг үгийг өгүүлбэрийн эхэнд орсон байдлаар хэрхэн оноосныг авч үзэхэд:

(5) а. ... Ер нь эднийг тэгж ажилла гэж хэл амаа орооцолдуулж байгаад яах вэ?

总之, 你何苦为他们白费口舌, 要求他们要这样做或是那样做呢?

б. ... Ер нь Дондогмаа ч зөөлтийн ажлыг гардаад хийж байгаа биднээс бараг илүү мэднэ шүү дээ гэж нэгэн зөөгч хэлэв.

总之, 董德玛比起我们这些亲手干这搬运生铁的工作的人.....

(6) а. ... Ер нь бидний ширэм зөөлтийн ажилд Дондогмаа оролцох ямар хэрэгтэй юм бэ?

其实董德玛有什么必要干预我们搬运生铁的工作呢?

б. ... Ер нь тантай яриад байвал хөөдөж мэдэх нь байна гээд

总之, 跟你讲话简直是自寻晦气。

в. ... Би ч ер нь муудахгүй, сайдахгүй, дунд хэрд нь гэлдэрч явбал боллоо гэж боддог шүү гэж хэнэг ч үгүй хариулаад царайгаа үрчийлгэн байв.

总之, 我认为不用太好, 也不可再坏, 停留在中等的程度也就行啦。

¹⁵ П.Бямбасан “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, Улаанбаатар, 2006, 294-р тал

¹⁶ П.Бямбасан “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, Улаанбаатар, 2006, 292-293-р тал,

Дээрх жишээнд “ерөнхийдөө, тоймдоо” гэсэн утгаар хэрэглэгдэж, ерөнхийлөн дэлгэрүүлсэн утгаар орчуулсан байна. Харин (2а) жишээнд хятад хэлээр 其实 үнэндээ гэсэн утгаар буулгасан байна.

Үүнээс гадна, өгүүлбэрийн дунд орсон байрлалаар хэрхэн орчуулагдсан жишээг харьцуулж үзвэл:

(7) а. ... Энэ Дондогмаа ер нь яасан их завтай хүн бэ?

董德玛吃饱了饭怎么这样空呢?

б. ... Дондогмаа өөрчилж орхивол үгүй ер орчлонгийн нар хаанаас гарах бол?

...太阳还不是要从西边升起来了吗?

Дээрх (1а) жишээнд ер нь гэдэг үгийг хятадаар орчуулахдаа 怎么, харин (1б) жишээнд 还不 гэсэн үгээр буулгасан байна.

(8) а. Чи ч ер ингээд л тэр хүүхэнтэйгээ сууж орхидог юм биш биз дээ гэж сурвалжлагч асуув.

б. “你就这样和那个姑娘结了婚吗?”

Эдгээр жишээнд *ер, ер нь* гэдгийг 2а, 3, 4 зэрэг жишээнээс өөрөөр буюу 怎么这样, 还不是, 就 зэргээр орчуулсан нь өгүүлбэрийнхээ утгыг харгалзан үзэж, хам сэдвийн хүрээнд орчуулан буулгасан гэж болох юм.

Дүгнэлт

Монгол зохиолчдын хятад хэлээр орчуулсан зохиол, бүтээлийн нэг болох Д.Тарвын “Дамирангийнхан” зохиолын хятад хэлээрх орчуулгын эхийг монгол орчуулгатай нь тулган, уг зохиолд гарч буй үгүйсгэх утгатай “огт”, “ер” хэмээх үгийн орчуулгын дүйцлийг үгийн сан, орчуулгын хувьд хятад хэлээр хэрхэн оноосныг харьцуулан авч үзлээ. Мөн үгийн сангийн хувьд ойролцоо утгатай болох “огтхон ч” хэмээх үг орсон жишээ баримтын ажиглалт хийж судалсан болно.

Энэхүү судалгааны зорилго нь үгсийн утга, хамаарлыг синтакс болон утгын хувьд харьцуулах явдал юм. Энэхүү судалгаа нь монгол хэл болон чимэх үгийн ялгаа, түүнд харгалзах хятад орчуулгыг шинжлэн судалснаар хоёр хэлний найруулга зүйн болон үгийн сангийн утгаараа ижил төстэй болон ялгаатай талуудыг илрүүлэх болно.

Монгол хэлний “ер”, “огт” зэрэг үгс нь зөвхөн ‘从来’, ‘简直’ гэсэн үгүйсгэх утгатай хятад үйл үг төдийгүй бусад олон төрлийн хятад үг хэллэгтэй тохирч байна. Өгүүлбэрзүйн талаас нь авч үзвэл монгол, хятад хэлний дайвар үг буюу чимэх үг ижил төстэй шинж чанартай байдаг нь тэдгээртэй дүйцэх, ихэвчлэн нэмэлт, зарим тохиолдолд орчуулгыг өөрчилдөг.

Эцэст нь монгол, хятад хэлний дайвар үг, ялангуяа үгүйсгэх утгатай үгийн хооронд харьцуулсан судалгааг төрөл бүрээр тал талаас нь илүү нарийвчлан хийх шаардлагатай байна.

Номзүй

Бямбасан., П “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, Улаанбаатар, 2006

Мөнх-Амгалан., Ю “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, Улаанбаатар, 1998

Цогзолмаа.,Г, “Дамирангийнхан” Улаанбаатар, 2020

Төмөртоогоо.,Д “Хэл шинжлэлийн нэр томъёоны хураангуй толь” УБ, 2004

Магсар.,Ц “Уран зохиолын орчуулгад тавих шаардлага: “Дүйцэл” ба “нийцэл” ойлголтын тухайд”, “Орчуулгазүй”, МУИС, ШУС-ийн ЭШБ, 2018 № 6 (481).

Элдэв-Очир.,Г “Орчуулгын дүйцлийн тухай асуудалд”, “Орчуулгазүй”, МУИС, ШУС-ийн ЭШБ, 2018 № 6 (481).



МОНГОЛ УРАН ЗОХИОЛЫН ХЯТАД ОРЧУУЛГЫН БАЙДАЛ, ОНЦЛОГ

Ш.Эгшиг¹⁷

Товч агуулга: Монгол уран зохиолыг хятад хэлээр орчуулах үйл явц бүр Хүннүгийн үеэс ч эхэлсэн байх магадлалтай. Дундад зууны үед буюу Юань улсын үед орчуулгын ажил идэвхтэй өрнөж, бүр орчуулгын ажил эрхэлсэн хороо хүртэл байгуулагдаж байсан юм. Монгол зохиол хятад хэлнээ орчуулагдаж байсны нэг тод жишээ бол Монголын нууц товчооны бүлгийн хятад орчуулга болон үг бүрийн ард хадсан хадмал орчуулга гэж үзэх үндэслэл бий. Монголын шинэ үеийн уран зохиолын хятад хэлээрх орчуулгын ажил XX зууны дунд үеэс эрчимтэй хөгжсөн гэж үзэж болно. Эдүгээ XXI зуунд орчуулгын ажил зохих хэмжээнд үргэлжилж байгаа ч, монгол үндэстний уран зохиолын орчуулгын ажил сүүлийн жилүүдэд ӨМӨЗО-ны орчуулагчдын нийгэмлэгийн цөөнх үндэстний уран зохиолын орчуулгыг дэмжих бодлогын хүрээнд харьцангуй идэвхтэй өрнөж байгаа дүр зураг ажиглагдаж байна.

Түлхүүр үг: монгол уран зохиол, хятад орчуулга, эртний уран зохиол, шинэ үеийн уран уран зохиол, соёлын харилцаа, орчуулагч

Эрт үеийн уран зохиолын орчуулга

Манай тооллоос өмнөх үед холбогдох хүннүчүүдийн дуулж байсан хоёр дуу¹⁸ хятад орчуулгаар дамжин өнөө үед уламжлагдан ирсэн байдаг. Энэ нь НТӨ 121 онд хамаарна. Чингэхээр монголчуудын уран зохиолыг хятад хэлээр орчуулсан үйл явц нь бусад хэлнээ орчуулагдсан баримттай харьцуулбал эрт үеийнхэд тооцогдоно. Монголчуудын өвөг дээдсийн уран зохиолын бичмэл түүхийг мянган жилээр зааглан үздэг ч, аман зохиол, тэр дундаа үлгэр домгийн агуулгаас үзэхэд, хүн төрөлхтний балар эртний үеийн ойлголт, сэтгэлгээний агуулга оршиж байдгийг бид “Сүмбэр уулыг дов байхад, сүн далайг шалбааг байхад...” зэрэг өгүүлэмжээс мэднэ. Монголчууд нүүдэлчин ард түмэн. Сүүлийн үеийн торгоны замын судалгаагаар евразийн их орон зайд нүүдэлчдийн орчин явдаг замын зургийг гаргасан байдаг, хэрэв түмэн жилийн тэртээгээс нааших археологийн олдворыг авч үзвэл, талын морьтон ард түмэн өнөөгийн Монголын нутгаас баруун тийш евразийн хойд биеэр өнөөгийн Европ руу, зүүн тийш далайн хөвөө хүртэл чөлөөтэй зорчдог

¹⁷ Монгол Улсын Их Сургууль, Ази судлалын тэнхим тэнхим, дэд профессор

¹⁸ Таргуд Шагдарсүрэнгийн Эгшиг Хятадын сонгодог зохиолын орчуулга, хэлний онцлог, Боловсролын докторын зэрэг горилсон зохиол, Улаанбаатар, 2000, 108-109-р тал.

亡我祁连山

Чилинь уулнаасаа хагацсанаас хойш

使我六畜不蕃息

Зургаан хошуу мал маань үржихийг болилоо.

失我焉支山

Яньжы уулнаасаа салснаас хойш

使我妇媿颜色

Янзлаг бүсгүйчүүдийн маань царай гундлаа.

байсан¹⁹ гэж үзсэн эрдэмтэн байна. Энэ өргөн уудам их дайр монголчууд өөрийн соёл, тэр дундаа уран зохиолын солилцоонд орж байсан нь дамжиггүй. Манай уран зохиолыг олон хэлнээ орчуулсан байх магадлалтай, гагцхүү бичгээр уламжилж ирсэн баримтыг бид шинжлэх ухааны үндэстэй нотолгоо болгоно. Умардын суурин иргэншилт хятад хүмүүс бичгийн асар их дурсгал үлдээсэн нь, аз болоход тэдний бичиг дурсгалын санд манай утга зохиол, соёлын мэдээ хадгалагдан үлджээ. Түүний нэг жишээ нь дээрх хүннүгийн үеийн дуу ажгуу.

Хүннүгээс хожим Тоба, Сяньбийн уран зохиолоос мөн хятадын түүх, сурвалжаар дамжин уламжлагдан үлджээ. Монгол угсаатны уран зохиолыг баатарлаг, эрэмгий, хөдөлгөөнт соёл гэдгээр нь суурин иргэд таашаан үзэж, үйл явдлын сонин сайхныг өөрийн хэлнээ буулгаж байсан гэж үзэхэд хүргэнэ. Ийм зохиолд, Хятадын Ордны дуулал (乐府)-д багтсан хэдэн дуулал, шүлэг орно.

Эдгээрт “Ахын дуулал”²⁰, “Чылөгийн дуулал”²¹, “Уд модыг хугачсан дуулал”²², “Хүрэн хээр морины дуу”²³, “Лан яа вангийн дуу”²⁴ зэргийг нэрлэж болно. Эдгээр шүлэг дууллын хятад орчуулгыг Гүнжийн Сүхбаатар, Б.Сумьяабаатар, Хаганчулууны Саран, оросын монголч эрдэмтэн В.С.Таскин болон Т.Каррол (Th.Carrol), Л.Лигети (L.Ligeti), Ф.Токей (F.Tokei), Огава Тамаки (Ogawa Tamaki), Г.Шрайбер (G.Schreiber) нар судалж, орчуулж, орчуулгын шинжилгээ хийсэн нь бий.

Дээрх шүлэг дуулал нь нүүдэлчдийн сэтгэлгээ, ахуй, аж байдлыг тусгасан байдаг юм. Тухайлбал, нүүдэлчдийн эрхэлдэг мал аж ахуйн байдал, байгалийн үзэмж, хөгжмийн зэмсэг, нутгаа санасан сэтгэл зэргээс гадна тухайн үед дайн тулааны хөлд гэр бүл, үндэс угсаагаа хамгаалан авч үлддэг, тэтгэн гэрлэх ёсны талаар нэг бус шүлэг дуулалд хадгалагдан үлдсэн нь сонирхолтой бөгөөд энэ үзэгдэл түгээмэл байсны илрэл гэж үзэхээр байна.

Зохиогч бээр “Хуа Муланы дуулал” хэмээх хятад хэлээр уламжилж ирсэн зохиолыг монгол угсааны нүүдэлчдийн уран зохиол болох тухай хэлний баримтаар нотлон нэгэн илтгэлдээ бичиж байсан юм. Мулан бол нүүдэлч угсаатны баатар болохоос бус суурьшмал иргэний баатар биш юм. Энэ дуулал бол мөнхүү Тобагийн үед хамаарах зохиол гэгддэг, анх тухайн үеийн нүүдэлчний хэлээр зохиогдож, хожим нүүдэлчин угсааны эмэгтэйн эрэмгий баатарлаг дүр суурин иргэдийн зүрх сэтгэлийг эзэмдэн тархахдаа хятад хэлээр уламжлан, мөн Ордны дуулалд орсон байдаг²⁵ билээ. Энэ зохиол бол бусад шүлэг дууллаас хэмжээний хувьд харьцангуй урт, найргийн шинжтэй зохиол болно.

Дундад үеийн уран зохиолын орчуулгын байдал

Дундад зууны монгол уран зохиолын хятад орчуулгын жишээнд Монголын Нууц Товчоон (МНТ) заавал орно. МНТ бол монгол хэлээр анх зохиосон монголчуудын алтан ургийн түүх гэдэг ч уран яруу өгүүлэмжтэй, уран зохиол гэж олон судлаач үзсэн байдаг. Ямар ч байсан Мин улсын Хун Ү хааны ор суусан үес Юань улсын түүхийг Хуянгаа, Маш Их нарыг томилон зохиолгосон гэдэг. Иймээс түүхчид МНТ-г түүхэн талаас, уран зохиол үг, утга уянгын талаас нь хэл шинжлэлч, утга зохиол судлаач олон эрдэмтэн МНТ-г судалжээ. МНТ-г анх монгол хэлээр

¹⁹ Jeong Su-il, Steppe Road, The heart of northern eurasian nomadic civilization, Гадаад хэл, соёл судлал, 2019, No.507(23) 7-11-р тал.

²⁰ Мөн тэнд, 112-р тал.

²¹ Мөн тэнд, 120-р тал.

²² Мөн тэнд, 123-р тал.

²³ Мөн тэнд, 126-р тал.

²⁴ Мөн тэнд, 129-р тал.

²⁵ Ш.Эгшиг *Хятад хэлээр уламжилсан зарим монгол шүлгийн орчуулга*, Орчуулах эрдэм (3), Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Улаанбаатар, 2011.05 сар, 148-167-р тал.

зохиогдсон гэдэгтэй ихэнх монголч нангиадч эрдэмтэд²⁶ санал нийлэн хүлээн зөвшөөрч, зарим нь уг зохиолыг дөрвөлжин үсгээр анх зохиогдсон гэж үзсэн нь бий. Хятадын Мин улсын үед МНТ-г монгол хэлний сурах бичиг болгон сонгон авч хятад үсгээр монгол хэлний агуулгыг бүрэн буулгаж, бүлэг бүрийн ард хятад орчуулгыг хавсаргасан байдаг. МНТ-ны хэлний судалгаа хийсэн эрдэмтэн Л.Маналжав МНТ-ны энэ хятад орчуулгыг МНТ-ны хамгийн анхны гадаад хэлээрх орчуулга²⁷ гэж үзсэн юм. Энэ орчуулгын онцлогийн талаар английн нэрт хэлшинжлэлч М.А.К.Халлидей судалж, бүр докторын диссертациаа²⁸ энэ сэдвээр бичжээ. Тэрээр уг хятад орчуулгын хэлний онцлогийг тодорхойлжээ.

МНТ өнөөг хүртэл дэлхийн 20 гаруй үндэстний хэлээр орчуулагдсаны дотор хятад хэлнээ хэд хэдэн орчуулгаар гарсан билээ. Мэдээж хамгийн анхны орчуулга бол Мин улсын үеийн МНТ-г монгол хэл сурахад зориулан дахин найруулахдаа хийсэн бүлэг бүрт хадсан товчилсон орчуулга юм. Бидний үед уламжилсан МНТ-ны эхэд монгол дуудлагаар хятад үсгээр бичсэн үндсэн зохиолын хажуугийн хятад хадмал орчуулга ба бүлэг тус бүрийн агуулгыг товчилсон хятад орчуулга бүлэг бүрт бий. 12 эсвэл 15 бүлэг, 282 зүйл уг зохиолын зүйл бүрийн ард хятад орчуулгыг оруулсан нь энэ зохиолын нэгэн онцлог тал юм. МНТ-ны орчуулгыг XIV зууны 80-аад оноос өмнө хийсэн байх магадлалтай юм, учир нь 1382 онд хэвлэгдсэн МНТ-ны бүрэн бус эх олдсон гэж үздэг. Чингэвч, МНТ-ны хэлний талын судалгааг хийсэн эрдэмтэн Л.Маналжав уг орчуулгыг хийсэн үеийг 1382-1404 онд хийсэн байх гэж үзжээ. Юутай ч, МНТ-ны зүйл доторх мөр тус бүрт хадсан хадмал үгийн орчуулга ба зүйл бүрийн ард буй товч хятад орчуулга бол яах аргагүй монгол уран зохиолын нэгэн үеийн хятад орчуулга мөн. Үүнээс хожим, энэ орчуулгад нь дулдуйдан, 1951 оны Е Дөхуйгийн орчуулга, 1956 оны Ше Зайшань-ий орчуулга, 1960-1961 онд Яо Цун-ү, Захчид Цэцэн нарын сонинд зориулсан цуврал орчуулга, 1979 оны Захчид Цэцэний шинэ орчуулга тайлбар зэрэг хятад орчуулга ар араасаа гарсан байдаг юм.

Монгол уран зохиолын дундад зууны үед хятад хэлээр орчуулагдаж байсан байдлыг зөвхөн МНТ-ны жишээгээр бичлээ. Гэвч энэ үед монгол уран зохиол янз бүрийн хэлбэрээр хятад хэлд бууж байсан баримт бий. Тухайлбал, Юань улсын үед хамаарах өнөөгийн хятадын болон Төв Азийн нутагт олддог гэрэлт хөшөөний хятад бичээс голдуу монгол хэлнээс хятад хэлд орчуулан буулгасан бичээс байдаг гэдгийг анхаарч үзэх ёстой. Мөн Хятадын уран зохиолын түүхэнд Юаний дуурилга (元曲) гэж алдаршсан уран зохиолын нэгэн онцгой төрөл жанр бол яах аргагүй монгол хэл, уран зохиолын нөлөө тусгалаар биежиж гарч ирсэн жанр гэдгийг бодолцох ёстой гэж үзэж байна. Иймд энэ чиглэлээр илүү гүнзгий судалгаа хийж, монгол уран зохиол хятад хэлэнд буусан баримтыг тодруулах ажил судлаачдын өмнө буй гэдгийг тэмдэглэе.

XX, XXI зууны монгол уран зохиолын хятад хэлээрх орчуулга

Хятад судлаач Г.Цогзолмаа манай нэрт зохиолчдын зохиолын XX зууны 50, 60-аад оны хятад орчуулгууд Хятад улсад хэвлэгдсэн байдгийг Улаанбаатарт дахин тайлбар хийж, эх зохиолтой нь зэрэгцүүлэн бэлтгэж цувралаар хэвлүүлжээ. Тэдгээр зохиол бол БНХАУ байгуулагдсаны дараа Монгол, Хятадын урлаг соёлын хамтын ажиллагаа цэцэглэн хөгжиж байсан үед хоёр орны уран зохиолыг харилцан орчуулж ирсэн үеийн орчуулга бөгөөд энэ харилцаа иргэний гэхээс илүү улс төрийн агуулгатай, хоёр орны соёлын бодлогын хүрээнд

²⁶ Лувсанвандангийн Маналжав “Монголын нууц товчоон” анх ямар бичгээр байсан тухай асуудалд, “МНТ”-ны хэлний судалгаа”, Улаанбаатар, 2017, 127-р тал.

²⁷ Мөн тэнд, Лувсанвандангийн Маналжав “Монголын нууц товчоон”-ы хятад орчуулгын тухай товчхон, “МНТ”-ны хэлний судалгаа”, Улаанбаатар, 2017, 130-р тал.

²⁸ Halliday, M.A.K. 1959 “The language of the Chinese ‘Secret History of the Mongols’”. Philological society publication: 17, 1959.

төрийн байгууллагын хооронд хийсэн гэрээ, хэлцэл, зохиолчдын эвлэл, урлагийн зөвлөлийн хооронд зохион байгуулагдсан томоохон урлаг соёлын арга хэмжээ, түүхэн айлчлал зэрэгт зориулан орчуулгын ажил идэвхтэй өрнөсөн үеийн орчуулгууд юм. Бид 2019 онд Монгол-Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой тэмдэглэх Засгийн Газар хоорондын бүтэн жилийн төлөвлөгөөний хүрээнд Хятадын уран зохиолын монгол орчуулгыг бүртгэн, зөвхөн 1952-1962 онд хэвлэгдсэн богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгын зохиолыг дахин хоёр ботиор өмнөх орчуулгын хэлбэрийг хадгалан хэвлэсэн²⁹ билээ.

БНХАУ байгуулагдсан үеэс Монгол-Хятадын соёлын харилцаанд шинэ үе эхэлж, социалист орнуудын харилцааны шинэ хандлагаар хуучин уран зохиолын орчуулга хийх ажлыг үзэл сурталд таарахгүй гэдэг үүднээс дэмжихээ больж, шинэ үеийн уран зохиолыг харилцан өөр өөрийн хэлд орчуулах ажил БНМАУ, БНХАУ-д өрнөж эхэлсэн байна. 1950-иад оноос Д.Нацагдорж, Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ч.Чимэд, Ч.Лодойдамба, Д.Цэвэгмид, Д.Сэнгээ, С.Тарваа, Д.Намдаг, Ц.Цэдэнжав, Ч.Ойдов, Н.Надмид, С.Дашдэндэв нарын зохиолоос орчуулжээ. Манай улсын Гадаад Харилцааны Төв Архивт монголын уран зохиолын орчуулга 1952 онд Ц.Дамдинсүрэнгийн зохиолыг хятад хэлд орчуулснаар эхэлсэн³⁰ гэж нотолсон баримт байна.

БНХАУ-д Монголын уран зохиолыг орчуулсан байдлын талаар Хятадын судлаач Ван Мөн (王萌) 2009 онд Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы хятад орчуулгын шинжилгээ хийх явцдаа бичсэн өгүүллийн удиртгал болгож нэлээд дэлгэрэнгүй авч үзжээ. Түүний хийсэн бүртгэл бол Монголын шинэ үеийн уран зохиолын хятад хэлний орчуулгын байдлын талаар нэлээд дэлгэрэнгүй хийсэн жагсаалт болсон³¹ гэж үзүүштэй байна. Түүний жагсаалтаас санаа авч, дараах 2 хүснэгтийг толилуулж байна.

Хүснэгт 1. Монголын уран зохиолын хятад хэлд орчуулсан байдал (1949-өнөө үе)

Д/д	Зохиолч, зохиолын нэр	Орчуулагч, орчуулгын зохиолын хятад нэр	Хэвлэлийн газар, хэвлэсэн он
1	Ц.Дамдинсүрэн нар Монголын өгүүллэг, туужийн түүвэр	丰子凯、丰一吟： 蒙古短篇小说集 орос хэлнээс	Соёл, амьдрал хэвлэлийн хороо 文化生活出版社 1953
2	Д.Цэвэгмид нар “Чөлөөт Монголын наран дор”	于平、熊源平： 太阳照耀着自由蒙古 (小说集) орос хэлнээс	Шанхайн урлагийн нэгдсэн хэвлэлийн хороо 上海文艺联合出版社 1954
3	Д.Нацагдорж нар “Миний нутаг - БНМАУ-ын шүлгийн түүвэр”	伊霍尔查、陶漠南： 我的祖国·蒙古人民共 和国诗集	Шинэ урлаг хэвлэлийн хороо 新文艺出版社 1955
4	Ч.Лодойдамба “Манай сургуулийнхан”	诺尔伯、陈伯雄： 我们的学校	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1955
5	Д.Сэнгээ “Аюуш”	色道尔基： 阿尤喜	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1955
6	Д.Тарва	陈乃雄：	Зохиолчдын хэвлэлийн хороо

²⁹ 1952-1962 онд орчуулагдсан Хятад өгүүллэгийн түүвэр, I, II боть, Улаанбаатар, 2019.

³⁰ Bu He, Ch.2. The development of cultural relations between the MPR and PRC in the early stage (1949-1953), In the name of proletarian internationalism: Cultural Relations between the Mongolian People's Republic and the People's Republic of China (1949-1967), Dissertation for the degree of Ph.D, Ulaanbaatar, 2022, p.51 (давхар эшилбэл, ГХТА, Ф-5, Д-2, ХН-87, тал.62)

³¹ 王萌, 蒙古国现代文学中译本中存在的问题——以产篇小说《清澈的塔米尔河》为例, 内蒙古师范大学学报(哲学社会科学版) 2010 年 1 月第 39 卷第一期 (Journal of Inner Mongolia Normal University (Philosophy & Social Science), Jan. 2010, Vol. 39 No. 1. 26 页。

	“Дамирангийнхан”	达米伦一家	作家出版社 1956
7	Ч.Лодойдамба “Малгайтай чоно”	齐星宝： 戴帽子的狼	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 1956
8	Ч.Лодойдамба “Алтайд”	色道尔基： 在阿尔泰山	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1956
9	Д.Цэвэгмид “Булшин дээр”	诺敏： 诗歌《在墓旁》	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1956
10	Ч.Лодойдамба “Ард түмнийхээ төлөө амьдаръя” ³²	坪父： 活着为人民	Хүүхдийн хэвлэлийн хороо 少儿出版社 1956
11	Д.Намдаг нар “Баатарлаг танкчин эмэгтэй” ³³	坪父、郝苏民、哈斯： 英勇的女坦克手	Хүүхдийн хэвлэлийн хороо 少儿出版社 1957
12	Ж.Жоож нар “Улаан тугийн одон” ³⁴	陈乃雄： 红旗勋章	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1957
13	Д.Нацагдорж “Учиртай гурван толгой”	诺敏： 戏剧《三座山》	Шинэ урлагийн хэвлэлийн хороо 新文艺出版社 1957
14	Б.Ринчен “Үүрийн туяа”-1 Манжийн талхинд	达基： 曙光第一部 在清朝的奴役下	Ардын утга зохиолын хэвлэлийн хороо 人民文学出版社 1958
15	Б.Ринчен “Үүрийн туяа”-2 Гал усны гашуун зовлон	文西： 曙光第二部 水深火热之中	Ардын утга зохиолын хэвлэлийн хороо 人民文学出版社 1958
16	Д.Нацагдорж “Учиртай гурван толгой”	安柯钦夫： 五幕歌剧三座山	Хятадын ший жүжгийн хэвлэлийн хороо 中国戏剧出版社 1959
17	Ц.Цэдэнжав Ц.Цэдэнжавын сонгомол шүлгүүд	曹都： 策登扎布诗选	Шанхайн урлагийн хэвлэлийн хороо 上海文艺出版社 1959
18	Ч.Ойдов “Зам”	鲁青： 话剧《路》	Хятадын ший жүжгийн хэвлэлийн хороо 中国戏剧出版社 1960
19	Н.Надмид “Залуу жуулчид”	陈乃雄： 少年探险家	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 1960
20	Ц.Дамдинсүрэн Ц.Дамдинсүрэнгийн шүлэг зохиолын түүвэр	张玉元： 达木丁苏伦诗文集	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1961
21	Д.Дашдэндэв “Саруул замдаа”	陈乃雄： 光明之路	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1961
22	Б.Ринчен “Үүрийн туяа”-3 Байлдаж олсон эх орон	达基： 曙光第三部 在战斗中成长的祖国	Ардын утга зохиолын хэвлэлийн хороо 人民文学出版社 1962
23	Дашзэвэгийн Сэнгээ Уянгын бадгууд ³⁵	陈乃雄： 诗集《深厚的情感》	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 1963
24	“Шагдарын үлгэр”	陈乃雄、道布	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо

³² Ч.Лодойдамбын 1950-иад он болон түүнээс өмнө зохиосон ийм зохиол буй эсэхийг нягтлах хэрэгтэй гэж үзнэ.

³³ Дээрхтэй мөн адил

³⁴ Дээрхтэй мөн адил

³⁵ Д.Сэнгээгийн шүлгийн түүврийг “Уянгын бадгууд” гэх цувраа шүлгийн нэрээр нь нэрлэсэн байх магадлалтай гэж үзлээ. Үүнийг нягтлан тогтоох нь зүй.

		沙格德尔的故事	内蒙古人民出版社 1963
25	Д.Нацагдорж нар “Цагаан сар ба хар нулимс”	陈乃雄: 白月和黑泪	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 1980
26	Ч.Лодойдамба “Тунгалаг Тамир”	温中和: 清澈的塔米尔河	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 1984
27	Б.Лхагвасүрэн Б.Лхагвасүрэнгийн сонгомол шүлгүүд	哈森: 巴·拉哈巴苏荣诗选	Үндэстний хэвлэлийн хороо 民族出版社 2008
28	Д.Нацагдорж нар Монголын уран зохиолын сонгомол- туужийн боть	照日格图: 蒙古国文学经典·小说 卷	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 2016
29	Ц.Дамдинсүрэн нар Монголын уран зохиолын сонгомол- шүлэг найргийн боть	哈森: 蒙古国文学经典·诗歌 卷	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 2016
30	Г.Аким Тэнгэрийн нохой	姚克成 天狗-蓝色蒙古的苍狼 ³⁶	Хөх мөрний уран зохиолын хэвлэлийн хороо 长江文学出版社 2012.7
31	Ордосын Аянга “Манба дацан”	哈森: 《满巴扎仓》	Чунчиний хэвлэлийн хороо 重庆出版社 2014.9
32	Монголын уран зохиолын шилдэг орчуулга, хэвлэлийн төсөл-4 1. Өлзийт (浩·乌力吉图) "Шин Аний үхэл" 2. Бай Жиньшөн (白金声) “Асган жанжин” 3. Ш.Бөхөө (沙·布和) “Хужиртын зэрэглээ” 4. “Уулсаа даган нүүхүйд” 5. “Тархин дэм” 6. “Эрдэнэгуагийн салхи” 7. “Дахин хүмүүжил” 8. “Үнэний тэнгэр”	1. 特·胡日查: 《兴安之殇》 2. 伍·甘珠尔扎布 《阿思根将军》 3. 春华 《胡吉日图的迷雾》 4. 海尔汗等: 《游动的群山》 5. 乌吉斯古冷 等 《脑术》 6. 《额尔敦华的风》 7. 《再教育》 8. 《苍天》	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 2016.12, 2017.3
33	Дулаан Монгол Улсын яруу найргийн сонгомол	陈岗龙: 《蒙古国诗选》 ³⁷	Зохиолчдын хэвлэлийн хороо 作家出版社 2019
34	Ордосын Аянга “Тэнгэрт өргөст тор байдаггүй”	哈森: 《天上没有铁丝网》	Орчуулгын ой хэвлэлийн газар 译林出版社 2019. 12
35	Б.Лхагвасүрэн “Сонгомол шүлгийн түүвэр”	哈森: 《巴·拉哈巴苏荣诗选》	Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо 内蒙古人民出版社 2020.7

³⁶中蒙经典著作互译 60 余载重要成果一览

<https://www.cctss.org/article/headlines/5648>

³⁷ Мөн тэнд

Хүснэгт 2. Монгол уран зохиолыг орчуулан нийтэлсэн Хятадын сэтгүүлийн мэдээ³⁸

Д/д	Зохиолч, зохиолын нэр	Орчуулагч, орчуулгын зохиолын хятад нэр	Сэтгүүлийн нэр, хэвлэсэн он, сар
1	Ш.Гаадамба “Хөдөө талын баясгалан”	色道尔基: 《草原的欢乐》	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1956.9
2	Ч.Лхамсүрэн “Ард түмний их урсгал” ³⁹	《人民的洪流》 (小说)	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1956.9
3	Д.Нацагдорж “Учиртай гурван толгой”	范均宏:《三座山》	«Жүжгийн зохиол» сэтгүүл 《剧本》 1956.7
4	Д.Нацагдорж “Од”, “Цэнхэрлэн харагдах уул”	卢永: 诗二首《火星》 《远山发着青色》	«Жүжгийн зохиол» сэтгүүл 《剧本》 1957.8
5	М.Гаадамба “Элбэг дээл”	道布:《肥大的皮袄》	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1957.9
6	“Өглөө” ⁴⁰	丁师灏:《早晨》	«Ардын уран зохиол» сэтгүүл 《人民文学》 1957.10
7	Д.Нацагдорж “Миний нутаг”	丁师灏:《我的祖国》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1958.9
8	Б.Бааст ⁴¹ “Бороо”	丁师灏:《细雨》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
9	С.Доржпалам “Энх тайвны гудамж”	丁师灏:《和平街》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
10	Ч.Чимид “Хамар даваа” ⁴²	丁师灏:《哈木尔达巴山》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
11	Ц.Гайтав “Лениний үг”	丁师灏:《列宁的话》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
12	Д.Намдаг “Тайхуулахын учир юунд оршив оо?” ⁴³	丁师灏:《那有什么奇怪》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
13	Д.Сэнгээ “Салхи тэнгис хоёр”	丁师灏:《风和海》	«Яруу найраг» сэтгүүл 《诗刊》 1959.6
14	Ц.Дамдинсүрэн “Хурга жаалхүү хоёр” ⁴⁴	纲纪:《羊羔和小孩》 (小说)	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1958.10
15	С.Дашдооров “Бүргэдийн үхэл” ⁴⁵	丁师灏:《雄鹰之死》 (诗歌)	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1958.10

³⁸ МУИС-ийн 2021-2022 оны хичээлийн жилд Магистр, докторын ахисан түвшний “Гадаад хэлний орчуулга” хөтөлбөрийн “Хятад хэлний уран зохиолын орчуулга” хичээлийг сонгон судалсан магистрант Хө Юншюний бие даах ажлаар гүйцэтгэсэн “Монгол уран зохиолыг нийтэлсэн Хятад улсын сэтгүүлийн мэдээний баримт” ажилд үндэслэн уг хүснэгтийг дэлгэрүүлэн зохиов.

³⁹ Хятадын сэтгүүлд хэвлэгдсэн монгол зохиолчдын зохиолын хятад орчуулгыг дурдсан сэтгүүлийн тухайн дугаарыг үзэж дахин нягтлах хэрэгтэй гэж үзнэ.

⁴⁰ Дээрхтэй мөн адил, Н.Банзрагчийн “Өглөө” хэмээх зохиолын орчуулга мөн эсэхийг нягтлах;

⁴¹ Б.Баастын “Бороо” гэдэг зохиол 1958 онд хэвлэгдэж байжээ. Б.Бааст 1953 оноос Монгол-Хятадын найрамдлын өдрүүд болон хоёр орны зохиолчдын эвлэлийн хамтарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байсан баримт бий. Иймд энэ зохиолыг Б.Баастын зохиолын орчуулга байх магадлалтай гэж үзэж байна.

⁴² Дээрхтэй мөн адил

⁴³ Д.Намдагийн зохиолтой орчуулгын зохиолын нэр ойролцоо байсан тул энд орууллаа, үүнийг дахин нягтлах хэрэгтэй.

⁴⁴ Дээрхтэй мөн адил

⁴⁵ Дээрхтэй мөн адил, С.Дашдооровын “Бүргэдийн үхэл” хэмээх зохиол 1950-иад онд зохиогдон, бас өөр нэрээр гарч байсан тухай мэдээ буй. Энд Д.Сэнгээгийн зохиол гэж хятад эх дээр байгааг нягтлан, энэ хоёр зохиолчийн хэний зохиол болохыг тодруулах нь зүйд нийцнэ.

16	Ч.Лхамсүрэн “Тэнгис”	乌兰汗:《海》(诗歌) орос хэлээс	«Орчуулга» сэтгүүл 《译文》 1958.10
17	Д.Сэнгээ “Гадаадын сурвалжлагчдад” ⁴⁶	刘伶:《致外国记者》	«Дэлхийн уран зохиол» сэтгүүл 《世界文学》 1959.9
18	Ц.Дамдинсүрэн “Найрын дуу”	图力更:《宴歌》	«Дэлхийн уран зохиол» сэтгүүл 《世界文学》 1959.12
19	Ц.Гайтав “Лениний үг”	邹绛:《列宁的话》 орос хэлээс	«Дэлхийн уран зохиол» сэтгүүл 《世界文学》 1960.4
20	С.Эрдэнэ “Жаргах нас”	史习成:《享福之年》 (小说)	«Дэлхийн уран зохиол» сэтгүүл 《世界文学》 1989.5
21	Ч.Лодойдамба “Хугараагүй ноён нуруу”	史习成:《不断的脊梁》	«Гадаадын уран зохиол» сэтгүүл 《国外文学》 1982.4
22	Ж.Пүрэв “Зүрхний хилэн” ⁴⁷	楚勒特木、吴新英: 《悔恨》	«Гадаадын уран зохиол» сэтгүүл 《国外文学》 1984.3
23	Д.Мягмар “Тээрэмчин”	史习成:《磨面人》	«Гадаадын уран зохиол» сэтгүүл 《国外文学》 1986.1,2
24		倪申源:《过三关》 ⁴⁸	«Гадаадын уран зохиол» сэтгүүл 《国外文学》 1986.4
25	Ц.Дамдинсүрэн “Чемодантай юм” ⁴⁹	楚勒特木、吴新英: 《考验》	«Гадаадын уран зохиол» сэтгүүл 《国外文学》 1988.2
26	В.Сайнцогт (瓦·赛音朝克 图) “Үдэш” ⁵⁰	朵日娜: 《傍晚》	«Үндэстний уран зохиол» сэтгүүл 《民族文学》 2009.7

БНХАУ байгуулагдсанаар Монголын шинэ үеийн уран зохиолыг монгол хэлнээ орчуулах явдал эрс эрчимжжээ. Ялангуяа БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойг тэмдэглэх үеэр буюу 1952 оноос эхлэн уран зохиолын орчуулгыг дэмжих нам засгийн бодлого Монгол, Хятад хоёр оронд аль аль талдаа адил тэнцүү хэмжээнд өрнөсөн нь манай шинэ үеийн уран зохиолыг хятад хэлнээ орчуулах явдлыг эрчимтэй өдөөсөн юм. Тиймдээ ч ойн арга хэмжээний үеэр орчуулах зохиолыг монгол хэлээс нь бус орос хэлнээс дам орчуулж байсан нь тухайн үед монголын уран зохиолыг эх хэлээс нь орчуулах орчуулагч цөөн, үзэл суртлын ажил яаруу давчуу байсныг Фөн Зыкай (丰子凯)、Фөн Илин(丰一吟)、Юй Пин(于平)、Шюн Юаньпин (熊源平) нар орос хэлнээс манай тухайн үеийн нэрд гарч байсан үзэл сурталд тааруулсан үргэлжилсэн үгийн зохиолуудаас түүвэрлэн орчуулж, орчуулгын түүвэр гаргаж байснаар илэрчээ. Эхний үеийн давалгааг эхлүүлснээр монгол эхээс нь орчуулах ажил эрчимтэй хөгжиж иржээ. Орчуулагчдын судалгааг

⁴⁶ Дээрхтэй мөн адил

⁴⁷ Зохиолч Ж.Пүрэвийн зохиолоос энэхүү сэтгүүлд орчуулга нь гарсан он цаг болон орчуулгын зохиолын нэрийг харгалзан үзэж, зохиолчийн “Зүрхний хилэн” романы нэртэй дүйж байна гэж үзлээ, чингэхдээ заавал нягтлууштай.

⁴⁸ Дээрхтэй мөн адил, Бээжингийн их сургуулийн төгсөгч Ни Шэньюань багшийн орчуулга гэдэг нь тодорхой, эх зохиол нь хэний ямар зохиол гэдгийг одоогоор нягтлах боломжгүй ч, цар тахлын дараа сайхан цаг ирэхүйд, эрхэм судлаачдаас Хятад улсад очиж нягтлан шинжлэх боломж гарах буй заа хэмээн найдна.

⁴⁹ Бээжингийн их сургуулийн профессор Ү Шинь-ин багшаас энэ зохиолын орчуулгын тухай лавлахад, өөрийн багш Чүлтэмийн удирдлагаар орчуулж хэвлүүлсэн орчуулга гэдгийг батлан хэлсэн юм. Энэ зохиолын уг нэр болох “Чемодантай юм” нэрийг нь хятад уншигчдад ойлгомжтой болгох үүднээс ‘Сорилго шалгалт’ гэх утгатай хятад нэртэй болгож өөрчилсөн гэдгээ дурсав.

⁵⁰ Дээрхтэй мөн адил

илүү лавшруулан намтар судлалын судалгаа хийх хэрэгтэй юм. Өвөр Монголын Их сургуулийн профессор Чэнь Найшюн (陈乃雄), Түлигөн (Дөлгөөн) (卜·图力更), Дов (道布), Бээжингийн Их сургуулийн профессор Шы Шичөн (史习成), Ни Шэньюань (倪申源), Чүлтэм (楚勒特木), Ү Шинь-ин (吴新英), Өвөр Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн Сээдорж (色道尔吉), Анькөчиньфү (Анчинхүү) (安柯钦夫), Номин (诺敏) Норбу (Норов) (诺尔布) зэрэг монгол хэлний судлалд бие сэтгэлээ зориулсан Хятадын хүндтэй судлаач багш, орчуулагч нар байхаас гадна Хятад улсын шинэ үеийн шүлгийн 3 их багшийн нэг, онолч Зөү Жян (邹绛) хүртэл монголын уран зохиолоос 1960-аад онд орчуулж байв. Түүний намтарт “Сүхбаатарын дуу”-г орчуулсан гэж оржээ. Зөү Жян болон Улаанхан (乌兰汗) нар бас орос хэлнээс орчуулсан байх магадлал өндөр юм. Дарамсэнгээ хэмээх Цао Ду болон Сун Линь гэх Цао Ду гэсэн хоёр ижил нэрт монгол үндэстний орчуулагч (曹都) нар байжээ. Энд нэр нь гарч буй нь аль нь болохыг тодруулах хэрэгтэй юм.

Монголын шинэ уран зохиолыг орчуулсан байдлыг хятадын зарим судлаач цаг хугацаагаар үечлэн авч үзэх гэж оролдсон зүйл мэр сэр байдаг ч, орчуулгын байдлыг үзэх юм бол 1953-1963 он хүртэлх 10 жилийн хугацаанд маш эрчтэй орчуулгын ажил өрнөн хөгжсөн байна. Гагцхүү “соёлын хувьсгал”-ын нөлөөгөөр урлаг соёлын харилцаа манай хоёр орны хувьд тасарсан гэдэг ч, үүнээс илүү ЗХУ-ын Хятадтай байгуулсан харилцаандаа 1960-аад оноос эхлүүлсэн хөндий харилцаа нь БНХАУ, ЗХУ-ын харилцаа төдийгүй БНМАУ, БНХАУ-ын харилцаанд гүнзгий нөлөөгөө тусгажээ. Үүнээс хойш монголын уран зохиолыг дорвитой орчуулсан байдал өнөө хэр ажиглагдахгүй байна гэж үзэхээр байна. 1980-аад оноос уран зохиолын орчуулгыг хийж эхэлсэн ч, хэдэн жилд ганц хоёр уран зохиол орчуулж байгааг орчуулгын хөгжил гэхэд хэцүү, зарим зохиолыг орчуулсан ч, зохиолын нэг хоёр бүлгийг орчуулсан байх юм. Ийм нөхцөлд орчуулгын хөгжлийг үе шатлан ангилахад одоогоор эртдэх мэт.

БНХАУ-д монгол уран зохиолын орчуулга хийх үйл явц нь хоёр чиглэлээр өрнөж байгаа хандлагыг харин онцлууштай. Нэг нь Монгол улсын зохиолчдын зохиолыг хоёр орны соёлын харилцааны нэг чиглэл болгож орчуулж байгаа бол нөгөө нь Өвөр Монголын зохиолчдын монгол хэлээр туурвисан зохиолыг хятад хэлд орчуулж байгаа чиглэл бөгөөд үүнийг цөөнх үндэстний уран зохиолын орчуулга гэж үздэг. Үүний нэг жишээ нь Ц.Цолмон, Дорнотэнгэр, Хайрхан, Дулаан, Саранцэцэг, Л.Чулуунбаатар, М.Цэдэнбал, Р.Цэцэнцогт нарын яруу найргаас түүвэрлэн орчуулж гаргасан “Уулсаа даган нүүхүйд” орчуулгын түүвэр бол Өвөр Монголын шилдэг яруу найргийн орчуулга болно. Энэ бол Монголын уран зохиолын шилдэг бүтээлийн орчуулга, хэвлэлийн төсөл-4-т багтсан 8 номын нэг юм. Чингэхээр цуврал орчуулгын цөөнгүй төсөл хэрэгжиж байгаа нь тодорхой байна.

Хятад улсын Үндэсний хэлний орчуулгын товчооны орчуулагч Хасан Ордосын Аянгын “Манба дацан”, “Тэнгэрт өргөст тор байдаггүй” үргэлжилсэн үгийн зохиол орчуулснаас гадна яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн 60 шүлгийг сонгон авч хятад хэлнээ орчуулж, 2008 онд анх хэвлүүлсэн байна. Улмаар 2020 онд дахин нэмж 100 шүлэгтэйгээр “Сонгомол шүлгийн түүвэр” хэвлүүлжээ. Өвөр Монголын Орчуулагчдын нийгэмлэгээс 2011 оноос эхлэн өнөөг хүртэл 5, 5 жилийн төлөвлөгөөтэйгээр монгол уран зохиолыг хятад хэлнээ орчуулан хэвлэх ажлыг шат дараатай цогц байдлаар хийж байна. Эхний таван жилд 21 роман, 44 тууж, 72 өгүүллэг, 36 найруулал, 18 яруу найрагчийн 317 шүлгийг хятад хэлд орчуулсан бол хоёрдугаар таван жилд нийт 10 боть 547 бүтээлийг орчуулан⁵¹ тархаажээ. Энэхүү бүтээлч ажлаар монгол уран зохиолыг олон сая уншигчтай хятадын зах зээлд толилуулснаас гадна, хятад хэлээр дамжуулан, гадаадын

⁵¹ 内蒙古翻译家协会：精心打造品牌工程 推进翻译事业发展
http://www.imflac.org.cn/zx_sheyling/2908.html

уншигчдад хүрэх боломжийг олгож, Хятад улсын дотоодын шагналт бүтээл олноор гарч байгаагаас гадна, гадаадын уншигч, орчуулагчдын анхаарлыг татан, эхнээсээ англи зэрэг гадаад хэлэнд орчуулагдаж эхэлсэн⁵² байна.

Манай улсад хятадын орчин үеийн уран зохиолыг орчуулан нийтлэх ажил сүүлийн жилүүдэд “Бүс ба Зам” санаачилгын хүрээнд хятадын талын идэвхтэй дэмжлэгтэйгээр өрнөж, орчуулгын олон ном хэвлэгдэн гарсан юм. Үүнтэй харьцуулахад монгол уран зохиол хятад хэлээр орчуулах ажил тэнцвэргүй цөөн байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. 2022 онд МУИС-д Б.Гэгээнхүү “Монголын орчин үеийн уран зохиол БНХАУ-ын уншигчдын хүртээл болсныг шинжлэх нь” (1990-2010) сэдвээр магистрын зэрэг хамгаалав. Түүний үзсэнээр дурдсан хугацаанд хоёрхон шүлгийн түүвэр гарсан⁵³ гэжээ. Энэ талд хоёр орны соёлын болон орчуулгын салбарынхан хүчин зүтгэж, ялангуяа Монголын уран зохиолын орчуулгаар дамжуулан өөрийн орны соёлыг гадагшаа дэлгэрүүлэх явдал чухал болохыг энд цохон тэмдэглэсү.

Энэхүү өгүүлэлд монгол уран зохиолыг хятад хэлнээ орчуулагдсан байдлыг бүртгэн, нэгтгэхийг хичээлээ. Энд ороогүй монгол уран зохиолын хятад орчуулгын зохиол байх нь мэдээж бөгөөд цаашид энэ бүртгэл улам баяжин нэмэгдэх буй заа.

Дүгнэлт

1. Монголчуудын уран зохиолоос хятад хэлнээ Хүннүгийн үеэс орчуулж эхэлсэн гэж үзэх үндэслэл бий.
2. Монголын нууц товчооны хятад орчуулга бол монгол уран зохиолын орчуулгын дундад зууны үеийн төлөөлөл болно.
3. БНХАУ байгуулагдсанаас хойш Монголын шинэ үеийн уран зохиолоос идэвхтэй орчуулж байсан нь Монголд хятадын уран зохиолыг олноор орчуулж байсан үетэй давхцаж байсны дээр монгол уран зохиолыг хятад хэлэнд орчуулан түгээж байсан оргил үе байжээ.
4. XX, XXI зуунд монголын уран зохиолыг хятад хэлнээ орчуулах явдал тасраагүй үргэлжилж байна.

Abstract: The process of translating mongolian literature into chinese probably began even in Huns'(Xiongnu)s time. During the Yuan Dynasty, translation work was actively carried out, and a translation committee was established. One of the clear examples of Mongolian literature being translated into Chinese is the Chinese translation of the Secret History of Mongols. In modern time the New Mongolian literature was translated into Chinese since the middle of 20th century. The translation works continue in the 21st century, the translation work of Mongolian literature has been relatively active in recent years within the framework of the policy of supporting the translation of mongolian literature (it means literature of minority ethnic groups) in Inner Mongolia.

⁵² "Манба дацан" роман нь "Үндэсний (Хятад улсын) 100 шилдэг номын үндэсний 3-р каталог"-д сонгогдсон бөгөөд энэхүү романы хятад хэлний орчуулгын хувилбарыг Чунчиний хэвлэлийн групп хэвлэжээ. Мөн үүнийг Жим Вилтон англи хэлнээ хөрвүүлж, Британийн Аврора Пресст хэвлүүлсэн нь уншигчдын таашаалд хүрсэн зохиол болсон гэжээ.

⁵³ Б.Гэгээнхүү “Монголын орчин үеийн уран зохиол БНХАУ-ын уншигчдын хүртээл болсныг шинжлэх нь” (1990-2010), Хэл бичгийн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ШУС, ХУС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим, 67-р тал.

Номзүй

Монгол хэлээр:

- 1952-1962 онд орчуулагдсан Хятад өгүүллэгийн түүвэр, I, II боть, Улаанбаатар, 2019.
- Гэгээнхүү.Б “Монголын орчин үеийн уран зохиол БНХАУ-ын уншигчдын хүртээл болсныг шинжлэх нь” (1990-2010), Хэл бичгийн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, МУИС, ШУС, ХУС, Утга зохиол, урлаг судлалын тэнхим.
- Маналжав Лувсанвандангийн, “Монголын нууц товчоон” анх ямар бичгээр байсан тухай асуудалд, “МНТ”-ны хэлний судалгаа”, Улаанбаатар, 2017 он.
- Эгшиг Таргуд Шагдарсүрэнгийн, Хятадын сонгодог зохиолын орчуулга, хэлний онцлог, Боловсролын докторын зэрэг горилсон зохиол, Улаанбаатар, 2000 он.
- Эгшиг.Ш *Хятад хэлээр уламжилсан зарим монгол шүлгийн орчуулга*, Орчуулах эрдэм (3), Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, Улаанбаатар, 2011.05 сар, 148-167-р тал.

Англи хэлээр:

- Bu He, Ch.2. The development of cultural relations between the MPR and PRC in the early stage (1949-1953), In the name of proletarian internationalism: Cultural Relations between the Mongolian People's Republic and the People's Republic of China (1949-1967), Dissertation for the degree of Ph.D, Ulaanbaatar, 2022, p.51 (давхар эшилбэл, ГХТА, Ф-5, Д-2, ХН-87, тал.62)
- Jeong Su-il, *Steppe Road, The heart of northern eurasian nomadic civilization*, Гадаад хэл, соёл судлал, 2019, No.507(23) 7-11-р тал.
- Halliday, M.A.K. 1959 “The language of the Chinese ‘Secret History of the Mongols’”. Philological society publication: 17, 1959.

Хятад хэлээр:

- 王萌, 蒙古国现代文学中译本中存在的问题----以产篇小说《清澈的塔米尔河》为例, 内蒙古师范大学学报(哲学社会科学版) 2010 年 1 月第 39 卷第一期 (Journal of Inner Mongolia Normal University (Philosophy & Social Science), Jan.2010, Vol.39 No.1.

Цахим эх сурвалж:

- 内蒙古翻译家协会: 精心打造品牌工程 推进翻译事业发展
http://www.imflac.org.cn/zx_sheyang/2908.html

中蒙经典著作互译 60 余载重要成果一览

<https://www.cctss.org/article/headlines/5648>



ОРЧУУЛГЫН ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА БЭЛТГЭЖ СУРГАЛТАД ХЭРЭГЛЭХ АСУУДАЛД

Н. Амаржаргал⁵⁴

Abstract: Translation textbooks and manuals development is important not only for training professional translators and interpreters, but also for enhancing the effectiveness of foreign language teaching. Universities and researchers have developed and used a large number of translation textbooks and manuals as part of their professional translator training activities. This process demonstrates that the study of translation materials and aids plays an important role in the development of translation studies. In the framework of this article, we have studied the design of translation teaching materials on the example of handbook named “Translation techniques 1”, “Translation techniques 2” developed by ourselves. As the basis for explaining the design of these 2 handbooks, several theoretical works on translation studies have been studied.

Түлхүүр үг: Орчуулгын гарын авлагын зохиомж, хэрэглэгдэхүүн сонгох зарчим, гарын авлагын шаардлага, дасгал даалгавар

Сэдвийн үндэслэл

Орчуулгын сурах бичиг, гарын авлагыг чанартай бэлтгэх нь мэргэжлийн орчуулагч, хэлмэрч бэлтгэхэд төдийгүй гадаад хэлний сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байдаг. Манай оронд 1990 оноос хойш гадаад хэлний мэргэжлийн орчуулагч бэлтгэдэг ангиуд Монгол улсын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн их дээд сургуулиудад олноор нээгдэж даруй 30 гаруй жил өнгөрчээ. Энэ хугацаанд их дээд сургуулиуд мэргэжлийн орчуулагч бэлтгэх сургалтын үйл ажиллагааныхаа хүрээнд орчуулгын сурах бичиг, гарын авлага чамгүй олныг бэлтгэн хэрэглэж иржээ. Тухайлбал эрдэмтэн А. Шархүү “Туурвилзүй, орчуулга судлалын зарим асуудал”, О. Адьяа “Орчуулга: онол, туршлага, сургамж”, Л. Чулуунбаатар “Орчуулга болон бас бус зүйлийн тухай өгүүлүүд” зэрэг орчуулгын онол, дадлагаар хийсэн эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Ц. Базаррагчаа “Монгол Хятад хэлний орчуулга зүй” /Онол, дадлага/, Ц. Отгонсүрэн “Орчуулгад суралцах бичиг” /Монгол-Англи/, Д. Нармандах “Орчуулгын онол, дадлага, дасгал” /Монгол-Солонгос, Солонгос-Монгол/, Чвэ Жон Хва “Хэлмэрчлэх орчуулах үндэс” /М. Амартайваны орчуулгаар/ зэрэг бүтээл хэвлэгджээ. Бид энэ үйл явцад өөрсдийн хувь нэмрийг оруулахыг зорин “Орчуулах аргачлал 1”, “Орчуулах аргачлал 2”, “Орчуулах аргачлал 3” гарын авлага боловсруулан англи хэлний орчуулагч, багш, олон улсын харилцааны бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн Англи хэлний орчуулга хичээлд хэрэглэж байна. Эдгээрийг мэргэжлийн ангийн багш, оюутнууд сургалтын хэрэглэгдэхүүн болгон хэрэглэхийн зэрэгцээ эрдэмтэн судлаачид судалгааны эх сурвалж болгон ашиглаж байна. Мөн гадаад хэл сурч буй хүмүүст ч ашиг тусаа өгч байгааг тэмдэглүүштэй байна. Энэ үйл явц

⁵⁴ Дэд проф., доктор, МУИС, Эрдэнэт салбар сургууль, Хүмүүнлэгийн ухааны тэнхим

орчуулгын хэрэглэгдэхүүний судалгаа орчуулгазүйн хөгжилд чухал үүрэгтэй⁵⁵ болохыг харуулж байна. Гагцхүү орчуулгын сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулж их дээд сургуулийн сургалтын практикт хэрэглэж байгаа байдлыг хэл тус бүрээр нь авч үзвэл хангалттай сайн биш байна гэж үзэж болохоор байна. Иймд орчуулгын сургалтын хэрэглэгдэхүүний зохиомжийн асуудлыг судлах нь орчуулгын сурах бичиг, гарын авлага олширч, чанар, үр өгөөж нь дээшлэхэд чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Сэдвийн судлагдсан байдал

Орчуулгын хэрэглэгдэхүүний судалгаа орчуулгазүйд чухал байр суурь эзэлсээр ирсэн болох нь судалгаанаас харагддаг. Тухайлбал, энэ нь Жеймс Холмс /1988/, Жидён Түри /1995/ нарын орчуулгазүйн судлахууны бүтцийн зургаас тодорхой харагддаг. Жеймс Холмс орчуулгазүйг цэвэр орчуулгын судалгаа ба хэрэглээний судалгаа гэж хоёр ангилан, цэвэр орчуулгын судалгааг онолын ба тайлбар, хэрэглээний судалгааг орчуулагчийг бэлтгэх сургалт, орчуулгын хэрэглэгдэхүүний судалгаа, орчуулгын шүүмж судлал гэж авч үзжээ. Улмаар онолын орчуулгазүйн судалгаанд орчуулгын ерөнхий болон хэсэгчилсэн асуудлыг хамааруулсан байна. Харин тайлбар орчуулгазүйн судалгаанд бүтээгдэхүүн, үйл явц, үүрэгт чиглэсэн асуудлыг хамааруулсан. Жеймс Холмсын боловсруулсан орчуулгазүйн судлахууны бүтцийн зураг дахь орчуулгазүйн салбаруудын хоорондын холбоог Жидён Түри тодруулан улам нарийвчилсан. Түүний үзэж байгаагаар орчуулгын бүтээгдэхүүн, үйл явц болоод үүрэгт чиглэсэн тайлбар судалгаанууд нь орчуулагч бэлтгэх, орчуулгын хэрэглэгдэхүүн, орчуулгын шүүмжийн судалгаа зэрэг орчуулгазүйн хэрэглээний салбар бүрт нөлөөлдөг байна. Мөн орчуулгын онолын судалгаа нь орчуулагч бэлтгэх судалгаанд нөлөөлж, түүгээр дамжуулан орчуулгын хэрэглэгдэхүүний судалгаа болон орчуулгын шүүмж судлалд нөлөөлдөг болох нь Жидён Түригийн боловсруулсан орчуулгазүйн судлахууны бүтцийн зургаас харагдаж байна. (Ж. Түри. 1995:1-14)

Судлаач Соня Колина орчуулгын онолын болон тайлбар орчуулгазүйн судалгаанд суурилан орчуулга заах арга зүйг орчуулгазүйн дэд салбар болгон хөгжүүлэх нь зүйтэй юм гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Тэр “Орчуулга заах нь: Судалгаанаас танхимын хичээл хүртэл” хэмээх бүтээлдээ орчуулгазүйн судалгааны онолын үндэслэл, орчуулгын курс хичээл, сургалтын хэрэглэгдэхүүн зохиомжлох асуудал, орчуулгын үнэлгээ, алдааны шинжилгээ зэрэг орчуулга заах арга зүй, орчуулгын сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах асуудлыг цогцоор нь авч үзсэн байна. “Судалгааны суурьгүй мэргэжлийн орчуулагчийг үйл ажиллагаандаа онолын болон тайлбарлах судалгааны үр дүнг уялдаа холбоотой, үр дүнтэй хэрэглэнэ гэж хүлээх нь бодитой бус зүйл гэдэгт итгэдэг” хэмээгээд судалгааны үр дүнг ашигтай хичээлийн хэрэглэгдэхүүн юм уу, аргачлал болгон хувиргах нь тодорхой цаг хугацаа төдийгүй зарим мэргэжлийн орчуулагч юм уу, багшийн эзэмшээгүй ч байж болох тусгай сургалт шаарддаг гэж үзжээ. (С.Колина, 2003:5) Улмаар тэрээр орчуулгын дасгал даалгаврыг цаг хугацааны хувьд дараахь байдлаар ангилсан байна. Үүнд: 1. Орчуулгын өмнөх дасгал 2. Уншиж ойлгох хэсэг 3. Орчуулгын хэл судлах хэсэг 4. Орчуулгын дараах дасгал зэрэг болно. (С. Колина, 2003:81) Сургалтын гарын авлагыг боловсруулахад дасгал даалгаврыг зохиомжлох, сонгох, оновчтой дараалуулах асуудал чухалд тооцогддог тул судлаач Соня Колинагийн судалгаа ач холбогдолтой байна.

Их дээд сургуулийн сурах бичиг, сургалтын гарын авлагын судалгаанд түүний агуулга, арга зүй, зохиомж, хэрэглээний судалгаа зэрэг олон асуудал ордог. Эрдэмтэн Н.Цэдэвсүрэн “Сурах бичгийн онол арга зүйн зарим асуудал” номдоо сурах бичгийн шинэчлэл, аргазүйн асуудал, агуулга хэрхэн сонгох, сурах бичгийн материалын дидактик боловсруулалт, сурах

⁵⁵ Дэд профессор доктор, МУИС, Эрдэнэт салбар сургууль, Хүмүүнлэгийн ухааны тэнхим

бичгийн дизайны асуудлын талаар өгүүлсэн байна. Эрдэмтэн Ж.Даваа, Г.Сарантуяа нар “Дээд сургуулийн сургалтын технологи” номдоо сурах бичгийн үүрэг, бүтэц, бүрдэл хэсгүүд, сурах бичгийн бүтцэд тавигдах дидактик шаардлага, сурах бичгийн бүрэлдэхүүн тус бүрийн үүрэг, сурах бичгийг хэрхэн бичих дараалал зэргийг авч үзсэн. Сурах бичигт сургалтын агуулгыг бүрэн илэрхийлж чадахуйц, мөн судлагдахууны дэс дарааллыг нарийн баримтлан бичигдсэн байх шаардлага тавьсан. Судлаач Ж.Даваа, Г.Сарантуяа нар “Сурах бичгийн агуулгын бүтэц нь бүлэг, дэд бүлэг, зүйл, дэд сэдэв гэсэн хэсгээс бүрдэнэ. Бүлэг, дэд бүлэг, зүйл нь сурах бичгийн агуулгыг бүхэлд нь мөн тойм байдлаар илэрхийлсэн байна. Бүлгийн бүхэллэг байдал нь агуулгыг тодорхой уялдаатайгаар илэрхийлэх, зохих мэдээллийг дамжуулахад чиглэсэн үндсэн эх сурвалжийг тайлбарласан, салбар мэдлэгүүдийн хоорондын уялдааг тодорхойлсон зэрэг хэв шинжтэй байна” гэж үзжээ. (Ж. Даваа, О. Сарантуяа, 2007:102)

Баримт бичгийн судалгаанаас орчуулгын хичээлийн гарын авлагыг сургалтын зорилгодоо нийцүүлэн боловсруулахдаа түүнд оруулах сэдэв сонгох, дасгал даалгаврыг зохиомжлох, оновчтой дараалуулах зэрэг асуудлыг хянамгай авч үзэх шаардлага байдаг болох нь ажиглагдлаа. Энэхүү судалгааны ажлын хүрээнд англи хэлний орчуулгын хичээлийн гарын авлага боловсруулахдаа зохиомжийн асуудлыг хэрхэн шийдвэрлэснээ тайлбарлахыг зорилоо.

1. Орчуулгын гарын авлагын зохиомжийн судалгаа

Их дээд сургуулийн орчуулгын хичээлийн гарын авлагыг боловсруулахдаа:

1. Сэдэв, үг хэллэг, дүрмийг тодорхой шалгуурын дагуу сонгох
2. Гарын авлага дахь бичвэр шаардлага хангасан байх
3. Дасгал даалгаврыг зохиомжилж, оновчтой дараалуулах зэрэг асуудлыг шийдвэрлэн “Багш, гадаад хэлний боловсрол (англи)” бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн хүрээнд Англи хэлний орчуулга 2 хичээлээр судалдаг “Орчуулга аргачлал 1”, “Орчуулах аргачлал 2” гарын авлагыг хэрхэн зохиомжилсноо тайлбарлая.

А. Хичээлийн материалыг судлаач Миллетийн санал болгосон дараахь шалгуураар сонгосон. Үүнд:

1. Сэдлийн хүчин зүйл: Суралцагчдын сурах сэдэл тэмүүллийг өрнүүлэх зорилгоор танин мэдэхүйн ач холбогдолтой сэдвүүд сонгон, уялдаа холбоо сайтай дасгал боловсруулж оруулсан.
2. Сонирхол: Сэдэв сонирхолтой байх нь суралцагчдад сурах хэрэгцээ бий болгож, улмаар дасгал боловсронгуй байх нь суралцагчид тухайн хичээлийн материалыг сайн эзэмшихэд дэмжлэг болох ач холбогдолтой гэж үзсэн.
3. Сэдэв: “Орчуулах аргачлал 1” гарын авлагад “Улс төр”, “Бизнес”, “Орчуулах аргачлал 2” гарын авлагад “Хууль”, “Эдийн засаг” зэрэг нийгэм улс төрийн зохиол бүтээлийн орчуулгын сэдвийг сонгож оруулсан. Эдгээр сэдвүүд Англи хэлний орчуулга 1, 2 хичээлийн хөтөлбөрт тусгагдсан байдаг нь сэдэв сонгох нөхцөлийг бүрдүүлсэн.
4. Бичвэр ойлгомжтой байх чанарыг хангахын тулд гарын авлагад суралцагчдын тухайн шатны мэдлэг, чадварт тохирох түвшний бичвэрүүдийг сонгосон.
5. Үгийн сангийн болон дүрмийн материал дөхөмтэй байх чанар. Улс төр, бизнес, хууль, эдийн засгийн нэр томьёо 2 гарын авлагын үгийн санг бүрдүүлсэн. /Миллет.М, 1988/

Б. Сургалтын бичвэрт тавигдах шаардлага хангасан байдал

Энэхүү гарын авлагад зохиомжлон оруулсан бичвэрүүд нь сургалтын бичвэрт тавигдах:

1. Хүмүүжүүлэх үр нөлөө
2. Танин мэдэхүйн ач холбогдолтой байх
3. Суралцагчдын сэтгэхүйг хөгжүүлэх

4. Суралцагчдын үгийн сангийн нөөцийг хөгжүүлэхүйц байх
5. Дүрмийн мэдлэгийг бататгахад тодорхой үүрэг гүйцэтгэхүйц байх
6. Суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх зэрэг шаардлагыг хангасан.

В. Дасгал даалгавар, тайлбарын дараалал

Дээрх сургалтын гарын авлагад тавигдах шаардлага, шалгуураар гарын авлагын 1 хичээлийг боловсруулсныг хүснэгтээр танилцуулбал:

Хүснэгт 1. Гарын авлагын “Эдийн засаг: Татвар” сэдэвт дасгал, тайлбар сэлтийг дараалуулсан байдал

№	Бүтэц	Дасгал, тайлбар, хэсэг тус бүрийн агуулга
1	Сэдэв	“Эдийн засаг: Татвар”
2	Орчуулж сурах дүрмийн загвар	Ирээдүй цагт хувилсан үйл үгийн идэвхгүй хэвийг орчуулах
3	Үг хэллэг	Эдийн засаг, татвартай холбоотой түгээмэл хэрэглэгддэг үг хэллэг, нэр томъёо оруулсан.
4	“Харьцуул” гэсэн гарчиг бүхий хайрцаг	Энэ хэсэгт тусгайлан сонгож авсан англи өгүүлбэрийг түүний орчуулгатай загвар болгон оруулж, орчуулгын онцлогийг тайлбарласан.
5	Зарим үг хэллэгийн тайлбар	Ийм гарчигтай хэсэгт түлхүүр үгсийн олон утга, утга тус бүрийн жишээг оруулсан.
6	Үг хэллэг орчуулах дасгал	Идэвхтэй болон идэвхгүй хэвд хувилсан үйл үгсийг орчуулах дасгал оруулсан.
7	Өгүүлбэр орчуулах дасгал	Зарим үг хэллэгийн тайлбар хэсгийг судалсны үндсэн дээр өгүүлбэр орчуулах зорилготой. Өмнөх дасгалд орчуулсан үг хэллэг бүхий өгүүлбэр орчуулах дасгал оруулсан. Суралцагчид өмнөх 2 дасгалаар эзэмшсэн мэдлэгээ бататгана.
8	Тодорхой нэг үг орсон нийлцийн орчуулга судлах дасгал	Тодорхой нэг үгийн холбогдох үгтэй үүсгэсэн нийлцүүдийг /economic crisis, economic development гэх мэт/ тэдгээрийн орчуулгатай оруулсан тул суралцагчид тухайн үг англи хэлэнд ямар ямар нийлц үүсгэсэн болоод тэдгээрийг хэрхэн монгол хэлэнд орчуулсныг ажиглан тогтооно.
9	Өгүүлбэр орчуулах дасгал	Өмнөх дасгалд орчуулсан нийлц бүхий өгүүлбэр орчуулах дасгал оруулсан. Суралцагчид өмнөх 2 дасгалаар эзэмшсэн мэдлэгээ бататгана.
10	Орчуулах аргачлал	And холбоос үгийг орчуулах 4 тохиолдлыг түүний утга, хам сэдэв, өгүүлбэрт гүйцэтгэх үүргийн талаас тайлбарлан, жишээ бүрийг орчуулгын хамт оруулсан.
11	Үг сонголт:	Ийм гарчигтайгаар үгийн олон утгаас оновчтойг сонгох дасгал орууллаа. Энэ дасгалд англи өгүүлбэр тус бүрийн дор түлхүүр үгийн 2 утгыг оруулсан бөгөөд суралцагч оновчтой утгыг сонгон өгүүлбэрээ орчуулна.
12	Үгийн олон утга:	Энэ хэсэгт 1 үгийн олон утгыг ялгаж зөвийг сонгож сургах зорилготой англи өгүүлбэрийг түүний монгол орчуулгатай оруулсан. Зарим хичээлд энэ дасгалыг суралцагчаар өөрөөр нь орчуулуулахаар зохиомжилсон.
13	Аман орчуулгын дадлага А, Б	Энэ хэсэг аман орчуулгын дадлага хийлгэх зорилготой. Тус бүр нь 10 өгүүлбэр, түүний орчуулгаас бүрдэж байна. Суралцагчид хосоор ажиллан, харилцан бие биенээ дадлага хийлгэх, шалгах боломжтой.

Дээрхээс гадна толь бичигтэй ажиллах дасгал /суралцагч өгөгдсөн үгийг толь бичиг судлан орчуулж, үг хэллэг орчуулж сурахын зэрэгцээ толь бичигтэй ажиллах дадал чадвар эзэмшинэ/, ижил язгууртай үгийн орчуулга /нэг язгуур бүхий өөр өөр үгсийн аймагт хамаарах үгийг ялгаж орчуулж сурна/ зэрэг дасгал даалгавар, сэдэв тус бүрийн эцэст үг хэллэгийн жагсаалт оруулсан.

Энэхүү гарын авлагаар орчуулгын хичээл заах арга нь тайлбарлах, суралцагчаар өөрсдөөр нь мэдлэг бүтээлгэх болон ярилцлагын арга байна. “Орчуулах аргачлал 1”, “Орчуулах аргачлал 2” гарын авлага нь хоорондоо уялдаа холбоо сайтай, хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн, тодорхой зорилт бүхий дасгалуудаас бүрдэж байгаа бөгөөд бүгд нийлээд орчуулах аргад сургах дасгалын тогтолцоог бүрдүүлж байна.

Дүгнэлт

1. Орчуулгын сурах бичиг, гарын авлагын зохиомжийг сайжруулах, боловсронгуй болгох, тэдгээрийг орчуулгын сургалтын практикт хэрэглэх асуудлыг гүнзгийрүүлэн судалбал мэргэжилтэн бэлтгэх ажлын чанарт сайн нөлөө үзүүлэхээр байна.

2. Сурах бичгийн зохиомжийн судалгаанд дасгал даалгавар зохиомжлох, үг хэллэг, бичвэр сонгох, тэдгээрийг оновчтой дараалуулах явдал зүй ёсоор ордог бөгөөд орчуулгын гарын авлага, сурах бичигт үгийн олон утгаас бичвэрийн хам сэдвийг харгалзан оновчтойг сонгох, нэг үгийн бусад үгтэй үүсгэсэн олон нийлцийг орчуулах, ижил язгууртай өөр өөр үгсийн аймгийн үгийг орчуулах, толь бичигтэй ажиллах, эх зохиолын өгүүлбэрийг түүний орчуулгатай харьцуулан судлах, аман орчуулгын дадлага хийх, орчуулгын алдаанд шинжилгээ хийх зэрэг дасгал даалгаврын төрлүүдийг оруулбал зохино.

3. Орчуулгын гарын авлагын дасгал бүр зорилттой байх, хоорондоо уялдаа холбоо сайтай байх, өмнөх дасгал нь дараагийн дасгалыг амжилттай хийх суурь болохуйц байх, дараагийн дасгал нь өмнөх дасгалын бататгал болохуйц байх зэрэг нь суралцагчдад орчуулгын чадамж эзэмшүүлэх чухал нөхцөл болно гэж үзэж байна.

Номзүй

Монгол хэлээр:

Амаржаргал Н. (2015), *Орчуулах аргачлал 1*, УБ. МУИС Пресс Хэвлэлийн газар
Амаржаргал Н. (2016), *Орчуулах аргачлал 2*, УБ. МУИС Пресс Хэвлэлийн газар
Даваа Ж, Сарантуяа О, *Дээд сургуулийн сургалтын технологи*, (р. 102). УБ. Арт Софт.
Цэдэвсүрэн Н. (2007). Сурах бичгийн онол арга зүйн зарим асуудал, УБ. Соёмбо Принтинг

Гадаад хэлээр:

Миллет М., *Критерий отбора текстового материала для обучения чтению на русском языке студентов вузов*, Русский язык за рубежом, Москва. 1988
Колина С (2003). “Орчуулга заах нь: Судалгаанаас танхимын хичээл хүртэл”. МкГрау Хийл
Түри Ж. (1995). Тайлбар орчуулгазүй ба бусад. Бенжаминсийн орчуулгын номын сан
Холмс Ж. (1988). Орчуулгазүйн нэр ба мөн чанар. Амстердам



РЕАЛИ ҮГИЙГ БУУЛГАСАН АРГЫН ТУХАЙ

(Д. Нацагдоржийн зарим богино өгүүллэгийн орос, англи орчуулгын жишээн дээр)

Б.Батчимэг⁵⁶

Abstract: This paper aims to examine how foreign and domestic translators solve problems encountered in literary translation of realia, words or phrases which denote something that is specifically unique and local, that have no equivalents in other languages. For this purpose, Russian and English translation of nine short stories, out of many of works by D.Natsagdorj, one of the founders of Mongolia's contemporary literature, have been selected. By comparing the English, Russian translation of these stories, we examined the types of transformation used in translation of realia, accuracy of translation, distinction among translations by foreign and domestic authors. Main accentuation has been given to identifying more typical strategy of translating Mongolian realia into the above-mentioned languages. Accordingly, the study revealed that transcription, transliteration, description and substitution are the most frequent tools used to render the words and phrases denoting realia.

Key words: literary translation, transformation, realia, rendering, translation strategy

Оршил

Үндэстэн бүр тус тусын өвөрмөц соёл, ёс заншил, уламжлал, ахуй амьдралын хэв маяг, сүсэг бишрэлтэй.

Монголчууд шинэ чулуун зэвсгийн үеэс мал амьтан гаршуулан тэжээж, хоол хүнс, хувцас хэрэгсэл, нүүдэл, арилжаа, худалдаа гэх мэт бүх хэрэгцээгээ хангах амь зуулгын гол эх үүсвэр болгон хөгжүүлж иржээ. Жилийн дөрвөн улирлынхаа онцлогоос хамаарч хүйтэн үед эвэр, дулаан, зуны халуунд сэрүүн дэнж газар бууж, шим тэжээлт өвс ургамал сайтай, ус, хужир мараа бүхий бэлчээрийг сонгон малаа хариулан улмаар ашиг шимийг нь хүртэж амьдардаг монголчуудын хувьд нүүдэл аж төрөн, оршихуйн үндсэн хэв шинж нь болсон байна. Тиймээс ч монгол хэл аж төрөхүйн энэ өвөрмөц оршихуй соёлд холбогдох үгсийн арвин сантай аж. Жишээ нь: гэр, өрх, тооно, унь, хоймор, дээл, хөөрөг, тоорцог, хөхүүр, өрөм, эзгий, араг, аргал, хорхог, боодог, ерөөл, хөөмий, биелгээ, шагай харвах гэх мэт. Доктор, дэд профессор Ц.Нацагдорж “Нүүдлийн соёл иргэншлийн түүхээс” илтгэлдээ мал маллах, ахуй амьдралын ажлаа хамтран хийж хот айл, саахалт айл, нэг голынхон, саах тавих, мал оторлох, гүү барих, хонь хяргах, эсгий хийх, хурга ишиг хөнгөлөх, хурдан морины хүүхдийн гийнгоо, тоо зүйн холбогдол бүхий эх тоо, хүү тоо, төв хөвч (косинус), өлгүү хөвч (синус), өлгүү шахах хямцаа (тагенс), төв шахах хямцаа (котангес) зэрэг олон нэр томъёо уламжлагдан ирсэн тухай тэмдэглэсэн байна. Өнчирсөн, гологдсон төлийг эхэд нь авхуулахын тулд хонийг тойглох, ямааг чээглэх, үнээг өөвлөх, ингийг хөөсөлдөг талаар “малдаа дуу дуулж өгдөг, малаа дуу хөгжмөөр аргадан тайтгаруулдаг үндэстэн

⁵⁶ Ахлах багш, МУИС, ШУС, ГХТөв

дэлхий дээр нэг л байдаг нь Монголчууд...” гэж тайлбарлажээ. (Ш.Сүхбат, 2009:94) Харамсалтай нь өнөө үед монгол үндэснийхээ өвөрмөц соёлын онцлогтой ийм үг хэллэгийг ойлгодог, хэрэглэдэг хүн цөөрчээ.

Эх хэл, соёл, үндэсний дархлаагаа хамгаалах төр засгийн бодлого зохицуулалт сул, үндэсний онцлогтоо нийцэхгүй, харийн хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлснээс боловсролын тогтолцоо гажуудсан, эцэг эхчүүд хүүхдээ бага наснаас нь гадаад хэлний сургалттай цэцэрлэг, дунд, ахлах сургуульд сургах хандлага газар авсан, хүүхэд залуусын амралт чөлөөт цагаа өнгөрөөх орчин хязгаарлагдмал учир ихэнхдээ интернэт, телевизээр америк, солонгос, хятад, орос гэх мэт гадаадын кино, нэвтрүүлэг үздэг. Үндэсний телевизийн сувгууд нь бага насны хүүхдийн нас, хэл сэтгэхүйн онцлогт тохирсон нэвтрүүлэг бараг явуулдаггүй учир англи, америкийн хүүхдийн нэвтрүүлэг, хүүхэлдэйн киноны сувгаас өөр сонголтгүй. Өсвөр үе, хүүхэд, залуучуудын нас, сэтгэхүйн онцлогт тохирсон зохиол бүтээл ховор гэх мэт олон шууд болон дам шалтгаан, хүчин зүйлийн улмаас өнөө үед уламжлалт хэл соёлынхоо талаар мэдлэг тааруу, монгол хэлээрээ ярьж чаддаггүй, ойлгодоггүй бүтэн нэг үе өсөж өндийж байна гэхэд хэтрүүлэг болохгүй байх. “Даяаршлын нөлөөгөөр соёлын олон төрөл зүйл уламжлалт хэл соёлыг амьдралаас шахаж, оршин тогтнох орон зайгүй шахам болгож байна” хэмээн соёл судлалын ухааны доктор Б.Мөнхбадрал илтгэлдээ дурджээ. Мөн тэрээр “Европын соёл түрж дэлхийн соёлд нөлөөлж байгаа. Үүнд автаж үндэсний дүр төрхөө алдаж гээхгүйн тулд язгуур соёлоо эзэмшиж, түүх соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр дамжуулан үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна” хэмээн Монгол УИХ-ын 2020 оны 52-р тогтоолын 1-р хавсралтад заасныг илтгэлдээ дурджээ. Тогтоолд “олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон монголын түүх, хэл, соёл, ёс заншил, нүүдлийн соёл, иргэншил, шашин гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгох, дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлэх, гадаад нэр хүнд үнэлэмжийг дээшлүүлэх, хилийн чанад дахь монголчууд монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинө” хэмээн заасан байна. (Б.Мөнхбадрал “Монгол үндэсний соёлын дархлаа ба үндэсний нэгдмэл үнэт зүйл” илтгэл) Хэл соёл, уламжлалаа хадгалж үлдэх, хойч үедээ өвлүүлэх талаар төр засгийн түвшинд анхаарч бодлого шийдвэр авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай хэрэг. Мөн илтгэлд үндэсний өвөрмөц соёлоо харийнханд ойлгомжтой, хүртээмжтэй, жинхэнэ мөн чанараар нь хүргэж чадвал бидний соёлыг гайхан биширч, хүлээж авдаг тухай (хэдийгээр аялал жуулчлалтай холбож тайлбарласан) байсан нь энд хөндсөн асуудлаар судалгаа хийхэд түлхэц болсон юм. Монголын зохиолчдын бүтээлийг харь хэлнээ буулгах ажлыг эрчимжүүлбэл, түүний чанар чансааг сайжруулбал дэлхийн олон улс орны иргэд монголчуудын аж амьдрал, ахуй соёлын онцлогийн талаар мэдлэг мэдээлэлтэй болох, улмаар монголчуудын өвөрмөц соёлыг хамгаалахад бага боловч хувь нэмэр болох нь лавтай. Үүний учир юуны өмнө гадаад хэлээрх монголын уран зохиолын орчуулгад холбогдох эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, илтгэл, хэлэлцүүлгийн материалууд судаллаа. Хуучнаар ЗХУ-тай идэвхтэй харилцаатай байсан социализмын үед монголын зохиолчдын бүтээлийг орос хэлнээ идэвхтэй орчуулж байжээ гэж тоймлож болохоор байлаа. Тиймээс орос хэлнээ орчуулсан бүтээл сонгож тухайн зохиол дахь үндэсний өвөрмөц онцлогтой үгийг хэрхэн буулгасныг судлахаар зорив. Өнөө цагийн “даяаршлын хэл” хэмээн тооцогдох болсон англи хэлнээ монголын зохиолчдын бүтээлийг орчуулсан байдлыг судалж үзлээ. Гаднынхан орчуулсан нь ховор юм. Голдуу монголын орчуулагч, зохиолч нар орчуулсан байна. Сүүлийн үед АНУ-ын Нью Жерси мужийн Ратгерсийн Их Сургуулийн профессор, орчуулагч монгол судлаач, Саймон Уикхэм Смит монголын яруу найраг, зохиол бүтээлийг англи хэлнээ орчуулж байгаа ажээ. Эндээс гаднынхан монголын уран зохиолыг орчуулахдаа үндэсний онцлогтой үгийг хувиргалын ямар аргыг голчлон ашиглаж буулгасныг Д.Нацагдоржийн богино

өгүүллэгийн орос орчуулгын жишээгээр, Монгол орчуулагч нар хэрхэн буулгасныг мөн зохиолчийн англи орчуулгын жишээгээр харьцуулж үзлээ.

Мөн ажилд холбогдуулан үндэсний онцлогтой үгийн талаарх эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүд судалсан. Болгарын эрдэмтэн, орчуулагч Сергей Флорин, Сидор Влахов нар “үндэсний онцлогтой үг буюу реалийг зөвхөн тухайн улс үндэстэнд хамаатай, өөр улс оронд байдаггүй, ахуй амьдрал, соёл, нийгэм түүхэн хөгжилд хамаарах, юмс зүйлс, ухагдахуун, ойлголтыг тэмдэглэсэн үг” гэж тодорхойлсон байна. (С.Флорин С. Влахов, 1986:10–48). Тэд реалийг 1. газар зүй, ургамал амьтны төрөл зүйлийн нэр: цунами, киви, коала 2. угсаатны зүйн: шпaгeти, саун, кимоно, иглуу, банжо 3. улс төр нийгмийн: дум, большевик, самурай, фараон, лобби гэх мэтээр ангилжээ (С.Флорин С.Влахов, 1986:52). Реалийн талаар, Нидергаард-Ларсен, Питер Ньюмарк нар судалгаа хийсэн байна. Монгол хэлний реалийн талаар эрдэмтэн орчуулагч Д.Дашдаваа, Г.Аким, Р.Гүрбазар, Г.Томтогтох нар судалгаа хийж эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл хэвлүүлжээ.

Реалийг орчуулах аргын тухай орчуулгын онол, судалгааны бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл цөөнгүй байдаг. Монголын эрдэмтдээс орчуулагч Р.Гүрбазар “реалийг: 1.галиглах 2. хуулбарлах буюу үгчлэх 3. ойролцоо утгатай үгээр орлуулах 4. тайлбарлах аргаар орчуулна” гэсэн байна. (Р.Гүрбазар, 1996:111) Доктор профессор А.Шархүү: 1. галиглах 2. хуулбарлан буулгах 3. тайлбарлан буулгах 4. утга ойролцоо үгээр нөхөн орчуулах арга байдаг (А. Шархүү, 2005:15) гэжээ.

Реали үгийн англи, орос орчуулгад хийсэн ажиглалт

Энэхүү судалгааны хүрээнд өмнө дурдсанчлан их зохиолч Д.Нацагдоржийн зарим богино өгүүллэгийн англи, орос орчуулгад реали үгийг хэрхэн буулгасныг тодорхойлж, орчуулгад дүн шинжилгээ хийх зорилго тавьсан. Судалгааны хэрэглэгдэхүүнд Д.Нацагдорж, А.Дэлгэрмаа, Б.Дамдин, Г.Цэрэндорж нарын англи орчуулгыг, монголч эрдэмтэн Т.Бурдукова, А.Дамбаренчино нарын орос орчуулгыг ашиглав. Орчуулгыг ажиглахад реалийг галиглах, галиглах тайлбарлахыг хослуулах, ойролцоо үгээр буулгах, тайлбарлах, хуулбарлах аргаар буулгажээ. Жишээ нь: **“Шувуун саарал”** зохиолын (англи орчуулгыг Б.Дамба, орос орчуулгыг Т.Бурдукова) хоёр орчуулгад ихэнх реали үгийг ойролцоо үгээр буулгасан байна. Үүнд: “хэдэн залуус морь **тарлаж байна**” гэдгийг англиар “**horsemen racing across the plain**”, оросоор “увидеть юношей, весело **мчащихся**” гэж тус тус ойролцоо үгээр буулгасны англи орчуулга нь илүү оновчтой байна. Харин орос орчуулга дахь **“мчащихся”** гэдэг нь “хурдан, эрчээрээ давхих” гэсэн утгаараа ойролцоо гэж сонгосон бололтой. Мөн **“овооны дэргэд буун”** гэдгийг “**dashed to the winning post**”, **“спешился у финиша”** гэж буулгасныг ажиглавал эхэд “дэргэд буун” гэдгийг “яаран давхих” гэж өөрчилж буулгасан байна. **“...сүүмэлзэн сүүмэлзэн харагдах нь Сүнжидмаагийн нутаг”** гэх өгүүлбэрийг “**In the far distance he could glimpse a nomad camp. That was where Sunjidmaa lived**”, “...а то-едва- едва виднется вдали-это **кочевье**, где живет Сунжидма” гэх мэтээр ойролцоо утгатай үгээр буулгасан байна. “Зохиолч морины хурдан гэдгийг **“Шувуун саарал нь хазаар даран, хоногийн газрыг өдөрт хүрэхээр** тэмүүлэн хатирна, Хурдлан давхих нь нэн их, хараахан **нэг зуур эрэгцүүлэхийн зуур далд орон сураггүй болжээ**” гэж үлгэрт гардаг морьдтой адил хэтрүүлэл ашигласныг” (Д.Отгонсүрэн, 1984:30) **“to cover a distance of two days’ travel in one”**, **“за день покрыть расстояние двухдневного пути”** гэж буулгасан байна. Англи, орос орчуулгад Сүрэнхүү яарч явааг тодруулж буулгаснаар морины хурдныг тодруулсан өнгө аяс алдагдсан байна. **“Шувуун саарал”-г “Shuvuun Saaral”** хэмээн галиглан буулгаад түүнийгээ **“A Swift footed steed”** хэмээн уншигчид юун тухай өгүүлэх гэж байгааг илүү ойлгомжтой хүргэхийн тулд тайлбарлан буулгасан бололтой. Орос орчуулгад **“Шувуун саарал”-г “Быстрый буланный скакун”** хэмээн ойролцоо үгээр буулгасан байна. Англи орчуулгад **“айраг** найрын цаг

мэдэгдэвч” гэснийг “..it was the time of **airag** (fermented mare’s milk, favourite drink of Mongols) and feasting” гэж галиглах ба тайлбарлах аргыг хослуулсан бол, орос орчуулгад “чувствовалась пора **кумыса и пиров**” хэмээн ойролцоо утгатай үгээр буулгажээ. “**гэрээс гарч**” гэдгийг “stepped out of his **ger**” гэж галиглах аргаар буулгасан байна. Харин оросоор “вышел из **юрты**” гэж ойролцоо үгээр буулгасан байна.

“**Цагаан сар ба хар нулимс**” зохиолын хоёр орчуулгыг харьцуулахад (англи орчуулгыг Дэ.Нацагдорж, орос орчуулгыг Т.Бурдукова) англи орчуулгад реалийг галиглах ба тайлбарлах, ойролцоо үгээр буулгах аргыг түлхүү, цөөн тооны үгийг бусад аргаар буулгажээ. Орчуулагч Дэ.Нацагдорж галиглан буулгасан үгийг доор тайлбар зүүлттэй оруулсан нь уншигчдад илүү ойлгомжтой болжээ. Жишээ нь: “**банш хийж**” гэхийг “making **banshes**”, “**гэрээс гарч ирээд**” гэснийг “coming out of... **ger**”, “**шанзны аялгуу лугаа**” гэхийг “with the strains of a **shanz**”, “**банш буузыг**” **banshes and booses**, “**жангийн орос байшингийн цонхоор**” гэдгийг “through the window of....five-**jang** long house” гэх мэтээр орчуулсан байна. Орос орчуулгад “**шанзны аялгуу лугаа**” гэхийг “с младшей **шанзы**” хэмээн галиглан буулгасан байна. “**малчин ардын бүсгүй**” гэдгийг “the daughter of a herdsman” хэмээн ойролцоо үгээр “**цагаан сар**” гэдгийг “white month festival” хэмээн хуулбарлах ба ойролцоо утгатай үгийг хослуулан буулгасан байна. “**цагаан сарын шинийн нэгэн**” гэдгийг “the New Year”, “**новый год**”, “ногоон торгон дээл”-ийг “green silk gown”, “темно зеленый **халат**” гэж ойролцоо үгээр буулгасан байна. Энд дээлийг “халат” гэж буулгасан нь зөрүүтэй орчуулга болсон байна. “**арагт агуулж үүрэн**” гэснийг “into a basket and carrying”, “собрала.. в **корзинку**”, “**пүүсний хятадууд**”-г “Chinese **tradesmen**”, “**китайские купцы**” гэж ойролцоо үгээр буулгасан бол, харин “**цагаан ваадантай боов**” гэснийг “a bundle of cakes wrapped in white cloth”, “**завернутые в белую ткань праздничные подарки и угощение**” хэмээн аль аль хэлэнд тайлбарлах, ойролцоо утгатай үгээр буулгах аргыг хослуулсан байна. Орос орчуулгад “**баярын бэлэг амттан**” хэмээн ерөнхийлөн орчуулсан байна. Зохиолын орос орчуулгад галиглах аргаар буулгасан үг цөөн байна.

“**Үзэгдээгүй юм**” зохиолын англи орчуулгад (англи орчуулгыг Г.Цэрэндорж орос орчуулгыг Т.Бурдукова) реали үгийг галиглах ба тайлбарлах аргыг хослуулан буулгахыг орос орчуулгатай харьцуулахад түлхүү ашигласан байна. Жишээ нь: “**дээл, хоргой хамжаарыг**” гэснийг “**deel** with braiding around its edges”, “**алтан ганжир**” гэснийг “a large golden motif called a **ganjir**”, “**цам, жажар бүжиглэж**” гэснийг “to celebrate **Tsam jinkhar** , a religious holiday” гэх мэтээр галиглах тайлбарлахыг хослуулан орчуулсан. Зарим үгийн орчуулга нь хэт нуршуу тайлбартай болсон байна. Үүнд: “Тэдгээр хүмүүсийг дээрэмчин буюу зандалчин гэж хэлэлцэн хүүрнэж байхад зүүн айлын Гонгор **тайж** суулцаж байсан билээ. Энэ өгүүлбэрийг дараах байдлаар буулгажээ” гэснийг “While the family was talking about the three men who had led Bold away, an old man called Gongor was sitting listening. Gongor was a direct descendant of Chinggis Khaan. Before the revolution of 1921 in Mongolia, people who were related to Chinggis Khaan were called **Taij**. Often, they had servants who worked for them and helped them to pay of their debts” гэж орчуулжээ. Түүнчлэн “Хөх **даалимбан дээлийг** өмсөж, шар ногоон дурдан бүсийг ороосон бөгөөд **гээггүй**, орос эсгий малгайг хэлтгий тавьжээ” гэснийг “He was wearing a **traditional Mongolian costume called a deel, which was made of blue cotton**. Around his waist was a greenish yellow silk sash. **In those days, in Mongolia, many men had their hair in pigtails, but this young man had no pigtails**, he was wearing a trilby, tilted to one side” гэж галиглах тайлбарлах аргыг хослуулсан байна. Зохиолын орос орчуулгад реалийг орчуулсан тухай доктор Ч.Жаргалсайхан “үгийн утгыг эндүүрсэн, хэлний мэдлэг сайнгүйгээс үг хоорондын хэлзүйн холбоог анхааралгүй, хар таамгаар орчуулсны улмаас “жанжин манжин” гэсэн хам утгыг илтгэсэн холбоо үгийг “Генерал Манжин” гэж оноосон нэр болгон ташаарсан, мөн “зуурдын дэвсгэр” гэдэг үгийн цаад утгыг ойлгоогүй учир “зузаан дэвсгэр” гэсэн утгаар “тюфяк” гэж орчуулсан мөн “сүлд хийморь”-

г “төрийн сүлд” гэж эндүүрэн “герб народа”, “манжлага цамхагт өлгөсөн хонх” гэдгийг “суваргын энд тэндээс унжсан хонхны дуу” мэт болгож орчуулжээ” гэж тэмдэглэсэн байна.(Ч.Жаргалсайхан, 2011:189-190, 197)

“Хуучин хүү” зохиолын хоёр орчуулгад реали үгийг галиглах аргаар буулгасан байна. Жишээ нь: “Гавж Жамбал, зайсан Намжил” гэснийг “**Gavji Jambal...zaisan Namjil**”, “Гомбо хангай ороод ирсэн” гэснийг “**Gombo returned from his trip to Khangay**”, “хэсэг хусам олж идээд” гэснийг “**having been given... a hunk of khusam**”, “зүүн ховуу” гэдгийг “**eastern khoshuun**”, “гурав дөрвөн өртөө эргэн тойрон” гэдгийг “**passed within the confines of but three or four ortoo**” гэх мэтээр, орос орчуулгад мөн адил эдгээр үгийг галиглан буулгасан. Үүнд: “Гавж Жамбал... зайсан Намжил” гэснийг “Гавжи Жамбал... зайсан Намжил”, “Гомбо хангай ороод ирсэн” гэдгийг “Гомбо съездил на Хангай” гэх мэт. “эсгий гэрийг шарна” гэдгийг “печет войлочную юрту” хэмээн хуулбарлан буулгасан байна.

“Ламбугайн нулимс” зохиолын реали үгийн орчуулгыг хэрхэн буулгасныг харьцуулж үзвэл англи орчуулгад реали үгийг голчлон галиглаж, зүүлтээр тайлбарлах аргаар, харин орос орчуулгад галиглах ба тайлбарлахыг хослуулах аргаар буулгажээ. Жишээ нь: “винайн ёсыг сахисан” гэдгийг “**a master of the Vinaya**”, “Гандангийн наад хүр рүү”-г “**down the eastern terrace of Gandan**”, “ам хамрыг орхимжоороо бөглөн” гэснийг “**covering his mouth and nose with one end of his orkimzi**”, “Дуйнхорын аймаг дахь... ба хэдэн гүнгэрваатай бурхнаа” гэснийг “**in Duinker district with its framed statues of Buddhas**”, “нэгэнт Баруун Зууд одоод” гэснийг “**had flown back to the Western Zuu**”, “гавж болохын тулд бэлтгэсэн юмаа” гэснийг “**all the things he had prepared for the degree of Gabji**” Орос орчуулгад “винайн ёсыг сахисан” гэснийг “придерживался принципов виная (клерикальная дисциплина), “гэвш” гэдгийг “гэвш (ученая степень)” гэх мэтээр тайлбарын хамт галиглан буулгасан байна.

Мөн “Харанхуй хад”, “Хөдөө талын үзэсгэлэн” зохиолын англи, орос орчуулга, “Үүрийн жавар уурын чимээ”, “Соёлыг гайхав” зохиолын орос орчуулга дахь реали үгийг буулгасан аргыг харьцуулж үзэхэд мөн галиглах, тайлбарлах, ойролцоо үгээр буулгажээ.

Дүгнэлт

Эцэст нь дүгнэж үзэхэд, монгол, орос орчуулагч нарын орчуулгад галиглах, ойролцоо утгатай үгээр орчуулах арга голлож байгаагаас харахад үндэсний онцлогтой үг, реалийн орчуулгад “үгийн утгыг харгалзан, орчуулж байгаа хэлний боломжийн үгээр орлуулах” чиглэлийг баримталсан байна. “Гэхдээ бүрэн тохироо болдоггүй учир уг эхээс баахан холддог, бас утгын талаар баахан хэлбэлздэг” гэж орчуулагч Р.Гүрбазар тэмдэглэснийг анхаарах хэрэгтэй. (Р.Гүрбазар, 1996:112-113). Түүнчлэн реалийн орчуулгад галиглах арга түгээмэл ашигладаг талаар жишээ татан дурдаад, “дутагдалтай тал нь үгийн утга уншигчдад бодит утгаараа буухгүй гаж буруу үг олноор бий болгодог сөрөг талтай гэжээ. Хуулбарлах аргаар гадаад үг болгоныг буулгаад байвал үгчлэх орчуулга руу хэлбийдэг. Ингээд эцэст нь дээр дурдсан аргаар орчуулах боломжгүй үгийг тайлбарлах аргаар орчуулахаас өөр аргагүй” (Р.Гүрбазар, 1996:112-113) гэснийг, мөн бусад эрдэмтдийн судалгаа, дүгнэлтэд тулгуурлан дүгнэвэл, реали үгийг орчуулахдаа тухайн үгийн цаад утга, хам сэдэвт илэрхийлж байгаа утга, зохиогчийн уран сайхны дүрслэлийн арга, орчуулж байгаа хэл соёлын онцлог гэх мэт олон хүчин зүйлийг анхаарч байж буулгах нь зүйтэй ажээ. Харьцуулан судалсан хоёр орчуулгад галиглах арга, галиглан тайлбарлах, ойролцоо утгатай үгээр орлуулан буулгах аргыг голчлон ашигласан нь нөгөө талаар энэ судалгааны материал болгосон богино өгүүллэгүүд дахь реалийн төрөлтэй холбоотой байж болох юм. Энэ талаас нь дүгнэвэл хүн болон газар орны нэр, хувцас хэрэгсэл, цол хэргэм, шашны холбогдолтой үгийг голчлон галиглах, галиглах ба тайлбарлах аргыг хослуулан, нүүдэлчин ахуй амьдрал, ёс уламжлал, ахуйн эд хэрэгслийг нэрийг, ойролцоо утгатай үгээр орлуулан буулгажээ.

Зарим реали үгийн орчуулга ташаарсан байсан нь орчуулагч тухайн үгийн цаад утгыг ухаж ойлгоогүйгээс болсон байсан. Үүнээс улбаалаад дүгнэхэд үндэсний онцлог үг тухайн улс үндэстний түүх, соёл шашны өргөн утга агуулгатай байдаг учир энэ талын бүрэн дүүрэн мэдээлэл мэдлэгтэй болж байж оновчтой орчуулж буулгах боломж бүрддэг ажээ.

Ном зүй

Монгол хэлээр

- Гүрбазар Р. (1996), Орчуулгын онол дадлагын асуудал. УБ.
Жаргалсайхан Ч. Д. Нацагдоржийн зохиол бүтээл орос хэл дээр. УБ
Отгонсүрэн Д. (1984), Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог. УБ
Мөнхбадрал Б. (2021), Монгол үндэсний соёлын дархлаа ба үндэсний нэгдмэл үнэт зүйл. УБ
Цэвэл Я. (1966), Монгол хэлний товч тайлбар толь. УБ.
Шархүү А. (2005), Үндэсний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал. УБ
Сүхбат Ш. (2009), Монголчуудын сурган хүмүүжүүлэх өв уламжлал. УБ
Орчуулах эрдэм сэтгүүл (1990). №2, 3, УБ.
Монголын орчин үеийн үргэлжилсэн зохиолын эмхэтгэл (2005). УБ

Гадаад хэлээр

- Влахов С, Флорин С. (1986), Непереводимое в переводе. Moscow
Some modern Mongolian stories in Mongolian and English. УБ



МОНГОЛ ШҮЛГИЙН ХЭМЖЭЭ ХЭМНЭЛ, УНШИГДАХ “АЯЛГУУГ” ОРЧУУЛАХ НЬ

(Б.Явуухулангийн “Уулын оргил” шүлгийн англи орчуулгын жишээн дээр)

Д.Долгорсүрэн⁵⁷

Abstract: This paper will focus on the translation of Mongolian verses of poetry into English and its main features. The translation is an activity that aims at conveying the meaning or meanings of a given linguistic discourse from one language to another. We define translation in terms of the sameness of meaning across languages. One of the most significant features of the Mongolian verses is their alliteration and assonance and their “melodic” onomatopoeic rhythms or tones in their lines, word numbers, and whether or not they are stressed or unstressed in certain syllables. Overall, when we translate the alliteration of Mongolian verses into other languages, specifically into English, we write them expressing their meanings in the same letters that each last word in the lines has. The main aim of this article is to compare and do some analysis of a verse named “A mountain peak” by Yavuukhulan Begz, one of the best poets in Mongolia.

Keywords: Mongolian verses, the alliteration of Mongolian verses, Assonance, onomatopoeic rhythms and harmony,

Уянгын зохиолоос хамгийн төгс боловсорсон авианы байгууламж нь шүлэг тул шүлгийг орчуулах нь орчуулагчаас ихээхэн мэдлэг, чадвар, дадал шаарддаг. Шүлэг бол яруу хэлэгдэх, яруу сонсогдох урлаг агаад уянгын зохиол юм. Аливаа шүлэгт хэмнэл гэж байдаг. Хэмнэл бол дуу шүлэг зэргийн жигд айзам, хэм бүхий сэлгэл гэж Монгол хэлний их тайлбар тольд бичжээ. *Шүлэгт хүний сэтгэлийг хөдөлгөх чадал байдаг... Сэтгэлийг хөдөлгөх тэр чадлыг нь эрхбиш орчуулах хэрэгтэй. Шүлгийн үг өгүүлбэр ба хэв журмыг хэдийгээр нарийн нягт орчуулж чадавч энэ сэтгэлийг хөдөлгөх чадлыг орчуулж эс чадвал амьд морийг үхсэн мориор арилжсантай адил болно.* Тиймд монгол шүлгийг гадаад хүн тухайлбал англи хэл дээр уншихад уран сайхны талаар англи хүн англи шүлгээ уншсанаас доргүй байвал сая уг шүлгийн уран чадлыг орчуулж чадсан гэж болно.⁵⁸ Тэгэхийн тулд монгол шүлгийг аливаа гадаад хэл рүү орчуулахдаа шүлгийн хэмжээ, уншигдах аялгууг өөрөөр хэлбэл шүлгийн уран сайхан хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг хэвээр буулгахыг чухалчлах ёстой аж.

Аливаа шүлэг нь үргэлжилсэн зохиолоос мөрийн хэмжээ, холболт хоёроороо ялгардаг. Монгол шүлгийн түүхэн хөгжил хувьслаас харахад аль ч цаг үед толгой холбох ёс зонхилж байжээ. Тэгэхдээ шүлгийн мөрүүдийн эхлэлийг ижил, ойролцоо, эсрэг дуудлага, утгатай үе, үгээр холбож шүлгийн толгой холбоцыг хийдэг байна. Ингэж шүлгийн мөрүүдийн эхлэл хэсэг тодорхой зүй тогтолд орж холбогдсоноор шүлгийн мөрүүд бие биендээ ижилсэн уусаж, тэр

⁵⁷ МУИС-ийн ШУС-ийн багш, доктор (PhD)

⁵⁸ Ц.Дамдинсүрэн “Олег цэцний орчуулгын тайлбар”., Орчуулгазүй 2014, №03. х.146

хэмжээгээрээ адилхан хэмнэл үүсгэдэг байна. Адил хэмнэлд орсноор шүлгийн мөрүүд хоорондоо үе, өргөлтийн хувьд мөн адил болж жигдэрдэг ажээ.⁵⁹

Шүлэгт тогтсон хэмжээ буюу бадаг, шад, мөр, дүрслэх ур маяг гэж байдаг. Бадаг гэж холбоц хийгээд аялгын нэгэн хэмнэлд захирагдан, тодорхой утга төгссөн айзам буюу хэд хэдэн шадын нийлбэрийг хэлдэг. Шүлгийн мөрийг шад гэнэ. Шүлгийн шадыг бичигт тэмдэглэсэн хэвлэлийн горимыг мөр гэнэ. Уран дүрслэлийн ур маяг буюу дүрслэх ур маяг гэдэг нь уран зохиолын найруулгад дүрслэлийг уран яруу болгохын тулд үгийн утгыг шилжүүлэн хэрэглэхийг дүрслэх ур маяг хэлдэг. Үүнд: адилтгал, зүйрлэл, төлөөлөл, тойруулал, ихэсгэл, багасгал, ёгтлол, егөөдөл, амьшуулал, хүншүүлэл, хэтрүүлэл зэрэг арга орно. Эдгээр нь шүлгийн хэмжээ, уншигдах аялгуунд нөлөөлдөг. Шүлэгт холбоц үүсч, улмаар хэмнэл бий болсноор шүлгийн үндсэн шинж илэрч гарч ирдэг. Өөрөөр хэлбэл холбоц, хэм хэмнэл нь шүлгийг үргэлжилсэн үгийн зохиолоос ялгаж өгдөг. Тиймээс судлаач, зохиолч Ц.Дамдинсүрэн “Шүлэг бол үргэлжилсэн үгийн зохиолоос мөрийн хэмжээ, холбоц хоёроор ялгарна” гэж бичсэн байдаг.

Монгол шүлэгт хөг аялгуу чухал үүрэгтэй бөгөөд шүлгийн толгой холбоц Alliteration буюу Аллитераци бол монгол шүлгийн гол шинж юм. “Монгол шүлгийн гол онцлог бол толгой холбох явдал” гэж Оросын монгол судлаач А.Позднеев үзжээ. Мөн Чехийн монгол судлаач П.Попуха “Монгол шүлгийн гадаад гол шинж нь гэвэл толгой холбож ая нийлүүлэх явдал юм. Ийм шинж монгол шүлэглэлд эрт дээр үеэс тодорчээ.” гэж бичжээ. Мөн монголын зохиолч нар ч үүнтэй ижил дүгнэлт хийсэн байдаг, тухайлбал Л.Түдэв “Монгол шүлэг гэж хармагц эсвэл сонсмогц таних тэмдэг нь ‘толгой холбоц’ юм” гэсэн бол зохиолч, орчуулагч Н.Жамбалсүрэн “Монгол шүлгийн толгой холбох нь европ шүлгийн сүүл холбохтой адил юм” хэмээн бичсэн.

Монгол шүлэгт толгой холболтыг үе болоод үгээр хийдэг зарчимтай ажээ. Шүлгийн толгой холбоц хэмээх ойлголтыг шүлгийн онолын бүтээлүүдэд “Толгой холбоц гэдэг нь шүлгийн мөрийн эхний авиаг ижилсүүлэхийг хэлнэ... Толгой холболт тодорхой тоогоор айзамт мөрүүдийг аялгуулан зааглах үүрэгтэй.” хэмээн судлаач Д.Цэрэнсодном бүтээлдээ өгүүлсэн байдаг. Монгол шүлгийн толгой холбоцын тухай одоогийн байдлаар мэдэгдэж байгаа хамгийн эртний баримт бол “Мэргэд гарахын орон” (1740) гэдэг бүтээл ажээ. “Иргэн үгс сүүл даран хэлж, монгол үг толгой холбон өгүүлэх, төвд үсэг түргэн төдийг эрхэлж, манж үсэг тус тааруулан зохиочихуй” хэмээн В.Инжинаш “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” романы өмнөх “Товч толь”-доо бичсэн байдаг.

Эрт үеэс Монголын шүлэгч, яруу найрагчид шүлэг зохиолоо бичихдээ толгой холбохоос гадна хэмжээг нь буюу үгийн тоог нь журамлах, журамтай болгох тал дээр ихэд анхаарч иржээ. Ц.Дамдинсүрэн “Толгой холбох нь үргэлжилсэн зохиолд чимэг, шүлэгт тулгуур болно”, “Монголын одоо цагийн шүлгийг үзвэл толгой холбох, хэмжээ тохируулах хоёрыг үндэс болгодог. Бас мөр зэрэгцүүлэх гэдэг нэгэн чухал зүйл бий. Гэвч толгойг холбохгүй хэмжээг эрхэмлэх ба хэмжээг эрхэмлэхгүй толгой холбон зохиож болно. Аль алиныг нь хайхрахгүйгээр гагцхүү мөр зэрэгцүүлэх ёсыг баримтлан зохиож ч бас болох, хэрэв энэ гурвын алиныг нь ч хэрэглэхгүй шүлэг бичих юм бол ийм зохиолыг шүлэг гэж нэрийдэх баримтгүй болно”⁶⁰ гэжээ. Монгол шүлэгт үгийн тоо чухал байдаг. Шүлгийн мөр нь хоёроос долоо хүртэл ба түүнээс дээш үгтэй байна. Нэг мөрөнд 8-9, заримдаа түүнээс дээш үгтэй шүлэг бий боловч элбэг биш аж.

Толгой холбон шүлэглэх ёс эрт үеэс байсан бөгөөд европын ард түмнүүдийн үг яриа, шүлэг зохиолд ч мөн ажиглагддаг. Оросын судлаач, хэл шинжлэлч Виктор Жирмунский “Шүлгийн онол” бүтээлдээ манай эриний 700-1100 оны хооронд англосаксон, эртний исланд, эртний саксон,

⁵⁹ Г.Галбаяр “Монгол шүлгийн толгой холбох арга, түүний зүй тогтол: The Regularity of Alliteration of Mongolian Verse”, 96/2018. Tokyo University of Foreign Studies, Area and Culture Studies (96/2018)

⁶⁰ Ц.Дамдинсүрэн “Олег цэцний орчуулгын тайлбар”, Орчуулгазүй 2014, №03. х.150

эртний германы толгой холбоцтой шүлэг нь хөгжлийнхөө явцад аажмаар шүлгийн адаг холбоц буюу хөл холбоцтой болсон талаар бичсэн байдаг.

Орчуулагч орчуулгын ажлын эхний үе шатанд эх зохиолыг задлан шинжлэхдээ түүний хэмнэл, хөг аялга, зохиолчийн санаа бодлоо илэрхийлсэн арга барил, тэдгээрийн өөр хоорондын нягт хэлхээ холбоог тайлж ухаарахад анхаарах ёстой. Үүнийг орчуулгын онолд утга учрыг тайлах оньс буюу түлхүүр гэж нэрлэдэг. Тэдгээр үгийг өөр хэлээр орчуулах тохиолдолд юуны өмнө таарч тохирох үг хэллэгийг орчуулга хийж байгаа хэлний үгийн сангаас түүж, заримд нь зүүлт тайлбар хэрэглэн уншигчдын ой тойнд ортол ойлгуулахдаа үнэн зөв ухааруулах нь орчуулагчийн үүрэг, үндсэн зорилт бөгөөд энэ нь бэрхшээлтэй ч нэр хүндтэй, гавьяатай үйлс юм. Ийм орчуулга нь үндэстний утга соёлыг арвижуулан баяжуулж буй хэрэг төдийгүй, нийт хүн төрөлхтний соёлыг харилцан баяжуулж байгаа хэрэг юм.

Орчуулах явцад үгс хоорондоо хэрхэн тохирохыг зөв шийдвэрлэх нь орчуулгын судлалын зангилаа асуудлын нэг болдог. Үгийн сангийн тохироог бүрэн /оноолт/, бүрэн бус /заримдаг/ гэж ялган үзэж болно. Эх зохиолд гарч буй үг орчуулж байгаа хэлний үгтэй утга санаа, баримжаагаараа аль алинаа гүйцэд орлохуйц байвал бүрэн тохирч байна гэж үздэг. Ийм үгс аль ч хэлний үгийн сангийн цөөн хувийг эзэлдэг. Нэг хэлний нэг үгийг нөгөө хэлний хэд хэдэн үгээр орчуулах буюу оноох тохиолдол хамгийн түгээмэл үйл явц юм. Ямар ч хэлний үг олон салаа утгатай, тэгэхдээ нэг хэлний үгийн олон салаа утгын тогтолцоо нь нөгөө хэлний тийм тогтолцоотой тохирохгүй байж болохыг анхаарах хэрэгтэй.

Монгол шүлгийг гадаад хэл рүү орчуулахдаа зөвхөн үг, утгыг гаргах биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг нь орчуулах хэрэгтэй болдог. Урьд цагт монголчууд шүлгийг зүгээр уншихаар зохиодоггүй, харин аялан дуулах маягаар, ерөөл магтаал шиг аялгуулан хэлдэг байж. Орчин үеийн монгол шүлгийг авч үзвэл дээр дурдсанаар толгой холбох, хэмжээг тохируулах хоёрыг үндэс болгох болжээ. Монгол шүлгийн хэмжээ найруулгыг жишээ нь англи хэлэнд буулгахдаа үеийн тоо хэмжээ, шад тутам дахь үгийн өргөлттэй болон өргөлтгүй үеийн найруулга зохион байгуулалтыг шинжиж, түүний нь буулгадаг байна. Урт эгшгийн оронд өргөлт, богино эгшгийн оронд өргөлтгүй үеийг хэрэглэх гэх мэтээр шүлэг болгоход хэрэглэсэн хэмжээний зарчим журмыг хэвээр хадгалан англи хэлнээ буулган найруулж болно.

Өрнөдийн шүлэглэх арга маягаас суралцсан 20-р зууны монгол шүлгийн холбоцыг энэ үеийн гол төлөөлөгчид болох Д.Нацагдорж, Б.Явуухулан нарын шүлгээр төлөөлүүлэн авч үзэж болдог.

Яруу найрагч Бэгзийн Явуухулангийн “Уулын оргил” шүлгийг англи хэлнээ орчуулсан байдаг бөгөөд энэхүү шүлгийн орчуулгыг эхтэй нь харьцуулан авч үзье. Б.Явуухулан “Уулын оргил” шүлгээ дөрөв дөрвөн мөрөөр нь зэрэгцүүлэн бичсэн бөгөөд тэгэхдээ ‘ө’ эгшиг авиагаар эхэлсэн дуудагдах аялгуу ойролцоо үгсээр тууш холбоцоор толгой холбож шүлэглэсэн байна.

Монгол шүлэг гол төлөв толгой холбоцтой байдаг журмаар шүлгийн мөрүүдийг 6 гэсэн тэгш тооны үгсээр ижилсүүлэн, тодорхой холбоц, хэм хэмнэлээр холбож, бадаглах аргаар буюу дотоод хэмнэлээр нь эрэмбэлэх маягаар уг шүлгийг бичсэн байна. Харин үүнийг англи хэл рүү буулгахдаа шүлгийн хөлийг буюу сүүлийг /сүүлийн үсгийг ‘n’ үсгээр/ тууш холболтоор холбосон байна. Англи шүлэг ерөнхийдөө хөл буюу сүүл холбоцтой байдаг. Дээрх шүлгийг хүүрнэл шүлгийн маягаар орчуулсан бөгөөд англи хувилбарын мөрүүд үеийн хувьд жигд биш, Prose poem буюу хүүрнэл яруу найраг маягаар орчуулсан байна. Шүлгийн орчуулгыг зэрэгцүүлэн харья:



УУЛЫН ОРГИЛ

Өндөр уулын оргилд мацан мацан гарвал
Өөр нэгэн уулыг олж хардаг жамтай.
Өндөр уулын оргилыг нэгэн удаа давбал
Өөр нэгэн уулыг давах зам тодорхой.

Өвгөн буурлын сэтгэлд нэвтрэн нэвтрэн орвол
Өөр нэгэн ертөнцийг олж хардаг жамтай.
Өвгөн буурлын сэтгэлийг нэгэн удаа танивал
Өөр нэгэн ертөнцөд аялах зам тодорхой.

THE SUMMIT OF THE MOUNTAIN

When clambering up and up to the summit of the high mountain
It is reasonable to see another high mountain.
Once you've trekked over the peak of this high mountain
The way to cross over another mountain is certain.

When penetrating into the silvery old man's heart deeper and deeper
It is sanctioned to see another world.
Once you've got known the silvery old man's heart
The way to travel round another world is plain.

Дөрөв дөрвөн мөрөөс бүтсэн энэхүү шүлэг нь хоёр бадагтай бөгөөд “өндөр, өөр, өндөр, өөр; өвгөн, өөр, өвгөн, өөр” гэсэн үгсээр толгой холбон бичсэн нь монгол хүнд үнэхээр сонсголонтой санагдана. Харин англи хэл рүү үүнийг “when, it, once, the; when, it, once, the” гэж яг хэмжээ хэмнэлийг нь тааруулан, мөн боломжийн хирээр сүүл холбон орчуулсан нь үнэхээр чадварлаг болжээ. Зарим үгсийг зэрэгцүүлэн ажвал:

МОНГОЛ	АНГЛИ
Мацан мацан гарвал	Clambering up and up
Давбал	Trekked over
Давах	Cross over
Нэвтрэн нэвтрэн орвол	Penetrating into – to be understood or realized by sb. None of my advice seems to have penetrated his thick skull
Өвгөн буурал	Silvery old man – having the color of silver - мөнгөлөг
Олж хардаг жамтай	Sanctioned to see – to give permission for sth to take place
тодорхой	Plain – easy to see or understand, clear

Энэ шүлэг дэх “мацан мацан гарвал” гэснийг англи руу “up and up” гэж угтвар үгийг давтах байдлаар буулгасан нь үнэхээр дүйжээ. Эхний бадгийн “when clambering up and up” гэсэн нь 2-р бадгийн “when penetrating into” гэсэнтэй ижил харагдаж уншигдахуйц байгаа нь монгол шүлгийн толгой холбох ёсыг баримтлан англи хэл рүү буулгасан орчуулга болсон байна. Мөн “нэвтрэн нэвтрэн орвол” гэж үг давтсаныг англи хэлэнд penetrating into хэмээн нэг л үгээр энгийн буулгасан нь англи хэлэнд үгийг бус харин угтварыг давтдаг үг зүйн онцлогтой холбоотой бөгөөд илүү сонсголонтой болгодог онцлогийг харгалзсан нь сайшаалтай. Англи хэлтнүүд шүлэг

зохиохдоо хэлэх гэсэн уран санаагаа мөр мөрөөр нь бичих, мөрийн үг үеийн тоог тэнцүү байхаар тохируулах, шүлгийн мөрүүдийг ижил буюу төстэй дуудлагатай авиагаар эхэлж төгсгөлийг нь ижилсүүлэн холбодог.

-Шүлгийн нэрийг орчуулахдаа оновчтой нэр өгч, уран сайхны тодотголуудыг ашиглах хэрэгтэй байдаг. Монгол хэлний зарим үгсийн сангийн үгс англи хэлнийхтэй шууд таардаггүй учраас шууд утга дүйцүүлэн орчуулбал утгын алдаа гаргадаг гэж судлаачид үздэг. Мөн орчуулах боломжгүй үгс байдаг учраас гадаад хэл рүү монгол шүлгийг орчуулахдаа давхар тайлбар хийж, утга санааг тодотгоход анхаарах нь зүйтэй. Тухайлбал “Уулын оргил” шүлгийн нэрийг “The Summit of the mountain” гэжээ. “Summit” гэдэг үг “уулын орой, оргил” гэсэн утгатай байхад дахиад “уул” буюу “mountain” гэж давтах шаардлагагүй тул “A Mountain peak” гэж буулгавал англи хэлтэнд илүү ойлгомжтой байна.

Монгол шүлгийн толгой холбоц нь шүлгийг сайхан харагдуулах, хэмнэлтэй сонсогдуулах хэлбэр төдий зүйл бус харин бадгийг бүтээж буй мөрүүдийн үе болон үгийг жигд хэмнэлд тааруулж, яруу сайхан эгшиглэнтэй сонсогдуулдаг тул шүлгийн тогтолцоо, дотоод аялгуут мөн чанарын чухал бүрдэл нь ажээ. Монгол шүлгийг аливаа гадаад хэлнээ, ялангуяа англи хэлнээ орчуулан буулгахдаа монгол шүлгийн хэмжээ, уншигдах аялгуут өөрөөр хэлбэл шүлгийн уран сайхан хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг хэвээр буулгахыг чухалчилж, үгсийг тааруулан зөв орчуулахын тулд толгой холбоцыг сайтар ойлгох нь, мөн англи шүлгийн сүүл холбоцтой үе болон үгээр тааруулж, хэмнэл хэмжээг нь тохируулан гаргах нь эх шүлгийн яруу сайхан байдлыг хадгалж, илүү ойлгомжтой, илүү сонсголонтой болгодог байна.

Ном зүй

- Г.Галбаяр “Монгол шүлгийн толгой холбох арга, түүний зүй тогтол /The regularity of alliteration of Mongolian verse/”, Tokyo University of Foreign Studies, Area and Culture Studies 96 (2018)
- Ц.Дамдинсүрэн “Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай (“Олег сэцэний дуулал”-ын орчуулгын тайлбар)”, Шинэ Толь, №2 (14), Улаанбаатар, 1938
- Ц.Дамдинсүрэн “Олег сэцэний орчуулгын тайлбар”, Орчуулгазүй 2014, №03. х.146-150
- Н.Жамбалсүрэн “Монгол шүлэг”, Утга Зохиол, Урлаг, №8 Улаанбаатар, 1966
- Н.Оюун-Ундраа, Н.Оюунзаяа “Дуслын Хэлхээс /A String of Drops/ III”, Улаанбаатар, 2008
- В.Жирмунский “Теория стиха”, Советский писатель, 1975
- Д.Цэрэнсодном “Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал”, Улаанбаатар, 1977
- Б.Явуухулан “Түүвэр зохиол”, Улаанбаатар, 1985



МОНГОЛ ХЭЛНИЙ ДҮР БАЙДАЛ ЗААСАН ДҮРСЛЭХ ҮГИЙН УТГЫГ АНГЛИ ХЭЛЭНД ИЛЭРХИЙЛЭХ НЬ

С.Дугармаа⁶¹, А.Амарзаяа⁶², Б.Оюунсайхан⁶³

Abstract: The article aims to introduce a survey of Mongolian literary works that have been translated from Mongolian into English by both Mongolian and foreign translators. Iconopoeic (form-depicting) Words are a literary tool, as can be seen in the works of Mongolian writers. We have tried to show how iconopoeic (form-depicting) words in Mongolian, especially verbs, are expressed in English in the examples of Mongolian literary translations. Examples are taken from translations by our famous translators, and conclusion was made based on the translation examples. It has been observed that iconopoeic (form-depicting) words were translated using free translation in Mongolian literature, especially in Mongolian prose and also these words were often omitted in the context.

Түлхүүр үг: дүрслэх үг, үүсмэл үг, үгийн утга, богино өгүүлэг, орчуулга

Оршил

Дүр байдал заасан үгс нь үгийн сангийн утгаараа бодит байдлын харагдах дүрийг болон түүний тухай төсөөллийг заан нэрлэсэн шинжтэй байна. Дүр байдал заасан үгс нь өөрийн өвөрмөц утга, хэл зүйн бүтэц, бүтэх ёсоороо ихээхэн онцлогтой нь уг асуудлыг судлах эрдэм шинжилгээний ач холбогдлыг улам өргөжүүлж эрдэмтдийн сонирхлыг татсаар иржээ.

19-р зуны дунд үед оросын монголч эрдэмтэн А.Бобровников (“Грамматика калмыцкого языка” Казань, 1849) дүрслэх, дуурайх үгсийг аялга үгст багтаан үзээд, эдгээр үгс нь өөрийн бүтэц авианы онцлогоороо юмс үзэгдлийг дүрсэлж байна (дав хийх-гэнэт хөдлөх утгатай) гэж үзэж байв. Судлаач М.Базаррагчаа, Ц.Өлзийхутаг, Г.Гэндэнсүрэн, Ц.Өнөрбаян, С.Василе нар монгол хэлний дүрслэх үгийг судлаад

1. Авиа, дуу чимээ дуурайсан үг
2. Дүр байдал заасан үг гэж ангилах нь зүйтэй гэж үзжээ.

Бид энэ удаа монголын уран зохиолын үргэлжилсэн үгийн зохиолуудад дүр байдал заасан үгсийг англи хэлнээ хэрхэн буулгасан талаар жишээгээр тайлбарлахыг оролдлоо.

Монголын үргэлжилсэн үгийн богино өгүүлэгийн орчуулгын талаар

Бид Монголын уран зохиолын орчуулгын тэр дундаа монголын зохиолчдын богино өгүүлэгүүдийг англи хэлнээ орчуулсан байдлыг тоймлон бичлээ. Монголын орчин үеийн уран зохиолын үндсийг тавьсан нэрт зохиолч Д.Нацагдорж, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен нараас эхлээд олон зохиолчдын өгүүлэг, туужийг монголын болон гадаадын үе үеийн орчуулагч нар англи хэлнээ хөврүүлэн дэлхийн уншигчдад хүргэж байжээ. Бид зохиолч, орчуулагч нартай уулзан

⁶¹ Доктор, ШУТИС, ГХС

⁶² Магистр, ШУТИС, ГХС

⁶³ Магистр, ШУТИС, ГХС

асууж сураглаж, улсын номын сан, хувь хүмүүсийн номын сан, интернэт эх сурвалж ашиглан судалгаагаа явууллаа.

Монголын үргэлжилсэн үгийн уран зохиолыг англи хэлнээ орчуулах нь 1960-аад оноос эхэлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улсын Их Сургуульд 1956 онд ЗХУ-аас уригдан ирсэн мэргэжилтэн багш нар англи хэл зааж эхэлснээр Монголын анхны англи хэл судлалын тэнхим байгуулагдан сургалт явуулж 1962 онд 8 оюутан англи хэл мэргэжлээр төгсөж Монгол Улсад англи хэлний мэргэжлийн орчуулагч бэлтгэж эхэлсэн ба МУИС төгсөгчдөөс (<https://www.num.edu.mn/files/tugsugch/diplom/>) Дэ.Нацагдорж, Ж.Гэндэндарам, Б.Дамдин нар, мөн 1963 онд Москва хотноо Морез Торезын нэрэмжит Гадаад хэлний дээд сургуулийг англи хэлний мэргэжлээр төгссөн Ц.Гомбосүрэн, 1968 онд төгссөн Д.Алтангэрэл нар богино өгүүллэг орчуулж байжээ.

1960-аад оноос монголоос англи уруу утга зохиол орчуулах ажлыг багш, орчуулагч Дэмбэрэлийн Нацагдорж шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, зохиолч Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” (“Tears of a Venerable Lama”), “Цагаан сар ба хар нулимс” (“White month and bitter tears”) өгүүллэг орчуулснаар эхэлж байв. Хожим нь орчуулагч Б.Дамдин, зохиолч Д.Нацагдоржийн “Шувуун саарал” (“A swift-footed steed”), Б.Ринчений “Нууцыг задруулсан захиа” (“Letter of betrayal”), “Ану хатан” (“Lady Anu”), орчуулагч Ц.Гомбосүрэн Б.Ринчений “Шүхэрч Буниа” (“Bunia, A parachutist”), “Гар” (“The hand”), Л.Түдэвийн “Хоёр улиас” (“Two Aspens”), С.Удвалын “Баглаа цэцэг” (“A bouquet of flowers”) зэрэг өгүүллэгийг орчуулсан байдаг. Д.Алтангэрэл 1976 онд “Хөхөө Намжилын домог” (“The Legend of Khukhuu Namjil”), 1979 онд нэрт Монголч эрдэмтэн Оуэн Латтимортай хамтран “Монгол ардын үлгэр” (“Modern Mongolian folktales and stories”)–ийг орчуулан хэвлүүлжээ.

1980-1990 онуудад МОНЦАМЭ агентлагаас орос, англи хэлээр эрхлэн гаргаж байсан “Mongolia” сэтгүүлд монголын зохиолчдын богино өгүүллүүдийг орчуулан хэвлэж байжээ. Мөн 1988 онд Ц.Болдын эмхэтгэн гаргасан “Монгол богино өгүүллэгүүд” (“Some short stories from Mongolia”) түүвэрт орсон Монголын зохиолчдын 22 богино өгүүллэгийг Дэ.Нацагдорж, Б.Дамдин, Ц.Гомбосүрэн, Д.Алтангэрэл, Б.Чинбат, Д.Цэрэннадмид нар орчуулсан байна. Монголын зохиолчдын зарим орчуулгын бүтээлийг Ази, Африкийн зохиолчдын “Lotus” (“Лянхуа”) цоморлигт нийтэлж, чингэхдээ орос хэлнээс дам орчуулан нийтэлж байсан явдал бий.

2004 онд С.Нарантуяа, С.Дугармаа нарын эмхэтгэсэн “Монголын богино өгүүллэгүүд Англи хэлнээ” (“Some modern stories in Mongolian and English”) түүвэрт Монголын зохиолчдын 33 богино өгүүллэгийг Дэ.Нацагдорж, Б.Дамдин, Ц.Гомбосүрэн, Д.Алтангэрэл, Б.Чинбат, Д.Цэрэннадмид нар орчуулснаар оруулжээ. 2008 онд “Сувдан дуслын хэлхээс 1”, “Дуслын хэлхээс 2”, “Дуслын хэлхээс 3”, “Дуслын хэлхээс 4”, “Дуслын хэлхээс 5” (“A string of pearly drops 1”, “A string of drops 2”, “A string of drops 3”, “A string of drops 4”, “A string of drops 5”) – д богино өгүүллэг, найраглал, шүлэг болон дууны үгсийн цуврал номыг Н. Оюун-Ундраа, Н. Оюунзаяа нар орчуулсан ба уг цуврал номд Д.Нацагдоржийн “Хуучин хүү” (“A fellow of the old time”), С.Эрдэнийн “Өвгөн шувуу” (“The old bird”) өгүүллэгүүд (Н.Оюун-Ундраа, О.Ган-Энх, 2015:115-123) багтжээ.

Гадаадад Монголын үргэлжилсэн үгийн зохиолыг монголын болон гадаадын орчуулагчдын орчуулсан байдлаар эмхэтгэсэн хэд хэдэн бүтээл хэвлэгдсэн байна. Үүнд: 1974 онд “Mongolian Short Stories” edited by Henry G. Schwarz, Center for East Asian Studies, Western Washington University, 21 өгүүллэг багтсан бүтээл болон 2021 онд “Suncranes and Other Stories: Modern Mongolian Short Fiction” by Simon Wickhamsmith, Columbia University Press. 296 pp.

**Монгол хэлний дүр байдал заасан дүрслэх үгийн
утгыг англи хэлэнд илэрхийлэх нь**

Доктор Э.Равдан монгол хэлний дүрслэх үгийн дүр бүтээх чадамжийг орос хэлний дүрслэх үгтэй зэрэгцүүлэн судалж монгол хэлний дүрслэх үгийн өвөрмөц онцлогийг, уран зохиолын олон жишээгээр нотолжээ. Тэрээр монгол, орос хэлний уран зохиолд хүний хөдөлгөөн, бие эрхтний байдал, сэтгэл хөдлөлийг дүрслэхэд дүрслэх үг их ач холбогдолтой гээд ялангуяа монголын уран зохиолд хөдөлгөөн бүрийг нарийвчлан илэрхийлэх нь их элбэг байдаг түүнчлэн тэдгээрийг хүний хөдөлгөөн, /алхах, явах, гишгэх, гүйх, морь унаж явах/, амьтны хөдөлгөөн дүрсэлсэн үгс гэж хувааж монголын уран зохиолын жишээгээр тодруулан тэдгээрийг орос хэлнээ орчуулсан орчуулгаар үзүүлж монгол хэлний уран зохиолын уран сайхны дүрслэлийн энэ хэрэглүүр орос хэлнээ тэр бүр буухгүй байгааг ажиглан бичжээ. Тухайлбал морь унаж яваах үед *өндөс өндөс, өндөгнөх, халбиг халбиг, халбигнах, сэлбэг сэлбэг, сэлбэгнэх, холбиг холбиг, холбигнох, намбиг намбиг, намбигнах* гэх мэт хөдөлгөөн заасан үгс мөн *тоодог тоодог тоодогнох, моодогнох, поодогнох, дэгдгэнэх, жирэлзэх* гэх мэт амьтадын хөдөлгөөн дүрсэлсэн үгс орос хэлэнд ажиглагдаагүйг бичжээ.

Монгол хэлний дүр байдал заасан үгс нь авиа дуурайх язгуураас дагавраар болон туслах үйл үгтэй хамтран үйл үг, цаашлаад нэр үг, тэмдэг нэр үүсгэн хэрэглэгддэг. Монгол хэлний дүр байдал заасан дүрслэх үгийн бүтцийн талаас нь авч үзвэл:

Дүр байдал дүрслэх үгс нь монгол хэлэнд дан язгуур байдлаараа харилцах дохио болж, бодит байдлын талаарх төсөөллийг дуурайн нэрлэснээрээ бие даасан үгийн үүрэгтэй хэрэглэгдэхээс гадна мөн дараах байдлаар хэрэглэгдэнэ. Монгол хэлэнд “Ганц үет дүр байдал заасан үгс нь бүтцийн хувьд авиа дуурайх үгтэй тохирно. Энэ төрлийн дүрслэх үгс нь ихэвчлэн ГЭГ гэсэн бүтэцтэй байна. Ярианы хэлэнд *"хийх, гэх"* гэсэн туслах үйл үгийн хамт хэрэглэгдэнэ” (П.Бямбасан, 1987: 4-35) гэжээ.

Үүсмэл бус авиа дуурайх язгуураас үүссэн ганц үет дүр байдал заасан үгсийг уран зохиолд хэрхэн хэрэглэгдсэн болон англи хэлэнд орчуулагдсаныг авч үзвэл: “Ядам ирмэгц хоёулаа маш их айн сандран даруй түшмэл На-д мэдүүлмэгц түшмэл **давхийн** цочиж...”. (Ц.Д “Гологдсон хүүхэн”) “When the official Na heard of this, he jumped with alarm and showed his anger on the two. (Ts.D. “The Rejected Girl” translated by D.A)

“Адуучин хөвгүүдийн дотор нь **зарс гэж**, царай нь **барс гэх** болов.” (Ж.П)

“...хайрт Нина миний сэтгэлд **зурсхийж** үзэгдэвч, түүний биеийг олж би дахин уулзаж чадахгүй болсон болов уу?” (Д.Н “Харанхуйхад”)

My Nina had gone away, was lost forever. (D.N. “Dark Rock” translated by A.Delgermaa)

“Гал ирмэгц өнөөх дэрс **дүрхийгээд** их өндөр улаан гал болж ноцов” (Ц.Д “Хув зусаг”) /Д. Алтангэрэлийн орчуулсан “A Minikin-eared Ewe”-д энэ өгүүлбэр *орчуулагдаагүй* орхигдсон /С.Д./

Ийм дүрслэх үгс нь англи хэлэнд **V+Preposition+N** /үйл үг+утгвар+нэр үг/ гэж орчуулагдсан эсвэл орчуулагдахгүй орхигдсон байгаа нь бидний авсан жишээнээс харагдаж байна.

Дүр байдал заасан үгийн язгуур, үндсийг давтах ба хорших аргаар үйл явдлын олон давталтыг илэрхийлдэг бөгөөд энэ тохиолдолд дүрслэх шинж нь буурдаг. (Ц.Өнөрбаян, 1998:98). Давтсан дүр байдал заасан үгс нь дараах бүтэц хэлбэртэй байна. Үүнд: “Ийм шүд амтай амьтны аманд миний муу хавчиг хөх ингэ өртсөн бол ч алтан харгана шиг л **масар масар** хазагдах байж шүү дээ” (Б.Б. “Элсэн манхан далай”)

“If my poor camel had been caught by such an animal with a mouth and teeth like this, it would have been bitten to pieces **crunch, crunch** us as if it were.” (B.B. “The Ocean of Sand” translated by B. Chinbat)

“Лодон ам хамрыг орхимжоороо таглан хүүхний хойноос **намс намс** алхална” (Д.Н)

“In the end he yielded to her and started walking **majestically** to her home, following her.” (D.N. “Tears of a Venerable Lama” translated by De. N.) Д.Нацагдоржийн “Ламбагуайн нулимс” зохиолын орчуулгад **дайвар үгээр** буусан байна.

“Нижгэр наадам хийхээр төлөвлөөд 7 дугаар сарын 1 хүртэл **эрвийх дэрвийхээрээ** хөдөлжээ. (Л.В. “Жож Сэрээнэн”) Бидний ажигласнаар “Serenen, the Recluse”-д энэ өгүүлбэр **орчуулагдаагүй** орхигдсон.

Дүр байдал заасан язгуур үгс нь үгийн авиаг өөрчлөх замаар хоршиж тухайн үйл явдал дүр байдлын олон янз байдал, өөрчлөлт хувирлыг илэрхийлэн дараах байдлаар тохиолдоно. Үүнд: “Байн байн хоёр тийш ээлжлэн эзнээ харж **тэнтэр тунтар** алхлах тарган тэмээдийн том хар нүдэнд бүлтэлзэн” (Б.Б. “Элсэн манхан”)

“The camels **were plodding** through the strong flavored Gobi grass with distended nostrils and their large black eyes stared at their owner.” (B.B. “The Ocean of Sand” translated by B. Chinbat)

“Чавганц хөгшид, лам мам нар нийлж **навсайж, савсайлцан** эрэмдэг зэрэмдэг буу сэлэм, эвэр хулсан нум сум, бялуу шийдэм хүртэл барилан...” (Д.Н. “Үзэгдээгүй юм”)

The old women, the lamas, and everyone else stood up with their ancient guns, swords, bows and arrows, and clubs dangling. (D.N. “Unseen Things” translated by G.Ts.)

Монгол хэлний хоршсон дүр байдал заасан үгс нь англи хэлнээ *дан үйл үгээр* буух буюу эсвэл орчуулагдаагүй байгаа нь эндээс харагдаж байна.

Дүр байдал заасан үгсийн язгуур нь дуу чимээ дуурайсан үгсийн язгууртай тохирдог ба монгол хэлэнд үйл үг үүсгэх тухайлбал авиа дуурайх язгуураас дүр байдал заасан үйл үг үүсгэх - *айд*, -*ги*, -*вна* гэсэн цөөхөн хэдэн дагавар авдаг.

-*ай* дагавраар үүссэн үгийг ажиглавал энэ дагавар нь дүр байдал заасан язгуураас дүр байдал заасан үйл үг үүсгэдэг ажээ. (гэд + ий, тэвх + ий, барз+ ай, хавт + ай, бонд + ой, ов + ой, тор + ой)

“Өвгөн царайгаа **барайлгаж** гараараа зангаж тийшээ очиж яасан ч болохгүй гэж мэдэгдээд...” (Ц.Д. “Хоёр цагаан юм”)

“The old man **showed annoyance** when he heard me and with his hands clenched he made signs to me forbidding me to go over to me spring...” (Ts.D. “The two white things” by D.Khandbaldir)

“Машин чинь эвдэрчихээ юу гэж тэртээ дор давааны зам дээр **торойх** ГАЗ-69-ийг заав” (Д.Г. “Даваан дээр”)

“Is that your truck **stranded** on the pass?” she continued”. (D.G. “At the Pass”)

-*ги* дагавар: Энэ дагавар нь авиа дуурайх язгуураас дүр байдал заасан үйл үг үүсгэдэг. (долгих, боргих, бургих, тургих, баагих, уугих)

“... хэтээ ганц хавирангуут, тэр бялтанд оч тусан уул нь **уугитал**, саадгаасаа нумаа суга татаад, манж дайсны зүг харвав.” (Б.Р” Ану хатан”)

“The tinder **was lighted** by sparks struck from a flint and steel he took a bow out of the case and an arrow towards the direction of the Manchus.” (B.R. “Lady Anu” translated by B.Damdin)

“Бөөн хар утаа **баагин** дайсны онгоц доошоо унаж, **дүрэлзсэн** улаан гал болж хувирав” (Ч.Л)

“**Smoking** heavily, the enemy aircraft began to drop and suddenly **burst** into flames” (Ch.L “Off to the Battlefield” translated by D.A)

-*вна* дагавар: Энэхүү дагаврыг авиа дуурайсан язгуурт залгаж, үйл хөдөлгөөний байдал илэрхийлсэн үйл үг үүсгэнэ. (бав+вна, був+тна, бөв+тнө, гүв+втнэ)

“Хажуугийн өрөөнөөс гурван хүний хөгжөөнтэй **бөвтнөх** яриа сонсогдох боловч юу ярж байгаа нь үл ойлгогдоно” (Л.Т “Будаг амилна”)

“The gay but **muffled** talk of three people could be heard from the other room, but he could understand none of it.” (L.T. “The color will come alive” translated by D.A)

Монгол хэлний дагаврын аргаар бүтсэн үүсмэл дүр байдал заасан үйл үгс нь англи хэлнээ нөхцөл үйл (participle), үйлт нэр(gerund)-ээр орчуулагдсан нь элбэг байна.

Монгол хэлний дүр байдал дүрслэх үйл үгсийн утгаар нь хэрхэн ангилдаг болон тэдгээрийг англи хэлнээ хэрхэн орчуулсныг авч үзвэл:

-Хүн амьтны үйл хөдөлгөөн дүрсэлсэн үгс (гүйх хөдөлгөөнийг дүрсэлсэн үгс, морь унаж явах хөдөлгөөнийг дүрсэлсэн үгс, биеийн хөдөлгөөнийг дүрсэлсэн үгс)

“Бяцхан хар үрээ нь омголон тул, тогтож ядан **годгононо**” (Д.Н. “Үзэгдээгүй юм”)

“The young man’s small black horse was high-spirited and **continually trying to run** around in circles” (D.N. “Unseen Things” translated by G.Tserendorj)

“Суу! гэж хүүхэн хэлээд өөрөө өвдгөн дээрээ **цомцойж** яг л айлд ирсэн зочинг дайлах мэт халуун савнаасаа цай аягалан... (Д.Г. “Даваан дээр”)

“Sit down, “she said and, as if showing him an example, squatted down. Then she lowered one knee to the ground for support, arranged herself more **compartably** and begin treating her guest...” (D.G. “At the Pass” translated by D.A)

“-Тиймээ.Яаж мэдэв? -Андашгүй л дээ...гэж хүүхэн **жуумалзах нь** их доогтой мэт” (Д.Г)

“-How did you guess? It’s hard to make a mistake in this case, “she replied with **light mockery**” (D.G. “At the Pass” translated by D.A.)

“Хүүхдийн төрөхөд эх барьж авах гэсэн Дамдингийн ээж **майжиг жайжиг** гэж оролдсоор хэдэн муу гэрээ ачаалсан боловч Мядагийн ганцаар хоцроход хүрснийг мэдэж харгалзан хүлээв.” (Ц.Д. “Тологдсон хүүхэн”)

“Damdin’s mother, who was soon to become a mid-wife to the to-be-bom new child, **roughly moved** about and finally managed load her shabby ger, but when realized that Myadag was about to be left alone she decided it was better to wait for her.” (Ts. D. “The Rejected Girl” translated by D.Altangerel)

Энд үйл үг+угтвар-нэр үг, дайвар үг ба үйлт нэрээр (*V+Preposition+N or Gerund*) англи хэлэнд буусан байна.

-Хүн юмсын гадаад овор төрхийг дүрсэлсэн:

“Дараа нь шатсан танкийн **арсайсан** дүрс харагдав” (Ч.Л “Хоёр нөхөр”)

“The pilot saw the ruins of a demolished enemy emplacement and a **crippled**, smoking tank nearby.” (Ch.L. “Off to the Battlefield”)

-Өнгө гэрэл дүрслэх үгс:

“Түймрийн гал **улалзсаар** манай гэрийн дэргэд хүрээд ирлээ.” (Ц.Д “Хув зусаг”)

“**The blazing** flames approached our ger. (Ts.D. “A Minikin-eared ewe” translated by D.A) Энд орчуулгад орхигдсон бол харин дараах жишээнд үйлт нэрээр буусан байна. “Оройн наранд ийнхүү **улайран** харагднам бөгөөд...” (С.Э “Наран тогоруу”)

“They **seemed red** under the rays of the settings sun...” (S.E. “Sunny Granes” translated by D.A)

Дүгнэлт

Монгол хэлний дүр байдал заасан дүрслэх үгийг англи хэлнээ буулгах нь ярвигтай асуудал ажээ. Ганц үет дүр байдал заасан үгс нь бүтцийн хувьд ихэвчлэн ГЭГ гэсэн бүтэцтэй байх бөгөөд “хийх, гэх” гэсэн туслах үйл үгийн хамт хэрэглэгдэх бөгөөд үүнийг орчуулах нь бэрхшээлтэй болох нь ажиглагдлаа.

Мөн дүр байдал заасан үгс нь давтсан хоршсон байдлаар хэрэглэгдэх ба энэ нь англи хэлэнд тэр бүр орчуулах боломжгүй байгаа нь жишээнээс ажиглагдлаа.

Монгол хэлний дагавраар үүссэн үүсмэл дүр байдал заасан үйл үгсийг англи хэлний үйлт нэр, нөхцөл үйлээр орчуулсан нь элбэг байгаа нь залгамал хэл болох монгол хэл ба төрөл бус хэл болох англи хэлний ялгаатай талын нэг илэрхийлэл гэж үзэж байна.

Монгол хэлэнд дүрслэх үгс нь үргэлжилсэн үгийн зохиолд яруу сайхан дүрслэх хэрэглүүр байдлаар элбэг хэрэглэгддэг нь уран зохиолын жишээ баримтаас харагдаж байна.

Ашигласан ном хэвлэл

Бямбасан П. ба бусад (1987), “Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал”

Нарантуяа С., Дугармаа С., (2005) “Some Modern Mongolian Stories in Mongolian and English”

Оюун-Ундраа Н. Ган-Энх О. (2015), “Англи хэлнээ орчуулсан монгол уран зохиолын бүтээлийн тойм англи хэлнээ орчуулсан монгол уран зохиолын бүтээлийн тойм”

Өнөрбаян Ц. (1998), “Орчин цагийн монгол хэлний үгзүй”

Равдан Э. (1994), “Сопоставительная стилистика русской и монгольской художественн речи”

<https://www.num.edu.mn/files/tugsugch/diplom/>

<https://www.montsame.mn/mn/read/51531>



ОРЧУУЛАГЧИЙН ХЭЛЗҮЙН ЧАДАМЖИЙН ТУХАЙД

Г.Бат-Учрал⁶⁴
В.И.Павлов⁶⁵

Abstract: Due to the current situation, learning a foreign language has become a necessity for everyone. As a result, everyone who speaks a foreign language is daily facing with the situation to do the translation if necessary. This raises the issue of translation quality, which is directly or indirectly related to the translator's knowledge and reception and production competences of the mother tongue and the target language. Linguistic competence is an important part of a translator's linguistic knowledge, and this time we have analyzed how linguistic competence is reflected in the Common European Framework of Reference for Languages: Learning, Teaching and Assessment.

Түлхүүр үг: Европын олон хэлний суурь хөтөлбөр, орчуулагч, харилцааны чадамж, хэлмэрч, хэл зүйн чадамж

Техник технологийн хөгжлийг даган гадаад хэлийг бие даан суралцах боломж хүн бүрд бий болсон нь нэг талаараа мэдээ мэдээлэл олж авах, насан туршдаа сурч боловсрох зэрэг хувь хүний хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа хэдий ч нөгөө талаараа хэлтэй хүн олширохын хэрээр тэдгээрийн мэдлэг чадвар, орчуулгын чанарын асуудлыг хөндөх шаардлага гарч байна. Гадаад хэлтэй хүний хоёрдогч хэлний мэдлэг, ур чадвар, хандлагын түвшнийг Европын олон хэлний суурь хөтөлбөр (ЕОХСХ)-т дурдсан байдаг бөгөөд орчуулагчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг уг хөтөлбөрт хэрхэн тусгасантай дүйцүүлэн авч үзэх боломжтой юм. Манай улс гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэж эхэлснээс хойш гадаад хэлний сургалтад хэлзүй орчуулгын аргыг түгээмэл хэрэглэж ирсэн бол сүүлийн 20-гаруй жил харилцааны аргыг сургалтад хэрэглэж ирлээ. Тухайн үед хэлний мэдлэгээс хэлэхүйн чадварт чиглэсэн сургалт давамгайлж байсан бол өнөөдөр хэлэхүйн чадвараас хэлний мэдлэг рүү чиглэсэн сургалт голлох байр суурьтай болсон нь хоёрдогч хэлийг харилцааны нэгэн хэрэглүүр гэдэг талаас авч үзэх болсонтой холбоотой бөгөөд гадаад хэлний сургалтад харилцааны аргыг илүү чухалчилсаар байна. Гэвч энэ нь харилцаанд ороход хэл зүйн чадамж хэрэггүй гэсэн үг биш бөгөөд тухайн хэлээр харилцахад өөрийн бодол, санаагаа бүрэн дүүрэн илэрхийлэхэд зайлшгүй шаардагдах чадамж гэдгийг анхаарах хэрэгтэй.

“Орчуулагч”-ийг монгол хэлний их тайлбар толь бичигт “орчуулах ажил эрхэлдэг хүн, дуун хөрвүүлэгч” гэж тодорхойлсон бөгөөд ажиллах салбар, тухайн салбарт гүйцэтгэх үүргийг ажил мэргэжил судлалын бүтээлүүдэд дараах байдлаар ангилсан байна.

Хэвлэл, мэдээлэл (Батбаатар, 2019) болон соёл урлагийн салбарын (Батбаатар, 2019) хэл шинжээч, орчуулагчийн ажлын байранд хэл шинжлэлч, толь бичиг зүйч, орчуулагч, дохионы хэлний орчуулагч, хэлмэрч ажиллахад тохиромжтой гэж үзсэн байна.

⁶⁴ МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Европ судлалын тэнхим

⁶⁵ Доктор Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Европ судлалын тэнхим

Хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн салбарын орчуулагч нь “хүний шууд ярьж буй яриа, цаасан дээр буулгасан болон дохионы ярианы текстийг нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулна. Эх материалын утга, агуулга, мэдрэмжүүд, орчуулгын дараа хадгалагдсан эсэхийг эх тексттэй тулгах буюу эсвэл зохиогчтой ярилцаж шалгана” (Нарангарав, 2014) гэж тодорхойлсон байна.

Хэвлэл мэдээллийн салбарын орчуулагч нь “Бичмэл материал, кино, радио, телевизийн нэвтрүүлэг, онлайн мэдээллийг орчуулах, ажил хэргийн уулзалт, хэлэлцээрийн үед шууд (синхрон) орчуулга хийх, гадаад, дотоодын иргэд, жуулчдад орчуулга хийж үйлчлэх зэрэг мэргэжлийн үүрэгтэй ажиллаж, шинжлэх ухаан, технологи, бизнес, урлагийн бичмэл материал, тогтмол хэвлэлийг орчуулах, (эх материалын утга санаа, нэр томьёо, ойлголтын оноосон утгыг зөв орчуулах), ажил хэргийн уулзалт, хэлэлцээрийн үед шууд (синхрон) орчуулга хийх, гадаад иргэдийн аяллыг зохион байгуулахад оролцох, гадаад иргэд, зочдыг дагалдаж орчуулга хийх, гадаад иргэд зочид буудалд байрлах, түр амьдрахад нь орчуулга хийж үйлчлэх, гадаад улс орныг зорьж байгаа өөрийн орны иргэд, ажил хэргийн хүмүүс, жуулчдад орчуулга хийж үйлчлэх, кино, радио, телевизийн нэвтрүүлэг, онлайн мэдээллийг орчуулах, компьютер, техник хэрэгсэл ашиглан орчуулга хийх, дохионы хэлийг орчуулах, хурал, уулзалт зэрэг арга хэмжээг орчуулж мэдээллийн хэрэгслээр дамжуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ (Гомбо, 2013) гэж тодорхойлсон байна.

Европын ажил мэргэшлийн хүрээнд “**Орчуулагч** нь бичмэл эхийг нэг болон олон хэлнээс нөгөө хэлнээ буулгах бөгөөд эхийн найруулгын өнгө аясыг орчуулж буй хэлнээ хадгалж, худалдааны болон үйлдвэрлэлийн баримт бичиг, хувийн бичиг баримт, сэтгүүл зүй, роман, зохиол бүтээл, шинжлэх ухааны бичвэрийг орчуулна”, **хэлмэрч** нь багагүй мэдээллийг тэмдэглэл хөтлөх замаар хүлээн авч, утга агуулгын нарийн өнгө аясыг хадгалан нөгөө хэлнээ шууд хөрвүүлнэ” гэж дэлгэрэнгүй тодорхойлсон байна.

Дээр дурдсанаас харахад орчуулагч нь хэлний мэдлэгээс гадна харгалзах салбарын онцлогоос шалтгаалан зайлшгүй эзэмших олон салбарын мэдлэг, ур чадвар, хандлагад тасралтгүй суралцах нь зүйтэй бөгөөд мэдлэг, ур чадвар, хандлагын түвшнийг хөдөлшгүйгээр тогтоох нь боломжгүй юм.

Энэ удаад бид орчуулагч, хэлмэрчийг монгол хэлний тайлбар тольд дурдсан “**орчуулагч**” гэдэгт багтаан авч үзлээ.

Харин “**competence**” хэмээх нэр томьёоны хувьд **чадавх, мэдлэг** (Равдан, 2013), **чадавх, чадвар** (Буяннэмэх, 2004), **хэлний чадвар, чадамж** (Энхбат, 2003), **чадамж** (Алтанцэцэг & Дэлгэрмаа, 2004), **чадамж** (Браун, Хэл сурах, сургах зарчим, 2014), **цогц чадамж** (Гомбосүрэн, 2010), **чадамж** (Щукин, 2014) зэргээр олон эрдэмтэд өөрсдийн хувилбарыг дэвшүүлснээс “**чадамж**” гэх хувилбарыг хэрэглэж хэвших хандлагатай байна.

Хэлийг харилцааны үндсэн хэрэгсэл талаас нь хэрэглэдэг хэдий ч хэл хүний тасралтгүй сурч боловсрох үйлд мөн чухал үүрэгтэй билээ. Ялангуяа гадаад хэлийг хувь хүн нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу сурахаас гадна ерөнхий мэдлэгийн цар хүрээгээ тэлэх, насан туршийн боловсрол эзэмшихэд олон давуу талтай юм. Орчин үед гадаад хэлний мэдлэгийн тухай агуулгад “харилцааны чадамж” гэдэг нь үндсэн нэр томьёо болоод байна. Харин “**хэл зүйн чадамж**” нь гадаад хэлээр амжилттай харилцахад туслах суурь чадамжуудын нэг бөгөөд харилцааны чадамжийн нэгэн дэд хэсэгт тооцож ангилдаг байна. Судлаачид харилцааны чадамжийг хэрхэн тодорхойлсныг хүснэгт 1-г үзүүлэв.

Судлаач	Чадамжийн ангилал	
Канэйл, Свэйн	Хэл зүйн	
	Дускурсын	
	Нийгэм-хэл шинжлэлийн	
	Стратегийн	
Бакман	Зохиох	Хэл зүйн
		Бичвэрийн (дискурсын)
	Аж хэрэглээний	Зорилтот утга илэрхийлэх болон ойлгох
		Нийгэм-хэл шинжлэлийн
Литлвүүд	Хэл шинжлэлийн (хэл зүйн)	
	Дискурсын (бичвэр)	
	Аж хэрэглээний (стратегийн)	
	Нийгэм-хэл шинжлэлийн	
	Нийгэм-соёлын	
Европын олон хэлний суурь хөтөлбөр	Хэл шинжлэлийн	
	Нийгэм-хэл шинжлэлийн	
	Аж хэрэглээний	
Гадаад хэл сурах АНУ-ын стандарт	Хүн хоорондын харилцаа	
	Тайлж тайлбарлах	
	Таниулах	

Дээрх ангиллаас харахад хэл зүйн чадамж нь харилцааны чадамжийн буюу гадаад хэлээр харилцахад шаардагдах мэдлэг чадварын салшгүй нэг хэсэг болох нь харагдаж байна. Гадаад хэлээр харилцахад шаардагдах чадамжийг Европын олон хэлний суурь хөтөлбөр (ЕОХСХ)-т **ерөнхий болон хэлээр харилцах чадамж** хэмээн ангилсан байна (North, Tunde, & Tim, 2018). Ерөнхий чадамжийг **“декларатив мэдлэг (declarative knowledge/savoir)”**, **“гүйцэтгэх ур чадвар (skills and know how/savoir faire)”**, **“экзистенциал чадамж (existential competence/savoir etre)”**, **“сурах чадвар (ability to learn/savoir apprendre)”** хэмээн ангилсан бөгөөд хувь хүний онцлог шинж, нас, суурь мэдлэг, танин мэдэхүйн хөгжил, хувийн туршлага зэрэгтэй холбоотой юм.

Декларатив мэдлэгийг **“ертөнцийн тухай мэдлэг (knowledge of the world)”**, **“нийгэм соёлын мэдлэг (sociocultural knowledge)”**, **“соёл хоорондын ялгааг ухамсарлахуй (intercultural awareness)”** хэмээн агуулгын хувьд нарийн зааглаж, ялгажээ. Декларатив мэдлэг гэж дадлага туршлагаас бий болсон эмпирик мэдлэг болон албан сургалтаар эзэмшсэн онолын мэдлэгийг хэлнэ.

Гүйцэтгэх ур чадварыг **“практик ур чадвар ба нөү хау (practical skills and know how)”**, **“соёл хоорондын ур чадвар ба нөү хау (intercultural skills and know how)”** хэмээн ангилсан нь туршлагаас олж авсан мэдлэгээ олон соёл зэрэгцэн орших өнөөгийн нийгэмд хэрхэн ашиглах тухай ажээ. Гүйцэтгэх ур чадвар гэдэг нь аливаа үйлийг хийж сурсан хүн тухайн үйлээ ухамсаргүйгээр бие даан гүйцэтгэх ур чадварыг хэлнэ.


Экзистенциал чадамжийг хандлага, сэдэл, үнэ цэнэ, итгэл үнэмшил, танин мэдэхүйн төрөл, хувь хүний зан төлөв зэрэгт хуваан авч үзсэн байна. Энэ нь хувь хүний онцлог шинж, зан чанар, хандлагын цогц нэгдлийг хэлнэ.

Сурах чадварыг **“хэл ба харилцааны ухамсарлахуй (Language and communication awareness)”**, **“авиа зүйн суурь ухамсарлахуй ба ур чадвар (General phonetic awareness and skills)”**, **“сурах ур чадвар (Study skills)”**, **“бүтээлчээр суралцах ур чадвар (heuristic skills)”** хэмээн ангилснаар сурах олон талт үйл ажиллагааг дэвшүүлсэн байна.

Ерөнхий мэдлэг нь хэлний мэдлэгтэй шууд холбоогүй ч гадаад хэлээр харилцахад чухал үүрэгтэй байдаг. Үүнээс харахад орчуулагчийн мэдлэгийн цар хүрээ хэр өргөн, гүн гүнзгий байх шаардлагатай нь харагдаж байна.


Ерөнхий чадамж болон хэлээр харилцах чадамжийг хэлээр харилцах үйл болон хэлээр харилцах стратегитай хослуулан “хэлний ерөнхий чадамж”-ийн дүр зургийг гаргасан байна.

Бүдүүвч 1. ЕОХСХ-т дурдсан “хэлний ерөнхий чадамж”



Иймд хувь хүний суурь мэдлэгийг харилцааны үндэс буюу хэлээр харилцахад шаардагдах мэдлэгийн чухал хэсэг гэж үзэж болох юм.

Бүдүүвч 2. ЕОХСХ-т дурдсан “хэлээр харилцах чадамж”



ЕОХСХ-т дурдсан хэлээр харилцах чадамжийг “аливаа хэлний хэл зүйн айг аман болон бичгийн аль ч хэлбэрээр нийгэм, соёлын орчин, аж хэрэглээний талыг харгалзан хэрэглэх мэдлэг, ур чадвар” гэж тодорхойлон бүдүүвчилсэн байна. Хэлээр харилцах чадамж гэдэгт хэлний чадамж, гүйцэтгэлийн нэгдлийг голчлон хэлнэ. Хэлний чадамж гэдэг нь хэлний тогтолцоо буюу хэл зүйн дүрэм, үгийн сан, хэлний бүх нэгж, тэдгээрийн уялдаа холбооны тухай хүний суурь мэдлэг бөгөөд нүдэнд үл үзэгдэх чадвар юм. Харин гүйцэтгэл гэдэг нь хэлний чадамжийн бодит илрэл, хэрэгжилт буюу сонсох, ярих, унших, бичих зэргээр хэлийг бодитоор хэрэглэх чадвар юм.

Оновчтой, зөв орчуулах, хэлмэрчлэхэд хэл зүйн мэдлэг чухал болохыг гадаад, дотоодын судлаачид бүтээлээрээ дамжуулан дэвшүүлсээр байна. Канэйл, Свэйн нар хэл зүйн чадамжийг “үгийн сан, үг зүй, өгүүлбэр зүй, өгүүлбэрийн түвшинд илрэх утга зүй, авиалбар зүйн мэдлэг”-ийг багтаасан харилцааны чадамжийн нэг хэсэг юм”, Л. В. Щерба “дүрэм бол ярьж сургана”, эрдэмтэн Э. Равдан “хэл зүйн мэдлэггүйгээр хэн ч хэлээр харилцаж чадахгүй (Равдан, 2005), С. Галсан “... хэл зүйн дүрэм гэдэг нь чанартаа дууны бол нот юм”, Ц. Батмөнх, С. Эрдэнэмаам нар “... дүрэм хэл сургахад туслах үүрэгтэй бөгөөд барилгатай зүйрлэвэл барилгын хэрэгсэл, тоосго зэргийг хооронд нь зүйж тогтооход хэрэг болдог цементэн зуурмаг юм” (Батмөнх Ц., 2014), “хэл зүйн чадамж нь аливаа хэлний хэл зүйн хэрэглэхүүнийг хэрэглэх мэдлэг, чадвар гэж тодорхойлж болно” (Равдан, 2012) гэж үзсэн байна. Гадаад хэлээр харилцахдаа хэл зүйн хувьд алдаагүй, утга агуулгыг оновчтой, тодорхой хүргэх нь чухал юм. Гадаад хэлээр ярихад хэл зүйн мэдлэгээ сэргээн санах болон хэл зүйн зөв хэлбэрийг сонгох нь нэг цаг мөчид зэрэг үргэлжлэх сэтгэхүйн үйл тул хэл зүйн айг алдаагүй хэрэглэхэд багагүй бэрхшээлтэй байдаг.

ЕОХСХ-т орчуулагчийн буюу гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй хүний хэл зүйн чадамжийг анхан шатнаас ахисан түвшин хүртэл дурдсан бөгөөд хэл зүйн дараах агуулгыг харгалзсан байвал зохино гэж үзсэн байна. Үүнд:

1. Бүрэлдэхүүн махбод буюу бүтээвэр, язгуур бүтээвэр, нөхцөл залгуур.
2. Хэл зүйн олон ай буюу тоо, тийн ялгал, хүйс, тусах/эс тусах хэв, өнгөрсөн, одоо, ирээдүй цаг.
3. Ангилал буюу үйл үгийн хувилал, нэр үгийн ялгал, хавсрал нэр, дайвар үг.
4. Бүтэц буюу нийлмэл үг, хоршоо үг, өгүүлбэрийн бүрэлдэхүүн, энгийн, зэрэгцсэн, хавсарсан нийлмэл өгүүлбэр.
5. Үйлийг илэрхийлэх буюу нэршүүлэх, нөхөх, сэлгэх, хэлбэр хувьсах.
6. Хэл зүйн харьцаа буюу захирах, зохицох, дүйцэх г.м.

ЕОХСХ-ийн хэл зүйн агуулгыг B2 түвшинд “Өгүүлбэрийн бүтцэд санамсаргүй, дүрмийн бус алдаа ховор гаргах хэдий ч бие даан алдаагаа засах, хэл зүйн дүрмийн хэрэглээгээ сайн хянаж чадна. Хэл зүйн дүрмээ үл ойлголцол үүсгэхгүй хэмжээнд дээд зэргээр хянаж хэрэглэж чадна. Хэлний энгийн бүтэц болон хэл зүйн зарим түвэгтэй хэлбэрийг хэрэглэж чадна. Зарим түвэгтэй бүтцийг бага хяналттай хэрэглэхийг зорино”, C1 түвшинд “Хэл зүйн дүрмийн хэрэглээгээ маш сайн хянаж, алдаа бараг гаргахгүй бөгөөд гаргасан олдоог нь олж тогтооход хэцүү”, C2 түвшинд “Өөр зүйлд анхаарсан ч хэл зүйн дүрмийг цогцоор нь хэрэглэж хэл зүйн алдаа гаргахгүй” гэж тодорхойлсон байна. Орчуулагчийн хэл зүйн чадамжийн түвшнийг нарийн тодорхойлох нь бэрхшээлтэй. Гэсэн хэдий ч авиа зүй, үгийн сан болон хэлэхүйн чадварын түвшинд тулгуурлан хэл зүйн чадамжийг тодорхойлох боломжит хувилбарыг хэлний мэдлэгийн түвшин бүрд ялангуяа ахисан түвшинд боловсруулах хэрэгтэй байна.

Дүгнэлт

- Орчуулагчийн гадаад хэлний мэдлэгийн түвшнийг зөвхөн хэл зүйн чадамж бус, хэлний мэдлэг, хэлэхүйн чадвараар нь дэлгэрэнгүй ангилж боловсруулах.

- Хэлний мэдлэгийн өөрийн үнэлгээний загвар асуумж боловсруулах.
- Орчуулагчийг хэлний мэдлэгийн түвшинтэй нь уялдуулан тодорхойлох шаардлагатай байна.

Ном зүй

- North, B., Tunde, S., & Tim, G. (2018). *Common European Framework of Reference for Languages: Learning, teaching, assessment (Companion volume with new descriptors)*. Strassbourg .
- Алтанцэцэг, Л., & Д. ж. (2004). *Боловсролын нэр томъёоны англи-монгол товч толь*. Улаанбаатар.
- Батбаатар, М. (2019). *Ажил, мэргэжлийн хөтөч*. Улаанбаатар: Удам соёл.
- Батмөнх Ц., Э. С. (2014). *Гадаад хэл заах онол, арга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Браун, Д. (2014). *Хэл сурах, сургах зарчим*. Улаанбаатар: Удам соёл.
- Буяннэмэх, Г. (2004). *Хэл шинжлэлийн нэр томъёоны товч толь (франц-монгол-орос)*. Улаанбаатар.
- Гомбо, Д. (2013). *Мэргэжлээ сонгох нь*. Улаанбаатар: Соёмбо.
- Гомбосүрэн. (2010). *Хэлний философи ба хэл шинжлэлийн философи*. Улаанбаатар.
- Нарангарав, Д. (2014). *Ажил мэргэжлийн лавлах толь*. Улаанбаатар.
- Равдан, Э. (2005). *Орчин цагийн хэл шинжлэл*. Улаанбаатар.
- Равдан, Э. (2012). *Европын олон хэлний суурь хөтөлбөр: сурах, сургах, үнэлэх*. Улаанбаатар: Удам соёл.
- Равдан, Э. (2013). *Хэрэглээний хэл шинжлэл (хэл сурахуйн онол)*. Улаанбаатар.
- Төмөртоогоо, Д. (2008). *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар.
- Ундармаа, А., & Ариунаа, Р. (2021). *Бага, суурь, бүрэн дунд боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж (англи хэл)*. Улаанбаатар: Интерпресс ХХК.
- Щукин, А. Н. (2014). *Гадаад хэлний сургалт, онол-практик*. Улаанбаатар: Удам соёл.
- Энхбат, Д. (2003). *Хэл шинжлэлийн англи-орос-монгол толь бичиг*. Улаанбаатар.



УРАН ЗОХИОЛЫН РЕАЛИ ҮГИЙГ ОРЧУУЛАХ НИЙТЛЭГ АРГУУД, ТЭДГЭЭРИЙГ УТГА ИЛЭРХИЙЛЭХ ТҮВШНЭЭР ЭРЭМБЭЛЭХ НЬ

Т. Мягмарсүрэн⁶⁶
О. Халиунаа⁶⁷

Abstract: Our aim with this paper is firstly to survey and outline common translation strategies used in realia words and expressions from Mongolian into English language and secondly, to propose an order of the translation strategies according to their equivalence based on literature translations. In this study, 32 Mongolian short stories translated by foreign and Mongolian translators into English were involved. We collected strategies for realia translation and analyzed how often they are applied in literature translations. Findings of the study showed that 11 strategies (transcribing, calque, neologism, synonymy, explanation, reformulation or equivalence, international word, adjective, modulation, notes and couplets) were offered by most of translation researchers, out of which 6 strategies (transcribing, calque, synonymy, explanatory, reformulation or equivalence, and couplets) are often used in Mongolian into English literature translation. Moreover, translators are using several couplets (transcribing & explanatory, transcribing & calque and equivalence & explanatory) for dealing with some cultural words. In connection with the 32 Mongolian short story translation into English, we attempted to make an order of 4 translation strategies due source language (SL) cultural words, translated by a target (TL). This order starts with reformulation or equivalence, and follows synonymy as well as explanation and ends with couplet.

Түлхүүр үг: реали, эквивалент (дүйцэл), орчуулга, харьцуулалт

Судалгааны зорилго: Уран зохиолын реали үгийг орчуулж байгаа нийтлэг аргыг нэгтгэн тоймлож, тэдгээрийг утга илэрхийлж буй түвшнээр нь эрэмбэлэх талаар санал дэвшүүлнэ.

Оршил

Хүн төрөлхтөнд анх үүсэн бий болох үед хоол хүнс, хувцас хунар, орон байрны адил хүмүүс бие биентэйгээ ойлголцох хэл яриа гол хэрэгцээнийх нь нэг болж байсан нь лавтай. Тиймээс дохио зангаа, нүүр царайны хувирал гэх мэт биеийн аль нэгэн үйл хөдлөлөөрөө хоорондоо хэл нэвтрэлцсээр цааш улам боловсронгуй болж авианаас үг, үгээс өгүүлбэр үүсчээ. Овог аймаг бүрийн амьдарч буй газар орон, цаг агаар, эрхэлж буй хөдөлмөр ялгаатай тул өөр өөрийн хэлтэй, мөн соёлтой болов. Ийнхүү олон төрөл хэл үүссэнээр овгууд хоорондоо харилцан ойлголцох шаардлагын улмаас нэг нэгнийхээ хэлийг сурах шаардлага гарч иржээ. Нэг нэгэндээ хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагаа хэлж илэрхийлэхэд өөрийн болоод цаад угсаатан үндэстний соёл, ёс заншил, зан үйл, ахуй амьдралын талаар хөөрөлдөх хэрэгтэй болсон байна. Хэл бол нэгэн үндэстний соёлын амьдралын суурь юм. (Сүхбаатар, 1998) Аливаа үндэстний соёлыг тээгч болох хэл нь тухайн ард түмнийхээ зан заншил, ёс уламжлал, аж амьдрал, сэтгэл

⁶⁶ Доктор, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Англи хэлний тэнхим

⁶⁷ Хэл шинжлэлийн магистрант, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль

сэтгэлгээнээс огтхон ч ангид оршихгүй. Иймд нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулга хийхэд хоёр үндэстний энэ мэт онцлогийг илтгэсэн үг, өгүүлбэрийг дамжуулах олон арга, аргачлал үүсч хөгжжээ. Энэ судалгаагаар монгол хэлний үндэсний онцлог бүхий үг хэллэгийг орчуулж буй гадаад, дотоодын орчуулагчдын ашиглаж байгаа орчуулгын нийтлэг аргыг илрүүлэн тогтоож, эдгээр аргыг утга илэрхийлж буй түвшнээр нь эрэмбэлэх оролдлогыг хийлээ.

Реали үг буюу үндэсний онцлог бүхий үг хэллэг

Гол төлөв зөвхөн тухайн үндэстэн угсаатны аж амьдрал, зан үйл, соёл сэтгэлгээний онцлогтой холбоотойгоор үүсэн бий болсон үгийг орчуулгад реали үг гэнэ. Үүнд тухайн үндэстний соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлэх энгийн ба нийлмэл үг, холбоо үг мөн тийм үг хэллэгтэй ассиоциатив холбоогоор шууд ба дам холбогдсон дүр дүрслэл бүтээх, ил далд утга санааг илэрхийлдэг ардын билэг зүйд хамаарах сургаал, сургамжийн үгс хамаардаг. (Жаргалсайхан, 2011) Өөрөөр хэлбэл эдгээр нь хэлц үг, зүйр цэцэн үг, бүдүүлэг үг, этгээд үг, нутгийн аялгуу, зүйрлэл, адилтгал юм. (Дашдаваа, 1998) Реали үг нь *жинхэнэ, бодит, биет, үнэн бодит* гэсэн утга бүхий латин хэлээс гаралтай тэмдэг нэр, *объект, биет юм, зүйл, юм* гэсэн утгатай америкийн англи хэлээс гаралтай нэр үгтэй анх нийлж үүсчээ. (Dictionary.com) Өөрөөр үндэсний онцлог бүхий үг хэллэг ч гэж бас нэрлэгддэг энэхүү үг нь аливаа үндэстний соёлын өвөрмөц онцлогийг илэрхийлж байдаг. Тухайлбал, монгол хэлд сэгсүүргэн дээл, тоорцог, хантааз гэх мэт үндэсний хувцас хэрэгсэл, өрх, хаяа, чагтага гэх мэт гэртэй холбоотой үгс, хонь тушгирах, үхэр мөөрөх, тэмээ туших, чөдөр зангидах, эмээлийн бүүрэг, жирэм, ганзага, гэдэс арилгах, чанах, ууц, үүц, цагаан тос, ааруул гэх мэт таван хошуу мал болон түүний ашиг шим, эдлэл хэрэгсэлтэй холбоотой үй олон үг бий.

Үндэсний онцлогийг харуулсан реалид тухайн орны ахуй амьдрал, сэтгэлгээ, шашин шүтлэг, түүх соёлын үзэгдлийн өвөрмөц байдлыг тусгасан үг хэллэг ордог. Өч төчнөөн эдгээр үгсийг төрөл зүйлээр ангилах оролдлогыг орчуулгын олон эрдэмтэн хийжээ. Тухайлбал, Влахов, Флорин нар 1) газар зүй, 2) угсаатны зүй, 3) улс төр нийгэм гэж гурав ангилжээ. Ц. Өлзийхутаг 1) мал аж ахуй, 2) зан үйл аж байдал, 3) нийтээр хэрэглэгдэх, 4) нийгэм улс төр гэж монгол хэлний үгийн сангийн хүрээнд энэхүү ангиллыг хийсэн бол Болгарын судлаач, орчуулагч Влахов, Флорин нар 1) газар зүй, 2) угсаатны зүй, 3) улс төр нийгэм гэсэн үндсэн дөрвөн хэсэгт, нэрт орчуулга судлаач Петер Ньюмарк 1) экологи, 2) эд материал, 3) нийгмийн соёл, 4) байгууллага, 5) дохио зангаа, дадал зан төлөв гэх мэт бүх хэлний түвшинд байхууцаар реали үгийн төрөл ангиллыг тус тус гаргажээ. Эдгээр судлаачдын ангилсан энэ ангилал нь тус бүртээ цааш хэд хэдэн дэд төрлөөр задарсан ихээхэн дэлгэрэнгүй шинжтэй. Мөн хэл шинжлэлийн ухааны доктор А. Шархүү 1) нийгэм улс төр, 2) амьдралын хэв шинж, эрхэлдэг аж ахуй, 3) ахуй ба оюуны хүрээ, эд өлгийн зүйлс, 4) зан үйл, ёс заншил, 5) түүхэн гэсэн ерөнхий таван төрлөөр аль ч хэлд хамааруулан авч үзэж болох байдлаар хуваасан байх бөгөөд энэ ангиллаас орчуулгын практикт соёлын зөрөөнөөс үүдэн хамгийн их бэрхшээл учруулдаг реали үгс бол гурав, дөрөвдүгээр ангилалд хамаарах үндэстэн угсаатны ёс заншил, шүтлэг бишрэл, зан үйлд холбогдох үгс, тэдгээрээс уламжлан гарсан бэлгэдэл утга, үгийн утга шилжүүлэн хэрэглэж дүр зураглал бүтээх ёс, нэгэнт түүх болж өнгөрсөн цаг үеийн хэрэг явдал, орчин ахуйтай холбогдох ойлголт ухагдахууныг илэрхийлсэн реали үгс мөн. (Шархүү, 2005)

Хүмүүс үр хүүхдүүдээ үзсэн харсан, дуулсан сонссон сонин содон зүйлсээ болон өөрсдийн үүх түүхээ ярьж өгч цээжлүүлсээр аман зохиолыг бий болгож, улмаар үүнийгээ бичиг үсгээрээ дамжуулан ном сударт буулган уран зохиолыг үүсгэжээ. Тиймээс уран зохиолд тэр чигтээ тухайн зохиолын дүрүүдийн амьдарч буй улс орон, ард иргэдийн аж амьдрал, соёл, ёс заншлыг дүрсэлсэн реали үгс элбэг бөгөөд үүнийг орчуулахад орчуулагчийг ур ухаанаа гаргаж, оновчтой

шийдлийг хийхэд хүргэнэ. Орчуулга судлаачид энэхүү үндэсний онцлог бүхий үг, хэллэгийг бусад төрлийн үгсээс дараах шинжүүдээр ялгаатай хэмээн тодорхойлжээ.

- Шинжлэх ухааны зохиол бүтээл, уран зохиол, ярианы хэлэнд зонхилон хэрэглэгддэг.
- Зөвхөн тухайн хэлний хүрээнд бүрэн утгаараа хэрэглэгддэг боловч гадаад хэлэнд галиглах замаар нэвтрэх ёс бий.
- Хоёрдмол утгагүй.
- Тухайн үгийн сангийн язгуур бүрэлдэхүүн хэсгийн хувьд уугуул хэлний үгийн сангийн шинж (авиа зүй, үг бүтэх ёс)-ийг өөртөө бүрэн агуулдаг.
- Нэр томьёоны бүрэн утгыг илэрхийлж чадна.

Судлаачдын реали үгийг тодорхойлсон эдгээр тодорхойлолтоос үзвэл энэ нь зөвхөн өөрийн хэлдээ л утга нь бүрэн илэрдэг, олон салаа утгагүй, ердөө нэг утгатай, аман ба уран зохиолд ихэвчлэн хэрэглэдэг уугуул хэлний үгс бөгөөд энэ шинжээрээ өөр хэлд орчуулан буулгахад утга нь бүрэн илэрхийлэгддэггүй дүйцэлгүй үгс байна. Үүгээрээ үе үеийн орчуулагчдын анхаарлын төвд байсаар ирсэн бөгөөд тал бүрээс нь судалдаг судлагдахуун болжээ.

Орчуулга судлаач (Osimo, 2004)-ийн бүтээлд Влахов, Флорин нарыг реали үгийн талаар дорвитой судалгааг хийсэн анхны судлаачид гээд *“Реали бол зөвхөн нэг ястан үндэстний бусдаас ялгарах зан чанар, сэтгэл сэтгэлгээ илэрхийлдэг далд утга санааг агуулсан үгс тул орчуулахад байнгын мухардалд оруулдаг.”* гэсэн тэдний үзэл санааг тэмдэглэн бичжээ. Ийнхүү реали үгс соёлын нөлөөгөөр хэлэнд тогтмол бий болсоор байх бөгөөд төгс орчуулахын тулд эх зохиолын хэл, орчуулгын хэл хоёрыг сайтар мэдэхээс гадна орчуулж байгаа зохиолчийнхоо уран бүтээлийн онцлог болон тэнд гарч байгаа үндэсний онцлог бүхий үгийг сайтар мэдвэл зохино. (Дашдаваа, 1972)

Судалгаа 1: Орчуулгын нийтлэг арга

Петер Ньюмаркыг орчуулга судлалд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн гэж бусад судлаачид нь үздэг. Тэрээр орчуулгын дараах 17 арга стратеги (боломж)-ийг тодорхойлсон байх бөгөөд энэ нь тун өргөн дэлгэрэнгүй хувилбар юм.

Хүснэгт 1. Петер Ньюмарк: Орчуулах арга стратеги

№	Арга стратеги	Орчуулгын арга	
1	Дүйцэлгүй үгийг орчуулах хэлнийх нь цагаан толгойн үсэг ашиглан галиглах	Transference (loan word, transcription)	Галиглах
2	Дүйцэлгүй үгийг эх хэлнийх нь дуудлагаар нь орчуулах хэлд галиглах	Naturalization	Нутагшуулах
3	Эх хэлний соёлын холбогдолтой үгийг орчуулах хэлний утга тохирохуйц үгээр дүйцүүлж орчуулах	Cultural equivalent	Соёлын утга дүйцүүлэх
4	Соёлын утгыг гэж тэр үгийн утгыг нөгөө орчуулах хэлд нь өөр нэгэн үг үүсгэх замаар орчуулах, мөн эх хэлний үгийн утгын тодорхой нэг хэсгийг гэж орчуулах хэлэнд утгыг нь саармагжуулах	Functional equivalent	Соёлын утга гэж дүйцүүлэх
5	Эх хэлний үгийн утгыг нэмж дэлгэрүүлэн тайлбарлаж дүйцүүлэх	Descriptive equivalent	Тайлбарлаж дүйцүүлэх
6	Эх хэлний хам сэдэвт байгаа үгийн утга санаа, дүр дүрслэл орчуулах хэлэнд дүйцэл султай тохиолдолд тэр үг /гол төлөв тэмдэг нэр, дайвар үг/ нь эх сэдэвтээ утгын хувьд чухал нөлөө үзүүлэхээргүй хэмжээнд байгаа тохиолдолд уг үгийг орчуулах хэлний ойролцоо утгатай үгээр орлуулах	Synonymy	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах

7	Байгууллагын нэр, түгээмэл хэрэглэгддэг холбоо үг, нэг бүхэл зүйлийг бүрдүүлэгч хэсэг /элемент/ зэрэг үгийг хуулбарлах	Through-translation (loan translation)	Зээлэх/хуулбарлах
8	Хэлзүйн түвшинд хувиргал хийх, тухайлбал 1) ганц тоог олон тоо болгох, тэмдэг нэрийн байрыг солих, 2) орчуулах хэлний хэл зүйн бүтэц эх хэлдээ огт байхгүй үед, 3) үгчлэн орчуулахад хэл зүйн хувьд боломжтой ч утга гарахгүй үед 4) үгийн орон зай дутагдсан үед түүнийг хэл зүйн хэлбэрээр орон зайг нь нөхөх гэх мэт, жишээ нь эх хэлний ХНӨ-ийг орчуулах хэлд тусдаа бие даасан ЗНӨ болгож холбох үгээр холбож хувиргах	Shifts of transpositions	Хэл зүйн хувиргал хийх
9	Үгчлэн орчуулаад ч утга нь төдийлөн олигтой гарч чадахгүй бол уг мэдээллийн утга санааг хадгалан өөр үгсээр чөлөөтэй орчуулах	Modulation	Утгачлан хувиргах
10	Өмнө нь орчуулаад нэгэнт тогтчихсон, олонд танигдчихсан, албан ёсны болчихсон тэр үгийг шууд ашиглах	Recognized translation	Танигдсан үг ашиглах
11	Гол төлөв аль нэг байгууллага, салбарт шинээр бий болж байгаа нэр томъёог үгчлэн орчуулж хашилт (“”) -ын дотор хийж түр ашиглаж байгаад тун удалгүй уг үгийг хэрэглээнээс хасах	Translation label	Түр орчуулга хийх
12	Эх хэлнээс орчуулах хэлд орчуулалгүй хаясан утга санааг тухайн өгүүлбэр, хам сэдэвтэй тун ойролцоо өөр нэг өгүүлбэр, хам сэдэвт уг утгыг шингээж оруулах	Compensation	Нөхөх
13	Үгсийг бүрэлдэхүүний утга утгаар нь буюу нэг, хоёр, гурав, дөрөв гэх мэт үг үгээр нь салгаж задалж орчуулах	Componential analysis	Бүрэлдэхүүнэ эр нь задлах
14	Эх хэлнээс нөгөө хэлэнд орчуулга хийхэд илүүдэж байгаа үгийг хасах, мөн дутаж байгаа үгийг нэмэх замаар орчуулах	Reduction and expansion	Үг хасах, нэмэх
15	Санаа нь бүрхэг, дутуу эсвэл далд утга санаа агуулсан зэрэг ойлгомжгүй бичигдсэн, мөн бичсэн эзэн нь тодорхойгүй бол уг мэдээллийг нэмж дэлгэрүүлэх, тайлбарлах	Paraphrase	Өөр үгээр нэмж тайлбарлах
16	Соёлын холбогдолтой үг, хэллэг, өгүүлбэрийг орчуулахдаа хоёр ба түүнээс дээш аргыг хослуулж хэрэглэх	Couplets	Хосолмол арга ашиглах
17	Соёлын зөрүүтэй мэдээллийг хоёр хэлний хооронд дамжуулахдаа нэмэлт тайлбар хийх, жишээ нь, 1) бичвэрийн дотор хаалт, хашилтан дотор тайлбар бичих, 2) бичвэрээс тусдаа хуудасны доор зүүлт хийх, орчуулж байгаа бүлгийн эцэст, эсвэл тухайн орчуулж буй номын эцэст нэмэлт тайлбар оруулах гэх мэт	Notes, addition, glosses	Нэмэлт тайлбар орлуулах

Петер Ньюмаркын тодорхойлсон эдгээр арга дотроос галиглах, нутагшуулах, хуулбарлах, танигдсан үг ашиглах, түр орчуулга хийх гэсэн 4 арга нь эх хэлний үгийн утгыг орчуулах хэлд бүрэн буулгаж чадахгүй бол үлдсэн 13 нь утгын дүйцлийг хангах төрөл бүрийн арга замыг эрэлхийлсэн аргууд юм. Тэрээр соёлын ба соёлын бус мэдээллийг орчуулах арга боломжийг ийнхүү тодорхойлж 1988 онд “Орчуулгын сурах бичиг” бүтээлээ гаргасан нь дараа дараагийн олон судлаачдын судалгааны ажлын гол эх үүсвэрийн нэг болжээ.

Винэй, Дарбэлнэт нарын орчуулга судлаачид орчуулгад ашиглаж байгаа олон аргыг нэгтгэж зээлэх, хуулбарлах, үгчлэх, үгийн аймгийн хувиргал хийх, утгачлан хувиргах, дүйцүүлэх, нийцүүлэх гэсэн 7 аргыг орчуулгын нийтлэг аргууд гэж үзжээ. Орчуулагч хүн зорилгодоо нийцүүлж энэ 7 аргыг нэг нэгээр нь эсвэл хэд хэдээр нь нийлүүлэн ашиглаж орчуулгаа хийж болно. (Vinay, J.P., & Darbelnet, J., 2000) Эдгээр хоёр эрдэмтний нэгтгэсэн

долоон арга дээр дараа нь орчуулга судлаач Габриела Боско нөхөх аргыг нэмж санал болгоод, энэ 8 аргыг орчуулгад түгээмэл хэрэглэгдэж байгаа аргууд гэж үзээд дараах жишээгээр тайлбарлажээ.

Хүснэгт 2. Винэй, Дарбэлнэт: Орчуулах арга стратеги

№	Арга стратеги	Жишээ	Орчуулгын нийтлэг арга		
1	Орчуулахгүйгээр шууд зээлж авах	Café-/Франц/ → cafe /Англи/	Borrowing	Зээлэх	Шууд
2	Шууд үгчлэн орчуулж хуулбарлах	Biergarten-/Герман/ → beer garden /English/	Calque	Кальк/хуулбарлах	
3	Өгүүлбэрийг үг нэг бүрээр нь орчуулах	El equipo está trabajando para terminar el informe. /Испани/ → The team is working to finish the report. /Англи/	Literal translation or word for word translation	Үгчлэх	
4	Үгсийн аймгийг өөрчилж орчуулах	Hand knitted-/Англи: noun+participle/ → Tejido a mano /Испани: participle + adverbial phrase/	Transposition	Үгийн аймаг хувиргах	Шууд бус
5	Өөр үг, хэллэгээр орчуулах	Te lo dejo. /Испани/ → үгчлэн орчуулбал “I leave it to you.” гэж орчуулахыг утгачлан “You can have it.” гэж өөр үгээр орчуулж байна. /Англи/.	Modulation	Утгачлан хувиргах	
6	Үгийн утгыг найруулгын болон бүтцийн янз бүрийн арга хэрэглүүр ашиглан шинээр үг бүтээж бий болгох	Ouch /Англи/ Aie /Франц/ Гараа алханд цохьсон англи хүний Ouch гэж дуу алдахыг францаар Aie гэж дүйцүүлнэ.	Reformulation or Equivalence	Дүйцүүлэх	
7	Соёлын агуулгатай үг, мэдээлэл орчуулах хэлд огт байхгүй тохиолдолд эх хэлнийхээс тэс өөр үг, хэллэг, өгүүлбэрээр орчуулах хэлэнд хувиргаж орчуулах	Pinho /Испани: рестораны нэг төрлийн хоол/ → kebab /Англи/	Adaptation	Нийцүүлэх	
8	Соёлын онцлогийн улмаас орчуулах боломжгүй болсон үгийн утгыг тухайн тэр хэсгээс нь тусдаа өөр нэг хэсэгт утгыг нь шигтгэн оруулах	Tú албан хэлбэр нь usted /Испани/, Tu, vous /Франц/, Du, sie /Герман/ → you /Англи/	Compensation	Нөхөх	

Дээрх 8 аргыг шууд ба шууд бус /чөлөөт/ хоёр ангилалд хуваасан (Bosco) бөгөөд зээлэх, хуулбарлах, үгчлэх аргыг шууд, үгийн аймаг хувиргах, утгачлан хувиргах, дүйцүүлэх, нийцүүлэх, нөхөх гэсэн 5 аргыг шууд бус гэсэн ангилалд багтаажээ.

Судалгаа 2: Реали үгийг орчуулах нийтлэг арга

Үндэсний онцлог бүхий үг хэллэгийг нэг хэлээс нөгөө хэлд орчуулахад шууд онож дүйх үг гэж байхгүй. Тиймээс реали үгийг орчуулах бэлэн жор байдаггүй (Дашдаваа, 1998) ч нэг ард түмний

өвөрмөц онцлог амьдралыг харуулсан олон олон шилдэг зохиолыг өөр нэг ард түмэнд ойлгуулан орчуулах оролдлогыг хийсэн орчуулагчдын туршлагаас үүдэлтэй янз бүрийн аргууд бий болжээ. Үүнд галиглахаас эхлээд бүтэн хам сэдвийн хүрээнд хүртэл орчуулдаг олон арга техник багтана.

Орчуулга судлаачид орчуулах арга стратегийг тодорхойлохдоо заримыг нь тодорхой нэр томъёогоор нэрлэсэн, бас нэрлээгүй гэх мэт янз бүр байна. Судлаачийн зүгээс реали үгийг орчуулж буй аргуудыг судалгааны объект болгон авч ашиглаж байгаа тул орчуулга судлаачдын тодорхойлон нэрлэсэн, нэрлээгүй аргуудыг нэг ижил нэр томъёогоор оноон нэрлэж тайлбарлах шаардлагын улмаас орчуулагчдын өөрсдийн нэрлэсэн нэр томъёог энэхүү судалгааны ажлын хүрээнд нэрлэж буй нэр томъёотой давхар тэмдэглэж байгаа болно.

Орчуулга судлаач Гидеон Тури “*Реали үгсийг нэгд, эх бичвэрт нь нийцүүлэх, хоёрт, орчуулж буй хэлний соёлд бүрэн нийцүүлэх гэсэн үндсэн хоёр зарчмаар орчуулна.*” гэж үзээд дараах 10 аргыг санал болгожээ.

Хүснэгт 3. Гидеон Тури: Реалиг орчуулах арга стратеги

№	Арга стратеги	Жишээ	Орчуулгын нийтлэг арга		
1	Эх хэлний үгийг орчуулах хэлний цагаан толгойн үсгээр орлуулан галиглах	Gideon Toury /Израйл/ → Гидеон Тури /Монгол/	Transliteration	Үсэгчлэн галиглах	
2	Орчуулах хэлний авиазүйн зарчмыг баримтлан эх хэлний үгийг галиглах	Kashmir /Хинди/ → cachemire /Франц/	Transcription	Авиачлан галиглах	
3	Шинээр үг бүтээх буюу калькын (хуулбарлах) арга	Flea market /Англи/ → <i>marché aux puces</i> /Франц/	Calque	Кальк/ хуулбарлах	
4	Эх хэлний үгтэй ижил төстэй боловч орчуулж буй хэлний нутгийн шинжийг агуулсан шинэ үг зохиох	mu'adhdhin /Араб/ → muezzin /Ислам/	Neologism	Шинэ үг зохиох	Шууд бус
5	Эх хэлний үгтэй ойролцоо холбоо хамаарал бүхий утгатай өөр үгээр буулгах	Cappuccino /Итали/ → latte /Англи/, италиар сүү гэсэн утгатай үгээр	Synonymy	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах	
6	Өөр үг хэллэгээр тайлбарлах	Synagogue /Грек/ → Еврей сүм гэсэн өөр үгээр буулгах	Explanatory	Тайлбарлах	
7	Орчуулах хэлд байдаг ижил төсөөтэй үгээр орлуулах	Jugendstil /Герман/ → art nouveau /Франц/ буюу үгчилбэл “шинэ урлаг” гэсэн үгээр орлуулах	Equivalent	Дүйцүүлэх	
8	Олон улсын шинжтэй нийтлэг үг хэллэгээр орлуулан орчуулах	Beaujolais /Франц/ → улаан дарс	International word	Олон улсын шинжтэй үгээр орлуулах	
9	Реали үгийн үүсэл гарвал, материал, шинж байдал зэргийг заасан тэмдэг нэрээр тодотгон нэмж дэлгэрүүлэх	Pampa → Argentine pampa. Тал нутаг гэсэн утгатай Pampa гэсэн үгийг харьяалагдаж буй газар зүйн бүсийнх нь Argentine гэж тодотгох	Adjective	Тэмдэг нэрээр тодотгох	

10	Өгүүлбэр болон хам сэдвийг утгаар нь орчуулах	Does the National Health Service cover this drug? /English/ → Is this drug expensive /American/ “Энэ эмийг эрүүл мэндийн үндэсний газраас хөнгөлдөг үү?” гэсэн өгүүлбэрийг “Энэ эм их үнэтэй юү?” гэж утгачлан орчуулах	Modification	Утгачлан хувиргах	
----	---	---	--------------	-------------------	--

Гидеон Туригийн реали үгийг орчуулах боломжтой гэж үзсэн дээрх аргууд бүгд өмнөх эрдэмтдийн тодорхойлсон орчуулгын аргуудад бүрэн тулгуурласан, тэдгээрийн аль нэгэн шинжийг шингээсэн байх бөгөөд зарим талаараа орчуулах арга стратегийг задалсан, зарим талаараа нэгтгэсэн зэрэг шинжтэй байна.

Энэ судалгаанд монгол хэлний реали үгийг англи хэлэнд орчуулж байгаа нийтлэг аргыг илрүүлэн тогтоох зорилготой бөгөөд монгол судлаачдын тодорхойлсон аргуудаас авч үзвэл, Монгол улсын гавьяат багш А. Шархүү дүйцэлгүй үгийг нэг хэлээс нөгөө хэлэнд орчуулах дараах 4 арга боломж байна гэжээ.

Хүснэгт 4. А. Шархүү: Реалиг орчуулах арга боломж

№	Орчуулах арга боломж	Орчуулгын нийтлэг арга		
1	Хуулбарлан орчуулах	Calgue	Кальк/ хуулбарлах	Шууд
2	Реали үгийн галиглан буулгах	Transcribing	Галиглах	
3	Утга ойролцоо үг хэллэгээр нөхөн орчуулах	Synonymy	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах	Шууд бус
4	Уг реали үгийн илэрхийлж буй байгаа утга санаа, дүр төсөөллийг өөр үг хэллэгээр тайлбарлан буулгах	Explanatory	Тайлбарлах	

Судлаач Ё. Баярсайхан “Монгол хэлний реалийг орос хэлэнд орчуулсан нь” өгүүлэлдээ монгол хэлээс орос хэлд реалиг дараах 7 аргаар орчуулах боломжтой гэж үзсэн байна.

Хүснэгт 5. Ё. Баярсайхан: Реалиг орчуулах арга боломж

№	Орчуулах арга боломж	Орчуулгын нийтлэг арга		
1	Галигаар буулгах	Transcribing	Галиглах	Шууд
2	Хуулбарлаж, шинэ үг бүтээх	Calgue & Neologism	Кальк/ хуулбарлах, шинэ үг зохиох	
3	Орчуулгад зүүлт тайлбар хийх	Footnote	Зүүлт хийх	
4	Утга ойролцоо үгээр орлуулах	Synonymy	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах	Шууд бус
5	Тайлбарлан орчуулах	Explanatory	Тайлбарлах	
6	Нөгөө хэлд байгаа дүйх үгээр орчуулах	Equivalent	Дүйцүүлэх	
7	Галигаар буулгах, тайлбарлан орчуулах хоёр аргыг хослуулах	Transcribing & explanatory	Галиглах, тайлбарлах	Шууд, шууд бус

Судлаач Ж. Ганцэцэг “Нэр томьёо, үг хэллэгийн орчуулга” судалгаандаа монгол хэлний сүү, цагаан идээтэй холбоотой үг хэллэгийг орчуулж байгааг аргуудыг судалж үзээд, дараах 6 аргыг боломжит аргууд гэж үзжээ.

Хүснэгт 6. Ж. Ганцэцэг: Реалиг орчуулах арга боломж

№	Орчуулах арга боломж	Жишээ	Орчуулгын нийтлэг арга		
1	Хуулбарлан орчуулах	Сүү загсаах-to cool milk, цагаан идээ-white meal	Calque	Кальк/ хуулбарлах	Шууд
2	Үсэгчлэн буулгах, галиглах	Айраг-airag, дээл-deel	Transliteration	Үсэгчлэн галиглах	
3	Тайлбарлан орчуулах	Хусам– khusam (the scratched down crusted milk at the bottom of the pan)	Explanatory	Тайлбарлах	Шууд бус
4	Зүйлчлэн орчуулах	Сүү хөөрүүлэх-to simmer milk so as to clot the cream	Synonymy	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах	
5	Ижилтгэн орчуулах	Идээ-food, нэрмэл архи-distilled liquor	Equivalent	Дүйцүүлэх	
6	Галиглах, тайлбарлах аргыг хослуулах	Айраг-airag (mare's milk, Mongolian's favorite drink)	Transcribing & explanatory	Галиглах, тайлбарлах	Шууд, шууд бус

Монгол улсын гавьяат багш А. Шархүүгийн санал болгосон галиглах, хуулбарлах, ойролцоо утгатай үг хэллэгээр оруулах, тайлбарлах гэсэн 4 арга нь цаг хугацааны хувьд Гидеон Туригийн ангиллаас өмнө тодорхойлогдсон бөгөөд цөөн тоотой ч реалиг орчуулах гол аргуудыг багтааснаараа онцлог байна. Ё. Баярсайхан, Ж. Ганцэцэг нарын судлаачдын судалгааны үр дүнг харахад хосолмол арга ашиглах буюу соёлын онцлог бүхий мэдээллийг орчуулахад хоёр, гурав, дөрвөн аргыг хослуулж реали үгийг хэд хэдэн аргаар орчуулах нь оновчтой шийдлийн нэг мөн (Newmark, 1998) гэж үздэг үзэл баримтлалыг дэмжиж байгааг харуулж байна.

График 1. Реали үг, хэллэгийг орчуулах нийтлэг арга




А. Шархүү, Ё. Баярсайхан, Ж. Ганцэцэг, Гидеон Тури нарын дөрвөн судлаачийн реали үг хэллэгийг орчуулах боломжтой гэж үзсэн аргыг нэгтгэж үзэхэд дээрх 11 арга судалгаагаар гарч ирлээ. Эдгээрээс галиглах, хуулбарлах, ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах, дүйцүүлэх гэсэн таван аргыг дөрвөн судлаач дөрвүүлээ үндэсний онцлог бүхий үг хэллэгийг орчуулах боломжтой гэжээ.

Судалгаа 3: Монгол хэлээс англи хэлд орчуулсан реали үгийн орчуулга ба арга


Энэхүү судалгаанд Н. Мөнхбаяр, Б. Нямсүрэн нарын “Learning English through literature” хэмээх гарын авлагыг авч ашиглалаа. Тус гарын авлагад монголын шилдэг 16 зохиолчийн 32 өгүүллийг, орчуулсан англи хувилбартай нь хамт оруулжээ.

График 2. Монголын уран зохиолын реалиг орчуулж буй нийтлэг арга



Судалгааны хэрэглэгдэхүүн болгон авсан 32 өгүүллэгийг орчуулсан гадаад, дотоод орчуулагчдын ашигласан аргыг нэгтгэж үзэхэд галиглах, тайлбарлах, утга ойролцоо үг хэллэгээр орлуулах, хуулбарлах, дүйцүүлэхээс гадна галиглах аргыг тайлбарлах болон хуулбарлах түүнчлэн дүйцүүлэхийг тайлбарлах аргатай хослуулан хэрэглэжээ. Үүнээс галиглах аргыг (27%), тайлбарлах аргыг (26%), дүйцүүлэх аргыг (25%) –иар тус тус илүү ашигласан байна.

График 3. Монгол, гадаад орчуулагчдын реали үгийг орчуулахад ашиглаж байгаа аргын харьцуулалт



Судалгаанаас гарсан үр дүнгээс үзвэл, монгол орчуулагчид галиглах аргыг 25%, тайлбарлах аргыг 31%, гадаад орчуулагч галиглах аргыг 30%, дүйцүүлэх аргыг 28%-р тус тус түлхүү ашигласан байна. Галиглах аргыг аль ч орчуулагчид илүү хувиар ашигласан нь өгүүллэгт хүн, газар орны нэр ихээхэн орсонтой холбоотой. Соёлын онцлог бүхий реали үг хэллэгийг гадаад орчуулагч дүйцүүлэх аргаар голчлон орчуулсан нь өөрийн төрөлх хэл нь орчуулах хэл байсан нь давуу тал болсон байх гэж үзэж байна. Харин монгол орчуулагчид тайлбарлах аргыг илүүтэй авч ашигласан нь уран зохиолыг төрөлх монгол хэлээр нь бичсэнтэй холбоотой байж болох юм гэж таамаглаж байна.

Судалгаа 4: Уран зохиолын реали үгийг орчуулах болон орчуулж байгаа аргын харьцуулалт

Монголын уран зохиолыг англи хэлэнд орчуулахад түгээмэл ашиглаж байгаа орчуулгын аргыг орчуулгын судлаачдын реали үгийг орчуулах боломжтой гэж үзэж тодорхойлсон нийтлэг аргуудтай харьцуулахад дараах дүр зурагтай байна.

Хүснэгт 7. Монголын уран зохиолын реали үгийг орчуулж байгаа аргууд

№	Реали үгийг орчуулах боломжтой арга	Уран зохиолын орчуулгад ашиглаж байгаа арга	
		Хэрэглээ	Хувь
1	Галиглах	+	27%
2	Хуулбарлах	+	5%
3	Шинэ үг зохиох	-	-
4	Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах	+	10%
5	Тайлбарлах	+	26%
6	Дүйцүүлэх	+	25%
7	Олон улсын шинжтэй үгээр орлуулах	-	-
8	Тэмдэг нэрээр тодотгох	-	-
9	Утгачлан хувиргах	-	-
10	Зүүлт хийх	-	-
11	Галиглах, тайлбарлах	+	6%
		+ (Галиглах хуулбарлах, дүйцүүлэх тайлбарлах)	1%

Орчуулга судлаачдын санал болгож байгаа уран зохиолд илрэх реали үгийг орчуулах боломжтой 11 аргаас 6-г нь хэрэглэсэн үр дүн гарлаа. Мөн үүн дээр нэмээд галиглах, хуулбарлах, дүйцүүлэх, тайлбарлах аргыг хослуулан ашиглажээ.

Олон улсын шинжтэй үгээр орлуулах, тэмдэг нэрээр тодотгох, утгачлан хувиргах, зүүлт хийх, шинэ үг зохиох аргыг энэ судалгааны хэрэглэгдэхүүний хүрээнд ашиглаагүй байна. Энэ нь 1-т төрөл бус хэлний орчуулга тул утгачлан хувиргах аргыг ашиглаагүй, 2-т мэргэжлийн биш уран зохиолын орчуулга учраас зүүлтийг тэр бүр хийгээгүй, 3-т эх хэл нь монгол, орчуулах хэл нь англи хэл мөн, уран зохиолын орчуулга зэрэг шалтгааны улмаас олон улсын шинжтэй үгээр орлуулаагүй, мөн орчуулагчдад тэмдэг нэрээр тодотгох, шинэ үг зохиох аргыг хэрэглэх шаардлага үүсээгүй байсан байж болох юм гэж үзэж байна.

Судалгаа 5: Уран зохиолын реали үгийг орчуулж байгаа аргуудыг утга илэрхийлж байгаа түвшнээр нь эрэмбэлэх боломж

Энэ судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байгаа 32 монгол өгүүллэгт орсон үндэсний онцлог бүхий үг хэллэгийг орчуулсан 8 аргын 6 нь дүйцүүлэх, утга ойролцоо үг хэллэгээр орлуулах, тайлбарлах, галиглах тайлбарлах, галиглах хуулбарлах, дүйцүүлэх хуулбарлах аргыг хослуулах зэрэг шууд бус аргууд, 2 нь галиглах, хуулбарлах шууд арга юм.

Хуулбарлах аргаар орчуулсан үгс нь тухайн эх хэлний үгийн утгыг орчуулах хэлд дамжуулах боломж нь сул байдаг бол галиглах аргаар орчуулсан үгийн утга огт гардаггүй. Гэхдээ галиглах аргаар хүн, газар орон, уул усны зэрэг оноосон нэрийг орчуулахад тэдгээрийн утга гарсан эсэхийг магадлах шаардлагагүй байдаг. Харин тухайн улс үндэстэн, угсаатны соёлыг илэрхийлсэн реали үгийг шууд аргаар орчуулахад энэ төрлийн үг хэллэгийн утгыг илэрхийлж гаргаж чадахгүй гэж үздэг тул аль болох эдгээр аргыг хэрэглэхээс зайлсхийх нь зүйтэй гэж орчуулга судлаачид зөвлөдөг.

Уран зохиолын реали үгийг орчуулахдаа тухайн үгийн утгыг орчуулах хэлний уншигч, сонсогчдод аль болох ойлгомжтой, тодорхой хүргэхийн тулд шууд бус орчуулгын аргуудыг ашиглах нь үр дүнтэй. Гэхдээ уг аргууд нь уг үгийн утгыг цаад хэлэнд хэр зэрэг, ямар түвшинд ойлгуулан дамжуулж байгааг мэдэж хэрэглэж байх нь орчуулагчид илүү их үр өгөөжийг бий болгоно.

Дээрх тайлбаруудыг үндэслэн орчуулагч Б. Дамдин, Н. Хандбалдир, Д. Алтангэрэл, Simon Wickham Smith нарын дүйцүүлэх, утга ойролцоо үг хэллэгээр орлуулах, тайлбарлах, хосолмол арга ашиглах гэсэн 4 аргыг утга илэрхийлж буй түвшнээр нь эрэмбэлэх оролдлогыг хийлээ. Уг аргуудыг ашиглаж орчуулсан зарим жишээг доор үзүүлэе.

Дүйцүүлэх: Төрөл бус хэлний хооронд соёлын утгатай үг хэллэгийг орчуулахад тохирсон арга бол дүйцүүлэх юм.

Хүснэгт 8. Дүйцүүлэх арга ба орчуулгын зарим жишээ

Тодорхойлолт	Жишээ	
	Монгол	Англи
- Эх хэлний соёлын холбогдолтой үгийг орчуулах хэлнийх нь утга тохирохуйц үгээр дүйцүүлж орчуулах (<i>Петер Ньюмарк</i>) - Орчуулах хэлэнд байдаг ижил төсөөтэй үгээр орлуулах (<i>Гидеон Тури</i>) - Үгийн утгыг найруулгын болон бүтцийн янз бүрийн арга хэрэглүүр ашиглан шинээр үг бүтээж бий болгох (<i>Винэй, Дарбэлнэт</i>)	Том <u>тулганы</u> хажууд	Around the large <u>brazier</u>
	гөлөм	Saddle-cloth
	Улаач	Guide
	Айраг <u>бүлэх</u>	To <u>churn</u> the airag
	<u>Ханхалзаж</u> явдаг болов.	Gombo was <u>full of himself</u> .

Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах: Энэ нь соёлын утга шингээсэн үндэсний онцлог бүхий үг хэллэгийг орчуулах хэлний ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулан орчуулах арга юм.

Хүснэгт 9. Ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах арга ба орчуулгын зарим жишээ

Тодорхойлолт	Жишээ	
	Монгол	Англи
- Эх хэлний үгтэй ойролцоо холбоо хамаарал бүхий утгатай өөр үгээр буулгах (<i>Гидеон Тури</i>) - Эх хэлний хам сэдэвт байгаа үгийн утга санаа, дүр дүрслэл орчуулах хэлэнд дүйцэл султай тохиолдолд тэр үг /гол төлөв тэмдэг нэр, дайвар үг/ нь эх сэдэвтээ утгын хувьд чухал нөлөө үзүүлэхээргүй хэмжээнд байгаа тохиолдолд уг үгийг нөгөө орчуулах хэлний ойролцоо утгатай үгээр орлуулах (<i>Петер Ньюмарк</i>)	Хурган <u>дээлийн</u> доороос	Under the lamb skin <u>coat</u>
	Арван алд <u>аргамж</u>	A <u>rope</u> ten fathoms in length
	Зуны <u>нажир</u> халуун цаг юмсан.	It was a summer of <u>severe</u> heat.
	Хар булигар <u>богц</u> барьсаар	Carrying a <u>saddle-bag</u> of black Russian leather

Тайлбарлах: Аливаа улс үндэстэн, угсаатны соёлын онцлогийг харуулсан үгийн утга агуулга, дүр дүрслэл гэх зэргээр орчуулах хэлэнд оноох үг олдохгүй тохиолдолд түүнийг их бага хэмжээгээр тайлбарлан орчуулах арга.

Хүснэгт 10. Тайлбарлах арга ба орчуулгын зарим жишээ

Тодорхойлолт	Жишээ	
	Монгол	Англи
Өөр үг хэллэгээр тайлбарлах (<i>Гидеон Тури</i>)	Гэрийн хоймор	The seat of honor
	Дээвэр цаваг	Felt roof patches around the enclosure
	Хар сүлд	The shamanic black military banner

Эх хэлний үгийн утгыг нэмж дэлгэрүүлэн тайлбарлаж дүйцүүлэх (Петер Ньюмарк)	Угаас омголон морь	He was fundamentally a proud horse
---	--------------------	------------------------------------


Хосолмол арга: Уран зохиолд илрэх үндэсний онцлог бүхий үг хэллэгийг дээр дурдсан аргуудын аль нэгээр нь орчуулахад утга нь хараахан бүрэн гүйцэд бууж чадахгүй тохиолдолд орчуулгын тусгай аргууд дотроос аль тохиромжтойг нь сонгож хэд хэдэн аргыг нэг дор ашиглана.

Хүснэгт 11. Хосолмол арга ба орчуулгын зарим жишээ

Тодорхойлолт	Жишээ		
	Арга	Монгол	Англи
Соёлын холбогдолтой үг, хэллэг, өгүүлбэрийг орчуулахдаа хоёр ба түүнээс аргыг хослуулж хэрэглэх (Петер Ньюмарк)	Галиглах, хуулбарлах	Жижиг бор гэрийн эсгий үүд	Felt door of small ger
	Галиглах, тайлбарлах	Гэрийн зүүн хаяанд	In the left-hand part of the ger
	Дүйцүүлэх тайлбарлах	Шимийн архи	Brandy, made from milk

Ихэнх орчуулга судлаачид орчуулга бол нэг үгийг нөгөө үгээр сольж хувиргахаас илүү утга санааг нь тайлбарлах, тайлах эсвэл утгыг шинээр томъёолох үйл явц гэж үздэг (Newmark, 1998) гэсэн үзэл баримтлалыг эш үндэс болгон дараах 4-н аргыг утга илэрхийлж буй түвшнээр нь эрэмбэлэх оролдлого хийснийг Зураг 1-т үзүүлье.

Зураг 1. Уран зохиолын реали үгийг орчуулах аргын эрэмбэ



Соёлын утга бүхий үгсээр элбэг уран зохиолын орчуулгыг эдгээр 4 аргаар голдуу орчуулсан байгаа бөгөөд эдгээрээс эхлээд дүйцүүлэх аргыг, үүгээр утга хараахан илэрч чадахгүй бол ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулан орчуулна. Энэ хоёр аргын аль алинаар нь эх хэлний үгийн утгыг илэрхийлж чадахгүйд хүрвэл тайлбарлан орчуулна. Эдгээрийн аль алинаар ч үгийн утгыг дамжуулах боломжгүй бол 2 ба түүнээс дээш аргыг хослуулан ашиглах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна. Гэхдээ дэвшүүлсэн энэ саналын хувьд энэхүү судалгаанд дараах хэд хэдэн

хязгаарлагдмал байдал илэрч байгааг харгалзах нь зайлшгүй юм. Эдгээр нь,

- Эх хэл нь монгол хэл, орчуулах хэл нь англи хэл
- Реали үг нь монгол үндэстнийх
- Олон биш цөөн орчуулагчийн жишээ
- уран зохиолын төрөл нь өгүүллэг зэргийг харгалзах юм.

Дүгнэлт, санал



Монголын уран зохиолын нэгэн төрөл болох өгүүллэгт орсон реали үгсийг англи хэлээр орчуулахад галиглах, хуулбарлах, дүйцүүлэх, ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах, тайлбарлах гэсэн 5 дан арга, галиглах аргыг хуулбарлах болон тайлбарлах аргатай мөн дүйцүүлэх тайлбарлах арга зэргийг хослуулсан зэрэг 3 арга, нийт 8 аргыг түгээмэл ашиглаж байна.

Эдгээр 8 аргаас хүний, газар орны гэх мэт оноосон нэрээс бусад монгол үндэстний ёс заншил, аж амьдрал, зан үйлийн холбогдолтой реали үгсийг англи хэлээр орчуулахад ашиглаж байгаа дүйцүүлэх, ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах, тайлбарлах болон бусад хосолмол аргуудыг утга илэрхийлж байгаа түвшнээр нь эрэмбэллээ. Эрэмбийн 1-т дүйцүүлэх, 2-т ойролцоо утгатай үг хэллэгээр орлуулах, 3-т тайлбарлах, 4-т хосолмол аргыг оруулсан болно.



Энэ судалгааны ажил нь зөвхөн монголын уран зохиолын реали үгийг англи хэлээр орчуулсан жишээгээр хязгаарлагдаж байгааг тул энд санал болгосон реали үгийг орчуулах аргуудын эрэмбэ дарааг бүх төрлийн хэл, бүх төрлийн уран зохиолын хэлбэр, бүх хэлд ашиглах боломжтой гэж үзэхгүй бөгөөд тэр бүрт нийцсэн эрэмбийн хувилбарууд байх боломжтой гэж үзэж байна.

Ном зүй

- Ганцэцэг, Ж. (2010). Нэр томъёо, үг хэллэгийн орчуулга /сүү, цагаан идээтэй холбоотой үндэсний онцлог бүхий үг хэллэгийн жишээн дээр/. *Орчуулах эрдэм-2*.
- Дашдаваа, Д. (1972). Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь . *Орчуулах эрдэм*.
- Дашдаваа, Д. (1998). Уран зохиолын орчуулгын тухай. *Орчуулах эрдэм*.
- Жаргалсайхан, Ч. (2011). Үндэсний онцлог бүхий дүйцэлгүй үг /реали/-ийг Д. Нацагдоржийн хүүрнэл зохиолын орчуулгад дамжуулсан байдал. *Орчуулах эрдэм-3*.
- Мөнхбаяр, Н., Нямсүрэн, Б (2017). *Learning English through literature*. Улаанбаатар: Соёмбо.
- Сүхбаатар, Ц. (1998). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: Адмон.
- Шархүү, А. (2005). Үндэсний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал.
- Халиунаа, О. (2021). Үндэсний онцлог бүхий үг хэллэгийг орчуулах аргууд.
- Bosco, G. (огноо байхгүй). *Translation techniques*. Interpro translation solutions .
- Dictionary.com. (огноо байхгүй). *what is the origin realia?*
- Newmark, P. (1998). *A textbook of translation (Vol 66)*. New York: Prentice Hall.
- Osimo, B. (2004). Neperovodimoe v perevode. Realii. *Manuale del Traduttore, Seconda Edizione*, 63.
- Vinay, J.P., & Darbelnet, J. (2000). A methodology for translation. L. Venuti-Д, *In the translation studies*



ЭРДМИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ





**ОРЧУУЛГЫН ӨДӨРТ ЗОРИУЛСАН ЭРДМИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:
“ОРЧУУЛГААР НЭГДЬЕ, ОЛИМПИЗМЫГ ДЭЛГЭРҮҮЛЬЕ!”⁶⁸**

Ш. Эгшиг: Сайн байцгаана уу? Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль нь Хүмүүнлэгийн ухааны салбарын гадаад хэлний хөтөлбөрүүд, тэр дундаа гадаад хэлний орчуулгын хөтөлбөртэй. Бид гадаад хэлний орчуулга хөтөлбөрийн семинараа эхэлж байна. Семинарынхаа талаар товчхон танилцуулъя. Олон улсын орчуулагчдын холбоо, нийгэмлэг болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас олон улсын орчуулгын өдрийг анх 1992 оноос хойш тэмдэглэж эхэлсэн. Орчуулгын өдөр нь жил болгоны 9-р сарын 30-ны өдөр байдаг. Орчуулгын өдрийг дэлхий нийтээрээ тэмдэглэхийн тулд жил болгон тодорхой уриа гаргадаг бөгөөд орчуулгын салбарыг хөгжүүлэхэд тулгамдаж байгаа чиглэл рүү хандсан уриатай байдаг. Бид бүхэн 4 удаа орчуулгын өдрийг тэмдэглэж өнгөрүүлжээ. Тэмдэглэхдээ гадаад хэлний орчуулга хөтөлбөрийн болон гадаад хэлний орчуулга зүйн профессорын хамтлагаас энэ өдрийг хэлэлцүүлэг өрнүүлэх эсвэл өөр ямар нэгэн үйл ажиллагаа өрнүүлэн тэмдэглэж иржээ. Энэ жилийн хувьд “Орчуулгаар нэгдье” гэсэн уриатай байгаа. Сая болж өнгөрсөн Токиогийн олимпыг нэвтрүүлсэн Монгол улсын 13 телевизийн спортын нэвтрүүлгийг дамжуулах байдал болон орчуулгын үйл явцыг бид бүхэн Монгол орон даяар үзлээ. Үүнтэй холбогдуулан орчуулгаар нэгдье гэдгийг олимпизмтай холбох санал манай гадаад хэлний орчуулгын багаас гарсан юм. “Орчуулгаар нэгдье, олимпизмыг дэлгэрүүлье” гэсэн уриатайгаар энэ удаагийн хэлэлцүүлгийг хийж байна. Та бүхнийг энэ хэлэлцүүлэгт хүрэлцэн ирж оролцож байгаад талархаж байна. Манай энэ үйл ажиллагаанд бид эрдэм шинжилгээний гэхээсээ илүү манай оронд спортын салбарын орчуулгын асуудал ямар байгаа вэ гэдэгт хандуулъя гэсэн үүднээс энэ хэлэлцүүлгийг хийж байгаа. Тиймээс энэ салбарын хоёр эрхмийг урьсан юм. Хэлэлцүүлгийг нээх явцад спортын сэтгүүл зүй орчуулгатай хэрхэн холбогддог талаар хэдхэн үг хэлье гэж бодож байна. Даяаршиж байгаа дэлхийд орчуулгын үүрэг нэмэгдэж байгаа, орчуулгын зах зээл дэлхий дээр хамгийн их өсөлттэй байгаа зах зээл. Гэхдээ орчуулгын салбар бол эрдэм шинжилгээний судалгааны чиглэлээсээ илүү зах зээл, бизнесийн чиглэлд илүү хөгжиж байгаа хандлага ажиглагддаг. Мэргэжлийн орчуулга гэх салбар байдаг бөгөөд бүх мэргэжилтэй орчуулга холбогддог. Тэр дундаа анагаах ухааны чиглэлийн орчуулга, шүүхийн чиглэлийн орчуулга бол тусгайлан мэргэжлийн чиглэл рүү хандсан орчуулгын салбар юм. Бусад хүрээний орчуулга бол нийтлэг орчуулгын салбарт тооцогдож байдаг. Спортын орчуулгын асуудал сэтгүүл зүйтэй холбогддог, мөн сүүлийн үед орчуулгазүйн зах зээлийн салбарт хүч түрэн орж ирж байгаа салбар юм байна гэж бид бүхэн үзэж байгаа. Бид үзэж байгаагаар спортын ертөнцөд орчуулгын үйл явц 3 чиглэлд явж байгаа хандлага байна. Нэгдүгээрт, дэлхий даяаршиж байгаа учраас нэг спортын багт нэг орны биш олон орны хүмүүс нэгдэж бэлтгэл сургуулилтаа хийх юм уу нэг багт цугларах нөхцөлд хувь хүний хувьд

⁶⁸ МУИС-ийн Орчуулгазүйн профессорын багаас жил бүр Олон улсын Орчуулгын өдөр эрдмийн хэлэлцүүлэг хийж иржээ. 2021 оны энэ өдрийг тохиолдуулан 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 2024 оны Парисын зуны олимпын өмнө спортын үг хэллэгийн орчуулгын асуудлаар хэлэлцүүлэг хийснийг энд сийрүүлэн оруулсан юм.

хэлний бэрхшээл тулгардаг. Үүнтэй холбоотойгоор орчуулгын асуудал бол хувь хүний түвшинд ч тулгамддаг. Хоёрдугаарт, багийн түвшинд мөн энэ асуудал яригдаж байна. Багт олон орны хүмүүс нэг баг болсон тохиолдолд бие биеийнхээ санаа бодлыг ойлгохын тулд тусгайлан орчуулагч авах эсвэл өөр ямар нэгэн хэлээр дамжих зэрэг асуудал яах аргагүй гардаг. Гуравдугаарт, байгууллагын түвшинд ярина. Олон улсын холбоод байна, манай өнөөдрийн хэлэлцүүлэгт Монголын үндэсний олимпын хорооноос төлөөлөл байгаа, мөн дэлхийн бөхийн холбооны төлөөлөл бас байгаа. Жишээлбэл, бие биетэйгээ ойлголцохын тулд байгууллагын хувьд бол ямар нэгэн хэлийг тухайн байгууллагын хэл болгож авдаг байна. Сүүлийн үеийн спорт маш их эрчтэй, хөдөлгөөнтэй, хурдтай салбарын хувьд орчуулга нь мөн хүчтэй, хурдтай байгаа юм. Орчуулга бол орчуулга ба хэлмэрчлэхүй гэж 2 хэсэгт хуваагддаг. Бичгийн орчуулгаас илүү хэлмэрчлэх нь спортын орчуулгад их зонхилдог. Монголын орчуулгын салбарт хэлмэрчлэхүйн салбарын хөгжилд спортоор дамжин, спортоор жишээ болгон хэлмэрчлэхүйг заах, сургах үйл явц чухал болох юм гэж бид үздэг. Хэлмэрчлэх гэдэгт зөвхөн 2 хүний хооронд хэл, гүүр болдог зүйл биш юм, дохио зангаа, дохионы хэл үүнд хүртэл багтдаг. Жишээлбэл, бөхийн шүүгч ямар нэгэн хөдөлгөөн хийгээд түүгээрээ дамжуулан мэдээллийг шүүгч, тамирчид, хүмүүст ойлгомжтой байдлаар хэлж байгаа энэ үйл явц хүртэл орчуулгын нэг хэсэг гэж үздэг. Нэгд, хэлмэрчлэхүйн салбарт орчуулгын асуудал чухал байна. Удаах нь, сурталчилгааны орчуулга гэж спортын сурталчилгаанд орчуулгын асуудал их хөндөгддөг юм байна. Гуравт, цахим ертөнцөд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд ямар хэлээр тухайн спортын үйл ажиллагааг сурталчлах, спортын холбоод, нийгэмлэгийн үйл ажиллагааг таниулах вэ гэдэг асуудал мөн чухал бөгөөд зах зээлтэйгээ холбогддог. Аль хэлээр тухайн спортын веб сайт хөгжүүлэхэд илүү олон хөгжөөн дэмжигчдийг татах вэ, хөгжөөн дэмжигчдийг татсанаараа шилдэг тамирчдыг олон хүн дотроос сонгоход веб сайт, цахим орчин дах хэлний сонголт мөн чухал үүрэг гүйцэтгэдэг юм байна. Дөрөвт, бидний ярьж байгаа мэдээний орчуулга юм. Спортын ертөнцийн мэдээний орчуулга маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн бүх хүмүүс спортоор нэгддэг. Тухайн спортод болж байгаа үйл явцыг хамгийн түргэн бөгөөд хамгийн их мэдээлэлтэйгээр аль суваг, ямар телевиз нэвтрүүлэх вэ гэдгээрээ уралддаг байх. Үүнд орчуулагч нар ажилладаг. Хэн хамгийн хурдан, зөв үнэн мэдээллийг нэвтрүүлсэн тухайн спортын мэдээний агентлаг, суваг бизнесээ өсгөх зах зээлээ олж авдаг гэж ойлгож байна. Дараагийнх нь миний хувьд мэддэггүй нэг салбар бөгөөд их сонирхолтой. Спортын лото гэж ярьдаг шүү дээ, бооцоотой тэмцээнүүдэд орчуулга маш чухал юм байна. Хүн болгон бооцоо тавьж оролцох сонирхолтой байдаг. Гэхдээ хурдан орчуулсан, хэлмэрчилсэн суваг нь бооцооны зах зээлийг эзлэх магадлалтай байдаг. Үүгээр жинхэнэ хурд, үнэн зөв мэдээлэл, хурдан сэтгэх зэрэг бүх чадвар илэрнэ. Спортын орчуулга зүй, орчуулгын асуудал маш сонирхолтой, чухал салбар юм. Шинжлэх Ухааны Сургуулийн хурлын танхимд болж буй өнөөдрийн хэлэлцүүлэгт ирсэн хүмүүсийг танилцуулъя. Манай өнөөдрийн хэлэлцүүлгийн хүндэт зочноор Жүгдэрийн Отгонцагаан багш ирсэн байна. 1985 онд Монгол Улсын Их Сургуулийг төгссөн. Тухайн үедээ олон хэл мэддэг, сонирхдог байсан бөгөөд үүгээрээ оюутнуудынхаа дунд ялгардаг байсныг тэр үеийнхэн ярьдаг. Монголын Үндэсний Олимпын хороонд 31 жил ажилласан. Бие даан франц, испани хэл сурсан. Монголын Үндэсний Олимпын Хорооны хэвлэлийн албаны ажлыг дангаараа үүрч, орчуулгын маш олон ажлыг хийж гүйцэтгэж байсан. Социализмын үе, орчин үеийн бүхий л үед спортын, олимпын тэмцээн уралдаанд явж байсан туршлагатай хүн. Дараагийн илтгэгч бол Дэлхийн Бөхийн Холбооны Азийн Зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга Пэлжээгийн Буяндэлгэр. 1996 онд Монгол Улсын Их Сургуулийн Олон Улсын Харилцааны Дээд Сургуулийг франц хэлний мэргэжлээр төгсөж байжээ. Спортын салбарт Монгол улсаа төлөөлж байгаа хүн. Ж.Отгонцагаан, П.Буяндэлгэр нар ээлж дараалан илтгэх болно. Мөн Монгол Улсын Их Сургуулийн Ази судлалын тэнхим, Гадаад хэлний орчуулга хөтөлбөрийн ахлагч, дэд профессор Г.Элдэв-Очир, Монгол Улсын Их Сургуулийн

гадаад хэлний төвийн эрхлэгч, англи хэлний багш, дэд профессор Д.Отгонтуяа байна. За бүгдээрээ хэлэлцүүлгээ эхэлье. Хөтөлбөрт заасны дагуу Ж.Отгонцагаан “ах” эхний илтгэлийг тавина.

Ж. Отгонцагаан: Монгол Улсын Их Сургуулиас зохион байгуулж байгаа Гадаад хэлний тэнхимийн хэлэлцүүлэгт оролцож байгаадаа баяртай байна. Эрдмийн ажил хийгээгүй олон жил болсон учраас бага зэрэг бэлтгэл дутуу байж магадгүй, хүлцэл өчье. 1985 онд Монгол Улсын Их Сургуулийн Гунгаа багштай Хятад хэлний ангийг 6 оюутан төгсөж байсан. 1985 онд төмөр замын хатуу гарт орж, Замын-Үүд-д 4 жил ажилласан. 1989 онд хотод ирээд Монголын радиогийн Хятад хэлний редакцияд 1 жил, 1990 оноос “Монголын спорт сонин”-д сурвалжлагч, 1993 оноос Монголын Үндэсний Олимпын Хороо буюу олимпын салбарт 31 ажиллаж, нас маань 60 дөхөж 59 хэлбийжээ. Олон Улсын Олимпын Хороо нь дэлхийд хамгийн хүчтэй хөдөлгөөнийг удирдах дээд байгууллага, International Olympic Committee, ИОС гэх товчилсон нэрээр нь олимпын салбарынхан бүгд андахгүй. 1894 онд Сорбоны Их Сургууль дээр агуу их соён гэгээрүүлэгч, Францын эрдэмтэн Пьер де Купертен нөхдийнхөө хамт анх байгуулсан. Олон Улсын Олимпын Хорооны албан ёсны нэгдүгээр хэл нь франц хэл. Хүн болгон франц хэлээр ярьж чаддаггүй болохоор англи хэлийг хоёрдугаар хэл болгосон. Хурал зөвлөгөөн тухайн болж буй улсаас нь шалтгаалж франц, англи, испани, хятад, орос, араб хэл дээр явагддаг. Хятад улс өвөл, зуны олимпыг хоёуланг нь зохион байгуулсан цорын ганц улс болсон юм. Хятад улс олон улсын олимпизмын хөдөлгөөнд их нөлөөтэй болж байгаа учраас хятад хэлийг оруулсан. Орос улс мөн ялгаагүй. Анхны зуны олимп 1896 онд Грек улсад, өвлийн олимп Францын Шамони хотод болж байв. 1994 оноос өвөл, зуны олимпыг 2 жилийн зайтай зохион байгуулахаар болгожээ. Учир нь 1 жилд зун, өвлийн олимпыг зохион байгуулахад хүндрэлтэй, мөн жилд 2 олимпод орж чадахгүй улсууд байдаг. Эдгээр улсуудад дарамтгүй тэгш 2 жилийн зайтай болгосон юм. 2010 оноос Youth Olympic Games, олон улсын олимпын товчилсон хэлээр YOG гэж нэрлэдэг залуучуудын олимпын наадам эхэлсэн. Миний ажилласан хэдэн жилд бичгийн болон аман орчуулга, хэлмэрч, бичгийн хэллэг, аман хэллэг зэрэг олон янзын бүх хэлбэрийг ашигладаг байсан. Спортын орчуулга зүйн нэгдүгээрт, **түүх намтар салбарт** орчуулна. Эртний Грекийн олимп үүссэн талаар, нэн эртний олимп байсан талаар, спортын холбоод гэх мэт. Олимпын хөдөлгөөний тулгын гурван чулуу бол Олон Улсын Олимпын Хороо, Үндэсний Олимпын Хороо, Олон Улсын Спортын Холбоо гэж ярьдаг. IF буюу International Federation, NOC буюу National Olympic Committee, хятадаар бол 奥运会, Энэтхэгийн Indian Olympic Association, Ирландын Union гэх мэтээр хэлдэг. Зарим Үндэсний Олимпын Хороодын нэр миний мэдэж байгаагаар Хятад, Солонгос, Герман, Франц зэрэг улсуудын Үндэсний Олимпын Хороо, Биеийн тамир, спортын улсын хороод нь нэг байдаг. Герман улс Спорт, олимпын хороотой, төрийн мөнгийг олимпын хороонд зарцуулна гэсэн эрх мэдэлтэй байдаг. Янз янзын бүтэц байдаг. Дараагийнх нь **тэмцээний тайлбар тоймын орчуулга** байна. Тайлбар тойм хийхэд янз янзын спортын үг хэллэг зөв орчуулах тал нь чухал юм байна. Дараагийнх нь үндсэн ажил бол тамирчдын тэмцээн уралдаандаа очоод техникийн зөвлөгөөн, мэдүүлэг өгөх, сугалаа сугалах, медаль авсан тохиолдолд тэмцээний дараа хэвлэлийн бага хуралд оролцоно. Харин тэмцээн дууссаны дараа допингийн шалгалтад байнга ордог. Үүний нэг хэцүү зүйл нь сүүлийн 3 сард ямар ямар эм бэлдмэл хэрэглэсэн бэ гэхээр манай зарим дасгалжуулагч, эмч нар бичихэд хэцүү байдаг. Учир нь латин үсгээр бичдэг, англи дуудлага нь өөр, франц дуудлага нь өөр байдаг. Жил болгон допингийн жагсаалт нь солигддог бөгөөд спортын орчуулагч нар дор нь авч шинэчилж явах нь их чухал. Олимпын наадмын үг хэллэг гэж байна. Дээр үед оросууд олимпийские игры, олимпын тоглолт гэж буруу орчуулдаг байсныг зассан. Энэ бол тоглолт биш олимпын наадам. Хөл бөмбөгийн тоглолт байж болно, гар бөмбөгийн тоглолт байж болно, гэхдээ бөх, бокс бол тоглохгүй. Тийм учраас олимпын наадам

гэдэг нь Монголд бол таараад байдаг. Бас нэг хэцүү зүйл нь мэх байна. Бөхийн өчнөөн мэх байдаг. Бөхийн “өмсөх” гэдэг мэхийг оросоор “мельница” гэдэг, “салхин тээрэм” гэсэн утгатай. Би гайхаж л байсан. Төрөл төрлийн мэх, боксын цохилт, янз янзын техник, цанын тэшилтээр явах, тэшүүрээр эргэх, уран гулгалтын төрөл зэргийг хүний нэрээр нэрлэчихсэн. Анх тэр элементийг хэн хийсэн тэр хүний нэрээр нэрлэдэг. Хурал айлчлал болдгоороо болно. Үндэсний Олимпын хороод хоорондоо хамтын ажиллагааны чиглэлээр хурал зөвлөгөөн, Олон Улсын Олимпын Хороо жил болгоны хурал, Азийн зөвлөлийн жил болгоны хурал зэрэг болно. Эдгээр хурал, зөвлөгөөний үг бол дипломат орчуулгадаа хамрагдаад, тухайн үеийн байдлаас шалтгаална. Манайх анх бол гаднаас тусламж гуйдаг байсан. Одоо бол спортын салбарын хөрөнгө оруулалт хамаагүй дээр болсон учир тусламж гуйх нь багассан. Францын жудочид, Гүржийн жудочид зэрэг бусад орны тамирчид манайд ирж бэлтгэл хийдэг, манайхыг гуйдаг болсон. Энэ талын асуудлын орчуулгын утга, чиглэл нь өөрчлөгдөж байгаа. Дараагийн орхиж болохгүй зүйл бол **нийтийн биеийн тамирын үг хэллэг**. Спорт, олимпизмийг призм гэж үзвэл нийтийн биеийн тамираас эхлээд олимпын аварга хүртэл энэ дунд хамрагдана гэсэн үг. Энэ чиглэлийн талаар ард олондоо нийтийн биеийн тамирыг сурталчлах ажлын орчуулга, нийтийн гүйлт, гимнастик, янз янзын зүйлийг орчуулга, гарын авлага дээр төрөл төрлийн холбоодын орчуулагч нар сайн ажиллаж байдаг. Түүнээс гадна бидний харьцдаг хэд хэдэн олимпын системийн байгууллага байна. Сүүлийн үед харьцаж байгаа WADA буюу дэлхийн допингийн эсрэг байгууллага байна. Сүүлийн үед их хүчээ авч байгаа бөгөөд олимпын холбооноос тустай статустай хамтарч ажилладаг байгууллага юм. Дараагийнх нь CAS буюу Спорт арбитрын шүүх. Монголыг төлөөлж мөнгөн медаль авсан Ираны тамирчин Саид Моллайг Ираны засгийн газар Иранаас урвасан гэх шалтгаанаар CAS-д өгсөн. Үүн дээр Олон Улсын Олимпын Хороо, Жудогийн холбоо тусалцаа үзүүлсний хүчинд буруу байхгүй гэдгийг нь баталсан. Шүүхийн үг хэллэг бол маш хэцүү. Заримдаа бол би ч бараг мэддэггүй. Мэргэжлийн хүнтэй уулзаад яриад тулгалт хийхэд бол болдог. Дараагийнх нь **спорт хувцас хэрэглэлийн үг хэллэг**. Спорт хувцас хэрэглэлийн NIKE, ADIDAS, MIZUNO байна. NIKE –ийн “just do it” гэсэн уриа үг байна. Соёлтойгоор хэлбэл урдахаа л хий, ажлаа л сайн хий гэсэн утгатай, хараар олон юм ярилгүй наадахаа хий гэсэн утгатай. Энэ гуравхан үгийг Монгол хөрсөн дээр яаж буулгах вэ гэдэг бол хэдэн өгүүлбэр орчуулахаас хэцүү тал бас гардаг. Сүүлийн үед олимпын хөтөлбөр маш их өргөжиж, спортын олон шинэ шинэ төрөл бий болж байна. Өмнө нь олимпын наадамд үндсэн 28 төрөлтэй байсан бол одоо олимп зохион байгуулж буй газар 5 спортын төрлийг өөрөө санал болгоод, саналыг нь Олон Улсын Олимпын Хороо батлаад оруулдаг болсон. Сая гэхэд Япон улс каратэ, дугуйт тэшүүр, ханан хадны авиралт зэрэг 5 спортын төрөл оруулсан. Парис бол 4 спорт сонгогчихсон байсан. Хамгийн сонирхолтой нь break dance буюу бүжиг. Сүүлийн үед олимпын наадмын хандлага бол залуучууд үзэх нь багассан. Олон Улсын Олимпын Хороо судалгааны агенттай, өнөөдөр чөлөөт бөх, хүндийн өргөлт үзээд байх уу гэхээс өөр залуучуудын сонирхдог электрон талын спортуудыг судалж оруулдаг болсон байна. Олон Улсын Олимпын Хороо үзэгчдээ алдвал олимпын наадмын үнэ цэн алдагдана. Одоо бол олон наадам болж байгаа. Азийн өвлийн наадам, Азийн зуны наадам, Азийн хүүхдийн наадам, Азийн танхимын наадам, Азийн тулааны спортын наадам, Азийн элсний спортын наадам зэрэг маш их наадам болж байгаа. Хятадын олимпоос хойш 16 хоногийн наадамд зориулж 20 гаруй стадион барих хэрэг байна уу, хэмнэж, цэгцтэй, үрлэг багатай хийвэл зүгээр юм уу гэдэг яриа гардаг болжээ. 1976 оны Монтреалийн олимп гэхэд олимпод гарсан зардлаа одоо болтол нөхөөгүй алдагдалтай байгаа. Энэ талын тооцоотой эдийн засгийн орчуулга гардаг болсон. Олимпын наадмын хувь заяа өөрчлөгдөж байгаа. Социализмын үеийн орчуулга, орчин үеийн орчуулга хоёр өөр. Дээр үед бэйсбол, мэргэжлийн хөл бөмбөг капиталист спорт, хүн зоддог гэж дандаа буруу талаас нь бичиж, орчуулж харлуулах шинжтэй байдаг байсан. Одоо бол бүх спортоор хичээллэдэг

болчихсон. Америкчууд спортыг цоо шинэ төрөлтэй болгодог. Wrestling, Грек, Ромын буюу сонгомол бөх байсныг хөл авдаг чөлөөт бөх болгосон. Уулын уруу хурдтай буудаг цанын төрлийг дунд нь нүх ухаад дахин өөр төрөл гаргасан. Орчуулгын утга санаа бүх юмыг ялгаж салгаж орчуулах хэрэгтэй. Америкийн англи хэл дээр анзаарч байх ёстой. Олимпын академи гэж байдаг. Анхны олимп болсон газар Грекийн Олимп уулын энгэрт Олимпын академи гэж судалгаа шинжилгээ хийдэг, цаашдаа судалгаа шинжилгээний чиглэлээр ажиллах залуучуудыг урьж ажиллуулдаг. Америкийн хоккейн дасгалжуулагч, английн хөл бөмбөгийн дасгалжуулагч орчуулагч бэлтгэх хэрэгтэй болдог. Тоглолтын дунд, бэлтгэл дээр, яаралтай үед зэрэг орчуулга өөр байдаг учир хамтын ажиллагаа сайн байх хэрэгтэй. Шинээр дүрвэгчдийн баг гарчихсан. Эх орондоо улс төрийн шалтгаанаар байж болохгүй, дайн дажинтай, гай гамшигтай орноос ирсэн тамирчдыг Олон Улсын Олимпын Хорооны туг дор “Дүрвэгчдийн баг” гэж оруулчихсан учраас нэг араб, нэг африк, нэг ази, хуучин социалист орнуудын хүмүүс нэг багт орчихсон байвал тэдний хэлний асуудлыг зохицуулах тал дээр багийн ахлагч нь туслах тал байдаг. Төрөл нь өөр учир хөл бөмбөгийн баг нь Англи улсад бэлтгэл хийх, жудогийн баг нь Япон улсад бэлтгэл хийх, гимнастикийн баг нь Герман улсад бэлтгэл хийх гэх мэтчилэн янз янзын баазад аваад Олон Улсын Олимпын Хороо мөнгийг нь төлдөг. Иймээс хүссэн хүсээгүй орчуулгын асуудал гарч ирдэг. Дэлхийд Олон Улсын Спортын Сэтгүүлчдийн Холбоо гэж 1924 онд Парис хотноо байгуулагдсан байгууллага бий. Олон Улсын Олимпын Хорооны media committee буюу хэвлэл мэдээллийн хороотой хамтарч ажиллан олимпод явах сэтгүүлчдийг сонгон шалгаруулах, квотыг хянах, спортын үг хэллэгийг цэгцлэх гэх мэт олон ажлыг хийж ном товхимол нэлээн их гаргасан. Тэгэхээр спортын үг хэллэгийг нэг мөр болгох асуудлыг их олон жил ярьж байсан. Хэл зохиолын хүрээлэнгийн захирал Э.Пүрэвжав байх үед бид нар биеийн тамир спортын хороон дээр хурал хийж спортын үг хэллэгийг цэгцлэх, нэг мөр болгох комисс байгуулсан ч ажил яваагүй. Тууштай хийхгүй бол ажлын хажуугаар хийх хэцүү байсан. Социализмын үед аялгуу сайхан монгол хэл дээрээ орчуулах ёстой гэж биеийн тамир спортын хорооноос үг хэллэг гаргадаг байсан. Зарим олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн спортын нэр томъёог хэрэглэгдэж байгаагаар нь “curling” гэдэг нь хятадаар 冰壘 “мөсөн данхны спорт” гэж нэрлэлтэй биш, манай хэлэнд буухад хэцүү. Чарга гэхэд нуруугаар хэвтдэг, элгээрээ хэвтдэг чарга байна. Монголоор нуруун чарга, элгэн чарга гэж орчуулалтай биш. Манайд тэр спорт нь байх ч үгүй. Шинэ шинэ спорт гараад байна. Зарим спортын төрлийг олон улсад хэрэглэж заншсан Олон Улсын Олимпын Хорооны баталснаар хэрэгжүүлж байвал болно. Тэгээд зөвхөн Европын спорт биш Азийн спорт, Африкийн спорт орж ирж байгаа. Кабади гэж Энэтхэгийн спорт байна. Манайхаар бол чоно тарвагацахтай адилхан. Сепак такрав тоглоом, раттан гээд гөрмөл бөмбөг байгаа юм, тэрийг теннисний торонд хөлөөрөө өшиглөж тоглодог. Үүнийг Сепак такрав, гөрмөл бөмбөг гэлтэй биш. Сүүлийн үед олон улсын үг хэллэгийг орчуулаад эхний ээлжинд хаалтан дотор тайлбар хийвэл зүгээр байх гэж боддог. Теннис гэхэд талбайн теннис гэдэггүй, теннис л бол теннис, манайх хамгийн том теннис учир манайхыг теннис гэх ёстой, table tennis нь ширээний теннис, soft tennis нь энэ нэршлээрээ явдаг. Гэх мэтчилэн хоккей бол зүлгэн дээрх хоккей бол хоккей гэдгээрээ, яагаад гэвэл дэлхийн хамгийн том спорт, бусад хоккей нь мөсөн дээрх, бөмбөгтэй хоккей гэх мэтчилэн нэрлэ гэж хурлаар яриад баталчихдаг. Олимпын орчуулга яривал хэдэн өдөр ч ярих маш арвин сэдэв. Дэлхийн хэмжээний эрдэмтэн, хэл шинжээч, спортын нэр томъёогоор ажилладаг хүмүүс маш олон байдаг. Мөн олон ном зохиол гарсан байдаг. Хамгийн ойрын зорилт, мөрөөдөл ч юм уу өөрөө ч сайн тодорхойлж чадсангүй, спортын үг хэллэгийн толь бичиг, спортын үг хэллэгийн ярианы дэвтэр хэрэгтэй. Үүнийг залуучууд цаашдаа хамтраад гаргана гэж найдаж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ш. Эгшиг: За баярлалаа. Одоо П.Буяндэлгэр ерөнхий нарийн бичгийн даргыг урьж байна. “Олимпизмын үгсийн сан ба нэр томьёо” сэдвээр илтгэл тавих гэж байна.

П.Буяндэлгэр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Олон улсын орчуулгын өдрийг тохиолдуулан ийм сайхан арга хэмжээ зохион байгуулж буй та бүхэндээ талархал илэрхийлье. “Орчуулгаар нэгдье, олимпизмыг дэлгэрүүлье” гээд бид бүхний хувьд спортын орчуулгазүй маш хэрэгтэй зүйл болоод байна. Сая болж өнгөрсөн Токиогийн олимпын наадмын 13 телевиз шууд дамжуулалтаараа тайлбараа хүргээд, тухайн төрлийнх нь хүмүүс өөрийнхөө тайлбараар хүргэж байсан. Үзэж байхад дотор нь нэлээн хэдэн орчуулгын алдаа гэх юм уу, тухайн үедээ спортынхоо өөрийн төрлийн орчуулгыг зөв хүргэж байсан ч бусад хүмүүст ойлгогдохоор хүргэх анхаарууштай зүйл харагдаж байсан. Спортын орчуулга нэлээн төвөгтэй, социализмын үеийн орчуулгууд тийм байсан бол, одоо бол даяаршиж байгаа, хөгжиж байгаа, шинээр спорт нээгдэж байгаа, олон залуучууд нэгдэж байгаа тохиолдолд спортын шинэ хэллэг, спортын тухайн төрлийн өөрийн гэсэн хэллэгүүд байдаг. Ерөнхийдөө спортын орчуулгад спортын нэр томьёоны орчуулга, үгсийн сангийн орчуулга гэж байдаг. Мөн мэргэжлийн хэллэгийн орчуулга гэж байгаа, тухайн спортын төрлийн мэх, тоног төхөөрөмж, материал хэрэглэл нь спорт хаана үүсэж хөгжсөн байна вэ, тухайн үгээр нэрлэгдсэн байдаг. Жишээлбэл, “туялзуур сэлэм” гэж байна, “fencing” гэдгийг манайхаар бас “туялзуур жад” гэж орчуулдаг. Нэгдсэн нэг орчуулгад хүрэхгүй бол тэр нь дотроо тухайн спорт нь анх Францад сэлэмний байлдаан байсныг спорт болгочихсон. Зарим мэхнүүд нь франц үг, франц суурьтай байдаг, орчуулахад буух аргагүй. Эрдэм шинжилгээний, шинжлэх ухааны, спортын гээд орчуулгууд нэлээд бий. Бид нарын гол анхаарах зүйл нь юу вэ гэхээр нэр томьёо, үг хэллэг дээрээ нэгдмэл орчуулгад хүрчихвэл зүгээр юм болов уу гэж боддог. Жишээлбэл, волейболыг гар бөмбөг гээд яриад явчихсан, гандбол гэж бас байна, гандболыг бас гар бөмбөг ч юм уу, волейбол гандбол гэдгээрээ шууд орчуулагдахгүй буух спортын төрлүүд байгаа. ‘Luge’ гэж чарга байна, сүүлийн үед ‘urban sport’ гээд гудамжны чарга гэж гарчихсан street гээд явчихдаг. Шинээр олон спортын нэр томьёо түрж орж ирж байна. Тухайн спортын төрлийн хэллэгүүд болохоор тоног төхөөрөмжүүд байна. Жишээлбэл, волейболын сетканы дээдх зураас тэгж явна, шонгуудыг тэгж хэлнэ гэж байдаг. Волейболын цохилтууд бас өөр өөрийн хэллэгүүдтэй, сонгомол бөх, чөлөөт бөх дотроо мэхнүүдтэй. Уламжлалт спортын төрөлд бөхийн мэхийг монголоор хэлээд байгаа боловч шинэ спортын төрөлд шинэ үгнүүдээ гаргаж ирэхээр тэрийгээ монгол хэл дээр буулгахдаа тухайн спортын хэллэгээр хэлэхгүй бол болохгүй байгаа. Нийтлэг хэрэглэгддэг үг хэллэгүүд байна. Ерөнхийдөө спортын суурь дээр англи хэл нэлээн давамгайлж байна. Тухайн спорт хаана үүсэж, хөгжсөнөөрөө тэр улсынхаа хэллэгүүд явж байгаа боловч франц, испани хэл дээр спортыг тайлбарлах үед үг хэлэн дотор нь англи хэллэгүүд яваад байгаа. “Throw” гэж үг байна. Энэ үгийг спортын төрөл болгондоо өөр өөрөөр хэрэглэдэг. Нэг ижил утгатай, ижил дуудагддаг үгийн толь бичиг зохиох, толь бичиг боловч тайлбар толь бичиг байвал зүгээр юм болов уу. 2016 онд спортын ном, олон улсад спортын ногоон ном гэдгээрээ алдартай энэ номыг монгол хэл дээр орчуулсан. Эргээд харахад маш их учир дутагдалтай орчуулгууд бас байдаг. Монгол хэл дээр бүх спортын төрлийг дүрэмтэй, тоног хэрэглэл, үүсэл, түүхтэй нь оруулсан ном гарсан юм. Жишээлбэл, байт харваа юм уу, сур харваа юу, байт сур юм уу, тэр ном дээр редакторласан хүмүүс нумын харваа гэж оруулсан. Бидний спортын орчинд хэрэглэгдээд заншихсан нь байт харваа. Тэгэхээр үүнийг нэгдсэн нэг хэллэгээрээ хэлээд сурчихвал бид нарт хэрэгтэй байгаа. Биатлон, триатлон, пентатлон гэж байдаг. Пентатлоныг орчин үеийн таван төрөлт гэдэг. Орчин үеийн таван төрөлт гэхээр зарим өөр наадмуудад таван төрөлт өөр 5 төрөл байгаад байдаг. Тэгэхээр биатлон, триатлон, волейбол гэдгээрээ явахгүй бол монгол хэл дээр бүгдийг нь буулгана гэдэг хэцүү. Токиогийн олимпын наадмын тайлбар дээр харж байхад улсын нэрийг орчуулж байсан, улсын нэрийг орчуулна гэдэг бас их хэцүү. Кот Д’Ивуар гэж улс байна, энэ улсыг “Зааны ясан эрэг” гэж орчуулахгүй, Монгол улсын монгол гэдгийг орчуулахгүйтэй адил тухайн улсынхаа нэрээр явбал зүгээр байдаг. Мөн спортын тайлбар дээр бас анхаарах зүйл юу вэ гэхээр улсуудын нэр байдаг. Олимпын наадамд

орж байгаа улсуудыг улсаар нь биш орж байгаа Үндэсний Олимпын Хороогоор нь оруулдаг. Жишээлбэл, Тайвань-ыг Тайвань гэдгээр нь оруулдаггүй, Chinese Taipei гэж явдаг. Тайлбар дээр Тайвань улс гэж явбал алдаа болдог. Бас нэг тайлбар дээр Chinese Hong Kong буюу “Хятад Хонконгийн хамтарсан баг” гэж орчуулсан. Мэддэг хүмүүс нь Хонконгийн баг юм байна гэж мэднэ, мэдэхгүй хүмүүс, анх спорт үзэж байгаа залуучууд буруу ойлголт авна. Үнэхээр Хятад Хонконгийн хамтарсан баг юм уу, Тайвань яагаад тийм туг дор олон улсын тэмцээнүүдэд оролцдог юм бэ гэх иймэрхүү ойлголтуудаа нэг болгох зорилгоор толь бичиг, үг хэллэгийн гарын авлагатай болох нь бидний гол зорилго болов уу гэж бодоод байгаа юм. Мөн IIR буюу Islamic Iran Republic гэдгийг манайхан Ираны лалын улс гэж орчуулаад байдаг. Islamic гэдгийн тайлбарыг харахаар лалын гэж орчуулдаг. Ираны иргэд өөрсдөө дургүй хүлээж авдаг. Лал гэдэг шашин, ислам бол нэршил нь учраас улс нэр томьёог анхаарвал зүгээр юм аа. Товчилсон нэрийн асуудал бас байна. Олон Улсын Спортын Холбоод ихэвчлэн франц үгээр товчилдог. Сүүлийн үед англи хэлээр товчилдог болсон. Жишээ нь FILA-UWW, өмнө нь Францаар хэлдэг байсан нь сүүлийн үед англиар хэлдэг болсон бөгөөд нэгдсэн дэлхийн бөхийн холбоо болгочихсон. Зарим холбоодын нэрийн хувьд сонсогдох байдлаасаа болоод нэрээ сольсон. Жишээ нь таеквондогийн холбоог WTF буюу World Taekwondo Federation гэж нэрлэдэг байсан. WTF гэх товчилсон нэр нь хүмүүст эвгүй утгаар буудаг учир WT буюу World Taekwondo болгон өөрчилсөн. Орчуулга нь хэлмэрчлэл, спортын сурталчилгаа, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр яаж гаргах, яаж явж байна зэргийг тус тусад нь анхаарч хийх хэрэгтэй юм байна. Спортын орчуулга дээр тулгарч буй мөн нэг асуудал нь тухайн спортын спортын хэллэг. Спортын нэгдсэн орчуулга гэж байхгүй, нэгдсэн бааз гэж байхгүй, спортын олон улсын хэллэгүүдээ мэдэж байх нь хэрэгтэй байх, тиймээс тухайн спортын хэрэглэл, тоног төхөөрөмж, мэх, цохилт, шидэлт, харайлт, үсрэлт зэрэг нарийн зүйлсийг сайн мэдэж байж орчуулга хийх хэрэгтэй. Орчуулаад гаргачихсан спортын номыг эргээд харахад нэлээн олон зүйл засчихмаар байсан. Одоо шинэ шинэ спортууд гарч ирж байна, шинээр наадмууд хийдэг болчихсон. Urban games-г 2018 онд Унгар улсад хийсэн. Үүнд ихэвчлэн залуучуудын сонирхдог спортын төрлүүдийг оруулжээ. Жишээ нь extreme sport. Сүүлийн үед манай улсад E-Sport гэж гарч ирж байна. Эцэг эхчүүд хүүхдийгээ тоглоом л тоглоод байна гээд дургүйцдэг боловч e-sport тоглодог залуучууд e-sport хүүхдүүдийг бас зөв тал руу нь хөгжүүлдэг гэж тайлбарладаг. Үүгээр мөн сурталчилгаа нь яваад байгаа. Тухайн спорт өөрийн спортоо сурталчлахдаа зөв үг хэллэгийг нь гаргаад, давуу талаа дөвийлгөн сурталчилж, шинэ спортуудыг бий болгож, үүнийхээ орчуулга дээр бас их анхаарч байна. Спортын үг хэллэг толь бичиг, хоршоо үг, өгүүлбэрээр байна. Бид жудогийн “базари” зэрэг япон үгийг японоор нь сонсоод ойлгоод хүлээгээд авчихсан. Бөх дээр нэг тамирчин идэвхгүй барилдаад байвал “blue passive, red passive” гэж үзэгчдээс хэлдэг. Мөн албан ёсны шүүгчийн хэллэгүүд гэж бий. Хоёр талын бөх идэвхгүй барилдаж байвал ямар улсын тамирчнаас үл хамааран “давай давай” гэдэг үгийг хэлдэг. Идэвхтэй барилдуулах хэрэгтэй гэсэн утгатайгаар энэ үг шүүгчийн хэлэх ёстой дүрмэнд байдаг. Мөн шүүгч гэдгийг аудитор, жүри гэх зэргээр хэлдэг. Спортынхоо төрлөөс хамаарч шүүгч нь өөр өөр нэршилтэй. Дасгалжуулагчийн хувьд мөн адил. General manager гэдгийг ерөнхий менежер, ерөнхий зохион байгуулагч юм байна гэж бодоход Англи, Америкийн спортод багийн ахлах дасгалжуулагчийг хэлдэг. Энэ зэрэг зүйлсийг төдийлөн мэдэхгүй ч, анхаарах ёстой зүйлс бий. Хэлэлцүүлэг дээрээ өөр юун дээр анхаарах хэрэгтэй вэ, юу юуг чухалчлах хэрэгтэй вэ гэдэг дээрээ санал солилцоод явах байх гэж найдаж байна. Анхаарал тавьсан та бүхэндээ баярлалаа.

Ш. Эгшиг: Та бүхэн бол салбарын хүмүүс учраас бидний мэддэг, мэддэггүй маш олон зүйл ярьж байна. Орчуулгыг тухайн салбарыг мэддэг хүн хийхээс биш өөр салбарын хүмүүс орчуулахад амаргүй байдаг. Та бүхэн спортын салбарынхаа нэр томьёо, үг хэллэг дээр гарч буй асуудлыг тодорхой ярилаа. Хэлэлцүүлгийн ерөнхий санааг гаргаж өгсөнд баярлалаа. Хэлэлцүүлгээ эхэлбэ. Манай цахимд оролцож буй багш, оюутан, судлаач нар идэвхтэй оролцохыг хүсэж байна. Асуулт байна уу?

Д. Отгонтуяа: Манай орчуулгын хамтлагаас орчуулгын өдөрт зориулан зохион байгуулсан семинарт ирж оролцож, өөрсдийн арвин их туршлагаас хуваалцаж байгаа та хоёртоо баярлалаа. Та хоёрыг үг, нэр томъёо, нэршлийг яаж орчуулах вэ гэж ярьж байхад англи-англи 700,800 хуудастай толь аваад харахад penalty гэдэг үгийг давхар хавсарсан үгээр, өвөрмөц 50 үг байна. Торгуультай холбоотой хэлцүүд нь өөр спорт дээр яаж тайлбарлагдах вэ гэдэг нь 50 өөр тайлбар байна. Аливаа салбарын нэр нэршлийг онооно гэдэг маш хүнд. Олон жилийн нөр их хөдөлмөр шаарддаг. Бид бүхэн орчуулгын хичээлийг оюутнуудад заахаас илүүтэй өөрсдөө орчуулагч нарын зовлонг бага ч гэсэн мэддэг учраас өнөөдрийн хэлэлцүүлэг өвөрмөц сэдвийг хамарч байгаад баяртай байна. Монгол улсад мэргэжлийн спортын орчуулагч нар хэр олон байдаг вэ, мэргэжлийн орчуулагчдыг спортын сургуулиудаас бэлдэж гаргадаг юм болов уу? Энэ талаар мэддэг зүйл байна уу? Хэлний мэргэжлээр төгсчихөөд үргэлжлүүлээд өөрийн хүсэл сонирхол, авьяас билгээрээ цааш сайн дураараа явдаг уу, эсвэл спортын орчуулагч гэсэн тусгай мэргэжил байдаг уу? Монголын спортын холбооноос үүнийг хэр их анхаардаг вэ?

Ж. Отгонцагаан: Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харьяа биеийн тамирын сургууль гэж байсан. Хуучин энэ сургуульд спортын сэтгүүлч, спортын орчуулагчийн анги байдаг байсан. Одоо байгаа эсэхийг мэдэхгүй байна. Манайд ирж байгаа ихэнх хүмүүсийн 80 хувь нь гадаад хэлний идэвхтэй хүмүүс байдаг. Эдгээр хүмүүсийг биеийн тамир спортын хороо, спортын холбоод, олимпын хорооны янз бүрийн хэлтэст ажиллуулдаг. Хоёр янзын хүмүүс ирдэг. Нэгдүгээрт спортод дуртай хүмүүс байна. Хоёрдугаарт хэлэндээ сайн хүмүүс байна. Сүүлийн үеийн хувийн биеийн тамирын сургуулиуд спорт, орчуулгын чиглэлийн хүмүүс бэлтгэн төгсгөж байгаа юм байна билээ. Хуучин биеийн тамир, спортын чиглэлээр ОХУ, Болгар, Польш, Герман, Украин гэх зэрэг улсуудад мэргэжилтэн бэлдэж байсан. Одоо бол Олон Улсын Олимпын Холбооноос тавигдаж буй шаардлага нь дор хаяж хоёр хэлтэй байх ёстой. Олон Улсын Олимпын Хорооны ерөнхийлөгч Бах 6 хэлээр чөлөөтэй ярьдаг. Нөгөө талаас спортын салбарт ажиллаж буй хүмүүсийг хэлтэй байхыг шаардаж байгаа. Спортоо мэдэж байгаа хүмүүст ганц садаа болж буй зүйл нь хэлний асуудал байдаг. Олимпын хороон дээр семинар зохион байгуулаад, Олон Улсын Олимпын Хорооноос курс зохион байгуулдаг.

Д. Отгонтуяа: Тусгай мэргэжилтэн, орон тоо байдаг юм уу?

Ж. Отгонцагаан: Гадаад харилцааны мэргэжилтэн гэж байгаа. Орчуулагч гэж байхаа больсон. Спорт холбооны ажил, орчуулга, гадаад харилцаатай холбоотой бичиг баримт, олон улстай харьцах бичиг баримт, гадаадын элчин сайдын яам, айлчлал зэрэг бусад ажилтай шууд холбогдож ажилладаг.

Д. Отгонтуяа: Хэдэн хүн ажилладаг вэ?

Ж. Отгонцагаан: Надтай нийлээд 3 хүн ажилладаг.

П. Буяндэлгэр: Спортын холбоод, үндэсний холбоодод дотроо өөр өөрсдийн гадаад харилцааны ажилтнуудтай. Тухайн спортынхоо онцлог дээр ажилладаг. Жишээ нь, чөлөөт бөхийн холбоо гэхэд дэлхийн бөхийн холбооноос дасгалжуулагч, тамирчдадаа дундаас дээш түвшний англи эсвэл франц хэлний мэдлэгтэй байх ёстой гэсэн шаардлага тавьдаг. Хэлнийхээ мэдлэг чадвараас болоод гадаадад очоод хүндрэлтэй учирсан, үйл ойлголцсон. Техникийн зөвлөгөөн дээр ийм мэх хийвэл буруу, энэ мэх хийвэл зөрчилд авна гэж тайлбарладаг. Зөвлөгөөн дээр ихэвчлэн дасгалжуулагч нар оролцдог, орчуулагчтай суухгүй, өөрсдөө сууна. Жишээлбэл, энэ дэлхийн аваргын үеэр ийм зүйлсийг сайн анхаараарай, жинг нь 2 килограммын зөрүүтэй үзнэ, аль эсвэл тэглэж үзнэ гэдгийг техникийн зөвлөгөөн дээр хэлчихдэг. Үүнийг дасгалжуулагч нар нь сайн

ойлгохгүй бол тамирчдаа буруу мэдээлэл өгдөг. Жингээ үзүүлэхдээ 2 килограммын запастай гэж бодчихсон байтал тэглээд жингээрээ хасагдчихдаг. Ийм тохиолдол манайд байсан. Мөн олимпын наадам чөлөөт бөх дээр техникийн зөвлөгөөнөөр анхааруулсан зүйл дээр эсэргүүцэл илэрхийлсэн явдал гарч байсан. Спортын ёс зүйд дэвжээ, талбай дээр тамирчин хүн өөрийн сэтгэл хөдлөлөө барьж байх ёстой гэсэн зарчимтай байдаг. Орчуулагч байхгүй учир дасгалжуулагч, тамирчид нь хэлний мэдлэгтэй байхгүй бол алдаанд ордог, алдаа гаргадаг. Монголчууд медаль авчихаад тугаа бариад дэвжээн дээр гүйдэг. Энэ нь бас дүрэмтэй. Техникийн зөвлөгөөн дээр дэвжээн дээр алтан медаль авсан хүн тугаа барьж дэвжээн дээр гарах эрхтэй гэсэн байхад хүрэл медаль авчихаад тугаа бариад дэвжээн дээр гараад ирдэг. Үүний дүнд танайх үүнийг зөрчсөн учраас торголоо гээд шууд холбоо руу нь торгууль тавьчихдаг. Тэрийг сонсоогүйгээс болоод бэрхшээлтэй тулгарч байгаа юм.

Г. Элдэв-Очир: Миний асууя гэж бодож байсан зүйлийн талаар ярилаа. Тамирчдад тухайн спортын үг хэллэгийг зааж сургадаг уу?

Л.Буяндэлгэр: Тухайн холбоондоо байгаа тамирчдаа сүүлийн үед сургалтууд явуулж эхлээд байна. Би чөлөөт бөхийн холбоонд ажилладаг. Чөлөөт бөхийн холбоонд ерөнхийдөө тамирчид хэлний мэдэлгүйгээсээ болоод зочид буудалдаа ч юм уу дүрэм журмын хувьд хүндрэлтэй асуудлууд гардаг. Цар тахал ковидийн үед тэмцээн зохион байгуулж байгаа онцлог нь өөр болсон. Битүү, ямар ч үзэгчгүй зохион байгуулдаг болсон тиймээс маш өндөр шаардлага тавьсан дүрэм гаргасан. Үүнийг тамирчид заавал мэдэж байх учиртай. Бид нар тамирчдыг явахаас нь өмнө бүх тамирчдад мэдээлэл өгдөг. Та нар буудлаасаа гарахгүй юм байна шүү, буудлаасаа гараад хажууд нь энүүхэн энд харагдаж байгаа тав алхмын зайд байсан ч гэсэн автобусаар явах нь байна шүү, хэрвээ явган явбал торгох нь байна шүү, тийм асуудлууд байгаад байгаа. Гэхдээ тухайн спортын төрлийн үг хэллэгүүдийг тэмцээнд яваад ирсэн тамирчид бол мэддэг. Одоо бид өсвөр залуучууддаа сүүлийн жилээс нэлээн сургалт явуулж тамирчны ёс зүй, тамирчны баримтлах сахилга бат, үг хэллэг хэлний мэдлэг, тамирчны заавал мэдэж байх ёстой зүйлийг цаанаас нь тавьсан шаардлагын дагуу англи буюу франц хэлтэй байх ёстой гэсэн шаардлагыг нь заавал биелүүлэхээр хөтөлбөр боловсруулаад байгаа.

Ш.Эгшиг: За баярлалаа. Биднээс гадна 18 хүн цахимаар оролцож байна. Үүнээс Европ судлалын тэнхимийн эрхлэгч С.Булгантамир багшийгаа онцгойлон танилцуулмаар байна. С.Булгантамир багшийн маань үндсэн мэргэжил нь франц хэл байгаа. Уг хэлэлцүүлгийг хийхэд хамтран ажиллаж зохион байгуулах ажлыг хийсэн. Багшаас ямар санал байгаа вэ? Парисын олимптой холбож энэ хэлэлцүүлгийг хийж байгаа. Тэгэхээр франц хэлтнүүд их чухал үүрэгтэй гэж бодож байна.

С.Булгантамир: За баярлалаа, Эгшиг багшаа. Олон улсын орчуулгын өдрийг тохиолдуулаад манай гадаад хэлний орчуулга хөтөлбөрөөс Парисын 2024 онд болох зуны олимпын их наадмыг угтан “Орчуулгаар нэгдье, Олимпизмыг дэлгэрүүлэе” гээд уриан дор энэхүү эрдэм шинжилгээний их семинарыг зохион байгуулж байгаад маш их баярлалаа, тэгээд мөн маш сонирхолтой бидэнд тухайн спортын салбарын хүмүүс болох, Монголын Үндэсний Олимпын Хорооны ерөнхийлөгчийн зөвлөх Ж.Отгонцагаан, Дэлхийн Бөхийн Холбооны Азийн Зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн дарга П.Буяндэлгэр нар маш сонирхолтой сэдвээр хэлэлцүүлэг хийсэнд талархаж байна.

Миний хувьд спортын орчуулга хийж байсан туршлага байхгүй. Арай дөхөм орчуулга гэвэл бүжгийн салбарын орчуулгыг хийж байсан. Мөн уран зохиолын орчуулгыг өөрөө сонирхож хийдэг. Энэ хэлэлцүүлэгт зориулан уг сэдвийн хүрээнд жаахан судалж үзлээ. Францын Лионы их сургууль, Парисын хэлмэрчлэхүй орчуулгын сургууль орчуулагч нараа бэлтгэхдээ спортын

салбарын биеийн тамирын орчуулгыг хэрхэн авч үздэг юм бол? Францын үндэсний олимпын хорооноос спортын болон спортын сэтгүүл зүй тэр дотроо олимпизмтой холбоотой сургалт семинар хийдэг юм болов уу? гээд асуудлын хүрээнд судалсан. Тэгээд үүнтэй холбоотой хэд хэдэн сургалтын хөтөлбөрүүдийг олж харлаа. Хувийн орчуулгын сайт уруу ороод спортын чиглэлийн орчуулга авч болдог болов уу? гээд үзсэн чинь ийм компаниудын үйлчилгээ түгээмэл байдаг гэдгийг мэдэж авсан. Францад явган аялал, ууланд авирах, шүхэр гэх мэт чиглэлээр тухайн спортын тамирчид нь бас давхар Англи- Франц, Франц-Англи орчуулгыг хийдэг ийм үйлчилгээ үзүүлдэг юм байна. Олимпизмын академи гээд сургалт зохион байгуулдаг гэдгийг харлаа. Үүнээс би нэг асуулт асуухыг хүссэн юм. Олимпизмын академи гэж манай дээр байдаг болов уу? Олимпын хороо энэхүү академитай болов уу? гээд ийм асуултыг асуумаар санагдаж байлаа.

Хэлмэрчлэхүйн их дээд сургуулиудын хөтөлбөрийг харахаар спортын орчуулга бол шинжлэх ухаан, урлагтай ижилхэн өдөр тутам хувьсаж өөрчлөгддөг салбар юм. Тиймээс спортын нэр томъёо нь байнга шинэчлэгддэг учраас энэ салбарыг нэлээн анхаарах ёстой гэж үздэг. Спортын төрлийн орчуулгад хүний сонирхлыг татах хэрэгцээ шаардлага байдаг. Олимпын наадмыг ч юм уу нэвтрүүлгийг орчуулан дамжуулж байхдаа ч юм уу тухайн үзэгчийн сэтгэл хөдлөлийг бас бодолцох ёстой гэх шаардлага байгаа. Өгүүлбэрийн бүтэц, онцлог найруулгын хэв маягийг нэлээн анхаардаг гэх хөтөлбөрийн онцлогийг ч мөн харсан. Хэлмэрчлэхүйн сургууль нь хөдөө аж ахуй, байгаль орчин, урлаг, уран зохиол, хууль эрх зүй, эдийн засаг, санхүү гэх зэрэг 14 салбар байдгаас спорт, биеийн тамирын салбарыг орчуулагчаар төгсөх гэж байгаа оюутан төгсөх ангидаа сонговол энэ 14 салбараас 2 салбарыг сонгоод 3, 3 хичээл үздэг байгаа юм. Жишээ нь: Спорт, биеийн тамирын салбарыг сонгох юм бол энэ чиглэлийн ийм хичээлүүдийг үзнэ гэдгийг хөтөлбөртөө тусгадаг. Францын олимпын үндэсний хороо бол хажуудаа сургалтын төвтэй, сургалтын хөтөлбөрүүдтэй. Жишээ нь, олимпын наадмын англи хэлний орчуулагчийн хөтөлбөр гэх хөтөлбөр байсан. Уг хөтөлбөрөөс олимпизмын үг хэллэг үзэл санаа үнэт зүйл, бэлгэ тэмдэг гэх мэт зүйлс агуулагдаж байгаа нь харагдаж байсан.

Манай дээр энэ олимпизмын академи гэдэг зүйл байдаг болов уу? гэдэг асуултыг асуумаар байна. Баярлалаа.

Ж.Отгонцагаан: Булгаадаа баярлалаа, 1996 онд Манайд Монголын үндэсний академи гэж байгуулсан. Манай шууд харьяанд биш ч тусдаа байгуулагдаж байсан. Монголын үндэсний олимпын академийн ерөнхийлөгч нь биеийн тамирын тусгай сургуулилттай сургуулийн захирал Зоригтбаатараас шууд холбогдоод үндэсний олимпын академийн бүх үйл ажиллагааг асууж болно. Жилд 1 юм уу 2 залуу судлаач Грек уруу явдаг, заримдаа тусгай хөтөлбөрөөр бас нэг хоёр хүн нэмж Грек уруу явах боломжтой. Францад үндэсний олимпын академи бол байгаа. Volunteer-ийн асуудалд англи хэлтэй хүн авдаг ба нэг олимпийн наадамд 20000, 30000 volunteer буюу сайн дурынхныг бол шалгаж сорьж авдаг. Энэ нь зөвхөн Францад биш дэлхийн аль ч өнцөг булангаас очиж байрлаж болно. Гэхдээ тэр сайн дурынхан өөрсдөө байраа олно. Хувцас болон өдрийн 1 хоолыг Парис 2024 олимпын зохион байгуулах хорооноос өгдөг. Манайхаас Японд бас 3, 4 хүн сайн дураар ажилласан. Нэг нь Олимпик куолификейшн систем орж ажилласан. Францад байгаа монголчууд хөтөлбөрт хамрагдаад орвол сайхан үйлс болно гэж бодож байна. Лавлах юм байвал тодруулаарай.

С.Булгантамир: За, баярлалаа.

Л.Буяндэлгэр: Олон улсын тэмцээн мөн олон улсаас ирж байгаа хүмүүст зориулан орчуулгын багт ажиллах сайн дурын ажилтан бид авдаг. Сайн дурынхны залуучууд ихэвчлэн хэлний сургуулиудын оюутнууд байдаг. Тэдний дотор мөн спортын чиглэлээр орчуулга хийж байгаа хүмүүс бас нэлээн байдаг. Жишээлбэл: Боксын олон улсын тэмцээн, чөлөөт бөхийн олон улсын тэмцээн дээр ажилласан хүмүүс байгаа. Спортын салбарын чиглэлээр орчуулгаар сайн дурын ажлаа хийхдээ спортын үг хэллэг мэдэж авсан туршлагатай болдог. Одоо миний дор спортын орчуулга дээр ажиллая гэсэн 2 хүүхэд байна. Нэг нь оюутан нөгөө нь сургуулиа төгсөж байгаа оюутан байгаа. Тэд нар яг яаж орчуулгын гараагаа эхэлсэн бэ гэхээр сайн дурын ажлаар л эхэлсэн. Тэмцээн дээр багуудад орчуулга хийгээд явж байсан. Тэд нарын дур сонирхолд нь үндэслээд спортын орчуулагчаар бэлдэж болох боломжтой болж байгаа юм.

Ш.Эгшиг: Сайн дураас гараагаа эхэлдэг байна шүү дээ.

Л.Буяндэлгэр: Тиймээ, сайн дураас гараагаа эхэлсэн.

Ш.Эгшиг: Магистрант, докторантуудаас асуух асуулт байна уу? Эвээ багш байгаа гэсэн.

Эвээ багш: Сайн байцгаана уу? автомашин унаж оролцдог тамирчдыг юу гэж нэрлэдэг вэ? Нисгэгч гэж хэлдэг нь зөв үү? гээд чатаар нэг хүн асуулт асуужээ.

Ж.Отгонцагаан: Манайхаар бол жолооч гэж орчуулсан нь дээр байх аа. Ямар хамаагүй давхидаг жолооч гэж хэлэлтэй нь биш. Бусад машины уралдаанаас хурд нь маш хурдан учраас driver гэхгүй pilot гэж бас хэлдэг. Нисэж явдаг учраас нисгэгч гэж бас хэлдэг.

Г.Элдэв-Очир: Үүнтэй холбогдуулаад хэлэхэд энэ нь нэг төрлийн мэргэжлийн салбарын орчуулга юм. Сагс, хөл бөмбөг, бөх, бокс гээд өвөл зуныхаараа хуваагдвал маш олон спорт байгаа шүү дээ. Спорт болгон өөр өөрийн тусгай хэллэгтэй, тусгай дүрэмтэй, спортоосоо шалтгаалсан тоног төхөөрөмж, өмсгөл, зүүлт гээд бүх л юмнаас харахад маш их ялгаатай. Маш том салбар гэдгийг үүнээс харж болно. Тэгэхээр үг хэллэгийн толь бичиг зохиохдоо бол эхлээд Монголд түлхүү хөгжсөн хүмүүс мэддэг спортын төрлүүдийн толь бичиг үг гаргах хэрэгтэй. Жишээ нь: Гол үндсэн олимпизмын спортын төрлүүдийг англи, франц хэлнээс англи, монгол уруу орчуулах ч юм уу. “Curling” уг спорт бол Монголд одооноос ер нь танигдаж эхэлж байна. Иймэрхүү танигдаж эхэлж байгаа спортуудыг үе шаттайгаар толь бичиг гаргах ч юм уу, хамтад нь нэгтгээд ч юм уу, эсвэл тус тусдаа цуврал маягаар бас толь бичгээ гаргавал илүү дээр байх. Нэр томьёоны тухайд нэр үгийг бол харь үгээр нь орчуулах, үйл үгийг монгол боломжтой үгээр орлуулаад орчуулж болно. 3*3 гээд сагсны төрөл гэхэд л залуучуудын дунд маш эрчтэй хөгжиж байна. Яг энэ үед толь бичгийг гаргаад байвал илүү хүмүүст хүрэх, тэрийгээ дагаад хүмүүсийн сонирхол болон хэрэглээний давтамж өндөр байгаа болохоор хандалт өндөр байж магадгүй.

П.Буяндэлгэр: Тухайн спортын төрөл болгон дээр олон улс дээр гарч ирсэн. Оросын спортын хөнгөн атлетикийн тухайд гэвэл, хөнгөн атлетикийн нэр томьёоны толь бичиг байдаг. Уг толь бичигт англи гаралтай, франц гаралтай, грек гаралтай мөн латинаар хэлдэг үг ч байдаг. Спортын төрөл болгонд тайлбар толь байгаа. Миний хувьд спортын номыг орчуулахад бараг жил хагасын хугацааг зарцуулсан. Орчуулахад их хүндрэлтэй байсан. Би спортын холбооны хүмүүстэй уулзаж танай энэ спортын онцлог нь юу юм бэ? гээд асууж байлаа. Спортын хорооны хүмүүс маань бид нар чинь яриагаараа ойлгоод байдаг болохоос номон дээр буулгая гэхээр мэдэхгүй гэдэг асуудал гарч байсан л даа. Спортын төрөл болгон дээрээ л хүмүүсийг цуглуулж номоо орчуулсан даа.

Г.Элдэв-Очир: Толь бичиг бол нэр томьёогоо нэг ойлголттой болгох, тухайн спортыг Монгол улсад хөгжүүлэхэд том сурталчилгаа, таниулахад танин мэдэхүйн ач холбогдолтой. Миний бодлоор спортын сэтгүүлчид, тайлбарлагч нартаа үгээ зөв оноосон толь бичгийг өгвөл тухайн үгийг хэрэглээнд оруулах, хүргэх алхам болно.

Д.Отгонтуяа: Одоо үед нийгмийн сүлжээгээр хошин маягаар хүргэвэл илүү хурдан хүрээд байгаа юм биш үү. Олон улсын спортын нэр, нэр томьёоны нэршил бүх үгийг орчуулаад байх хэрэггүй юм шиг санагддаг. Үгээ галигчилж буулгачихаад тайлбарыг ард нь оруулбал зүгээр юм шиг санагдсан. Тайлбарыг нь ард нь оруулахгүй болохоор буулгасан үгээрээ тамирчин маань монголоор сэтгэн ойлгох талтай байдаг.

Ш.Эгшиг: Манай Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн зөвлөх профессор Бүрнээ багшийгаа урьж байна.

Д.Бүрнээ: Юуны өмнө Олон улсын орчуулагчдын өдрийг тохиолдуулан эрдэм шинжилгээний семинарыг зохион байгуулж байгаа Ш.Эгшиг, Г.Элдэв-Очир багш болон энэ хуралд ирж сонирхолтой илтгэл хэлэлцүүлсэн хоёр илтгэгчдээ их талархлаа. Энэ хуралд оролцсон олон оюутан, судлаачид, багш нартаа мөн талархлаа илэрхийлье. Хоёр илтгэгчийнхээ ярианаас бол спортын нэр томьёог судлах тал дээр ажиллаж байгааг мэдлээ. Ямар төрлийн спортын толь гаргах тухайгаа ярилцаж байгаа юм байна. Шинэ спортын төрөл дээр бол шууд нэр томьёог авах ийм хандлага бол байгаа гэдгийг ойлголоо. Өнөөгийн даяаршлын энэ цаг үетэй холбоотой мэдээлэл хурдтай байгаа энэ үед шууд нэр томьёог авах нь аргагүй байж магадгүй юм. Монгол хэлний хүний тухайд бол манайхны бодлоор нэр томьёог нутагшуулах, монгол хөрсөн дээр буулгах энэ зүйлийг бид нар анхаарах ёстой байдаг. Энэ асуудлын хувьд бидэнд судалгаа жаахан дутагдаад байна уу? гэж бодогддог. Жишээлбэл, Франц улс бол компьютер гэдэг энэ олон улс даяар хэрэглэж байгаа үгийг өөрийн улсын хэлээр орчуулаад хэрэглэдэг. Бид нар нэр томьёог авах нь зөв байж магадгүй. Нэр томьёог шууд авахын өмнө бидэнд монгол хэлэнд өөрт нь ямар нөөц боломж байна гэдгийг сайтар бодох хэрэгтэй. Манай Ц.Шагдарсүрэн багш “Айлаас эрэхээр авдраа ух” тухайн хэлийг илэрхийлэх манай хэлний ямар нөөц баялаг байна вэ тэрийгээ судалж үзэх хэрэгтэй гэж хэлсэн байдаг л даа. Тэрийг би зөв зүйтэй гэж боддог. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор толь хийхийн өмнө та нар эхлээд нэр томьёоны мэдээлэл бий болгоод нэр томьёогоо бүртгэж үзэх гээд тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэрэгтэй болно. Миний зүгээс судалгаа хийх хэрэгтэй гэж бодож байна. Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын мэргэжлийн спортын төрлийн толь бичгийг зохиосон арга туршлага ямар байдаг, бусад улс оронд эдгээр нэр томьёог хэрхэн яаж нутагшуулж байна вэ? Энэ зарчмыг судалж үзвэл бас зүгээр болов уу гэж би хувьдаа бодож байна. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны үндэстэй толь бичиг гаргахын тулд энэ дээр тодорхой хэмжээгээр судалгаа хийх хэрэгтэй. Шинжлэх ухааны академийн хүрээлэнд бол яг энэ нэр томьёоны чиглэлээр ажилладаг Н.Мөнхцэцэг Г.Гэрэлмаа гээд 2 эмэгтэй судлаач байдаг. Н.Мөнхцэцэг нэр томьёоны орчуулгаар тусгайлан нэг сэдэвт ном гаргаж ерөнхийлөгчийн шагнал хүртсэн байдаг. Тэгэхээр судлаач нартай холбогдож мэргэжлийн хүмүүстэйгээ хамтарч ажиллах юм бол тэр нэр томьёог нэршүүлэх юм уу яаж дагавар нөхцөлийг залгах юм бол, яаж залгавал оновчтой байна гэх зэргээр судалгааг үндэс болгосон толь бичиг гаргах юм бол шинжлэх ухааны хүмүүст ч гэсэн хэрэглэхэд чухам удаан настай гарын авлага болох болов уу л гэж бодож байна. Та бүхний ажилд амжилт хүсье.

Ш.Эгшиг: Багшийн ярианаас бодох их юм байна гэж бодогдлоо. Нэр томьёоны асуудлаас толь бичиг хийх тухай асуудал уруу өөрөө аяндаа хөтлөөд явчих шиг боллоо. Энэ бол манай хэлэлцүүлгийн үр дүн байх аа. Энэ асуудал дээр төвлөрч ажиллахаар бол П.Буяндэлгэр,

Ж.Отгонцагаан ах та бүхэн цаашдаа өөрийн салбарын хүмүүстэй бас ярилцаж үзэхийг хүсэж байна. Энэ тал дээр хамтрахаар бол манай судлаач багш нар, судлаач оюутнууд, мөн манай шинэ элссэн суралцагч нараас энэ сэдвээр бас хөтлөөд авах боломжтой эсвэл та бүхний дагалдаж байгаа хүүхдүүдээ манайд сурган, сурангаа давхар толь бичгийнхээ ажил хийх энэ чиглэлээр хамтарвал ямар вэ? гэсэн санал байна. Та бүхэн үүнийг бас бодолцож үзээрэй. Д.Бүрнээ багшийн ярианаас уг саналыг хэлмээр санагдлаа.

П.Буяндэлгэр: Бүрнээ багш үнэхээр бид нарт хүлээж авахуйц хэрэгтэй зүйлийг ярилаа. Учир нь бид нар үнэхээр судалгаан дээр суурилж байж, энэ толь бичгээ гаргах уу, үг хэл бичгийн толь бичиг байх уу, тайлбар толь байх уу, эсвэл үг хэллэгийн ярианы толь байх уу гэдэг дээр ярилцаж байгаа. Та бүхний дэмжлэгтэйгээр хамтын ажиллагаагаар бүтэх болов уу л гэж бодож байгаа. Тийм болохоор Хэл Зохиолын Хүрээлэн, Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургууль, хэл судалж байгаа хүмүүстэйгээ хамтраад бид нарын хувьд өөрсдөө спортынхоо талын судалгаа бусад оронд ямар байдалтай байдгийг өөрсдийнхөө нөөц бололцоогоор судалгаагаа хийе гэсэн бодолтой байна. Толь бичиг хийх гэдэг бидэнд зайлшгүй хэрэгтэй байгаа. Бид нар 2024 Парисын олимпын наадам уруу чиглэж, зорьж байна. Токиогийн олимпын наадмын спортын төрлүүдийн тайлбар толь бичигт ямар хүндрэл, ямар бэрхшээл, ямар алдаа гарч ирсэн энэ бүхнээс тулгуурлаад спортынхоо сэтгүүлч, тайлбарлагч нартайгаа спортын холбоонууд хамтраад спортын үг хэллэг, нэр томъёо өгүүлбэр зүй бүхнийг хамтраад нэг том бүтээл гарах байх аа гэж би найдаж байна. Тэгэхээр Д.Бүрнээ багшдаа маш их баярлалаа.



“ХЯТАД ХЭЛНИЙ ХЭЛЗҮЙН НЭРШЛИЙН МОНГОЛ ОНООЛТ” ХЭЛЭЛЦҮҮЛЭГ⁶⁹

Манай оронд 1957 оноос эхлэн дээд боловсролтой хятад хэлний мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн цагаас хятад хэлийг монгол суралцагчдад зааж, 65 жилийн турш олон мэргэжилтнийг дотоодод бэлдсэнээс гадна БНХАУ болон бусад хятад хэлт орнуудад мөн хятад хэлээр олон мэргэжилтэн төгсөж иржээ. Үүнээс гадна ерөнхий боловсролын сургуулиудад хятад хэлийг эрчимтэй заан сургаж байгаа юм. Хятад хэлийг сонгон суралцах зах зээлийн байдал сүүлийн жилүүдэд тогтвортой хэмжээнд буюу хятад хэлний сургалттай дунд сургуульд жилд дунджаар 7000 орчим, их дээд сургуульд 2000 орчим оюутан үндсэн мэргэжлээр, сонгоноор, хавсарга, хос мэргэжлээр суралцаж байгаа мэдээ⁷⁰ байна. Дотоодын хятад хэлний сургалтад хятад хэлний хэлзүйн нэр томъёог монгол хэлд буулган хэрэглэж байгаа байдлыг ажиглахад, сургууль сургуулийн багш нарын нэг нэршлийг монгол хэлээр оноон хэрэглэж байгаа нь өөр хоорондоо адилгүй, тэр бүү хэл нэг сургуулийн нэг тэнхимийн багш нар ч өөр хоорондоо өөр нэр томъёо ашиглаж буйг анзааран хэлэлцэх болсон билээ. Энэ асуудлыг МУИС-ийн багш Г.Элдэв-Очир 2017 онд “Хятад хэлзүйн нэр томъёог монгол хэлнээ оноох нь”⁷¹ илтгэлээрээ эрдэм шинжилгээнийхний хүрээнд асуудлыг дэвшүүлэн тавьж, зарим хятад хэлзүйн нэршлийг монгол хэлнээ хэрхэн оноох талаарх саналаа дэвшүүлсэн билээ.

Энэ нь хятад хэлийг заан сургадаг багш нарын хувьд хятад хэлний хэлзүйн нэр томъёог монгол хэлээр нийтлэг нэгэн жигд нэршилд буулгах сэдлийг бий болгож, энэ ажлыг хийхээр энэ онд Монгол Улсын Их сургууль (МУИС), Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС), Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийн Ази судлал, Дорно дахины судлалын тэнхимийн эрхлэгч нарын санаачилгаар нийт их дээд сургуулийн хятад хэлний багш нарын хэлэлцүүлэг хийх товыг гаргасан юм. Энэ ажлын бэлтгэл болгон, МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант Э.Бумбилэг хятад нэр томъёоны жагсаалтыг гарган, хэлэлцүүлэг хийх, санал авах хятад хэлний хэлзүйн нэршлийг бүртгэн харьцангуй бүрэн хэмжээнд цуглуулж өгсөн юм. Энэ жагсаалтын дагуу МУИС, МУБИС, ШУТИС, Хүмүүнлэгийн ухааны их сургууль (ХУИС), Отгонтэнгэр их сургууль (ОТИС), Улаанбаатарын их сургууль (УБИС) зэрэг хятад хэлний чиглэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн багш нарын дунд нэгтгэсэн хятад хэлзүйн нэршлийн монгол оноолтын санал авахаар явуулж, нэр бүхий багш⁷² нараас ирсэн саналыг нэгтгэн⁷³, хэлэлцүүлэг хийх хүснэгийг гаргаж ирсэн нь хэлэлцүүлгийг үр дүнтэй болгох бэлтгэл ажил болсон юм. Мөн ШУТИС-ийн суралцагч З.Хулан уг хятад нэршлийн англи оноолтыг хадах ажлыг гүйцэтгэсэн болохыг тэмдэглэе.

⁶⁹ Ш.Эгшиг, МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Ази судлалын тэнхимийн эрхлэгч

⁷⁰ 11. Монголын хятад хэлний сургалтын өнөөгийн байдал, Хятад судлалын салбар-Нэгэн жаран, МУИС, Улаанбаатар, 2017, 325-334 тал.

⁷¹ Г.Элдэв-Очир, 2017 онд Ази судлал ОУЭШХ-д хэлэлцүүлсэн илтгэлийн нэр

⁷² Санал өгсөн, Г.Элдэв-Очир (МУИС), Л.Чойжилмаа (ШУТИС), Б.Оюунчимэг (ХУИС), Д.Ундрах (МУИС), Б.Гэрэлт-Ирээдүй (МУИС), Л.Солонго (МУИС)

⁷³ Санал нэгтгэсэн, А.Дуламсүрэн (МУИС)

“Хятад хэлний хэлзүйн нэршлийн монгол оноолт” сэдэвт хэлэлцүүлгийг 2022 оны 2-р сарын 26-ны өдөр цахимаар зохион байгуулж, МУИС, МУБИС, ШУТИС, ХУИС, ОТИС, УБИС-ийн багш нарын төлөөлөл оролцон, нийт 198 нэр томьёо, нэршлийн талаар нэг бүрчлэн хэлэлцэн нэгдсэн саналд хүрсэн болно. Энэхүү хэлэлцүүлгийг МУБИС-ийн Дорно дахины хэл, заах аргазүйн тэнхимийн эрхлэгч Б.Ганчулуун, ШУТИС-ийн Ази судлалын тэнхимийн эрхлэгч Ц.Эрдэнэзаяа, МУИС-ийн Ази судлалын тэнхимийн эрхлэгч Ш.Эгшиг нар удирдан зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ОТИС-ийн Э.Номин тэргүүтэй багш нар, УБИС-ийн Ө.Саранцэцэг зэрэг багш нарыг дэмжин оролцсонд талархаж байна.

Энэ удаагийн хэлэлцүүлгийн үр дүнг нийтэлж байгаа нь хятад хэлийг заан сургадаг манай нийт багш сурган хүмүүжүүлэгч нарт хэрэгтэй лавлагаа болох болов уу хэмээн найдахын дээр эдгээр монгол оноолтыг цаашид зөв оновчтой оноох талд засан сайжруулах ажил үргэлжлэх боломжтой гэдгийг уламжилъя.

Жич, дор толилуулж буй хятад хэлзүйн нэршлийг монголоор оноосон баганад зарим нэршлийг хоёр хувилбартай оруулсныг ташуу зураасаар заагласан нь аль алианаар нь авч хэрэглэх боломжтой гэдгийг үзүүлэв.

ХЯТАД ХЭЛНИЙ ХЭЛЗҮЙН НЭРШЛИЙН МОНГОЛ ОНООЛТ

№	Хятад	Англи	Монгол
1	语素	morpheme	бүтээвэр
2	词	word	үг
3	词根	root	үгийн үндэс
4	词缀	affix	залгавар
5	短语	phrase	холбоо үг
6	句子	sentence	өгүүлбэр
7	词类	parts of speech	үгийн аймаг
8	实词	notional word	бодит үг
9	名词	noun	нэр үг
10	时间名词	time noun	цаг заасан нэр үг
12	处所名词	pronoun of place	орон байр заасан нэр үг
13	方位名词	noun of locality	Байр, чиг заасан нэр үг
14	动词	verb	үйл үг
15	及物动词	transitive verb	тусах үйл үг
16	不及物动词	in transitive verb	эс тусах үйл үг
18	助动词	auxiliary verb	туслах үйл үг
19	表示意欲的	express intention	- маар ⁴ , хүсэл эрмэлзэл заасан
20	表示意愿的	would like to do	- маар ⁴ , хүсэл заасан
21	表示可能的	might;	Магадлал заасан
22	表示必要的	expressing necessity;	Хэрэгцээ, шаардлага, зайлшгүй байдлыг заасан



23	表示许可的	allow	Зөвшөөрөл заасан
24	自主动词	act on one's own	үйлдэх үйл үг/ захирах үйл үг
25	非自主动词	non-autonomous verb	эс үйлдэх үйл үг/ эс захирах үйл үг
26	形式动词	formal verb	Хэлбэр үйл үг
27	离合动词	separate verb	авцдаг үйл үг/ холбоос үйл үг
28	相互动词	mutual verb	Харилцан үйлдэлдэх үйл үг
29	趋向动词	directional verb	чиглэл заасан үйл үг
30	形容词	adjective	тэмдэг үг
31	一般形容词	general adjective	ердийн тэмдэг үг
32	状态形容词	descriptive adjective	төлөв байдал заасан тэмдэг үг
33	非谓形容词	non-predicate adjective	өгүүлэхүүн бус тэмдэг үг
34	唯谓形容词	predicate adjective	өгүүлэхүүн тэмдэг үг
35	数量形容词	quantitative adjective	тоо хэмжээ заасан тэмдэг үг
36	数词	numeral	тооны үг
37	基数	cardinal number	үндсэн тоо
38	序数	ordinal number	дэс тоо
39	概述		тойм тоо
40	分数词	fractional number	бутархай тоо
41	倍数词	multiple word	дахил тоо
42	量词	measure word	тооллого үг/ хэмжүүр үг
43	名量词	noun/nominal measure word;	нэрийн тооллого үг
44	专用名量词	special noun quantifier	тусгай нэрийн тооллого үг
45	临时名量词	/a nonce noun/	зээлсэн нэрийн тооллого үг
46	计量名量词	quantitative measure word	хэмжил нэрийн тооллого үг
47	通用名量词	common measure word	түгээмэл нэрийн тооллого үг
48	动量词	verbal measure word	Үйлийн тооллого үг
49	专用动量词	special verbal measure word	тусгай үйлийн тооллого үг
50	工具动量词	instrumental verbal measure words	хэрэглүүрийн үйлийн тооллого үг
51	复合量词	compound measure words	нийлмэл тооллого үг
52	区别词	distinguish	ялгах үг
53	副词	adverb	дайвар үг
54	时间副词	adverbial of time	цаг заасан дайвар үг
55	范围副词	scope adverb	хамрах хүрээ заасан дайвар үг
56	程度副词	adverb of level, degree	хэр хэмжээ заасан дайвар үг
57	否定副词	negative adverb	үгүйсгэх дайвар үг
58	语气副词	modal adverb	баймж дайвар үг

59	情势副词	adverbial of circumstances	байдал заасан дайвар үг
60	关联副词	relevance adverb	холбох дайвар үг
61	代词	pronoun	төлөөний үг
62	人称代词	personal pronoun	биеийн төлөөний үг
63	指示代词	demonstrative pronoun	заах төлөөний үг
64	专指代词	specific pronoun	тусгайлан заах төлөөний үг
65	遍指代词	anaphora pronoun	ерөнхийлөн заах төлөөний үг
66	疑问代词	interrogative pronoun	асуух төлөөний үг
67	叹词	interjection	аялга үг
68	拟声词	onomatopoeia	авиа дуурайх үг
69	方位词	position	байр чиг заасан үг
70	离合词	separation and reunion	авцах үг/ холбоос үг
71	虚词	function word	хийсвэр үг
72	助词	auxiliary word	туслах үг
73	动态助词	aspect particle	үйлийн төлөв заасан туслах үг
74	结构助词	structural auxiliary word	бүтцийн туслах үг
75	语气助词	modality particle	баймж туслах үг
76	表示比况	comparison	адилтгал заасан
77	表示数量	quantity	тоо хэмжээ заасан
78	表示关系	express a relation	харилцаа хамаарал заасан
79	介词	preposition	утгвар үг
80	表示时间	time expression	цаг заасан
81	表示处所方向	direction expression	орон байр, чиглэл заасан
82	表示对象	target expression	оногдохуун заасан
83	表示工具	tool expression	хэрэглүүр заасан
84	表示方式	way expression	хэлбэр заасан
85	表示依据	according to expression	үндэслэл заасан
86	表示原因、目的	reason expression	шалтгаан, зорилго заасан
87	表示比较	compare expression	харьцуулалт заасан
88	表示排除- 除、除了	exclude – except	-аас гадна, ангид утга заасан
89	表示协同	coordination	хамтрах утга заасан
90	表示距离- 离、距	distance	хоорондын зайг заасан
91	表示经由	expressed via	дайран өнгөрөх утга заасан
92	表示关涉	expressed to relate	холбоо хамаарал заасан
93	连词	conjunction	холбоос үг
94	并列连词	coordinating conjunctions	зэрэгцүүлэх холбоос үг
95	主从连词	subordinator	захирах, захирагдах холбоос үг


96	短语类型	phrasal type	холбоо үгийн төрөл
97	主谓短语	subject-predicate phrase	өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүнт холбоо үг /хэлхэц/
98	述宾短语	predicate object phrase	өгүүлэхүүн тусагдахуунт холбоо үг
99	动词短语	phrase	үйлийн холбоо үг
100	形容词短语	adjective	тэмдэг үгийн холбоо үг
101	偏正短语	the endocentric phrase	тодотгох харьцаат холбоо үг
102	定中短语	centering phrase	Тодотгол, цөм холбоо үг /хэлхэц/
103	状中短语	adverbial phrase	Байц, цөм холбоо үг
104	中补短语	middle complement phrase	Цөм нөхвөрлөхүүнт холбоо үг
105	述补短语	predicate complement phrase	өгүүлэхүүн нөхвөрлөхүүнт холбоо үг
106	联合短语	coordinate phrase	холбоост/ хам холбоо үг
107	同位短语	appositive phrase	хамжсан холбоо үг/ зэрэгцээ холбоо үг
108	量词短语	classifier phrase	тооллого үгт холбоо үг
109	方位短语	directional phrase	байр, чиг заасан холбоо үг
110	介词短语	prepositional phrase	угтвар үгт холбоо үг
111	“的”字短语	“的” of word phrase	“的” бүхий холбоо үг
112	“所”字短语	“所” of word phrase	“所” бүхий холбоо үг
113	比喻短语	metaphorical phrase	адилтгасан холбоо үг
114	固定短语	fixed phrases	тогтвортой холбоо үг
115	连谓短语	continuous predicate phrase	угсарсан өгүүлэхүүнт холбоо үг
116	兼语短语	concurrently language phrase	хавсарсан гишүүнт холбоо үг
117	句子成分	members of a Sentence	өгүүлбэрийн гишүүн
118	主语	subject	өгүүлэгдэхүүн
119	谓语	predicate	өгүүлэхүүн
120	述语	state	хүүрнэхүүн
121	宾语	object	тусагдахуун
122	名词性宾语	noun sexual object	нэрийн шинжтэй тусагдахуун
123	动词性宾语	verb sexual object	үйлийн шинжтэй тусагдахуун
124	形容词性宾语	adjective sexual object	тэмдэг үгийн шинжтэй тусагдахуун
125	中心语	headword	цөм гишүүн/ гол гишүүн
126	定语	attribute	тодотгол
127	状语	adverbial modifier	байц
128	补语	complement	Нөхвөрлөхүүн/ нөхвөр гишүүн
129	句子的分类	types of sentences	өгүүлбэрийн ангилал
130	陈述句	declarative sentence	хүүрнэх өгүүлбэр
131	疑问句	interrogative question	асуух өгүүлбэр
132	是非问句	yes-no question	бататган асуух өгүүлбэр
133	选择问	alternative questions	сонгон асуух өгүүлбэр

134	特指问句	specific interrogation	Онцолж/ тодруулж асуух өгүүлбэр
135	反问句	rhetorical question	Сөргүүлэн асуух өгүүлбэр
136	猜问句	guess questions	Таамаглан/ тааварлан асуух өгүүлбэр
137	省问句	provincial question	лавшруулан асуух өгүүлбэр
138	正反疑问句	positive and negative questions	лавлан асуух/ эсрэгцүүлэн асуух өгүүлбэр
139	祈使句	imperative sentence	захирах хүсэх өгүүлбэр
140	命令句	imperative/command sentence	захиран тушаах өгүүлбэр
141	禁止句	forbidden sentence	сануулах/ хориглох өгүүлбэр
142	建议句	suggested sentence	санал болгох өгүүлбэр
143	请求句	request-sentence	хүсэх өгүүлбэр
144	感叹句	exclamatory sentence	аялга/ сэтгэлийн хөдөлгөөн илэрхийлсэн өгүүлбэр
145	句型	sentence pattern	өгүүлбэрийн хэв шинж
146	单句	simple sentence	энгийн өгүүлбэр
147	主谓谓语句	S-P predicate sentence	өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүнт өгүүлбэр
148	非主谓句	non-subject-predicate sentence	өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүнт бус өгүүлбэр
149	名词谓语句	noun - predicate sentence	нэр үг өгүүлэхүүнт өгүүлбэр
150	动词谓语句	verb-predicate sentence	үйл үг өгүүлэхүүнт өгүүлбэр
151	形容词谓语句	adjective-predicate structure sentence	тэмдэг үг, өгүүлэхүүнт өгүүлбэр
152	存现句	existential sentence	Байдал заасан өгүүлбэр
153	存在句	existential sentence	оршин байх утгат өгүүлбэр
154	隐现句	fugitive sentence	илрэх утгат өгүүлбэр
155	连谓句	continuous predicate sentence	дараалсан өгүүлэхүүнт өгүүлбэр
156	兼语句	pivotal sentence	хавсарсан өгүүлбэр
157	主谓谓语句	subject predicate predicate sentence	Гол гишүүнт өгүүлэхүүн гишүүн өгүүлбэр
158	复句	complex sentences	нийлмэл өгүүлбэр
159	基本复句	simple complex sentence	энгийн нийлмэл өгүүлбэр
160	多重复句	repeated complex sentence	холимог нийлмэл өгүүлбэр
161	紧缩复句	compendious complex sentence	хураангуй нийлмэл өгүүлбэр
162	联合复句	coordinate composite sentence	хам нийлмэл өгүүлбэр
163	偏正复句	modification complex sentence	тодотгох харьцаат нийлмэл өгүүлбэр
164	并列复句	compound complex sentence	зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
165	顺承复句	consistent complex sentence	угсарсан нийлмэл өгүүлбэр
166	选择复句	selective complex sentence	сонгох нийлмэл өгүүлбэр
167	递进复句	progressive complex sentence	дэвших нийлмэл өгүүлбэр
168	补释复句	supplementary complex sentence	тайлбарт нийлмэл өгүүлбэр
169	因果复句	causal complex sentence	шалтгаан, үр дагаварт нийлмэл өгүүлбэр
170	条件复句	conditional complex sentence	нөхцөлт нийлмэл өгүүлбэр

171	转折复句	turn complex sentence	утга эргэсэн нийлмэл өгүүлбэр
172	让步复句	concession complex sentence	найр тавьсан угсарсан нийлмэл өгүүлбэр
173	目的复句	purpose complex sentence	зорилго заасан угсарсан нийлмэл өгүүлбэр
174	假设复句	hypothetical complex sentence	болзол заасан нийлмэл өгүүлбэр
175	解说复句	explanatory complex sentence	тайлбарласан нийлмэл өгүүлбэр
176	连贯复句	coherent complex sentence	авцалдаат нийлмэл өгүүлбэр
178	“是”字句	“is” sentence	“是” – тэй өгүүлбэр
179	“在”字句	“in” sentence	“在” - тай өгүүлбэр
180	“有”字句	“there is” sentence	“有”- тай өгүүлбэр
181	离合动词	clutch verb	авцах үйл үг
182	动词重叠式	verb reduplication	үйл үгийн давтах хэлбэр
183	形容词重叠式	adjective reduplication	тэмдэг нэрийн давтах хэлбэр
184	“比”字句	“比” compare sentence	“比” -тэй өгүүлбэр
185	“不比/没有”句	“unlike/to not have” sentence	“不比/没有” -тай өгүүлбэр
186	补语	complement	Нөхвөрлөхүүн/ нөхвөр гишүүн
187	结果补语	resultative complement	үр дүн заасан нөхвөрлөхүүн
188	趋向补语	directional complement	чиглэл заасан нөхвөрлөхүүн
189	可能补语	potential complement	боломж заасан нөхвөрлөхүүн
190	程度补语	complement of degree	хэр хэмжээ заасан нөхвөрлөхүүн
191	情态补语	modal complement	төлөв заасан нөхвөрлөхүүн
192	数量补语	quantitative complement	тоо хэмжээ заасан нөхвөрлөхүүн
193	动量补语	momentum complement	үйлийн эрчим заасан нөхвөрлөхүүн
194	时量补语	time quantity complement	үргэлжлэх хугацаа заасан нөхвөрлөхүүн
195	比较数量补语	quantitative complement-sentence	тоо хэмжээг харьцуулсан нөхвөрлөхүүн
196	“把”字句	“把” “handle” sentence	“把” - тай өгүүлбэр
197	“被”字句	“被” sentence	“被” – тэй өгүүлбэр
198	“连”字句	“连” “continuous” sentence	“连” – тэй өгүүлбэр



ОРЧУУЛГЫН САН ХӨМРӨГ





БААТРЫН АНХНЫ ҮГ

Зөү Шыхуа

Түүн шиг ийм турьхан жаахан, угийн үзэсгэлэн төгөлдөр бүсгүйг дээрэмчний хурц ирт хүйтэн мэсний өөдөөс тийнхүү хүн цочирдон алмайрам, тэнгэр бурхад догдлом агуу их зориг гаргана гэж хэн санах билээ. Гэвч энэ бол нэгэнт үнэн бодит хэрэг болоод байлаа.

Одоо тэр бүсгүй эмнэлгийн орон дээр ухаангүй хэвтэж байна. Хэний ч санаанд багтамгүй тэр их мөнгийг авахаар дээрэмчин этгээд сейфний хаалгыг хөшиж онгойлгоод байх үед бүсгүй өчүүхэн ч эргэлзэлгүйгээр түүн рүү дайрсан юм. Бүсгүй олон удаа хутгалуулж, цус нөжиндөө холилдон байсан ч эргэн тойрны нь хүмүүс гүн нойрноос цочин сэрэх хүртэл дээрэмчнээс үхэн хатан зуурсаар байсан аж.

Хүн бүхэн нэгэн дуугаар түүнийг “Баатар, жинхэнэ баатар юм аа” хэмээцгээнэ.

Одоо тэр баатар маань эмнэлгийн тусламжийн ачаар аюулыг ардаа орхисон тул удахгүй ухаан орох ёстой. Түүний орны хажууд дээд байгууллагын дарга, бүсгүйн ажилладаг газрын албаны хүмүүс, хотын “Үдшийн мэдээ” сонины сурвалжлагч, радио, телевизийн сурвалжлагчид, бас баатрын маань гэр бүлийнхэн гээд олон хүн зогсож байлаа.

Баатар маань хөдөлж байна. Уруул нь татваганан, амаа нэг нээн, нэг жимийх аж. Орны нь дэргэд түүний ухаан орохыг хүлээх олон бүгд догдолцгооно. Баатар маань удахгүй сэрэх нь, тун удахгүй ам нээн юм ярих нь ээ.

Түүний хэлэх эхний үг чухам юу болохыг бүгд л мэдэхийг хүснэ. Учир нь тэр бол тун чиг чухал үг байх ёстой.

“Тэр лав ‘Улсын хөрөнгө мөнгийг алдаагүй биз дээ? Дээрэмчнийг барьсан уу?’ гэж хамгийн түрүүнд асуух нь эргэлзээгүй” хэмээн дээд газрын дарга бодож зогсох аж. Тэр дарга өөрийн бодолдоо тун ч итгэлтэй байлаа. Тэрхүү дээд газрын даргатай бүсгүйн ажилладаг байгууллагын дарга сэтгэл зүрхээрээ холбоотой мэт “Тэр мэдээж ‘Улсын хөрөнгө мөнгө үгүй болоогүй биз? Дээрэмчнийг барьсан уу?’ гэж асуух нь тодорхой” хэмээн бодно. Учир нь энэ байгууллагын дарга байнга сонин уншдаг бөгөөд сонин дээр иймэрхүү хэрэг явдлын тухай мэдээнд дандаа л тэгж бичсэн байдаг аж.

“Бүсгүй ‘Дарга аа, таныг надад анхаарал хандуулан, санаа тавьж байдагт талархаж явдаг шүү. Би өөрийн хийх ёстой зүйлээ л хийсэн төдий’ гэж хэлнэ дээ” хэмээн “Үдшийн мэдээ” сонины сурвалжлагч бодно. Учир нь тэр өмнө нь иймэрхүү үйл явдлыг сурвалжилж байсан агаад хэдийгээр тэрхүү амин чухал үгийг хэлж байхыг нь өөрөө сонсоогүй ч гэлээ ингэж хэлснийг нь хүмүүс түүнд хэлж байсан юм.

... ..

Энэ бүхний эцэст баатар маань нүдээ аажуухан нээлээ. Тэр яг л мартагдсан ой санамжаа эргэн санах гэж хичээн байх шиг эргэн тойрноо харна. Орны дэргэдэх хүмүүс нам гүм болжээ. Камерын дуран баатар луу чиглэж, дуу хураагуурын ажиллах товчийг аль хэдийн дарчихсан

байлаа. “Үдшийн мэдээ” сонины сурвалжлагч тэмдэглэлийн дэвтрээ нээчихсэн, хүн бүр л амьсгаа даран баатрыг ширтэцгээнэ. Тэд түүний хэлэх тэр бахдам үгийг хүлээн байлаа.

“Толь, надад толь өгөөч” гэх намуухан дуу гарав. Баатар маань үнэхээр ингэж хэллээ. Тэнд байх олон бүгд алмайран гайхаж хоцров. Ашгүй, орны дэргэд толь байж, нэг нь даруй толийг авч бүсгүйд өглөө. Баатар маань жаахан хүчлэх аястай толийг өргөж бариад, нүүр өөдөө дээш доош баруун зүүн тийш хэсэг харав.

“Нүүр маань гэмтээгүй байна” хэмээн баатар маань дахин хэлээд их л таатайхан инээмсэглэлээ.

Хоёр дарга бие биеэ гайхан харна. “Үдшийн мэдээ” сонины сурвалжлагчийн барьсан үзэг агаарт хөшиж орхив. Зөвхөн камерын дуран л баатрын инээмсэглэлийг яг байгаагаар нь буулгаж авлаа.

Хятад хэлнээс орчуулсан: Б.Гэрэлт-Ирээдүй